| Үйл ажиллагааны чиглэл | • Аялал жуулчлал<br>• Рашаан, ус, ундаа, цай савлах, үйлдвэрлэх, худалдах<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |
| Танилцуулга | Одоогоор үйл ажиллагаа явуулаагүй байна.<br>Рашаан усны нөөц бүхий газар эзэмшдэг. |

#### "Эс И Жи Вай Вай" ХХК

| | |
|---|---|
| Байгуулагдсан огноо | 2019.12.03 |
| Үйл ажиллагааны чиглэл | • Авто машины сэлбэгийн худалдаа<br>• Аялал жуулчлал<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа<br>• Ундааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа |
| Танилцуулга | "Эс И Жи Вай Вай" ХХК нь БНФУ-аас дарс импортлон оруулах үйл ажиллагаа явуулж байна. Компанийн нэр дээр орж ирсэн дарсны борлуулалтыг "Ти Эм Эл Трейд" ХХК хариуцан гүйцэтгэдэг. |

#### "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК

| | |
|---|---|
| Байгуулагдсан огноо | 2023.02.07 |
| Үйл ажиллагааны чиглэл | • Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа<br>• Аюулгүй хог хаягдал цуглуулах<br>• Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд гарган авах |
| Танилцуулга | "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь 2023 оны 2 дугаар сараас эхлэн ундаа, усны хуванцар савыг цуглуулах, дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд өдгөө 2,000 гаруй харилцагч, 1,000 гаруй ачилтын цэгт шууд болон шууд бус 1,600 гаруй ажлын байрыг бий болгон ажиллаж байна. |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

### 3.3. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь засаглалын хувьд дор дурдсан бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

**Схем 3. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

#### Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн засаглалын хувьд Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хууль болон Дүрэмд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх) байна. Компанийн тухай хуулийн 59.2-т "Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу Үнэт цаас гаргагчийн цор ганц хувьцаа эзэмшигч "Ти Эм Эл Трейд" ХХК нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хууль тогтоомж, Дүрэмд заасны дагуу хэрэгжүүлж ажиллаж байна.

2024 .04. сар 29 . өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

## Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь Компанийн дүрэмд заасны дагуу дүрэмд заасанаар хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага байна.

Үнэт цаас гаргагч нь Дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа заасанаар ТУЗ-ийг ес хүртэлх гишүүнтэй байгуулж, гишүүдийн 30 хүртэлх хувийг хараат бус гишүүдээр бүрдүүлэхийг зорьж ажиллана гэж тусгажээ.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчийн 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хурлын А/10 тоот дугаартай шийдвэр болон 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Б/485 дугаартай шийдвэрээр Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.

**Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд**

| Албан тушаалтан | Нэр |
|---|---|
| ТУЗ-ийн дарга | С.Алтантуяа |
| ТУЗ-ийн гишүүн | "Хүмүүжил" (төрсөн нэр Humujile) |
| ТУЗ-ийн гишүүн | "Сансар" (төрсөн нэр Shansier) |
| ТУЗ-ийн гишүүн | Б.Баярзул |
| ТУЗ-ийн гишүүн | Б.Амарбаясгалан |
| ТУЗ-ийн хараат бус гишүүн | Д.Басандорж |
| ТУЗ-ийн хараат бус гишүүн | С.Санасэр |
| ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Б.Ундрал |

***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Санхүүгийн зохицуулах хорооны "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-д нийцсэн ур чадвар, дадлага туршлагатай бөгөөд холбогдох хууль, тогтоомж болон бусад эрх зүйн бичиг баримтыг даган мөрдөж, зохистой засаглалыг хэрэгжүүлэн ажилладаг. ТУЗ-ийн гишүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Үнэт цаасны танилцуулгын 4-р бүлгээс үзнэ үү.

2024 .04 .29 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

## ТУЗ-ийн бүрэн эрх, чиг үүрэг

ТУЗ нь Монгол Улсын хууль тогтоомж, Дүрмээр тогтоосон бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна Гүйцэтгэх удирдлагын гаргасан санал, шийдвэрлэх асуудлыг хурлаар хэлэлцэх, охин болон хараат компанийн үйл ажиллагаанд эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээр хэрэгжүүлэх гэх зэрэг бүрэн эрхийг ТУЗ-ийн Үйл ажиллагааны журамд тусгасан байна. Түүнчлэн, компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлагнал, комплаенс, хувьцаа эзэмшигчдийн үйл ажиллагааны уялдаа, нийгмийн хариуцлагын асуудлаар Гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

## Гүйцэтгэх удирдлага

Компанийн тухай хууль, Дүрэмд зааснаар компанийн Гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал дангаар хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.
Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлаар Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 22/56 тоот шийдвэрийн дагуу Төмөрбат овогтой Дөлгөөн томилогдон ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй энэхүү Үнэт цаасны танилцуулгын 4-р бүлгээс үзнэ үү.

## Үнэт цаас гаргагчийн хэлтэс, нэгжүүд

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь тухайлсан чиглэлийн асуудлыг хариуцах үүрэг бүхий Гүйцэтгэх захиралд шууд харьяалагдах зургаан албатай үйл ажиллагаа явуулж байна.

### Санхүүгийн алба

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн зорилт, төлөвлөгөө, төсвийг тодорхойлон боловсруулах, гүйцэтгэлийг хянах, үйл ажиллагаанд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү, нягтлан бодох бүртгэлийн асуудалд хяналт тавих, тэдгээрийг жишиг стандартын дагуу хөтлөх, санхүүгийн гүйлгээнүүд буюу орлого, зарлагын бүртгэл хийх, хяналт тавих, хөрөнгө, хангамжийн ашиглалт, зарцуулалт, мөнгөн хөрөнгийн урсгалыг удирдах, хянах, санхүүгийн тайлан, холбогдох тодруулга мэдээллүүдийг боловсруулж тайлагнах, татварын тайлан, бүртгэл, нийгмийн даатгал, бусад тооцоонуудыг бэлтгэн боловсруулж холбогдох этгээдэд тайлагнах, Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцоолж эрх бүхий этгээдэд тайлагнах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

### Захиргаа, хүний нөөцийн алба

Үнэт цаас гаргагчийн урт болон дунд хугацааны стратеги зорилт, бизнес төлөвлөгөөний хүрээнд хүний нөөцийн нэгдсэн удирдлага, бодлого, стратеги, менежмент, ажилтнуудын сургалт хөгжлийг дэмжих, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хэвийн байдлыг хангах, хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх, бусад албаны хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулахтай холбогдсон асуудалд дэмжлэг туслалцаа үзүүлэх болон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн алба юм.
Захиргаа, хүний нөөцийн алба нь Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжил, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт зэрэг үйл ажиллагааг удирдлагаар хангахын зэрэгцээ оффисын болон үйлдвэрийн байрны өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалт, үйлчилгээг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

2024.04.29 сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### Борлуулалтын алба

Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь, хувийг өсгөх, борлуулалтын хувь хэмжээг тогтмол нэмэгдүүлэх борлуулалтын төлөвлөгөө, тоон зорилтыг баталж хэрэгжүүлэхэд чиглэсэн алба юм.
Борлуулалтын алба нь боломжит худалдан авагчдыг тодорхойлох, тэднийг татах арга замыг эрэлхийлж, урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах, худалдан авагчдад мэдлэг, мэдээлэл түгээх, харилцагчдын сэтгэл ханамжийг судалж улмаар бүтээгдэхүүнийг илүү хэрэглэгчдэд ойр, хэрэгцээтэй болгон хөгжүүлэх боломжийг эрэлхийлдэг байна.

### Түгээлтийн алба

Бэлэн бүтээгдэхүүнийг өдөр тутам харилцагч, худалдан авагчдын гарт хамгийн ойрхноор байршуулж, захиалгын дагуу хурдан шуурхай, мөн хадгалалт, тээвэрлэлтийн стандартын хангасан байдлаар чанар, үзэмжид өөрчлөлт оруулахгүйгээр түгээлт хийх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

### Үйлдвэрийн алба

Үйлдвэрийн алба нь эрүүл ахуй, ариун цэвэр, стандартын шаардлага хангасан газар, орчин, барилга байгууламж, ажлын байранд зориулалтын багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн шаардлага хангаж баталгаажсан технологийн зааврын дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой.
Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн технологийн горим стандартын дагуу, олон улсын хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан цэвэр ус үйлдвэрлэхийн зэрэгцээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэлийн өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### Чанарын алба

Цэвэр ус үйлдвэрлэлийн явцад технологийн горим, хууль болон олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартын хэрэгжилтэд хяналт тавих, лаборатори, үйлдвэр, тоног төхөөрөмж, агуулахын эрүүл ахуйн байдал, ариутгал, цэвэрлэгээг хангах, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.
Чанарын алба нь түүхий эдээс бэлэн бүтээгдэхүүн гарах хүртэлх бүхий л үе шатанд дотоодын лабораторийн хяналтыг хоёр цаг тутамд тогтмол тавьж ажилладаг бөгөөд хяналтын үед илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр залруулж, чанарын тогтолцоог сайжруулах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

## 3.4. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт, засаглалын тогтолцооны өөрчлөлтийн төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь СЗХ-оос баталсан Компанийн засаглалын кодекс (цаашид "Кодекс" гэх)-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, кодекст нийцсэн сайн засаглалын тогтолцоог урт хугацаандаа тасралтгүй мөрдөж, сайжруулан ажиллахаар төлөвлөж байна.

2022 оны 03-р сарын 23-ны өдөр СЗХ-ны 145 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс" нь компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, жишиг туршлагуудыг нэвтрүүлэх, компани болоод хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгын хүрээнд батлагдсан хувьцаат компани хэлбэртэй аж ахуйн нэгжүүдийн хувьд дагаж мөрдөгдөх бодлогын чухал баримт бичиг юм.

Үнэт цаас гаргагч нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлж, засаглалын урт хугацааны тогтвортой байдал, ил тод нээлттэй байдлыг хангах, компанийн үйл ажиллагаа дах санхүү, хууль зүйн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх механизмын хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг засаглалын жишиг стандартад нийцүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалтыг кодекст нийцүүлэн дараах байдлаар өөрчлөн байгуулахаар төлөвлөсөн байна.

**Схем 4. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо**




***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

### 3.4.1. ТУЗ-ийн дэргэдэх хороодын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасаа нийтэд санал болгон арилжаалсны дараа ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшуулал, аудит, нэр дэвшүүлэх хороодыг байгуулахаар төлөвлөсөн. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулснаар засаглалын сайн туршлагыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээх боломж бүрдэх юм. Үнэт цаас гаргагч нь уг үйл ажиллагаатай холбогдуулан Хуулийн зөвлөх компанитай хамтран дараах журмуудын төслийг боловсруулсан байна. Үүнд:

- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр.

Журмуудыг үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаасны дараа томилогдсон ТУЗ-өөр хэлэлцэн баталж мөрдөхөөр төлөвлөж байна.

СЗХ 2024.04.20 сар өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны төлөвлөгөө

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо (цаашид "Аудитын хороо" гэх) нь компанийн нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн бодлогыг холбогдох хууль, олон улсын стандартад нийцүүлэх, нийцэлд нь хяналт тавих, санхүүгийн тайлан болон санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах, аудитын шалгалтаар шаардлагатай болсон томоохон залруулгыг хийх, бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй байх зарчмыг хэрэгжүүлэх, дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын системийн үр дүнд хяналт тавих, санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитортай харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

Аудитын хороог үнэт цаасыг нийтэд санал болгон гаргасны дараах томилогдсон ТУЗ-өөр хэлэлцэн байгуулахаар төлөвлөсөн бөгөөд уг хүрээнд Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөх компанитай хамтран "Эм Жи Эл Акуа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журам"-ын төслийг бэлтгэсэн байна. Тус төсөлд Аудитын хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, хорооны дарга болон гишүүн, тэдгээрийн бүрэн эрх, хорооны хурал зохион байгуулах, шийдвэр гаргах ажиллагаа, ажлын тайлагнал зэрэг харилцааг зохицуулсан байна.

## ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, компанид мөрдөгдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх болон хууль тогтоомжид заасан болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, шийдвэр гаргах бүрэн эрх бүхий ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо (цаашид "Цалин урамшууллын хороо" гэх)-г үнэт цаасыг нийтэд санал болгон гаргасны дараах ТУЗ-өөр хэлэлцүүлэн байгуулахаар төлөвлөсөн байна.

Үнэт цаас гаргагч болон Хуулийн зөвлөх компани нь Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, гишүүдийн бүрэн эрх, гишүүдийг сонгох, хорооны зохион байгуулалт, хурал зохион байгуулах, шийдвэр гаргах ажиллагаа, ажлын тайлагнал зэрэг харилцааг зохицуулсан "Эм Жи Эл Акуа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам"-ын төслийг боловсруулсан байна.

## ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны төлөвлөгөө

ТУЗ нь хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, компанид ашигтай байдлаар гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо (цаашид "Нэр дэвшүүлэх хороо" гэх)-г байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох, ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлагад үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрийн хараат бус бие даасан байдлыг тогтоох, сургах, мэргэшүүлэх, компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийх, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, залгамж халааны болон хүйсийн бодлого тодорхойлох болон ТУЗ-өөс тогтоосон бусад асуудлаар үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй байна.

Үнэт цаас гаргагч нь "Эм Жи Эл Акуа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам"-ыг Хуулийн зөвлөх компанитай хамтран боловсруулсан бөгөөд уг журмаар Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, гишүүний бүрэн эрх, зохион байгуулалтын хэлбэр, хурал зохион байгуулах, шийдвэр гаргах ажиллагаа, ажлын тайлагнал зэрэг харилцааг зохицуулсан байна.

Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.04.29


MGL aqua

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

4

## 4. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд

Компанийн тухай хуулийн 84.1-т зааснаар компанийн эрх бүхий албан тушаалтанд компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог албан тушаалтнуудыг хамруулдаг. Компанийн тухай хуулийн 84.2-т заасны дагуу компани бүр өөрийн дүрэмдээ эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтыг гаргах үүргийг хүлээлгэсэн байдаг. Энэ хүрээнд Үнэт цаас гаргагчийн Дүрэм болон Компанийн тухай хуулийн 84.1-д зааснаар Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудад ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны ахлах нягтлан бодогч зэрэг албан тушаалтнууд хамрагдаж байна. Андеррайтер нь энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхдээ хөрөнгө оруулагчдад дэлгэрэнгүй мэдээллийг өгөх зорилгоор Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнуудаар хязгаарлагдахгүйгээр Үнэт цаас гаргагчийн засаглал, удирдлагын багт нөлөө бүхий гэж тооцсон дор дурдсан албан тушаалтнуудыг танилцуулж байна.

### 4.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн танилцуулга



Сэр-Од
**Алтантуяа**

ТУЗ-ийн дарга

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2019 оноос | "Ти Эм Эл" ГХОХХК, Дэд захирал |
| 2017-2019 | "Говь" ХК, Оёмол үйлдвэрийн дарга |
| 2015-2017 | "Говь" ХК, Маркетингийн албаны дарга |
| 2005-2014 | "М-Си-Эс Кока Кола" ХХК, Маркетингийн менежер |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2011-2013 | МУ, Удирдлагын академи, Бизнес удирдлага (Магистр) |
| 1999-2005 | БНХАУ, Бээжин хотын Олон Улсын Их Сургууль /Beijing International Studies University/, Олон улсын худалдаа, эдийн засагч (Бакалавр) |
| 1997-1998 | МУ, Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Англи хэлний багш, орчуулагч |



Хатанбаатар
**Хүмүүжил**

ТУЗ-ийн гишүүн

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2014 оноос | "Ти Эм Эл" ГХОХХК, Нягтлан бодогч |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2014-2018 | МУ, Монгол Улсын Их Сургууль, Нягтлан бодох бүртгэл (Бакалавр) |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03



Оюунчимэг
**Сансар**

ТУЗ-ийн гишүүн

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2019 оноос | "Ти Эм Эл" ГХОХХК, Санхүүгийн менежер |
| 2015-2019 | "Тайшэн Девелопмент" ХХК, Нягтлан бодогч |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2011-2015 | БНХАУ, Лиаонин Их Сургууль /Liaoning University/, Нягтлан бодогч (Бакалавр) |



Баатар
**Баярзул**

ТУЗ-ийн гишүүн

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2021 оноос | "Ти Эм Эл" ГХОХХК, Ерөнхий нягтлан бодогч |
| 2014-2021 | "Чоно групп" ХХК, Ерөнхий нягтлан бодогч |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2012-2014 | МУ, Мандах Бүртгэл Дээд Сургууль, Нягтлан бодох бүртгэл (Бакалавр) |
| 1999-2004 | МУ, Шинжлэх Ухааны Технологийн Их Сургууль – Компьютер Техник, Менежментийн Сургууль, Компьютерын инженер (Бакалавр) |



Баасанжав
**Амарбаясгалан**

ТУЗ-ийн гишүүн

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2022 оноос | "Ти Эм Эл" ГХОХХК, Хуулийн зөвлөх |
| 2021-2022 | "Саммит компьютер технологи" ХХК, Төслийн мэргэжилтэн |
| 2016-2017 | "М-Си-Эс Интернэшнл" ХХК, Төслийн мэргэжилтэн |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2023 оноос | МУ, Монгол Улсын Их Сургууль - Бизнесийн удирдлага (Магистр) |
| 2017-2021 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Хууль Зүйн Сургууль, Эрх зүйч (Бакалавр) |
| 2010-2014 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Гадаад Хэл Соёлын Сургууль, Орчуулагч (Бакалавр) |

СЗХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ-03



Содномдорж
**Санасэр**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2022 оноос | "Эн Эф Трийс" ХХК, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн |
| 2022 оноос | "Волтам" ХХК, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн |
| 2018 оноос | "Эс Пронисэс Консалтинг" ХХК, Үүсгэн байгуулагч |
| 2012-2017 | "Меррор Товер" ХХК, ТУЗ-ийн дарга |
| 2007 оноос | Монгол Улсын Их Сургууль - Эдийн засгийн сургууль, Ахлах багш |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2021-2023 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын ухаан (Доктор) |
| 2017-2018 | АНУ, Харвардын Их Сургууль, Төрийн удирдлага (Магистр) |
| 2004-2006 | АНУ, Калифорни Олон Улсын Их Сургууль, Шинжлэх ухаан (Магистр) |
| 1998-2002 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Эдийн засгийн сургууль, Бизнесийн удирдлага (Бакалавр) |



Даваа
**Басандорж**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2023 оноос | Монгол Улсын Ариун Цэврийн Байгууллага, Ерөнхийлөгч |
| 2021-2022 | Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Байгал орчин инженерийн тэнхимийн эрхлэгч |
| 2013 оноос | "Монголын усны түншлэл" ТББ, Гүйцэтгэх захирал |
| 1984-1994 | Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль, Техникийн ухааны доктор, дэд профессор |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2002 | ОХУ, Барилгын Инженер Архитектурын Их Сургууль, Ус хангамжийн инженер (Профессор) |
| 1984 | ОХУ, Усны Инженер Технологийн Их Сургууль, Ус хангамжийн инженер (Магистр) |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-29
БҮРТГЭВ-03



Батбаяр
**Ундрал**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2023 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 2018 оноос | "Ти Эм Эл" ГХОХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал |
| 2008-2016 | "Голомт Банк" ХХК, Эдийн засагч болон Харилцааны менежер |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2023 оноос | МУ, Монгол Улсын Их Сургууль, Санхүү менежмент (Магистрант) |
| 2005-2008 | МУ, Мандах Бүртгэл Дээд Сургууль, Нягтлан бодох бүртгэл (Бакалавр) |
| 1999-2004 | МУ, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Англи болон Орос хэлний орчуулагч (Бакалавр) |

## 4.2. Удирдлагын багийн гишүүдийн танилцуулга



Төмөрбат
**Дөлгөөн**

Гүйцэтгэх захирал

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2022 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Гүйцэтгэх захирал |
| 2017-2020 | "Ти Эм Эл Трейд" ХХК, Ерөнхий менежер |
| 2013-2016 | "Хуамейда" ГХОХХК, Хүний нөөцийн менежер |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2015-2016 | МУ, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Санхүү удирдлага (Магистр) |
| 2009-2013 | БНХАУ, Далянь хотын Их Сургууль, Бизнесийн эрх зүй /2+2 хамтарсан хөтөлбөр/, Эрх зүйч (Бакалавр) |



Баттулга
**Бат-Оргил**

Борлуулалтын албаны дарга

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2021 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Борлуулалтын албаны дарга |
| 2009-2021 | "М-Си-Эс Кока-Кола" ХХК, Борлуулалтын хэлтсийн дарга |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2005-2009 | МУ, Олон Улсын Улаанбаатар Их Сургууль, Мал аж ахуйн фермерийн удирдлага (Бакалавр) |

СЭХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03



Даариймаа
**Бат-Ирээдүй**

Ахлах нягтлан бодогч

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2016 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Ахлах нягтлан бодогч |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2012-2016 | МУ, Монголын Үндэсний Их Сургууль, Нягтлан бодогч (Бакалавр) |



Бямбацогт
**Дашзэвэг**

Түгээлтийн албаны дарга

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2021 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Түгээлтийн албаны дарга |
| 2017-2021 | "Таван Богд Групп" ХХК, Борлуулалт, маркетингийн ахлах менежер |
| 2014-2017 | "Витафит Групп" ХХК, Борлуулалтын хяналтын албаны дарга |
| 2007-2014 | "АПУ Трейдинг" ХХК, Хяналтын менежер |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2014-2016 | МУ, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Бизнесийн удирдлага, маркетинг (Магистр) |
| 2003-2007 | МУ, Тагнуулын Ерөнхий Газрын Дээд Сургууль, Эрх зүйч (Бакалавр) |



Баярхүү
**Мөнхцолмон**

Захиргаа хүний нөөцийн албаны дарга

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2023 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Захиргаа хүний нөөцийн албаны дарга |
| 2019-2023 | "Тэсо групп Милко" ХХК, Захиргаа хүний нөөцийн албаны дарга |
| 2017-2019 | "Тэсо групп Агь" ХХК, Хүний нөөцийн менежер |
| 2013-2015 | "Шууд Ти Ви" ХХК, Захиргааны ажилтан |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2017-2019 | МУ, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль - Бизнесийн Ахисан Түвшний Сургууль, Хүний нөөцийн менежмент (Магистр) |
| 2005-2009 | МУ, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Санхүүгийн менежмент (Бакалавр) |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL
Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ



Нямдаваа
**Магсаржав**

Үйлдвэрийн менежер

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2023 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Үйлдвэрийн менежер |
| 2021-2023 | "Дун Юань ХАА" ХХК, Үйлдвэрийн менежер |
| 2020-2021 | "Галт Уулын Жуулчин" ХХК, Шинжээч |
| 2010-2011 | "Гезауба групп", Орчуулагч |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2017-2021 | БНХАУ, Нийслэлийн Багшийн Их Сургууль, Газарзүй мэдээллийн систем (Магистр) |
| 2016-2017 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль, Байгал орчин (Магистр) |
| 2012-2015 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Гадаад Хэл Соёлын Сургууль, Хятад орон судлал (Бакалавр) |
| 2008-2012 | БНХАУ, Бээжин хотын Үндэсний Их Сургууль, Хятад хэлний бэлтгэл |



Батбаяр
**Ариунжаргал**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2021 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хариуцсан ажилтан |
| 2019-2021 | Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Сүхбаатар дүүргийн хог хаягдал хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн |
| 2017-2019 | "Адхими Селис Клен Ферпект" ХХК, Менежер |
| 2015-2017 | "Биродом" ХХК, Гүйцэтгэх захирал |
| 2011-2015 | "Адхими Селис Клен Ферпект" ХХК, Захирлын туслах |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2014-2016 | МУ, "Эко – Ази" Байгаль Орчин Менежментийн Дээд Сургууль, Хүрээлэн буй орчин судлал (Магистр) |
| 2010-2014 | МУ, "Эко – Ази" Байгаль Орчин Менежментийн Дээд Сургууль, Экологи байгаль хамгаалал (Бакалавр) |



Наранцэцэг
**Бямбацэцэг**

Технологич

**Ажлын туршлага:**

| | |
|---|---|
| 2023 оноос | "Эм Жи Эл Акуа" ХХК, Технологич |
| 2016-2022 | "Алко Групп" ХХК, Чанарын менежер |
| 2011-2015 | "Алко Групп" ХХК, Микро биологич |
| 2008-2011 | "Алко Групп" ХХК, Химич |

**Боловсрол:**

| | |
|---|---|
| 2008-2012 | МУ, Монгол Улсын Их Сургууль – Биотехнологийн Сургууль, Биохимич (Бакалавр) |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

2024.04.29 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 4.3. Эрх бүхий албан тушаалтнуудын эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааны талаарх мэдээлэл

**Хүснэгт 5. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын эзэмшиж буй хувьцааны талаар мэдээлэл**

| № | Албан | Нэр | Үнэт цаас гаргагчийн хувьцааг эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн дарга | С.Алтантуяа | Үгүй |
| 2 | ТУЗ-ийн гишүүн | Х.Хумүүжил | Үгүй |
| 3 | ТУЗ-ийн гишүүн | О.Сансар | Үгүй |
| 4 | ТУЗ-ийн гишүүн | Б.Баярзул | Үгүй |
| 5 | ТУЗ-ийн гишүүн | Б.Амарбаясгалан | Үгүй |
| 6 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Д.Басандорж | Үгүй |
| 7 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | С.Санасэр | Үгүй |
| 8 | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Б.Ундрал | Үгүй |
| 9 | Гүйцэтгэх захирал | Т.Дөлгөөн | Үгүй |
| 10 | Борлуулалтын албаны дарга | Б.Бат-Оргил | Үгүй |
| 11 | Түгээлтийн албаны дарга | Б.Дашзэвэг | Үгүй |
| 12 | Захиргаа, хүний нөөцийн албаны дарга | Б.Мөнхцолмон | Үгүй |
| 13 | Ахлах нягтлан бодогч | Д.Бат-Ирээдүй | Үгүй |
| 14 | Үйлдвэрийн менежер | Н.Магсаржав | Үгүй |
| 15 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан | Б.Ариунжаргал | Үгүй |
| 16 | Технологич | Н.Бямбацэцэг | Үгүй |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

СЗХ
2024 .04. 29
оны сар өдөр
БҮРТГЭВ

MGL aqua

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

5

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

# 5. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

## 5.1. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн

Үнэт цаас гаргагч нь бумбатын рашааны судалтай, 120 метрийн гүний цэвэр усыг үйлдвэрийн аргаар шүүн цэвэршүүлж, эрдэсжүүлэн 2 нэр төрлийн савлагаа болон хэрэглэгчдийн хэрэглээнд тохируулан 6 төрлийн эзлэхүүнтэй савлагаатайгаар хамгийн боломжийн үнээр зах зээлд нийлүүлэн ажиллаж байна.

### 5.1.1. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүний танилцуулга




Нэг багц
20 ширхэгтэй.

**200 мл**

Олон улсад хэрэглэгддэг Pocket water буюу халаасанд багтахуйц савлагаа бөгөөд Монгол Улсад худалдаалагдаж буй хамгийн жижиг савлагаа юм. Энэ савлагаа нь усны хаягдал багасгах зорилготой үйлдвэрлэгдсэн ба зорилтот хэрэглээ нь богино хэмжээний хурал уулзалт, эмийн сан, бага насны хүүхдүүдэд чиглэгдсэн.




Нэг багц
20 ширхэгтэй.

**Ph8.5 500 мл**

Тэнцвэрт хүнсний хэрэглээнд зориулсан шүлтлэг ус. Байгалийн цэвэршүүлсэн хужраар баяжуулж хүчил шүлтээр тэнцвэржүүлэн зөөлрүүлсэн тул ходоодны хүчин тогтмол ихэсдэг хэрэглэгчдэд зориулсан.




Нэг багц
20 ширхэгтэй.

**500 мл**

Борлуулалтын бүх сувгууд, бүх насны хэрэглэгчдэд зориулсан, амны цангаа тайлах зохимжит үндсэн савлагаа.




Нэг багц
4 ширхэгтэй.

**4.5 литр**

Гэр бүлийн хэрэглээнд зориулагдсан хамгийн том савлагаа. Авч явахад хялбар бариултай, баллонтой ус буцалгагчид суурилуулан ашиглах боломжтой ухаалаг бөглөөтэй.



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescore CAPITAL УЛААНБААТАР ХОТ




Нэг багц
12 ширхэгтэй.

800 мл

Бүх төрлийн спортоор хичээллэх үед хэрэглэхэд тохиромжтой савлагаа бүхий бүтээгдэхүүн.




Нэг багц
8 ширхэгтэй.

1.5 литр

RG, Mining, сувгийн хэрэглэгчдэд зориулсан хэмнэлттэй савлагаа.




Нэг багц
20 ширхэгтэй.

330 мл

Mining, At work, ED, Horeca, CVS сувгийн хэрэглэгчдэд чиглэсэн.

### 5.1.2. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүний онцлог, танигдсан байдал

#### Чанар

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын бүхий л үйл ажиллагаандаа ЧАНАР-ыг эрхэм зорилгоо болгон хэрэглэгчдийн өдөр тутмын шингэн хүнсний гол хэрэглээ буюу улсын хэмжээний стратегийн хүнсний бүтээгдэхүүнийг эрүүл аюулгүй, чанар стандартын өндөр түвшинд нийлүүлэхээр зорьж ажилладаг. Байгууллага нь стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах нь үйлдвэрлэл, үйлчилгээ болон менежментийн чанарыг тасралтгүй сайжруулах үндэс суурь болж байдаг.

Үнэт цаас гаргагч нь 2017 оноос эхлэн Олон улсын хүнсний аюулгүй байдлын стандарт болох FSSC 22000 (Food Safety System Certification), мөн 2023 оноос хойш Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг амжилттай нэвтрүүлэн, холбогдох шаардлагуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд чанарын тасралтгүй сайжруулалтыг хангал ажиллаж байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны үйлдвэр нь Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтын шаардлагад нийцүүлэн дотоодын шингэн хүнсний үйлдвэрийн стандартууд болох савласан цэвэр усны MNS 5007:2022 стандарт, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээг хангасан ундны усны MNS 0900:2016 шаардлагуудыг хангал ажилладаг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

СЗХ
2024 .04сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн стандартууд

FSSC 22000 стандартыг Дэлхийн хоол хүнсний аюулгүй байдлын санаачилга буюу GFSI (Global Food Safety Initiative) олон улсын байгууллагаас баталсан ба Европын улсуудад хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхэд тус стандартыг үйл ажиллагаандаа зайлшгүй нэвтрүүлсэн байхыг шаарддаг. Энэхүү стандарт нь хоол хүнсний аюулгүй байдлаас гадна хүнсний чанар, хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан цогц удирдлагын тогтолцоо бөгөөд хоол хүнс үйлдвэрлэгчдэд хүнсний аюулгүй байдлыг алдагдуулж болзошгүй эрсдэл, хяналтын цэгүүдийг тодорхойлох, улмаар эрсдэлийн удирдлагын арга хэмжээг цаг алдалгүй авах боломжийг олгодог.

FSSC 22000 нь ISO 22000:2018, ISO/TS22002-1:2009 ба бусад чанарын стандартууд дээр суурилдаг. Монгол Улсад энэхүү стандартын баталгаажуулалтыг олгодог цөөн магадлан итгэмжлэгдсэн байгууллага байдаг. Үнэт цаас гаргагч нь дэлхийд тэргүүлэгч магадлан баталгаажуулалтын SGS (Society of Surveillance) байгууллагаар уг стандартыг 3 жил тутам нэг удаа давтан баталгаажуулдаг.

ISO 9001:2015 стандарт нь түүхий эд материалыг хүлээн авахаас эхлэн үйлдвэрлэлийн бүх үе шатыг хянаж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг баталгаажуулах олон улсын стандарт бөгөөд уг стандартыг 3 жил тутам нэг удаа давтан баталгаажуулуулдаг.

**Зураг 2. Үнэт цаас гаргагчийн Олон улсын хүнсний аюулгүй байдлын FSSC 22000 стандарт болон Олон улсын чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартын гэрчилгээнүүд**


SGS
Certificate CN23/00004030
MGL AQUA LLC
Food Safety System Certification FSSC 22000
FSSC 22000


SGS
Certificate CN23/00004084
MGL AQUA LLC
ISO 9001:2015
IAF


СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
IAF
ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Нэр: Эм Жи Эл Аква ХХК
Регистр: 2628333
Утас/Факс: 77045555
Хаяг: УБ хот, СХД 40-р хороо, Баруун салаа
1. 23-2991 2023-07-05
2. Стандарт, хэмжил зүйн газар
1. "Voyage" 2201 MNS 5007:2007
2. "Voyage" 2201, 2202 MNS 5007:2007
2023-11-29
001415
2026-11-29

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

MNS 5007:2007 стандарт нь савласан усны үйлдвэрлэх, шалгаж хүлээх авах, савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх шаардлагыг тогтоосон Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй стандарт юм. Тус стандартын техникийн шаардлага нь Савласан усыг "MNS CAC 1, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (Олон улсын зөвлөмж)" стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлийн байранд батлагдсан технологийн заавар, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан үйлдвэрлэх нөхцөлүүдийг тусгасан байдаг. MNS 5007:2007 стандарт нь 2022 оны 12-р сарын 27-ны өдөр шинэчлэгдэж MNS 5007:2022 болсон.

MNS 0900:2018 стандартын зорилго нь хүн амын ундны болон ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн болон чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангуулах бөгөөд төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс ус олборлох, нөөцлөх, чанарыг сайжруулах, түгээх, зөөвөрлөх, хадгалах үе шат бүрд хүн амын ундны болон ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг хангуулдаг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь усны чанар, аюулгүй байдалд улирал тутам хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээг гүйцэтгүүлдэг. Тус хөндлөнгийн хяналтыг "Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Лавлагаа Лаборатори", "Геологи Судалгаа Шинжилгээний Төв Лаборатори", "Усны Газар Хяналтын Төв Лаборатори", "Номин Эко Стандарт хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатори" зэрэг итгэмжлэгдсэн байгууллагуудаар хийлгэдэг. Мөн үйлдвэрийн ээлж бүрээр 2 цаг тутамд өөрийн дотоод лабораторид усны дээжийн шинжилгээ хийдэг.

**Зураг 3. Voyage савласан цэвэр усны дээжийн шинжилгээний хуудас**



*Эх сурвалж: Voyage савласан цэвэр усны шинжилгээний бичгүүд*

## Дэвшилтэт технологи

Үнэт цаас гаргагч нь 170 гаруй жилийн түүхтэй, сав баглаа боодлын салбарт дэлхийд тэргүүлэгч Франц Улсын Sidel Группийн дэвшилтэт тоног төхөөрөмж бүхий бүрэн автомат компьютер удирдлагын системтэй хуруу сав үлээх төхөөрөмжөөр байгаль орчинд ээлтэй, өртөг багатайгаар цэвэр усны савлагааг үйлдвэрлэдэг. Тус төхөөрөмжийг Coca Cola, PepsiCo, Nestlé, Danone, Nongfu Spring зэрэг компаниуд ашигладаг байна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь хуруу сав үлээх үйл ажиллагааны дараах дамжлагад 24 жилийн түүхтэй, сав баглаа бодлын техник технологийн үйлдвэрлэлийн салбарт Ази тивд тэргүүлэгч БНХАУ-ын Techlong Packaging Machinery компанийн жижиг болон 4.5 л бүхий бүрэн автомат савлах, багцлах цогц шугамуудыг суурилуулснаар төрөл бүрийн хэмжээтэй, олон улсын стандартын дагуу савласан цэвэр усыг үйлдвэрлэж байна. Тус тоног төхөөрөмжийг Nongfu Spring, Bright Dairy & Food, Mengniu Dairy зэрэг компаниуд ашигладаг байна.

Мөн дээрх хоёр тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг нэгтгэсэн, 70 жилийн туршлагатай ХБНГУ-ын алдартай Krones брэндийн сав үлээх, савлах, багцлах цогц систем бүхий бүрэн автомат компьютер удирдлагын системтэй тоног төхөөрөмжийг 2023 онд суурилуулснаар Үнэт цаас гаргагчийн үйлдвэрийн хүчин чадал 3 дахин нэмэгдсэн. Үнэт цаас гаргагч нь жижиг ба том савлагааны нийт 2 шугамтай бөгөөд тус 2 шугамын хүчин чадал нь 6,000 лонх/цаг, жилд 40,000,000 лонх юм. 2023 онд Krones брэндийн жижиг савлагааны шугамыг суурилуулснаар Үнэт цаас гаргагчийн үйлдвэрийн хүчин чадал нь нийт 20,000 лонх/цаг, буюу жилд 120,000,000 лонх болж нэмэгджээ.

Улмаар үйлдвэрлэгдсэн эцсийн бүтээгдэхүүн нь өндөр чанартай, стандартад нийцсэн, байгаль орчинд ээлтэй ба хамгийн боломжийн үнээр олон нийтэд хүргэгдэж байна.

### 5.2. Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

Дэлхийн цэнгэг усны ¼ нь чулуун мандалд буюу газрын гүнд агуулагддаг ба түүнийг газар доорх ус буюу гүний ус гэж нэрлэдэг. Дэлхийн газар доорх усны нийт хэмжээ нь 60 сая км.куб байдаг нь хуурай газрын усны төрлүүдээс хамгийн их нь юм. Газар доорх усны энэхүү масс нь агаарын тунадас болон гол мөрөн, нуурын ус газрын гүн рүү шүүрэн нэвчих замаар үүссэн. Иймд газар доорх усны ихэнх нь цэнгэг байдаг.

Газрын гүнд байрлах их хэмжээний ус нь элс, элсэн чулуу, хайрга, шавар гэх мэт төрөл бүрийн чулуулаг дунд харилцан адилгүй гүнд байрладаг. Газрын доорх уст давхарга буюу гүний ус бүрэлдэх гол хүчин зүйл нь хур тунадас газрын гүн рүү нэвчин орж газрын доорх усыг үүсгэх нөхцөл болдог.

Гүний ус нь газрын гүнд байрлах чулуулгийн ханаагүй давхаргын бүсэд оршдог бөгөөд эх үүсвэрээсээ шалтгаалж усанд агуулагдах байгалийн эрдэс бодисын найрлага, хатуулгийн хэмжээ нь харилцан адилгүй байдаг. Иймд гүний усыг шүүж, усанд агуулагдах эрдэс бодисын хэмжээг зохистой хэмжээнд хүргэн цэвэршүүлж хэрэглэдэг. Олон улсад гүний усыг эх үүсвэрээс нь хамааруулан рашаан, эрдэст, цэвэршүүлсэн гэж үндсэн гурав ангилдаг ба цэвэршүүлсэн усыг ундандаа түлхүү ашигладаг байна. (Цэвэршүүлсэн усны хэрэглээтэй холбоотой судалгааг энэхүү Үнэт цаасны танилцуулгын 11-р бүлгээс үзнэ үү.)

#### 5.2.1. Үйлдвэрлэлийн ерөнхий үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны үйлдвэр нь 2001 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш 22 жил тасралтгүй газрын гадаргуугаас доош 120 метрийн гүнд орших байгалийн эрдсээр баялаг цэвэр усыг үйлдвэрийн аргаар цэвэршүүлэн боловсруулж, хүн амын хэрэгцээнд нийцсэн эрүүл, аюулгүй хүнсийг түгээн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны үйлдвэр нь Үнэт цаасны танилцуулга бичих үеийн байдлаар цэвэр усаар дагнасан Монгол Улсын хамгийн том үйлдвэр юм. Үйлдвэрийн хүчин чадал нь дангаараа Монгол Улсын нийт савласан цэвэр усны хэрэглээг бүрэн хангах боломжтой юм.

**Зураг 4. Усны үйлдвэр**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

СЗХ 2024 04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь дараах 4 шат дараалаас бүрддэг ба үе шат бүр нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны холбогдох журам, процесс зураглалаар зохицуулагдсан байна.

**Схем 5. Үйлдвэрлэлийн ерөнхий процесс зураглал**




*Эх сурвалж:* *Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

СЗХ 2024.04.29 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### 5.2.2. Бэлтгэн нийлүүлэлтийн үйл ажиллагаа

#### Ус олборлох үйл ажиллагаа

Савласан цэвэр усны үйлдвэрлэлд чанарын стандарт хангасан ундны ус олборлолт нь хамгийн чухал ач холбогдолтой байдаг. Үнэт цаас гаргагч нь ундны усны эрүүл ахуй, чанарын шаардлагын дагуу гүний усыг газрын гүнээс олборлож, цэвэршүүлэн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн гүний усыг олборлох, цэвэршүүлэн ариутгах үйл ажиллагаа нь дараах үе шатлалтай. Үүнд:

1. 120 метрийн гүнээс ус олборлоно;
2. Уснаас дээж авч хөндлөнгийн хяналтын лаборатори болон дотоодын лабораторид шилжүүлэн хими болон физикийн үзүүлэлтүүдийн нарийн шинжилгээ гүйцэтгүүлж, ундны усны шаардлага хангасан эсэхийг тогтооно. Шинжилгээний үр дүнг зохих стандарттай харьцуулан дүгнэлт гаргасны үндсэн дээр зориулалтын 5 тонн багтаамжтай нөөцийн 3 саванд нөөцөлнө;
3. Стандарт шаардлага хангасан гүний усыг 6 давхар шүүлтүүрээр цэвэршүүлж, озоны технологиор ариутган, зориулалтын 10 тонн болон 5 тонн багтаамжтай нөөцийн сав руу нөөцөлж, савлах дамжлага руу шилжүүлнэ. Бүтээгдэхүүний нөөцийн сав нь хэт том биш байгаа нь гүний усыг удаан хадгалахгүй, шинээр нь савлах зорилготой.

**Схем 6. Гүний усыг олборлох, цэвэршүүлэх, ариутгах үйл ажиллагааны процесс зураглал**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн Технологийн заавар*

Ундны усанд тохиромжтой байдлыг шинжлэх процесст байгууллагын дотоод чанарын хяналтын лабораторийн баг ажиллаж гүний усны шинжилгээг гүйцэтгэж, үнэлгээ дүгнэлт гаргадаг. Шинжилгээний дүгнэлт дээр үндэслэн стандартын шаардлага хангасан гүний усыг цэвэршүүлэн савладаг.

**Зураг 5. Ус олборлож, цэвэршүүлэх үйл ажиллагааны өрөө, технологийн хэсэг**



*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

СЗХ
2024-04-29
БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны үйлдвэр дараах чанарын шаардлага хангасан гүний усыг хүлээн авч цэвэршүүлэн стандартад нийцсэн савласан усыг үйлдвэрлэж байна. Гүний усыг төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс ус ашиглагч, хэрэглэгч хүртэлх ус хангамжийн сүлжээний үе шат бүрд хүн амын ундны болон ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын хүрээнд 3 төрлийн үзүүлэлт бүхий шаардлагуудыг авч үздэг бол савласан усыг үйлдвэрлэх, шалгаж хүлээж авах, савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэхэд 4 төрлийн үзүүлэлт бүхий шаардлагуудыг хангах шаардлагатай байдаг.

**Схем 7. Гүний ба савласан усны үзүүлэлтүүдийн төрөл**




***Эх сурвалж:** MNS 5007:2022, MNS 0900:2018 стандартууд*

Үнэт цаас гаргагч нь ундны усны эх үүсвэрийн болон савласан цэвэр усны чанарын шаардлагуудын дагуу бүх төрлийн үзүүлэлтүүдийг ханган ажилладаг.

### Гүний усны чанарын дундаж үзүүлэлт

Ундны усны эх үүсвэрийн чанар нь мэдрэхүйн буюу физикийн, химийн найрлагын, бичил амь судлалын гэх 3 төрлийн үзүүлэлт бүхий шаардлагуудыг хангасан байна.

**Хүснэгт 6. Voyage-ийн гүний усны шинжилгээний үзүүлэлт**

#### 1. Физикийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 0900:2018 стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage-ийн гүний усны үзүүлэлт |
|---|---|---|
| Өнгө | 20 градусаас ихгүй | Өнгөгүй |
| Булингар буюу тунгалагжилт | 5 NTU*-с ихгүй | 0.26 NTU, тунадасгүй, тунгалаг 30 см |
| Үнэр | Үнэргүи | Үнэргүй |
| Амт | Амтгүй | Амтгүй |
| Усны орчин Ph | 6.5 - 8.5 хооронд | 7.8 |
| Цахилгаан дамжуулах чанар | 1.0 мСм/см**-ээс ихгүй | 0.3 мСм/см |

*NTU (Nephelometric Turbidity Units) – Нефелометрийн булингарын нэгж

**мСм/см – Миллисименс/сименс – Цахилгаан дамжууллын хэмжилтийн нэгж

СЗХ 2024 .04. 29 сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ 03

## 2. Химийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 0900:2018 стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage-ийн гүний усны үзүүлэлт |
|---|---|---|
| Аммони, $NH_4^+$ | 1.5 мг/л-ээс ихгүй | 0.0-0.1 мг/л |
| Кальци, $Ca^{2+}$ | 100 мг/л-ээс ихгүй | 48.1-89.2 мг/л |
| Магни, $Mg^{2+}$ | 30.0 мг/л-ээс ихгүй | 12.2-20.1 мг/л |
| Натри, $Na^+$ | 200 мг/л-ээс ихгүй | 11.9 мг/л |
| Нитрат, $NO_3$ | 50 мг/л-ээс ихгүй | 1.7-45.0 мг/л |
| Нитрит, $NO_2$ | 1 мг/л-ээс ихгүй | 0.0-0.01 мг/л |
| Сульфат, $SO_4^{2-}$ | 500 мг/л-ээс ихгүй | 9.9-45.0 мг/л |
| Төмөр, Fe | 0.3 мг/л-ээс ихгүй | 0.0-0.01 мг/л |
| Нийт хатуулаг, $CaCO_3$ | 7 мг-экв/л-ээс ихгүй | 3.4 мг-экв/л |
| Хлорид, Cl | 350 мг/л-ээс ихгүй | 8.5-62.5 мг/л |
| Хуурай үлдэгдэл | 1,000 мг/л-ээс ихгүй | 221.0 мг/л |
| Гидрокарбонат | 500 мг/л-ээс ихгүй | 0.0-195.2 мг/л |

**Дүгнэлт:** Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, хатуувтар ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.

***Эх сурвалж:*** *Стандарт, хэмжил зүйн газрын хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн шинжилгээний дүн, Худгийн ус/Бумбат дээж, 2023 оны 7-р сарын 5; Шинжлэх ухааны академи Газарзүй – Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораторийн "Эм Жи Эл Акуа" ХХК-ийн худгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт, 2023 оны 11-р сарын 7*

## 3. Бичил амь судлалын үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 0900:2018 стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage-ийн гүний усны үзүүлэлт |
|---|---|---|
| 1мл усан дахь нийт нянгийн тоо | 100-аас ихгүй | 100-аас ихгүй |
| Гэдэсний бүлгийн нянгийн тоо | 0 | 0 |
| Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян /Salmonella, Shigella гэх мэт/ | 0 | 0 |
| Шимэгч, эгэл биетэн | 0 | 0 |
| Энтеровирус | 0 | 0 |
| E.coli эсвэл халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян | 0 | 0 |
| Clostridium perfringens | 0 | 0 |

***Эх сурвалж:*** *Хяналтын Төв лабораторийн сорилтын дүнгийн хуудас, Гүний худгийн цэвэр усны микробиологи, 2023 оны 7-р сарын 5*



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd Улаанбаатар хот
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

СЗХ 2024.04.29 он сар өдөр БҮРТГЭВ № 01

## Савласан цэвэр усны чанарын дундаж үзүүлэлт

Савласан цэвэр усны чанар нь мэдрэхүйн буюу физикийн, химийн найрлагын, бичил биетний эрүүл ахуйн шалгуурын, хүнд металлын бохирдлын гэх 4 төрлийн үзүүлэлт бүхий шаардлагуудыг хангасан байна.

**Хүснэгт 7. Voyage-ийн савласан цэвэр усны шинжилгээний үзүүлэлт**

### 1. Савласан цэвэр усны физикийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 5007:2007 (MNS 5007:2022) стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage савласан цэвэр усны үзүүлэлт |
|---|---|---|
| Амт | Амтгүй | Амтгүй |
| Үнэр | Үнэргүй | Үнэргүй |
| Өнгө | 20 градусаас ихгүй, өнгөгүй | Өнгөгүй |
| Булингар буюу тунгалагжилт | 5 NTU*-с ихгүй, гадны механик хольц, тунадасгүй, тунгалаг | Тунадасгүй, тунгалаг 30 см |
| Цахилгаан дамжуулах чанар | - | 0.01 мСм/см |

### 2. Савласан цэвэр усны химийн найрлагын үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 5007:2007 (MNS 5007:2022) стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage савласан цэвэр усны үзүүлэлт |
|---|---|---|
| Ерөнхий хатуулаг, $Ca^{2+} + Mg^{2+}$ | 1.0-4.5 мг-экв/л ихгүй | 0.05-0.15 мг-экв/л |
| Исэлдэх чанар | 5 мг/л -ээс ихгүй | 2.56 мг/л |
| Усны орчин pH | 5.5 – 9.5 хооронд | 5.8 |
| Натри, $Na^{+} + K^{+}$ | 10 мг/л-ээс ихгүй | 3.5 мг/л |
| Кальци, $Ca^{2+}$ | 20-70 мг/л-ээс ихгүй | 1.0-2.0 мг/л |
| Магни, $Mg^{2+}$ | 5 мг/л-ээс ихгүй | 0.0-0.6 мг/л |
| Хлорид, Cl | 15 мг/л-ээс ихгүй | 6.3 мг/л |
| Сульфат, $SO_4^{2-}$ | 15 мг/л-ээс ихгүй | 0.09 мг/л |
| Нийт төмөр, $Fe^{2+} + Fe^{3+}$ | 0.2 мг/л-ээс ихгүй | 0.000-0.001 мг/л |
| Гидрокарбонат, $HCO_3^-$ | 100 мг/л-ээс ихгүй | 61.0 мг/л |
| Нитрат, $NO_3$ | 3.5 мг/л-ээс ихгүй | 0.0 мг/л |
| Нитрит, $NO_2$ | 1.0 мг/л-ээс ихгүй | 0.0 мг/л |
| Аммони, $NH_4^-$ | Илрэхгүй | 0.0 мг/л |

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL

3. Савласан цэвэр усны бичил биетний эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 5007:2007 (MNS 5007:2022) стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage савласан цэвэр усны үзүүлэлт |
|---|---|---|
| 1 мл усан дахь нийт нянгийн тоо | 100-с илрэхгүй, 20-с ихгүй | Илрээгүй |
| 100 мл усан дахь E.coli-ийн тоо | Илрэхгүй | Илрээгүй |
| 100 мл усан дахь ГБЭТ нянгийн тоо | Илрэхгүй | Илрээгүй |

4. Савласан цэвэр усны хүнд металлын бохирдлын үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | MNS 5007:2007 (MNS 5007:2022) стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Voyage савласан цэвэр усны үзүүлэлт |
|---|---|---|
| Хар тугалга, Pb | 0.01 мг/л-ээс ихгүй | 0.002 мг/л-ээс ихгүй |
| Хүнцэл, As | 0.01 мг/л-ээс ихгүй | <0.003 мг/л |
| Зөөлөн цагаан, Cd | 0.003 мг/л-ээс ихгүй | <0.002 мг/л |
| Зэс, Cu | 2 мг/л-ээс ихгүй | <0.004 мг/л |

**Дүгнэлт:** Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат-сульфатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн, сул шүлтлэг орчинтой ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Савласан ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 5007:2007" стандартын эрдэслэг ус" ангиллын шаардлага хангаж байна.

*Эх сурвалж: Шинжлэх ухааны академи Газарзүй-Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораторийн "Эм Жи Эл Акуа" ХХК-ийн савласан усны химийн шинжилгээний тодорхойлолт, 2023 оны 3-р сарын 28; Стандарт, хэмжил зүйн газрын хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн шинжилгээний дүн, Хүдгийн ус/Бумбат дээж, 2023 оны 7-р сарын 5*



**Жич:** Дээрх зөвшөөрөгдсөн хэмжээ нь MNS 0900:2018, MNS 5007:2007 (MNS 5007:2022) стандартын батлагдсан хувилбар буюу Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед мөрдөгдсөн хэмжээ болно.

Үнэт цаас гаргагч нь гүний усны болон савласан усны стандартын хяналт шалгалтыг өөрсдийн дотоод хяналтын лабораторид хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг ашиглан шинжилдэг.

**Зураг 6. Үнэт цаас гаргагчийн дотоод хяналтын лаборатори**

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

СЗХ 2024 04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

**Схем 8. Үнэт цаас гаргагчийн дотоод хяналтын бүтэц**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт*

## Усыг цэвэршүүлэх үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь олборлосон гүний эрдэст усаа цэвэршүүлэн боловсруулахдаа олон улсад өргөн хэрэглэгддэг Урвуу осмос аргаар зургаан давхар хагас нэвчүүлэх мембран технологийг ашигладаг. Тус аргын дагуу Үнэт цаас гаргагч нь усан дахь давс, хүнд металл, илүүдэл эрдэс бодис, нян бактери, вирус болон бусад механик нэгдлүүдийг шүүж өндөр түвшинд усыг цэвэршүүлэн боловсруулдаг.

### Урвуу осмосын арга

Осмос гэдэг нь байгалийн нэвчих үйл явц буюу усны молекулууд концентрат ихтэй орчноос концентрат багатай орчин руу мембранаар дамжин уусах үзэгдэл юм.

Урвуу осмос гэдэг нь байгалийн нэвчих үйл явцаас эсрэг процесс бөгөөд хагас нэвчүүлэх мембраныг ашиглан усанд агуулагдах хүн металлууд, бактери, вирус, эрдэс бодисуудыг шүүн усыг цэнгэгжүүлдэг процесс юм. Хагас нэвчүүлэх мембран нь маш нарийн сүвэрхэг бүтэцтэй байдаг тул усыг гадны биетээс 99 хувь хүртэл шүүдэг байна.

**Зураг 7. Урвуу осмосын үйл явц**




*Эх сурвалж: GoForum нийтлэл*

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23

**Зураг 8. Үнэт цаас гаргагчийн мембран шүүлтүүр**



*Эх сурвалж:* Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Хагас нэвчүүлэх мембран технологийг ашиглан усыг цэвэршүүлэх үйл явц нь усанд агуулагдаж буй бичил хэсгүүдийн хэмжээнээс хамааран 4 төрлийн аргаар хийгддэг ба эдгээр аргаас Үнэт цаас гаргагч нь хамгийн түгээмэл ашиглагддаг урвуу осмосын аргыг ашигладаг байна. Үүнд:

**Хүснэгт 8. Усыг шүүж цэвэршүүлэх аргуудын харьцуулалт**

| | Микро шүүлтүүр (Microfiltration) | Ультра шүүлтүүр (Ultrafiltration) | Нано шүүлтүүр (Nanofiltration) | Урвуу осмос (Reverse osmosis) |
|---|---|---|---|---|
| Цэвэршүүлэх потенциал | • Зэв, бактери, элс шороо, хүнд металл, булингар, бохирдол | • Бактери, вирус, бичил биет, хүнд металл, үүраг, булингар, бохирдол<br>• Цэвэршүүлсэн ус, хаягдал усны харьцаа 90:10 | • Бактери, вирус, бичил биет, хүнд металл, үүраг, булингар, бохирдол, олон валенттай ионууд, хүчиллэг бодисууд<br>• Цэвэршүүлсэн ус, хаягдал усны харьцаа 80:20 | • Бактери, вирус, бичил биет, хүнд металл, үүраг, булингар, бохирдол, бүхий л ион, химийн бодисууд<br>• Цэвэршүүлсэн ус, хаягдал усны харьцаа 80:20 хүртэл |
| Онцлог | • Их хэмжээний уснаас бичил биет, бохирдлыг шүүснээр ус цэвэршүүлэх процессын эхний үе шат болдог | • Ихэвчлэн гадаргын ус, булгийн ус, худгийн усыг боловсруулахад ашигладаг<br>• Давсархаг, далайн усыг нано шүүлт ба урвуу осмосоор давсгүйжүүлэх өмнөх шатны боловсруулалтад хэрэглэдэг<br>• Урвуу осмосын шүүлтүүртэй харьцуулахад бага даралтад ажилладаг<br>• Бассейны усны боловсруулалтад ашиглаж болдог | • Давсыг 80-90 хувь хүртэл шүүдэг<br>• Ионыг 90 хувь хүртэл шүүдэг<br>• Нэг валенттай ионоос олон валенттай ионуудыг илүү шүүдэг<br>• Бага даралтын насос ашиглаж болдог<br>• Урвуу осмосын шүүлтүүрийн өмнөх боловсруулалтад ашигладаг<br>• Урвуу осмосын шүүлтүүртэй харьцуулахад бага даралтад ажилладаг | • Олон улсад хамгийн өргөн хэрэглэгддэг ус цэвэршүүлэх арга<br>• Усыг гадны биетээс 99 хувь хүртэл шүүдэг<br>• Өндөр зэрэглэлийн бага даралтын мембраныг ашигладаг<br>• Усанд агуулагдах эрдэс бодис нь хүний биед зохих хэмжээнд хүрдэг |
| Давуу тал | • Осмос болон нано шүүлтүүрийн мембраныг том хэмжээний бохирдлоос үүдэн бөглөрөх, гэмтэхээс сэргийлдэг<br>• Хлор ба бусад химийн бодисуудыг шүүдэг<br>• Үрсгал зардал хамгийн бага<br>• Хаягдал хамгийн бага | • Хотын эсвэл хувийн ундны усны давсгүйжүүлэлд, химийн ба эмийн үйлдвэрүүд, хүнс болон ундааны үйлдвэрүүд, металл боловсруулах үйлдвэрт ашиглахад тохиромжтой<br>• Урвуу осмос шүүлтүүрийн процессын өмнөх үе шат болдог тул урвуу осмосын мембраны эдэлгээ, гарцын чанартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг | • Хотын эсвэл хувийн ундны усны давсгүйжүүлэлд, химийн ба эмийн үйлдвэрүүд, хүнс болон ундааны үйлдвэрүүд, металл боловсруулах үйлдвэрт, электролизийн бүрэлт, бойлерын усны боловсруулалтад ашиглахад тохиромжтой<br>• Ус зөөлрүүлэх төхөөрөмжийг орлох байдлаар ашиглах боломжтой | • Бага энерги зарцуулдаг урвуу осмосын мембраныг ашигладаг тул эрчим хүчний зарцуулалт бага<br>• Автоматжуулсан цэвэрлэх системтэй учир мембраны эдэлгээ удаан<br>• Бүхий л эдийн засгийн салбарт ашиглах боломжтой |



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore Capital

СЗХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Хүснэгт 8. Усыг шүүж цэвэршүүлэх аргуудын харьцуулалт

| | Микро шүүлтүүр (Microfiltration) | Ультра шүүлтүүр (Ultrafiltration) | Нано шүүлтүүр (Nanofiltration) | Урвуу осмос (Reverse osmosis) |
|---|---|---|---|---|
| Давуу тал | | | • Ашиглалтын үеийн даралт урвуу осмосын төхөөрөмжөөс бага шаарддаг ба усанд агуулагдах давсны хэмжээ бага байх нөхцөлд урвуу осмосын төхөөрөмжийг орлуулах өртөг багатай шийдэл болох боломжтой<br>• Ашиглалтын зардал бага<br>• Эрчим хүч зарцуулалт бага | • Химийн бодис ашигладаггүй олон дамжлагат ус цэвэршүүлэх систем<br>• Хаягдал усны 95 хувь хүртэл дахин боловсруулагдах боломжтой |
| Сул тал | • Сувэрхгийн хэмжээ хамгийн жижиг<br>• Вирус, ион, бичил биетүүдийг төдийлөн шүүж чаддаггүй | • Мембраны гадаргад шүүгдэн үлдсэн химийн бодисын үлдэгдлийг тогтмол цэвэрлэх шаардлагатай<br>• Ион болон давсыг төдийлөн шүүж чаддаггүй<br>• Засвар, ашиглалтын зардал өндөр | • Нэг валенттай ионуудыг төдийлөн шүүж чаддаггүй<br>• Олон валенттай ионуудыг шүүдэг ч тэр дундаас кальци, магни зэрэг хатуу ионуудыг төдийлөн шүүж чаддаггүй | • Усанд агуулагдах хлор, ион, хүчиллэг бодис их байх тусам урвуу осмосын мембран хурдан элэгддэг<br>• 35 хэмийн дулаанаас дээш нөхцөлд мембраны үйл ажиллагаа муудаг |

*Эх сурвалж: Bosaq усны технологийн компанийн "Ундны усыг цэвэршүүлэх технологийн хөгжлийн орчин үеийн хандлага" нийтлэл, 2022 оны 10-р сарын 13*



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагчийн гүний усыг цэвэршүүлэхэд ашигладаг урвуу осмосын арга нь ус цэвэршүүлэн шүүх технологиос хамгийн өргөн ашиглагддаг арга бөгөөд олон улсад уг аргыг ус цэвэршүүлэх дэвшилтэт арга гэж үздэг байна.

**Зураг 9. Ус цэвэршүүлэн шүүх аргууд, харьцуулалт**




*Эх сурвалж: Bosaq усны технологийн компанийн нийтлэл*

Үнэт цаас гаргагч нь урвуу осмосын аргаар зургаан давхар шүүлтүүрийг ашиглаж гүний усанд агуулагдаж буй эрдэс бодисыг тэнцвэржүүлэн, усны үндсэн бүтцийг алдагдуулахгүйгээр хүний биед шаардагддаг шингэнийг нөхдөг цэвэр усыг үйлдвэрлэж байна.

СЗХ 2024 04 29 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ 03

**Схем 9. Зургаан давхар шүүлтүүрийн үе шат**

**I — Механик / Элсэн шүүлтүүр**

Байгалийн гаралтай чулуулгийг нунтаглаж боловсруулсан сорбент юм. Өөрөөр хэлбэл 2 валенттай төмрийг исэлдүүлж 3 валенттай төмрийн гидроксидын нэгдэл /зэв/ болгох замаар тундасжуулан шүүж, усыг цэвэрлэх ион солилцооны процесст үндэслэгдсэн шүүлтүүр юм. Шүүлтүүрийн эхний үе шатаар булингар үүсгэгч бичил биетүүд, төмрийн нэгдэл, механик хольцуудыг шүүдэг. Механик шүүлтүүрийн ус нэвчих нүхний диаметр 10-20*10-10м хэмжээтэй байдаг. Тус шүүлтүүрийг давсны хүчлийн уусмалаар цэвэрлэдэг ба хэрэглэх боломжгүй болвол жилд 1-2 удаа солих шаардагатай болдог.

**II — Нүүрсэн идэвхжүүлсэн шүүлтүүр**

Энэхүү шүүлтүүрийн нүүрсэн мембраныг тусгай модноос гаргаж авдаг. Энэ нь усторөгчийн катионит бөгөөд ион солилцоо, адсорбцлох процесс дээр үндэслэгдсэн сорбент материал юм. Механик шүүлтүүрийн шүүгээгүй органик бодис, хлор, кальци, магни, давсыг шүүдэг. Энэхүү шүүлтүүрийн нүхний диаметр нь 20-50*10-10м байна. Уг шүүлтүүрийг 7 хоногт 1 удаа даралттай усаар сөргүүлэн цэвэрлэдэг ба 12 сард 1 удаа шинээр солих шаардлагатай байдаг.

**III — Нүүрсэн идэвхжүүлсэн шүүлтүүр**

1-р нүүрсэн шүүлтүүрийн шүүгээгүй үлдсэн органик бодис, хлор, кальци, магни, давсыг дахин шүүдэг.

**IV — Цаасан шүүлтүүр**

Шүүсэн ус нь өндөр даралтаар шүүлтүүрийн мембранаар дамжин дараагийн шүүлтүүр рүү урсдаг бол шүүгдсэн эрдэс бодисууд шүүлтүүрийн мембранд үлддэг. Энэхүү шүүлтүүрээр усанд агуулагдаж буй тунадас, илүүдэл эрдэс бодис, нян бактер зэрэг бичил биетийг бүрэн шүүдэг. Уг шүүлтүүрийг 2 сард 1 удаа тогтмол солих шаардлагатай байдаг.

**V — I мембран / Урвуу осмосын шүүлтүүр**

Энэхүү шүүлтүүр нь ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн гол шүүлтүүр юм. Шүүлтүүрийн ялтасны диаметр нь 1-10*10-10м байдаг ба усан дахь илүүдэл эрдсийн хэмжээ, гадны биетийг 98 хувь хүртэл шүүдэг. Улмаар цэвэршүүлсэн усны 70 хувийг савлаж, 30 хувийг хаягдал усаар гардаг байна. Уг шүүлтүүрийг цэвэрлэхэд бохирдлын хэмжээг харгалзан үздэг ба инженерийн зааврааар цэвэрлэгээг гүйцэтгэдэг.

**VI — II мембран / Урвуу осмосын шүүлтүүр**

Урвуу осмосын шүүлтүүрийн I мембраны шүүгээгүй үлдсэн илүүдэл эрдэс, гадны биетийг дахин шүүдэг.

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "Технологийн заавар"*

Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore Capital УЛААНБААТАР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
СЭХ
БҮРТГЭВ
№ 01

Зураг 10. Усыг цэвэршүүлэн халдваргүйжүүлэх процессын хяналтын самбар




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Зураг 11. 6 давхар RO шүүлтүүр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



MGL AQUA Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 .04. 29
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

### Халдваргүйжүүлэх үе шат

Усыг шүүх, цэвэршүүлэх процесс дууссаны дараа усанд агуулагдах нян, бичил биетний өсөлтийг зогсоох, усны хадгалах хугацааг уртасгах зорилгоор халдваргүйжүүлэх шаардлагатай байдаг. Ундны усыг халдваргүйжүүлэх олон арга байдгаас Үнэт цаас гаргагч нь түгээмэл ашиглагддаг озонжуулах аргаар цэвэршүүлсэн усыг халдваргүйжүүлдэг ба тус арга нь усан дотор нян бактери өсөж үржих боломжийг 100 хувь устгадаг байна.

**Хүснэгт 9. Ундны усыг халдваргүйжүүлэх аргуудын харьцуулалт**

| | Бичил биетний төрөл | | |
|---|---|---|---|
| **Халдваргүйжүүлэх арга** | **Шимэгч** | **Бактери** | **Нян** |
| Озонжуулах | Бүрэн устгана | Бүрэн устгана | Бүрэн устгана |
| Хлоржуулах | Устгахгүй | Устгахгүй | Бүрэн устгахгүй |
| Хэт ягаан туяаны гэрлээр шарах | Бүрэн устгахгүй | Бүрэн устгана | Бүрэн устгана |
| Нүүрсний шингээгч бодисоор шүүх | Бүрэн барьж авна | Бүрэн барьж авна | Бүрэн барьж авна |

***Эх сурвалж:*** *Барилга, хот байгуулалтын яам ба Барилгын хөгжлийн төв "Ус хангамж ариутгах, татуурга", 2017 он*

Озонжуулагч тоног төхөөрөмж нь зэвэрдэггүй никель материалаар хийгдсэн бөгөөд энэхүү төхөөрөмжийн дотор талд байрлах шил нь усны өндөр даралт, галд тэсвэртэй, энгийн шилнээс гурав дахин бат бөх байдаг. Мөн савласан цэвэр усны үлдэгдэл озоны хэмжээг Олон Улсын Савласан Усны Холбоо /International Bottled Water Association (IBWA)/-ноос тогтоосон хэмжээ болох 0.1 – 0.4 ppm хооронд барьж үйлдвэрлэдэг байна. Озоны хэмжээг зохих түвшинд байлгах нь усанд агуулагдах бичиг биетнийг бүрэн устгах, саванд амт оруулахгүй байхад чухал ач холбогдолтой юм. Озоны үлдэгдлийн хэмжээ зөвшөөрөгдсөн түвшнээс өндөр байвал саванд амт орох, бага байвал бактери, нян, амьд организмыг бүрэн устгахгүй байх эрсдэлтэй байдаг.

АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагаас хлоржуулсан ундны усны хэрэглээнд зохистой хэмжээг тодорхойлсон байдаг ба ундны усанд агуулагдах хлор нь эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм. Гэсэн хэдий ч хлор нь усанд агуулагдах бичил биет, байгалийн эрдэс бодистой нэгдэж халдваргүйжүүлэлтийн дайвар нэгдэл бий болгодог бөгөөд энэхүү нэгдэлтэй ундны усыг удаан хугацаанд хэрэглэснээр эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Иймд, ундны усыг озонжуулах нь хлороор халдваргүйжүүлснээс илүү үр дүнтэй буюу байгалийн нэгдлүүдийг өндөр түвшинд идэвхгүй болгож, устгадаг онцлогтой арга билээ.

Эцэст нь Үнэт цаас гаргагч нь цэвэршүүлсэн, халдваргүйжүүлсэн усыг таван тонн багтаамжтай хоёр саванд нөөцөлж, савлах дамжлага руу шилжүүлдэг байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### Түүхий эд материалын татан авалт

Үнэт цаас гаргагч нь түүхий эдийн төлөвлөгөөний дагуу 6 сарын хэрэгцээг нөөцөлдөг ба 1 жилийн хэрэглээг урьдчилж захиалга өгч баталгаажуулдаг. Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлд ашиглах хуруу сав, бөглөө, сав баглаа боодол, шошгыг дотоодын бэлтгэн нийлүүлэгчид нийлүүлдэг ба эдгээр бэлтгэн нийлүүлэгчдийн ихэнх нь Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд юм.

Жижиг савлагаанд ашигладаг 17.5 грамм, 28 грамм, 35.1 грамм хуруу савнуудыг "Эйч Эм Эн Эйч" ГХОХХК-аас, том савлагаанд ашигладаг 85 грамм хуруу савыг "Санвин" ХХК-аас худалдан авдаг. Эдгээр компаниуд нь хүнсний зориулалттай хуруу сав үйлдвэрлэдэг бөгөөд хуруу саванд шаардлагатай түүхий эд болох хүнсний зориулалттай мөхлөгийг Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох "ТЖТБ" ХХК-аас худалдан авдаг.

**Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид**

| | Түүхий эдийн нэр төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бэлтгэн нийлүүлэгч | Мөхлөг | Хуруу сав | Бөглөө, бариул | Багцлагч уут | Шошго |
| "Эйч Эм Эн Эйч" ГХОХХК | | + | | | |
| "Санвин" ХХК | | + | | + | |
| "Эм Пластик" ХХК | | | + | + | |
| "ТЖТБ" ХХК | + | | | | |
| "Ти Эм Эл" ГХОХХК | | | | | + |

***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн бэлтгэн нийлүүлэлтийн гэрээнүүд*

Дээр дурдагдсан бэлтгэн нийлүүлэгчдээс "Эм Пластик" ХХК, "ТЖТБ" ХХК болон "Ти Эм Эл" ГХОХХК нь Үнэт цаас гаргагчийн хамаарал бүхий компаниуд бөгөөд үйл ажиллагааны хувьд тус тусын бизнесийн чиг үүргийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбогддог. Эдгээр хамаарал бүхий компаниудаас түүхий эдээ худалдан авахын давуу тал нь түүхий эд нийлүүлэгч компаниуд нь Үнэт цаас гаргагчийн түүхий эд болон бусад харилцагчдын түүхий эдийн захиалгыг нэгтгэн гүйцэтгэснээр олон тоо хэмжээг хямд үнээр татан авах, түүнтэй холбоотой тогтмол зардлыг бага байлгах боломж бүрддэг. Мөн хамаарал бүхий компаниас татан авсан түүхий эдийн чанар стандартад итгэлтэй байх, түүхий эдийн тасалдалгүй тогтвортой байдалд хяналт тавих, бэлтгэн нийлүүлэгчийн найдвартай байдалд эргэлзээхгүй байх гэх давуу талуудыг бий болгодог байна.

Үнэт цаас гаргагч нь түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авахад дараах зураглалын дагуу хүлээн авдаг.

**Схем 10. Түүхий эд материал хүлээн авах үйл ажиллагааны процесс**




***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн Үйлдвэрлэлийн процессын журам*



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

Бэлтгэн нийлүүлэгчээс түүхий эд материалыг хүлээн авахдаа түүхий эдийн баталгааны хуудас, зарлагын баримт, чанарын гэрчилгээг тулган шалгадаг. Ирсэн түүхий эд материалаас дээжийг авч чанарын лабораторид хэмжилт, шалгалт хийн чанарын шаардлагад нийцэж буйг тодорхойлдог. Чанарын шаардлагад нийцсэн түүхий эдийг нэр төрөл, үйлдвэрлэсэн огноогоор ялган түүхий эд материал хадгалах тусгай зориулалтын агуулахад хүлээн авч хадгалдаг.

**Зураг 12. Лабораторид түүхий эдийн хэмжилт хийж буй нь**



*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

**Зураг 13. Түүхий эдийн дээжийн сорилтын дүнгийн хуудас**

*Хуруу сав, бөглөө, бариул, багцлагч уут*






Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 .04 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

Шошго


产 品 质 量 检 验 单

检验结论：

经检验，本批产品各项指标均符合技术标准，判合格。

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь бүх төрлийн сав баглаа боодлыг зэргэлдээ компаниудаас батлагдсан загварын дагуу худалдан авдаг. Сав баглаа боодлын захиалгыг өгөхөд өмнөх сарын үлдэгдэл зарцуулалтын мэдээг үндэслэх ба 180 хоногийн зайлшгүй нөөцтэй байхаар тооцоолон гаргадаг.

Аливаа түүхий эдийн худалдан авалтыг худалдан авалтын холбогдох дүрэм, зааврын дагуу гүйцэтгэдэг ба үнэ, чанар, хүнсний аюулгүй байдал, байгальд ээлтэй байдал, нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, ачилтын хугацаа зэргийг харьцуулан дүгнэсний үндсэнд худалдан авалтыг зохион байгуулдаг. Нийлүүлэгчийн барааг хүнсний аюулгүй байдлыг хангасан гэрчилгээтэй хамт хүлээн авдаг.

## Сав үлээх, савлах үйл ажиллагаа

Сав үлээх үйл ажиллагаанд сав үлээх үе шатаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн болж агуулахад хадгалагдах бүх үе шат хамаарах бөгөөд дараах процесс зүраглалын дагуу явагддаг. Үүнд:

**Схем 11. Сав үлээх, савлах үйл ажиллагаа**




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн Үйлдвэрлэлийн процессын журам



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаас гаргагч нь хуруу савыг үлээж савлагаа болгохоос өмнө сав үлээх төхөөрөмж рүү оруулж 80-96 хэмийн халуун уур болон озонжуулсан усаар тус бүр 10 секундийн хугацаанд ариутгадаг. Ариутгасны дараагаар хуруу савыг гуурсаар 0.7 MPa хүчтэй өндөр даралтаар үлээж сав болгодог. Шаардлагатай тохиолдолд үлээсэн савыг нөөцөлдөг ба нөөцлөхдөө битүүмжилж, 48 цагаас илүү хугацаагаар хадгалдаггүй байна.

**Зураг 14. Хуруу савыг үлээж сав болгох үйл ажиллагаа**




*Хуруу савыг үлээх төхөөрөмж рүү оруулах*



*80-96 хэмийн халуун уураар уян хатан болгох*



*Савыг үлээх*



*Савыг ариутгаж халдваргүйжүүлэх төхөөрөмж рүү оруулах*



*Савыг ариутгаж халдваргүйжүүлэх*

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

СЗХ 2024.02.23 он сар өдөр БҮРТГЭВ № 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Савлах үйл ажиллагаа эхлэхээс өмнө ус дамжуулах шугам хоолойг цэвэрлэх зорилгоор тодорхой хугацаанд савласан усыг дамжуулах шугамаар урсгадаг. Үүний дараа уснаас дээж авч чанарын хяналтын лабораторид шинжилдэг. Ус нь чанарын шаардлага хангаж байгаа тохиолдолд цэвэршүүлсэн усыг савлах үйл ажиллагаа эхэлдэг.

Усыг савласны дараа бөглөж, MNS 6648:2016 стандартын дагуу шошголож, огноог дарснаар дараагийн дамжлага буюу багцлах үе шатанд шилждэг. 6 төрлийн савлагаа бүхий бэлэн бүтээгдэхүүнийг багцлагч шугам руу оруулан дараах байдлаар багцалж бэлтгэдэг. Үүнд:

- 220 мл, 330 мл, 500 мл ус нэг багцад тус бүр 20 ширхэг;
- 800 мл ус нэг багцад 12 ширхэг;
- 1.5 литр ус нэг багцад 8 ширхэг;
- 4.5 литр ус нэг багцад 4 ширхэг байдаг.

Багцалсан бэлэн бүтээгдэхүүнийг зориулалтын поддон дээр савлагаа бүрд зохимжит тоогоор өрж ороодог. Поддон дээр өрж тавьсан уснуудыг агуулах руу зөөж, хадгалалтын стандартыг баримтлахын тулд ороогч цаасаар ороож бэлэн болгодог. Бэлэн бүтээгдэхүүний агуулахад хадгалсан савласан цэвэр усыг борлуулалт, түгээлтэд гаргахын өмнө усны химийн болон нянгийн шинжилгээний хариуг нягталж, шаардлага хангасныг баталгаажуулан түгээлтэд гаргадаг.

**Зураг 15. Багцалж савласан цэвэр усыг агуулах руу зөөх үйл явц**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаас гаргагч нь дээрх бүх шат дамжлагуудад Үйлдвэрийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрэм, Ариутгал цэвэрлэгээний дүрмийг баримталдаг ба дотоод хяналтын лабораторид цаг тухай бүрд хяналт тавьж ажиллаж байна.



MGL AQUA Co., Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

Зураг 16. Савласан цэвэр усны шинжилгээнд орсны дараах байдал




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

### 5.2.3. Борлуулалт, түгээлтийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь 5,000 гаруй харилцагчдаа үндсэн 5 төрөлд ангилдаг. Үүнд, хүнсний дэлгүүр, сүлжээ дэлгүүр, зах бөөний төв, хорека болон орон нутаг гэж ангилдаг. Ийнхүү ангилсныг хувь хэмжээгээр тооцож үзвэл нийт харилцагчдын 77.0 хувь нь Улаанбаатар хотын жижиглэн хүнсний худалдаа эрхлэгчид байна.

**График 1. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын сувгийн задаргаа, тоогоор, хувь**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

СЗХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Харин борлуулалтын гүйцэтгэлийн хувьд ангилан харвал Улаанбаатар хотын жижиглэн хүнсний худалдаа эрхлэгчид нийт борлуулалтын 33.0 хувийг, аймгийн төвийн жижиглэн хүнсний худалдаа эрхлэгчид 32.0 хувийг тус тус бүрдүүлдэг байна.

**График 2. Үнэт цаас гаргагчийн харилцагчдын борлуулалтын гүйцэтгэлийн хувиар**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 02-р сард захиалгын системээ шинэчлэн сайжруулж, дижитал платформ дээр суурилсан захиалгын аппликэйшныг нийт бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч харилцагчдадаа танилцуулан, савласан цэвэр усны захиалгыг 100 хувь онлайн системээр бүртгэдэг болсон.

Дижитал захиалгын систем нь "Смарт Логик" ХХК-ийн "Smart Sale" программ бөгөөд харилцагчийн гар утас дээр аппликэйшн хэлбэрээр байршсан. Энэхүү программын онцлог нь харилцагчийг бүрэн кодолсон бөгөөд харилцагчийг сувгаар ангилах, захиалгын түүхийг он цагийн дараалаар харуулах, харилцагчийн төлбөр тооцоо, авлагын үлдэгдлийг харуулах, агуулахын үлдэгдлийг харуулах гэх мэт системийн хувьд давуу талтайгаас гадна харилцагчид ашиглахад хялбар, найдвартай систем болж өгдөг. Харилцагч доорх схемийн дагуу худалдааны төлөөлөгчөөр дамжуулан бэлэн бүтээгдэхүүний захиалга урьдчилан өгдөг байна.

**Схем 12. Харилцагчийн бэлэн бүтээгдэхүүний захиалга өгөх процесс**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн Борлуулалт, захиалгын программ*

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ
MGL AQUA Co.,Ltd

СЭХ 2024.04.29 он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн хувьд "Smart Sales" системээс орж ирсэн харилцагчийн захиалга болон тооцооны мэдээллийг дотооддоо ашигладаг "Smart Distribution" нэршилтэй борлуулалтыг түгээлтийн систем рүү хөрвүүлэн бүртгэж харилцагчтай тооцоо нийлэх, борлуулалтын гүйцэтгэлийг хянах, бэлэн бүтээгдэхүүний нөөцийг хянах байдлаар ашигладаг.

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын алба нь захиалгын систем дээр бүртгэгдсэн захиалгыг нэгтгэн санхүүгийн алба, агуулахын хэсэгт өгөх ба бэлэн бүтээгдэхүүний нярав нэгтгэлийн дагуу захиалгат барааг дараа өдөрт нь холбогдогдох бичиг баримтын хамт түгээлтийн албанд хүлээлгэн өгч, түгээлтийн алба маршрутын дагуу харилцагчдад бараа бүтээгдэхүүнийг түгээдэг.

## Түгээлтийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн Түгээлтийн алба нь 60 ажилтны бүтэцтэйгээр, нийт 26 том оврын, жижиг оврын 2 төрлийн машинаар Улаанбаатар хот даяар өдөрт 500-600 хүнсний худалдаа эрхлэгч харилцагчдад 100-120 тонн савласан цэвэр усыг ажлын таван өдөрт цаг алдалгүй, захиалгын дагуу түгээж байна.

### Машин Техник

Долоо хоног тутам Үнэт цаас гаргагчийн механикийн инженерүүд болон засварчид бүх түгээлтийн машины техникийн үзлэг оношилгоог хийж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэдэг. Мөн Үнэт цаас гаргагч нь "Гайхам GPS" нийлүүлэгчтэй хамтран ажилладаг бөгөөд тус байгууллагын төхөөрөмжийн тусламжтайгаар түгээлтийн машины цаг зарцуулалтын үр ашгийг хэмжихээс гадна шатахуун зарцуулалт, шатахууны алдагдал, сул зогсолтыг, хурдны хязгаарыг давхар хянадаг.

### Бэлэн бүтээгдэхүүний буцаалт

Түгээлтийн явцад үүссэн бэлэн бүтээгдэхүүний гэмтэл болон харилцагчийн хүсэлтээс үүссэн бэлэн бүтээгдэхүүний буцаалтыг тээвэрлэх ажлыг түгээлтийн алба гүйцэтгэдэг. Түгээлтийн ажилтнаар хүргэгдэн ирсэн буцаагдсан бэлэн бүтээгдэхүүнийг Үнэт цаас гаргагчийн Чанарын алба хүлээн авч бүртгэл хийн, буцаалтын шалтгааныг оношилдог. Өөрөөр хэлбэл, буцаалтаар ирсэн бэлэн бүтээгдэхүүнд үүссэн гэмтэл доголдол нь тээвэрлэлтийн стандарт алдагдсан эсэх, хадгалалтын стандарт алдагдсан эсэх, өрөлтийн стандарт алдагдсан эсэх, үйлдвэрлэлтийн стандарт алдагдсан эсэхийг тодорхойлон оношилж, холбогдох алба нэгжид мэдэгдэж, сайжруулах арга хэмжээг эхлүүлдэг.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd Улаанбаатар хот
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL Улаанбаатар хот

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ УДИРДЛАГА

6

СЗХ
2024 04 29
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

# 6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зохистой удирдлага

## 6.1. Хүний нөөц

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Ти Эм Эл Трейд" ХХК нь хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдийг сайжруулан баталж, хэрэгжүүлж байгаа бөгөөд уг баримт бичгүүд нь бүх хамаарал бүхий компаниудад ижил үйлчилдэг.

**Зураг 17. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг**



*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар нийт 192 ажилтантай үйл ажиллагаагаа эрхэлж байна. Нийт ажилтнуудын 58 хувь нь эрэгтэй, 42 хувь эмэгтэй ба насны ангиллаар 65.4 хувийг 18-35 насны залуу боловсон хүчин бүрдүүлж байна.

**Зураг 18. Үнэт цаас гаргагчийн баг бүрэлдэхүүн**



*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

MGL AQUA Co.,Ltd
2628333
ГСТ1398
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23 БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагч нь нийгмийн хариуцлагын хүрээнд боломжит ажлын байран дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажиллах боломжийг олгодог ба Монгол Улсын Хөдөлмөрийн Яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж, сургаж, нийгэм болоод эдийн засагт хувь нэмэр оруулж буй компаниар удаа дараалан тодорч байсан.

**Зураг 19. Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн тоо, 2018-2023 оны 6-р сарын 30**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

### 6.1.1. Хүний нөөцийн бодлого

Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бодлогын гол зорилго нь тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож, байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хүний нөөцийн удирдлагыг цогцоор нь хэрэгжүүлэхэд оршино. Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагааг тогтвортой байлгахын тулд компанид шаардлагатай ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлж, ажилчдын ур чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах, ажилтанд ээлтэй ажиллах орчныг бүрдүүлж ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө хүний нөөцийн тогтвортой бодлого, ажлын таатай орчин, ажилтнуудын нийгмийн асуудал, сургалт хөгжил, ажилтны эрүүл бие, эрүүл сэтгэл зүйг дэмжих хөтөлбөрүүдийг тусгаж өгсөн байна.

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн бодлогын хүрээнд "Хөдөлмөрийн дотоод журам", "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журам", "Цаг бүртгэлийн журам", "Түгээлтийн албаны борлуулагч, жолооч нарын машин техник ашиглах хариуцлага тооцох журам" зэрэг дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнууддаа дараах үнэ цэнийг бий болгодог. Үүнд:

- Эдийн засгийн үнэ цэн;
- Байгууллагын соёлын үнэ цэн;
- Хөгжиж дэвших үнэ цэн;
- Орчны үнэ цэн;
- Шагнал урамшуулал байна.

#### Шагнал урамшуулал

Үнэт цаас гаргагч нь ажилтнуудын гүйцэтгэлийн үр дүн, компанийн үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэхийн тулд ажил үйлсээрээ манлайлсан, урт хугацаанд тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх бодлогыг баримталдаг. Энэхүү бодлогын хүрээнд ажилтнуудын тэтгэмж, хөнгөлөлт тусламж, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдгээс гадна урлаг, спортын гэх мэт олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Түүнчлэн, дотооддоо ажлын байр бүрээр амжилт бүтээл, ажлын гүйцэтгэлийг үнэлж, өндөр гүйцэтгэлтэй ажилласан манлайлагч ажилтнуудыг шалгаруулан жил бүр гадаад улс руу аялах эрхийн бичгээр шагнаж, тэргүүний ажилтнуудыг мөнгөн шагнал, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр урамшуулдаг.

СЗХ 2024 .04 .29 он сар едөр Nº 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ

Зураг 20. Шагнал урамшуулал





*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Шагнал урамшууллалтай холбоотой төсвийн санхүүжилтийг санхүүгийн төлөвлөгөөндөө жил бүр тусгаж, хэрэгжүүлдэг.

Салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулсан тэргүүний ажилтнуудаа Төрийн шагналд тодорхойлон шагнуулдаг ба Үнэт цаасны танилцуулга бичих үеийн байдлаар "Алтан гадас" одонгоор шагнагдсан 1 ажилтан, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар шагнагдсан 1 ажилтан, "Silk Road" одонгоор 1 ажилтан, "Салбарын тэргүүний ажилтан"-аар 2 ажилтан, "МЗХ-ны 100 жилийн ойн медаль"-аар 3 ажилтан, "Хүндэт жуух бичиг"-ээр 8 ажилтан, "Тэргүүний залуу" алтан медалиар 9 ажилтан шагнагдсан байна.

## Сургалт хөгжил, карьер төлөвлөлт

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудыг дадлагажуулах, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, шаардлагатай ур чадварыг эзэмшүүлж, ажилдаа хандах хандлагыг эерэгжүүлэх замаар байгууллагын зорилгыг хэрэгжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Тус журмын хүрээнд ажилтанд чиглэсэн 3 төрлийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж, тогтмол хугацаанд хэрэгжүүлдэг. Үнэт цаас гаргагчийн урт хугацааны сургалт хөгжлийн төлөвлөлтийн дагуу удирдлагын шатны залгамж халааг бэлдэх зорилгоор жил бүр хүний нөөц, манлайллын хөтөлбөрт менежер, захирлуудыг хамруулдаг.

Үнэт цаас гаргагч нь ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтыг "Хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, чиглүүлэх журам"-ын дагуу зохион байгуулдаг юм.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв зохистой, идэвхтэй өнгөрүүлэх зорилгоор спортоор хичээллэх боломж бүхий спорт заал болон чийрэгжүүлэх төвүүдтэй хамтран ажиллахын зэрэгцээ нийт ажилчдад хөнгөлөлт, хангамжийг тэгш хүртээмжтэй байдлаар олгодог.

Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescore CAPITAL [illegible] УЛААНБААТАР ХОТ

## Ажилтнуудын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь нийт ажилтнуудын эрүүл мэндэд анхаарч шинжилгээ, эмчилгээ, сувилгаа хийлгэх боломжоор хангах зорилгоор 2016 оноос эхлэн эрүүл мэндийн сайн дурын даатгалд 100 хувь хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулдаг болсон ба ажлын байрны онцлогоос хамааран гэнэтийн ослын даатгал, хариуцлагын даатгалд мөн хамруулдаг.

Үнэт цаас гаргагч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт ажилтнуудаа хамруулдаг байна.

## Хүний нөөцийн бодлого, ажлын таатай орчныг бүрдүүлэх төлөвлөгөө

Ажиллах хүчний мэргэжлийн байдлыг хадгалах үүднээс алба тус бүрийн ажилчдын мэргэжлийн ур чадавхыг тогтмол дээшлүүлж, туршлагатай ажилчдын залгамж халааг үүсгэн, сурган бэлтгэх, үүнтэй уялдуулсан карьер төлөвлөлтийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ. Үүнд:

- Залуу гэр бүлийг дэмжих, олон жил ажилласан жилийг урамшуулах, сэтгэл амар тухтай ажиллахад дэмжлэг үзүүлэх хүүхдийн цэцэрлэг, сургалтын тэтгэлэгт хөтөлбөр гэх мэт ажиллагсдынхаа нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ;
- Ажиллагсдын сургалт хөгжлийн бодлогыг тодорхойлж, дижитал технологийг нэвтрүүлэн үр ашигтай хүний нөөцийн системийг бий болгоно.

## 6.2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетингийн бодлого

Үнэт цаас гаргагч нь шинэ нэр төрөл, савлагаа бүхий бүтээгдэхүүнийг хүнсний аюулгүй байдал, олон улсын чанарын стандарт, зах зээлийн чиг хандлага болон хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа, шинжилгээ, цаг үетэйгээ хөл нийлүүлсэн хэрэгцээ шаардлагын дагуу шинээр зохион бүтээх, төлөвлөх, хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн бодлогын зорилго нь зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, нэмэгдүүлэх, шинэ зах зээлийг хөгжүүлэхийн тулд компанийн зорилго, зорилтуудад нийцүүлэн хэрэглэгчийн эрэлт, зах зээлийн чиг хандлагын дагуу зах зээлд тэргүүлэх бүтээгдэхүүнийг бэлтгэн гаргах, хэрэглэгч төвтэй бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулах, улмаар компанийн ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, нэмэгдүүлэхэд оршино.

Үнэт цаас гаргагч нь бизнесийн амжилтын зураглалыг дараах стратегийн дагуу төлөвлөдөг. Үүнд:

- Сонголттой бүтээгдэхүүнийг санал болгох;
- Бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах;
- Байршуулах стратеги болон оновчтой байршлыг тодорхойлох;
- Оновчтой үнийн бодлого хэрэгжүүлэх;
- Урт хугацааны хамтын ажиллагааны урамшууллын хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Борлуулалтын оновчтой арга хэрэгслийг сонгох.

## Сонголттой бүтээгдэхүүнийг санал болгох

### Савлагааны сонголтууд

Үнэт цаас гаргагч нь 2023 оны байдлаар 6 төрлийн ялгаатай хэмжээ бүхий савлагаатай савласан цэвэр усыг хэрэглэгчдэдээ санал болгож байна. Түүнчлэн, хэрэглэгчийн амьдралын хэмнэл, хэрэглээний онцлогт тохирсон савлагаа бүхий шинэ бүтээгдэхүүнийг танилцуулахаар судалгааны үе шатад явж байна.

Схем 12. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн процессын ерөнхий зураглал




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

**Бүтээгдэхүүний сонголтууд**

Үнэт цаас гаргагч нь цэвэр уснаас гадна витаминжуулсан болон эрдэсжүүлсэн цэвэр усны сонголтыг хэрэглэгчдэдээ хүргэхээр зорьдог. 2023 онд тэнцвэржүүлсэн хэрэглээ ph 8.5 буюу шүлтлэг цэвэр усыг 330 мл болон 500 мл савлагаатайгаар эрдэсжүүлсэн цэвэр усыг хамгийн боломжит үнэ, чанартай хэрэглээ бодлогын дор зах зээлд амжилттай танилцуулсан. Цаашлаад эрдэс амин дэмээр баяжуулсан олон сонголт бүхий шинэ бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдэдээ санал болгохоор ажиллаж байна.

**Эко савлагаа**

Нэг хуванцар савны байгальд задрах хугацаа нь савны хэмжээнээс хамааран 450 хүртэл жил байдаг гэсэн НҮБ-ын судалгаа байдаг. Үнэт цаас гаргагчийн хувьд хуванцар савны хэрэглээг үе шат дараалалтайгаар, байгальд ээлтэй байдлаар сайжруулан боловсруулж, жинг хөнгөрүүлж, хэрэглэгчдэд ухаалаг хэрэглээг санал болгож ирсэн. Цаашлаад Үнэт цаас гаргагч нь байгальд ээлтэй байх бодлогын хүрээнд хуванцар савыг дахин боловсруулах, дахин ашиглах, тойргийн эдийн засгийн урсгалыг бий болгох чиглэлд тодорхой ажлуудыг эхлүүлээд байна. Тойргийн эдийн засаг гэдэг нь хуванцар хог хаягдлыг дахин боловсруулан ашиглах үндсэн зарчим дээр суурилсан бөгөөд хэрэглэгч үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн худалдан авах ба үйлдвэрлэгч хэрэглэгчээс тухайн бүтээгдэхүүний сав баглаа буцаан худалдан авч дахин боловсруулан, шинэ бүтээгдэхүүн болгон хэрэглэгчид худалдах эргэх холбоо бүхий эдийн засгийн урсгалыг хэлдэг.

## Бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах

Үнэт цаас гаргагч нь "Вояж" ба "Voyage" нэрийн худалдааны тэмдгээ хуулийн дагуу баталгаажуулсан бөгөөд 2017 онд "Вояж" логог ребрэндинг буюу дахин загварчлан зах зээлд брэндийн шинэ өнгө төрх, шинэ шошго, шинэ савны дизайн бүхий "Voyage" брэндийг танилцуулсан.

**Зураг 20. Үнэт цаас гаргагчийн ребрэндинг**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

## Байршуулах стратеги болон оновчтой байршлыг тодорхойлох

Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүнээ зах зээлд таниулахдаа байршуулах супермаркет, жижиглэн, бөөний хүнсний худалдаа эрхлэгчид болон гэрээт хүнсний худалдаа эрхлэгчидтэй хамтран ажиллах арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлдэг. Савласан цэвэр ус бүтээгдэхүүний онцлог нь хэрэглэгчийн өдөр тутмын хэрэглээ тул бүтээгдэхүүний ялгарал багатай байдаг ба зах зээлд байрших хамгийн оновчтой стратеги нь хэрэглэгчдэд хамгийн ойр, хамгийн хүртээмжтэй байх жижиглэнгийн хүнсний худалдааны цэгүүд юм. Зорилтот эцсийн хэрэглэгчийн худалдан авалт, хэрэглээний хэв маяг, зан байдал, харилцагчдын зах зээлийн төлөв ба шинэчлэл зэрэгт үндэслэн Үнэт цаас гаргагч нь борлуулалтын сувгуудаа тогтмол шинжилж, харьцуулж, зохих бодлогуудыг тодорхойлж байдаг. Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлдэх үеийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 10,000 гаруй шингэн хүнсний борлуулалтын цэг, 6,000 гаруй харилцагчтай хамтран ажиллаж байна.

## Үнийн бодлого, өртгийн менежмент

Үнэт цаас гаргагч нь хамгийн үр ашигтай үйлдвэрлэлийн өртгийн менежментийн системийг бий болгож нэгж бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар үйлдвэрлэж чаддаг. Тиймээс Үнэт цаас гаргагчийн өрсөлдөөний стратеги нь хүртээмжтэй, боломжит хямд үнээр, хамгийн олон тоо ширхгээр бүтээгдэхүүнийг борлуулах үндсэн зарчим дээр суурилдаг.

Мөн бүтээгдэхүүний савлагааны хувьд боломжит хамгийн бага зардал шингэсэн шошго, шошгын хэвлэлтийн технологийг ашигладаг. Ийнхүү шошго, шошгын хэвлэлт гэх мэт бүтээгдэхүүний чанарт нөлөөлөхгүй боловч нэмүү өртөг нэмэгдүүлдэг зүйлсийг бага байлгаснаар нэгж бүтээгдэхүүний өртгийг бага байлгадаг байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь технологийн дэвшлийг ашиглан хуванцар савны жинг үе шаттайгаар бууруулсан нь өртгийг бага байлгахад нөлөөлөөд зогсохгүй байгаль орчинд ээлтэй шийдвэр болсон юм.

СЗХ 2024 .04 .29 сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ-03

**Схем 13. Үнэт цаас гаргагчийн хуванцар савны жинг бууруулсан мэдээлэл**

| 2019 он | | 2021 он | |
|---|---|---|---|
| 500 мл савлагаанд ашиглагддаг 26.26 грамм хуруу савыг 18 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 93 тонн хуванцар хэмнэсэн | 1.5 литр савлагаанд ашиглагддаг 36 грамм хуруу савыг 35.1 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 4 тонн хуванцар хэмнэсэн |
| 4.5 литр савлагаанд ашиглагддаг 110 грамм хуруу савыг 85 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 67 тонн хуванцар хэмнэсэн | **2023 он** | |
| 4.5 литр савлагаанд ашиглагддаг 45 грамм бөглөөг 85 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 26 тонн хуванцар хэмнэсэн | Жижиг савлагаанд ашиглагддаг 18 грамм хуруу савыг 17.5 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 10 тонн хуванцар хэмнэсэн |

***Эх сурвалж:*** *Үнэт цаас гаргагчийн мэдээлэл, тооцоолол*

Хуруу савны жинг бууруулснаар хуванцар савны жин буурч, улмаар хуванцар хог хаягдлын хэмжээ, үйлдвэрлэлд ашиглах эрчим хүч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахаас гадна дахин боловсруулах үйл явцыг хялбаршуулдаг байна. Тус шийдвэр нь үйлдвэрлэлийн зардлыг хэмнэхээс гадна хог хаягдлыг дахин боловсруулах салбарыг дэмжиж, тойргийн эдийн засагт хувь нэмэр, эерэг нөлөө үзүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь 2019 оноос хойш 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 674 тонн хуванцар савыг хэмнэсэн байна.

### Урт хугацааны хамтын ажиллагааны урамшууллын хөтөлбөр

Үнэт цаас гаргагч нь урт хугацаанд хамтран ажиллаж байгаа бөөний болон жижиглэн хүнсний худалдаа эрхлэгчид болон гэрээт борлуулагчдад борлуулалтын дүнгээс урамшуулал тооцох, тогтмол урамшуулах олгох хэлбэрээр хамтын ажиллагааг дэмжсэн хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлдэг. Тухайлбал, хүнсний бөөний болон жижиглэн дэлгүүрүүдийн хувьд ойролцоогоор 3-5 хувийн гүйцэтгэлийн урамшуулал, томоохон супермаркетуудад гэрээгээр зөвшилцсөн урамшуулалт хувь болон төлөвлөгөөний нэмэлт хувийг тооцон олгодог байна.

### Борлуулалтын оновчтой арга хэрэгслийг ашиглах

#### Хамтын ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын стратеги нь жижиглэн болон бөөний хүнсний худалдаа эрхлэгчид болон гэрээт борлуулагчидтай урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг бэлжүүлэхэд чиглэдэг. Үүнээс гадна Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүнээ олон тоо ширхгээр, бөөний үнээр буюу өрсөлдөгч бүтээгдэхүүнтэй харьцуулахад хямд үнээр санал болгодог нь худалдаа эрхлэгчдийн сонирхлыг татдаг байна. Цэвэр усны хэрэглээ нь хэрэглэгчдийн өдөр тутмын зайлшгүй хэрэгцээ тул хүнсний худалдаа эрхлэгчдийн хувьд барааны эргэлт сайтай байх үндсэн нөхцөл нь бүтээгдэхүүний боломжит хямд үнэ байдаг ба олон тоогоор, хямд үнээр бараагаа татан авах нь ашигтай байдаг байна.

### Зар сурталчилгаа

Үнэт цаас гаргагчийн зар сурталчилгааны зардал нь бусад өрсөлдөгч бүтээгдэхүүнтэй харьцуулахад харьцангуй бага байсан ба энэ нь аливаа маркетингийн зардал шингээгүй бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгох үндсэн бодлогыг дэмждэг байсантай холбоотой. Үнэт цаас гаргагч нь зар сурталчилгаанд чиглэсэн маркетингийн төлөвлөгөөг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж өгсөн бөгөөд цаашид нийтийн сурталчилгаагаар дамжуулан эрдэсжүүлсэн болон витаминжуулсан цэвэр усны зохистой хэрэглээний талаар, мөн байгаль орчинд ээлтэй ухаалаг хэрэглээний ач холбогдлыг таниулах хэлбэрээр өөрсдийн шинэ бүтээгдэхүүн болон бүтээгдэхүүний давуу талаа хэрэглэгчдэдээ таниулахаар төлөвлөж байна.

### Ивээн тэтгэлэг

Үнэт цаас гаргагч нь идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэмнэлийг сурталчлах ажлыг дэмжин ажилладаг бөгөөд цаашид энэ чиглэлд кампанит ажлуудыг дэмжих бодлогыг үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байна.

Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудаас дурдвал:

- 2017 онд Сонгинохайрхан дүүргийн 170-р цэцэрлэгийн 450 гаруй хүүхдийн ундны усыг бүтэн жилийн хугацаанд хангахаар болов.
- 2019 оноос хойш уулын спортыг хөгжүүлэгч "Хамтдаа алхацгаая" ТББ-тай хамтран ажиллаж, уулын спортыг таниулан дэмжих ажилд хувь нэмэр оруулан ажилласаар байна. Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд Үнэт цаас гаргагчийн "Voyage" брэндийн туг Монгол Улсын ноён оргилуудаас эхлээд Европ тивийн ноён оргил Эльбрус ууланд мандсан.
- "Скайраннинг" гүйлтийн холбоотой хамтран ажиллаж, уулын гүйлтийн спортыг таниулан сурталчлах ажлыг ивээн тэтгэж эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж байна.
- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар, "Сонгинохайрхан марафон-2019"-ийг ивээн тэтгэж талархал хүлээв.
- 2020 онд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр Сонгинохайрхан дүүргийн Хүүхдийн асрамжийн газар амьдардаг хүүхдүүдэд зориулсан сайн үйлсийн аян хийв.
- "Эх дэлхийгээ хайрлаж мод тарьцгаая" уриа дор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Мод тарих үндэсний өдөр"-өөр 2021 онд Бумбатын рашааны дагуу 2021 онд 300 мод, Төв аймгийн эрдэнэ сумын нутагт 2022 онд 500 мод, 2023 онд 500 мод, сүүлийн гурван жилийн хугацаанд нийтдээ 2,000 мод шинээр тарив.
- 2021 онд "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлж тогтвор суурьшилттай ажиллаж буй ажилтнуудын хүүхдүүдэд оюутны бүтэн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгов.
- 2021 онд цар тахлын үед ОБЕГ-т 15 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.
- 2023 онд Хоккейн спортын 18 нас хүртэлх буюу өсвөрийн баг тамирчдыг дэмжин ажиллав. Монгол Улсын өсвөрийн хоккейн шигшээ баг нь 2023 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн билээ. Үнэт цаас гаргагчийн хувьд хоккейн спорт нь залуучуудад бие бялдрын тэгш хөгжил, тамирчны болоод хувь хүний ёс зүйг төлөвшүүлдэг гайхалтай спорт юм.
- Монголын Хөл Бөмбөгийн Холбооны Үндэсний Дээд Лигийн 2023-2024 оны улирлын тоглолтод "Баварианс Эф Си Хөлбөмбөгийн Баг"-ийг дэмжин ажиллав.
- "Амьдрал бэлэглэе" уриа дор Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвтэй хамтран "Цусаа хандивлах өдөр"-ийг зохион байгуулав.
- 2023 онд Нийслэлд тохиолдсон үерийн гамшгийг даван туулахад НОБЕГ-ийн албан хаагчдад өөрийн бүтээгдэхүүнээр дэмжлэг үзүүлэв.

СЗХ
2024 он .04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

MGL aqua

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ

# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

7

СЗХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

# 7. Байгаль орчин, нийгэм засаглалын тогтвортой хөгжлийн бодлого

Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ийн мэдээллийг боловсруулах, үнэлэх чиглэлд зөвлөмж гаргаснаар БОНЗ-ын талаарх ойлголт бизнесийн орчинд өргөн хэрэглэгдэх болсон. Бизнесийн байгууллагууд БОНЗ-ын үзүүлэлтүүдийг стратегийн түвшинд тодорхойлж, байгууллагын урт хугацааны тогтвортой бизнесийн үндэс хэмээн чухалчлан авч үзэх болсон. Нөгөө талаас бизнесийн урт хугацааны тогтвортой оршин тогтох үндэс нь гагцхүү бизнесийн орлого, санхүүгийн амжилтаас гадна хүрээлэн буй байгаль орчин, нийгмийн бүтэц, байгууллагын дотоод эрүүл системээс хамаардаг болох нь судалгаагаар нотлогдсон юм. Тухайлбал, олон улсын судалгаагаар БОНЗ (ESG)-ын зарчмуудыг мөрдөж буй судалгаанд хамрагдсан компаниудын 88 хувийнх нь үйл ажиллагааны үр ашиг сайжирсан, 80 хувийнх нь хувьцааны ханшинд эерэг нөлөө үзүүлсэн, 90 хувийнх нь санхүүжилтийн зардал буурсан үр дүнгүүд илэрсэн байна.

## 7.1. Байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2017 оноос хойш буюу шинэ удирдлагын багийн манлайлал дор савласан цэвэр усны зах зээлд 160 мянга орчим тонн цэвэр усыг хэрэглэгчдэдээ хүргэсэн байна. Үнэт цаас гаргагч нь анх үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн байгальд ээлтэй (eco-friendly), цэвэр ус хүн бүрд хүртээмжтэй буюу боломжийн үнэтэй (affordability), тогтвортой бизнес хөгжил (sustainabile-leadership) гэсэн үндсэн 3 стратегийг бизнесийн үндсэн зарчим болгон ажиллаж хэрэглэгчдэдээ үнэ цэнийг бий болгосон.

Үнэт цаас гаргагч нь цаашид энэхүү бизнесийн стратегиа баримтлан хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэдээ бий болгох бизнесийн үнэ цэнээ улам бүр нэмэгдүүлж, урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгохын тулд НҮБ-аас гаргасан тогтвортой хөгжлийн 17 зөвлөмжөөс байгаль орчинд эерэг нөлөөлөл бий болгох чиглэлд ач холбогдол өгч ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн байгаль орчинд эерэг нөлөөллийг (environment impact) бий болгох стратегийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Материалын менежмент;
- Хүртээмжтэй цэвэр ус (affordability);
- Цэвэр усны нөөцийн хамгаалалт;
- Ухаалаг логистик.

### Материалын менежмент

Түүхий эд, сав баглаа боодлыг дахин ашиглах, байгальд задрах хугацааг бууруулах, дахин боловсруулах, хог хаягдлыг бууруулах, чанарын шаардлага хангасан, хурдан задрах материалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, цаашлаад энэ чиглэлд нийтийн боловсролыг нэмэгдүүлэхийг зорьж байна. Хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилтот хөтөлбөр нь НҮБ-аас гаргасан зөвлөмжийн 12 дахь зорилт бөгөөд хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилгын хүрээнд 2030 он гэхэд хэрэглээний түвшинд нэг хүнд ногдох дэлхийн хүнсний бүтээгдэхүүнээс үүсэх хаягдлыг хоёр дахин багасгах зорилтыг дэмжин ажиллахыг улс орнуудын засгийн газар, байгууллагуудад уриалсан. Үнэт цаас гаргагчийн цэвэр усны сав нь нэмэлт өнгө оруулагчгүй, хамгийн энгийн материал хийцлэлтэй бөгөөд энэ нь байгальд хурдан шингэх, дахин боловсруулах зардал харьцангуй багатай гэх зэрэг давуу талтай. Олон улсын гаргасан судалгаагаар хуванцар савны байгальд задрах хугацаа нь орц хэмжээнээс хамаараад 20-450 жил байдаг байна. Үнэт цаас гаргагчийн хувьд 2019 онд анх 26.26 грамм хуруу савыг 18 грамм болгож, 110 грамм хуруу савыг 85 грамм болгож, мөн 4.5 литрийн хэмжээтэй хуванцар савны бөглөөг 45 граммаас 38 грамм, 2021 онд 36 грамм хуруу савыг 35.1 грамм болгон тус тус амжилттай хөнгөрүүлсэн. Цаашлаад, 2023 онд өмнөх амжилтаа ахиулан 500 мл ашиглагддаг хуруу савны жинг дахин 17.5 грамм болгон хөнгөрүүлжээ.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd

Схем 14. Үнэт цаас гаргагчийн хуванцар савны жин бууруулсан мэдээлэл

| 2019 он | | 2021 он | |
|---|---|---|---|
| 500 мл савлагаанд ашиглагддаг 26.26 грамм хуруу савыг 18 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 93 тонн хуванцар хэмнэсэн | 1.5 литр савлагаанд ашиглагддаг 36 грамм хуруу савыг 35.1 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 4 тонн хуванцар хэмнэсэн |
| 4.5 литр савлагаанд ашиглагддаг 110 грамм хуруу савыг 85 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 67 тонн хуванцар хэмнэсэн | **2023 он** | |
| 4.5 литр савлагаанд ашиглагддаг 45 грамм бөглөөг 85 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 26 тонн хуванцар хэмнэсэн | Жижиг савлагаанд ашиглагддаг 18 грамм хуруу савыг 17.5 грамм болгон хөнгөрүүлэв | Жилд 10 тонн хуванцар хэмнэсэн |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл, тооцоолол*

Үүнээс гадна үнэт цаас гаргагч нь хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд дараах чиглэлийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Хуванцар савны байгальд шингэх хугацааг боломжит хамгийн бага түвшинд байлгах зорилготой судалгаа хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэх;
- Хуванцар савыг дахин боловсруулах;
- Хуванцар савны хог хаягдлыг цуглуулах, ялган ангилах чиглэлд нийтийн ухамсрыг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж эхлээд байна.

## Хүртээмжтэй, боломжийн үнэтэй цэвэр ус

Үнэт цаас гаргагч нь сургуулийн сурагчдаас эхлээд бүх салбарт ажил үйлчилгээ эрхэлдэг ажилтан, албан хаагчид, өндөр настан гэх зэрэг нийгмийн бүхий л давхаргад эрүүл ахуй, чанарын стандартыг хангасан цэвэр ус хэрэглэх боломжийг бий болгохоор зорьж байна. Мөн адил энэ чиглэлд цэвэр усны хэрэглээ ба эрүүл мэндийн тухай олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг дэмжин ажиллахаар төлөвлөжээ.

Хүн бүрийг ундны аюулгүй, боломжийн үнэтэй усаар хангах зорилтот хөтөлбөр нь НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтын 6 дахь зорилт бөгөөд Цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 2030 он гэхэд зохих дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, түүнчлэн устай холбоотой экосистемийг хамгаалж, сэргээх чиглэлд анхаарал хандуулахыг дэлхий дахинд уриалсан.

Үнэт цаас гаргагчийн зүгээс өртөг багатайгаар хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг бүрэн хангасан цэвэр усыг хэрэглэгчдэдээ түгээхээр зорин ажилладаг нь нийгмийн бүхий л давхаргын, бүхий л насны хэрэглэгчдэд цэвэр усны хүртээмжтэй байдлыг бий болгож байна.

## Цэвэр усны нөөцийн хамгаалалт

Цэвэр усны нөөцийг хамгаалах зорилтот хөтөлбөр нь НҮБ-аас гаргасан зөвлөмжийн 15 дахь буюу Хуурай газрын эко системийг хамгаалах зорилгын хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд 2030 он гэхэд хүн төрөлхтний нийтлэг өв болох байгаль болон түүний оршин тогтнох нөхцөлийг хамгаалах, дэлхийн хүнс, усны аюулгүй байдал болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаагаар дэмжин ажиллах чиглэлд анхаарал хандуулахыг дэлхий дахинд уриалсан байдаг.

СЗХ 2024.04.29 он сар өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн дотоод үйлдвэрлэлдээ хийсэн тооцоогоор 1,000 грамм цэвэр ус үйлдвэрлэхэд дунджаар 450 грамм ус хаягдал болон үрэгддэг байна. Тус хаягдал ус нь шүүлтүүрийн дамжлагаас гарсан ямар нэг бохирдолгүй цэвэр ус тул ахуйн хэрэглээнд ашиглах бүрэн боломжтой юм. Тиймээс Үнэт цаас гаргагч нь тус хаягдал усны хэмжээг бууруулах чиглэлд ажиллахаас гадна, үр ашигтай хэрэглээг бий болгоход анхаарч ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд ногоон байгууламжийн услагаа, гал унтраах анги, машин угаалга зэрэгт хаягдал усыг ашиглах боломжийг бүрдүүлэх дэд бүтэц бий болгоход анхаарч байна. Мөн Үнэт цаас гаргагчийн усны эх үүсвэр болох Бумбатын рашааны голдирол, урт хугацааны сэргээгдэх цэвэр усны нөөцийг хамгаалах зорилтот хөтөлбөрийн хүрээнд цэвэр усны эх ундарга болсон байгалийн тогтоц газрыг хүний хүчин зүйлээс үүдсэн аюулаас хамгаалах болон байгалийн онгон дагшин байдлыг сэргээх чиглэлд анхааран ажиллахаар төлөвлөжээ.

### Ухаалаг логистик

Үнэт цаас гаргагч нь логистикийн хамгийн үр ашигтай, ухаалаг системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн боломжийн үнэтэй цэвэр усыг хотын захын дүүрэг, сум суурин болон алслагдсан газар нутагт хүртээмжтэй байлгахыг зорьж байна. Мөн логистик системийг ухаалаг бөгөөд үр ашигтайгаар шийдсэнээр агаарын бохирдол болон хүлэмжийн хийн ялгаруулалтыг боломжит бага хэмжээнд барина.

Ухаалаг логистик систем нь боломжийн үнэтэй цэвэр усыг газарзүйн байршлын хувьд, нийгмийн өөр өөр статустай бүх хэрэглэгчдэдээ хүртээмжтэй хүргэх зорилтыг дэмжин ажиллах гол схем юм. Мөн энэхүү ухаалаг логистик систем нь дахин боловсруулах хуванцар савны хог хаягдлыг цуглуулах, хэрэглэгчээс дахин боловсруулах үйлдвэрт хүрэх зам дамжлагыг хөнгөвчлөх гэх мэт тойргийн эдийн засгийг үүсгэх гол бүтэц болон тэлэх боломжтой.

## 7.2. Нийгэм, эдийн засаг дахь нөлөөллийн тухай

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог нь хүний суурь хэрэгцээ болох ундны цэвэр усны хэрэглээн дээр суурилдаг. Тиймээс цэвэр усны зохистой хэрэглээ, витаминаар баяжуулсан, эрдэсжүүлсэн усны зохистой хэрэглээ, хуванцар савны хог хаягдлын ашиглалт чиглэлд олон нийтийг мэдээллээр хангах, нийтийн ухамсрыг нэмэгдүүлэх чиглэлд өөрсдийн олон нийтийн суваг, үйл ажиллагааны тайлан, сурталчилгааны материалаар дамжуулан хүрч ажиллана.

Мөн Үнэт цаас гаргагчийн ажиллах хүчний хувьд 68 эмэгтэй ажилчид, 94 эрэгтэй ажилчид байгаа нь ажиллах хүчний хүйсийн тэнцвэрт байдлыг ханган ажиллаж байгааг илтгэж байна. Үүнээс гадна нийт ажилтнуудын 7 хувь нь (13 хүн) мэргэжлийн тусгай боловсрол эзэмшсэн, 1 хувь нь 55-аас дээш буюу ахмад настай, 3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Цаашлаад Үнэт цаас гаргагч нь бизнесийн дунд хугацааны төлөвлөгөөндөө хүний нөөцийн бодлого, ажлын таатай орчныг бүрдүүлэх чиглэлд бодлого боловсруулах ажлуудыг тусгасан. Тус бодлогын хүрээнд залуу гэр бүлд чиглэсэн урамшуулал, хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөр, ажилтны хүүхдийн цэцэрлэг зэрэг ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого журмуудыг боловсруулан ажиллаж байна.

## 7.3. Засаглалын нөлөөллийн тухай

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгосноор хувьцаат компанийн статустай болно. Энэхүү томоохон өөрчлөлт, сайжруулалтын хүрээнд Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, засаглалыг бэхжүүлэхээр зорьж байгаагаас гадна Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон удирдлагын багийн гишүүд нь МУИС-ийн Бизнесийн сургуулийн зохион байгуулдаг “Компанийн засаглал” сургалтад хамрагдаж, Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс олгодог гэрчилгээг авсан байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd Улаанбаатар хот
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore Capital Улаанбаатар хот

СЗХ 2024.04.29 он сар өдөр № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23

## 7.4. БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

Үнэт цаас гаргагч нь 2019 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гаргуулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан ба энэхүү үнэлгээгээр байгаль орчинд нөлөөлөх гол хүчин зүйлсийг тодорхойлох, бизнесийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчин болон нийгэм, эдийн засгийн үнэт зүйлс, үүнд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэгддэг.

Үнэт цаас гаргагчийн байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үр дүн дараах байдалтай байна.

**Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний үр дүн**

| | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ ( - *сөрөг нөлөө*, + *эерэг нөлөө*) | | | |
|---|---|---|---|---|
| | Бага | Дунд | Их | Аюултай |
| | Байгаль орчин | | | |
| Газрын гадарга, хэвлий | -2 | 0 | 0 | 0 |
| Усан орчин | -1 | -1 | 0 | 0 |
| Агаарын орчин | -2 | 0 | 0 | 0 |
| Хөрс, ургамал | -3 | 0 | 0 | 0 |
| Нийт нөлөөллийн тоо | 8 | 1 | 0 | 0 |
| Эзлэх хувь | 88.9% | 11.1% | 0 | 0 |
| | Нийгэм эдийн засаг | | | |
| Нутгийн оршин суугчид | -2 | +3 | 0 | 0 |
| Түүх соёлын дурсгал | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт нөлөөллийн тоо | 2 | 3 | 0 | 0 |
| Эзлэх хувь | 40 | 60 | 0 | 0 |

***Эх сурвалж:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам "Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших "Voyage цэвэр ус"-ны үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотгол, 2019 он*

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 88.8 хувь нь бага зэрэг, 11.1 хувь нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 60 хувь нь дунд зэрэг эерэг, 40 хувь нь бага зэрэг сөрөг нөлөөтэй байна. Дээрх үнэлгээг дүгнэвэл Үнэт цаас гаргагчийн байгаль орчны бүрдэл хэсэг болон нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө нь бага байна.

Үнэт цаас гаргагч нь 2020 онд Байгаль Орчны Аудитын "Грийн Повер" ХХК-иар Байгаль орчны аудит хийлгэн, дүгнэлт гаргуулсан. Тус дүгнэлтээр Байгаль орчны аудитыг агаарын чанар, ус ашиглалт, газрын менежмент, хог хаягдал, химийн бодис, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, удирдлага зохион байгуулалт зэрэг зургаан чиглэлээр холбогдох нийт 50 гаруй хууль тогтоомж, төрийн бодлого хөтөлбөр, дүрэм журам, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 156 шалгуур үзүүлэлтээр баримт бичиг, газар дээрх ажиглалт судалгаа нотолгоонд үндэслэн нийцлийг тодорхойлоход Үнэт цаас гаргагчийн 112 үзүүлэлт нийцэлтэй гарсан байна.

Үнэт цаас гаргагч нь БОНЗ-ын бодлогын хүрээнд эрүүл амьдралын хэв маягийг дэмжихээс гадна байгаль дэлхийдээ ойр уулын спортыг дэмжин, тухайн спортоор дамжуулан эх дэлхийгээ хайрлах, хог хаягдалгүй дэлхийг хойч үедээ үлдээхийг уриалан ажилладаг.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd Улаанбаатар хот
Invescore Capital Улаанбаатар хот

СЗХ
2024.04.29 он сар өдөр
БҮРТГЭВ

MGL aqua

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

# ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

8

# 8. Эрсдэлийн хүчин зүйлс ба эрсдэлийн бодлого

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах асуудлыг ямагт анхаарч ажиллаж ирсэн. Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажиллагааг Компанийн засаглалын үндсэн оролцогчид буюу Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, удирдлагын багаас эхлэн хувь ажилтан бүрд системтэйгээр бий болгон төлөвшүүлэхэд анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд тусгайлсан хэм хэмжээ буюу "Эрсдэлийн удирдлагын журам"-ыг үйл ажиллагаандаа үндсэн чиглэл болгон мөрдөн ажиллаж байгаа бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй Компанийн бусад дүрэм, журам, бодлогын баримт бичигт тухайн зохицуулагдаж буй харилцааны онцлог байдлаас хамааран эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж мөрддөг.

## 8.1. Эрсдэлийн тодорхойлолт, ангилал

Үнэт цаас гаргагчийн Эрсдэлийн удирдлагын журамд Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг удирдах, хянах зорилгоор нийт 17 хүчин зүйлсийн эрсдэлийг тодорхойлсон байна. Андеррайтерийн зүгээс Үнэт цаас гаргагчийн Эрсдэлийн удирдлагын журмаар тодорхойлсон эрсдэлийн хүчин зүйлүүдийг Компанид материаллаг болон материаллаг бус нөлөө үзүүлж болзошгүй байдлаас хамааран дор дурдсаны дагуу 5 бүлэгт төрөлжүүлэн ангилсан.

**Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчид материаллаг болон материаллаг бус нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийн төрлүүдийн ангилал ба тайлбар**

| Эрсдэлийн төрлүүд | Эрсдэлийн төрлүүдийн хамрах хүрээ |
|---|---|
| Стратегийн эрсдэл | Эдийн засгийн төлөв байдал, зах зээлийн өрсөлдөөн, хууль эрх зүйн нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан Үнэт цаас гаргагчийн бизнесийн хэтийн хөгжил, гүйцэтгэл, стратегийг хэрэгжүүлэхэд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болох эрсдэлийн төрлүүд хамаарна. |
| Санхүүгийн эрсдэл | Зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, валютын ханш, хүү, инфляцын огцом өөрчлөлтөөс үүдэн орлого болон хөрөнгийн хэмжээнд үүсэж болзошгүй эрсдэлүүд, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс алдагдал хүлээх, төлбөрийн чадвараа алдах, хөрвөх чадварын эрсдэлийн төрлүүд хамаарна. |
| Үйл ажиллагааны эрсдэл | Үнэт цаас гаргагчийн дотоод үйл ажиллагаанд үүсэж болзошгүй процессын алдаа дутагдал, тоног төхөөрөмжийн хүчин чадал, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлүүд, бусад гадаад хүчин зүйлүүдийн нөлөөний улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй байдалд хүрэх, Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд учирч болох эрсдэлийн төрлүүд хамаарна. |
| Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын эрсдэл | Савласан усны үйлдвэрлэлийн технологийн процесс, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй химийн, микробиологийн, физик эрсдэлийн төрлүүд хамаарна. |
| Хууль эрх зүйн эрсдэл | Үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт орсны улмаас үйл ажиллагаа тасалдах, дотоод дүрэм, журам болон процесс хууль тогтоомжтой нийцэхгүйтэй холбоотойгоор үүсэх эрсдэл хамаарна. |

***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан эрсдэлийн төрөл тус бүрд хамаарах арга хэлбэрээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг ба эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлд авах арга хэмжээг Эрсдэлийн удирдлагын бодлогод зааж өгсөн байна.

СЗХ
2024 .04 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### 8.1.1. Стратегийн эрсдэл

#### Гадаад хүчин зүйлсийн болон давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл

Гадаад хүчин зүйлсийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлд Үнэт цаас гаргагчийн зүгээс урьдчилан тооцоолох эсхүл таамаглах боломжгүй, хяналтаас гадуур, тогтоон барих боломж бололцоо маш бага нөхцөл байдлыг хамруулдаг. Тухайлбал, байгалийн гамшигт үзэгдэл, нийтийг хамарсан өвчлөл, үймээн, улс төрийн нөхцөл байдал зэрэг хүчин зүйлүүдтэй холбоотой эрсдэлүүдийг хамааруулсан байна.

Давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлийн тухайд улс төрийн тогтворгүй байдал, жагсаал цуглаан, дайн, газар хөдлөлт, байгалийн гамшигт үзэгдлийн улмаас эрчим хүч, интернэт болон үйлдвэрлэл, борлуулалтын хэвийн үйл ажиллагаа тасалдах зэрэг эрсдэлийн нөлөөллүүд хамаарна.

Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлүүдийг үнэлж, эрсдэлийн түвшинд тулгуурлан авах арга хэмжээ, оролцогчдын чиг үүргийг тодорхойлсон байдаг ба энэхүү төлөвлөгөөг хариуцсан ажилтнуудад мэдээллээр хангадаг байна. Түүнчлэн, давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоолоор баталгаажуулан шаардлагатай мэдээллийг холбогдох ажилтнуудад мэдээлдэг. Мөн гадаад худалдааны хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан импорт саатах эрсдэлтэй тул зайлшгүй сав баглаа боодлын нөөцийн хэмжээг тодорхойлж, заавал байлгах нөөцийн хоногийг 180 хоногоор төлөвлөж татан авалт хийдэг байна.

#### Өрсөлдөөний эрсдэл

Монгол Улсын шингэн хүнсний салбарт үндэсний том компаниуд болон олон улсын брэндийн бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөөн өндөр байдаг. Өрсөлдөөний эрсдэлд ижил үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдэх, савласан цэвэр усыг орлуулах бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, улмаар Үнэт цаас гаргагч зах зээлийн өрсөлдөөнд харьцангүй давуу байдлаа алдах, зах зээлд эзлэх хувь буурах эрсдэлүүд хамаарна.

Чанарын шаардлага хангасан савласан цэвэр усны эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа өнөө үед шинэ, шинэлэг бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй сав баглаа боодлыг үйлдвэрлэлдээ ашиглах зэргээр шалгуурын түвшин жил ирэх бүр өсөж байна. Үнэт цаас гаргагч нь савласан цэвэр усны зах зээлд үнийн стратеги, байгальд ээлтэй сав баглаа боодол болон тогтвортой, тасралтгүй байх бодлогоор зах зээлд тэргүүлэх бодлого баримталдаг. Уг хүрээнд Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүний сав баглаа боодлыг хэрэглэхэд хялбар, бага өртгөөр, байгаль орчинд ээлтэй байдлаар үйлдвэрлэсэн цэвэр усыг санал болгохыг эрхэмлэдэг.

Үнэт цаас гаргагч нь өрсөлдөөний давуу байдлаа нэмэгдүүлэхийн тулд бүтээгдэхүүний нэр төрлийг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөлжүүлж, боломжийн үнэтэй, чанартай, байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нийлүүлэх бодлогыг үйл ажиллагаандаа баримталж, олон улсын болон дотоодын адил төстэй үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн сайн жишиг, шалгарсан арга барил, ноу-хауг судалж зах зээлийн өрсөлдөөнд тэргүүлэгч нь байхаар ажиллаж байна.

#### Гүйцэтгэлийн эрсдэл

Гүйцэтгэлийн эрсдэлд оновчтой бус санхүү, бизнесийн стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, гадаад орчны нөлөөллөөс үүдэлтэйгээр бизнес төлөвлөгөө цаг тухайд биелэгдэхгүй, хойшлогдох зэрэг бизнесийн хэтийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийг хамааруулна.

Үнэт цаас гаргагч нь бизнесийн стратеги, төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэхэд урьдчилан тооцоолсон болон тооцоолоогүй эрсдэлүүд, эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалт, улс төрийн нөлөө зэрэг олон хүчин зүйлс сөргөөр нөлөөлж болно. Эдгээр хүчин зүйлсээс шалтгаалан ирээдүйн бизнесийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болох нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.



MGL AQUA Co.,Ltd
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь гүйцэтгэлийн эрсдэлийн төрөлд хамаарах хүчин зүйлсээс үүсэж болох нөлөөллүүдийг бууруулахын тулд тухайн жилийн стратегийн төлөвлөгөөгөө батлахдаа өнгөрсөн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэн, тухайн жилд тавигдах үндсэн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах нөөц, гарч болзошгүй эрсдэл, тэдгээрээс сэргийлэх төлөвлөгөө зэргийг харгалзан үзэж үндэслэл бүхий бодитой төлөвлөгөөний боловсруулалтыг хийж ажиллаж байна.

### 8.1.2. Санхүүгийн эрсдэл

#### Эдийн засгийн эрсдэл

Макро эдийн засгийн хүчин зүйлс болох гадаад, дотоод зах зээлийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн чиг хандлага нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг. Тодруулбал, зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, ханш, хүү, инфляцын огцом өөрчлөлт нь борлуулалтын орлого болон хөрөнгийн үнэ цэнийг бууруулах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлэх, төлбөрийн чадвар алдагдах зэрэг эрсдлүүдийг бий болгох магадлалтай.

Үнэт цаас гаргагчаас эдийн засгийн эрсдэлээс үүдэлтэй хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах зорилгоор үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах арга хэмжээнүүдийг нэн тэргүүнд авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Үйлдвэрлэл дэх техник технологийн шинэчлэл, цаашлаад үйлдвэрлэлийн цар хүрээг нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нарийн тодорхойлохын тулд тайлант хугацаан дах мөнгөн урсгалын төлөвлөлтийг сараар болон жилээр урьдчилж гарган тооцоолох;
- Эдийн засаг болон улс төрийн нөхцөл байдлыг тогтмол ажиглаж, бодитой үнэлэлт дүгнэлт өгөх;
- Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд оновчтой нэвтрүүлэх замаар тогтвортой орлогын суурийг бий болгон ажиллах;
- Эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэх зэрэг багтана.

#### Ханшийн эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанаас үүдэлтэй, нөлөө бүхий эрсдэлд ханшийн эрсдэл буюу түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн гарах валютын ханшийн эрсдэлийг авч үздэг. Үнэт цаас гаргагчийн түүхий эд материал болох хуруу саванд ашиглагддаг мөхлөг худалдан авах төлбөр тооцоо гадаад валютаар хийгддэг тул валютын ханшийн огцом савлагаанд алдагдал хүлээх эрсдэлтэй. Үнэт цаас гаргагч нь олон улсын бэлтгэн нийлүүлэгч нарт төлөх төлбөрийг урьдчилж төлөх нөхцөлөөр, гадаад валютаар төлбөр тооцоог хийдэг бөгөөд тус хугацаанд валютын ханш суларвал Үнэт цаас гаргагчид валютын ханшийн эрсдэл үүсэж, ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй.

Үнэт цаас гаргагч нь валютын ханшнаас үүдэлтэй эрсдэлийг тухайн үеийн нөхцөл байдлаас хамааран зарим тохиолдолд түүхий эд нийлүүлэгч тал руу үе шаттайгаар шилжүүлэх тохиолдлууд үүсдэг. Үнэт цаас гаргагч нь валютын ханшид нөлөөлөх хүчин зүйлсийг судлах, мөн түүхий эд материалыг нөөцлөх замаар тус эрсдэлийн түвшнийг бууруулдаг.

## Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэлд компани ирээдүйн өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж чадахгүйгээс үүдэн санхүүгийн тогтвортой байдал алдагдах, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж чадахгүй болох эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагч нь өр төлбөр, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангаж ажиллахыг зорьдог. Нийт хөрөнгөд эзлэх өөрийн хөрөнгийн хувь жил бүр нэмэгдэж, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 60 хувьтай болон эргэлтийн харьцаа нь 1.2 байгаа нь Үнэт цаас гаргагч өр төлбөрөө зохих хугацаанд барагдуулахгүй байх эрсдэл харьцангуй бага байгааг харуулж байна.

Үнэт цаас гаргагч нь хөрвөх чадварын эрсдэлийг зээлээрх борлуулалтын зохистой хэмжээг хангаж ажиллаж, авлагын насжилт, бүтцийг тогтмол хянах замаар үйл ажиллагааны мөнгөн урсгалыг оновчтой удирдах, хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн тус эрсдэлийн түвшнийг бууруулдаг. Борлуулалтын орлогод эзлэх авлагын хувь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 22.8 хувьтай байгаа ба 0-30 хоногийн хугацаатай авлагын хэмжээ нийт дансны авлагад 69.5 хувь, 30-60 хоногийн хугацаатай авлага 9.3 хувь, 60-90 хоногийн хугацаатай авлага 6.4 хувийг тус тус эзэлж буй нь Үнэт цаас гаргагч авлагыг зохих хугацаанд цуглуулж чадахгүй байх эрсдэл харьцангуй бага байгааг харуулж байна.

## Зардал хэтрэх эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд аливаа тоног төхөөрөмж, түүхий эд материалын үнийн өсөлт, бусад гадны хүчин зүйлсээс хамааралтай үүсэх гэнэтийн эвдрэл, эсвэл харилцагчидтай холбоотой үүсэх томоохон асуудал зэрэг гэнэтийн тооцоолоогүй эрсдэлээс үүдэлтэйгээр төлөвлөсөн зардал их хэмжээгээр нэмэгдэх магадлалтай.

Энэ төрлийн эрсдэлүүд тохиолдох магадлалыг бууруулах зорилгоор Үнэт цаас гаргагч нь бизнесийн тогтвортой өсөлтийг бий болгох, үйл ажиллагаа болон байгаль орчин, нийгэм, засаглалын оновчтой бодлогоор эрсдэлийг хянаж бууруулах замаар санхүүжилтийн өртгийг боломжит бага түвшинд барьж, баталсан төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

## Борлуулалтын орлогын төсөөлөл биелэхгүй байх эрсдэл

Борлуулалтын орлогын төсөөлөл биелэхгүй байх эрсдэлд эдийн засгийн нөхцөл байдал муудах, зах зээлд Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүн гарч ирэх, өрсөлдөгч нэмэгдэх, хэрэглэгчдийн итгэлийг алдах зэрэг хүчин зүйлстэй холбоотойгоор борлуулалтын төсөөлөл биелэхгүй байх эрсдэл хамаарна.

Үнэт цаас гаргагч нь зах зээлд байр сууриа бэхжүүлж, түншүүд болон харилцагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ чанартай бөгөөд хамгийн боломжийн үнээр таниулж чадсан ба өнгөрсөн хугацааны түүхэн мэдээллээс борлуулалтын хэмжээ хурдацтай нэмэгдэж буй нь энэ төрлийн эрсдэлийн нөлөөллийг бууруулах томоохон хүчин зүйлс болж байна. Үнэт цаас гаргагч нь олон улсын чанарын стандартын дагуу бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байгаа нь чанарын шаардлага хангаагүйгээс харилцагчид, хэрэглэгчдийн итгэл алдах аливаа эрсдэл үүсэхээс сэргийлэхэд ихээхэн түлхэц үзүүлж байна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлага ба эрсдэлийн удирдлагын багууд хамтран улирал бүр санхүүгийн үр дүн, гол харьцаа үзүүлэлтүүдийг хянаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилладаг.

СЗХ 2024.04.29 он сар өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### 8.1.3. Үйл ажиллагааны эрсдэл

#### Нэр хүндийн эрсдэл

Үнэт цаас гаргагч нь нэр хүндийн эрсдэлийг үндсэн үйл ажиллагааны бус эрсдэлийн түвшинд авч үздэг боловч учирч болзошгүй эрсдэлүүдэд заавал тооцдог. Нэр хүндийн эрсдэлд хэрэглэгчийн сэтгэл ханамж буурах, үнэт цаас гаргагчийн нэр хүнд унах, худал болон гүтгэлийн шинжтэй сөрөг мэдээлэл олон нийтийн сүлжээ болон мэдээллийн сувгуудаар олон нийтэд хүрэх, бүтээгдэхүүн үйлчилгээнд хэрэглэгчид итгэлгүй болох эрсдэлүүд хамаарна.

Үнэт цаас гаргагч нь дараах эрсдэлүүдийг нэр хүндийн эрсдэлд хамаарна гэж тодорхойлсон. Үүнд:

- Үл тохирлоос үүдэлтэй сөрөг мэдээлэл гарах;
- Худал гүтгэлгийн шинжтэй мэдээлэл олон нийтэд тархах;
- Үйлчилгээний чанараас үүдэлтэй сөрөг мэдээлэл гарах.

Үнэт цаас гаргагч нь бизнесийн ёс зүйн дүрэм стандартыг мөрдөн ажилладаг бөгөөд байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээ, ажилтнуудын харилцаа, хандлагаас үүдэн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болохуйц аливаа эрсдэл, худал гүтгэлгийн шинжтэй сөрөг мэдээлэл зэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган ажилладаг. Байгууллагын ил тод байдал нь зөвхөн байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлээд зогсохгүй цаашлаад компанийн үндсэн үйл ажиллагааг олон нийтийн зүгээс үнэн зөв, бодитой үнэлж цэгнэх боломжийг бүрдүүлж, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг. Үнэт цаас гаргагч нь нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Харилцагчид болон хэрэглэгчдийн гомдол саналыг нээлттэй хүлээн авах, шийдвэрлэх, төлбөрийг нөхөн барагдуулах, цаашлаад холбогдох асуудал үүсэх магадлалыг бууруулахтай холбоотойгоор түгээлтийн алба болон борлуулалтын албадаас цаг тухай бүрд нь шийдвэрлэх арга хэмжээг авч хэлэлцэх;
- Худал мэдээлэлтэй холбоотой компанийн маркетингийн албанаас тухай бүр тодруулга, санал зөвлөмжийг авч шийдвэрлэх;
- Чанарын албатай холбогдон бүтээгдэхүүний чанараас үүдэлтэй эсэхийг шалгах, шуурхай шийдвэрлэх зэрэг арга хэмжээг авч ажилладаг.

#### Нийлүүлэлтийн эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, материалын ханган нийлүүлэлтийн үйл явцад тасалдал гарах, гүйцэтгэл хангалтгүй байх, улмаар харилцагчдадаа өөрийн бүтээгдэхүүнийг тогтвортой хүргэх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг удирдах, бууруулах хэрэгцээ шаардлага үүсдэг. Энэхүү шаардлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг. Түүнчлэн, бэлтгэн нийлүүлэгчидтэй харилцах харилцааг тодорхойлж, нийлүүлэлтийн тасалдал, гүйцэтгэлд хяналт, үнэлгээ хийх, ханган нийлүүлэгчдэд тавигдах шаардлагуудыг тодорхойлох гэх мэт асуудлуудыг зохицуулах дотоод журмыг боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөн ажиллаж байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР

СЗХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ-03

## Хүний нөөцийн эрсдэл

Хүний нөөцийн эрсдэл нь ажилтан байгууллагын соёл, засаглал, хүний нөөцийн зохион байгуулалт, ажилтнуудын ур чадвар, хариуцлага зэрэг хүчин зүйлсээс хамааран бизнесийн орчинд тодорхой бус байдал үүсгэж компанийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх ур дагавартай. Хүний нөөцийн эрсдэлд дараах эрсдэлийн хүчин зүйлс хамаарна. Үүнд:

- Нарийн мэргэжлүүдэд тохирох ажилтнуудын олдоц муу байх (инженер, механик инженер гэх мэт);
- Ажилтнуудын сэтгэл ханамж муу байх;
- Ажилтнуудын ажлаас гаралт нэмэгдэх (хүний нөөцийн эргэц өндөр байх);
- Ёс зүйн зөрчил, доголдол үүсэх;
- Ажилтнуудын ур чадварын дутагдал, сургалт хөгжлийн хоцрогдол;
- Ажилтны тухай зөрүүтэй хувийн мэдээлэл зэрэг хүчин зүйлс багтдаг.

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Байгууллагаас залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хянах, тасралтгүй хэрэгжүүлж ажиллах;
- Сонгон шалгаруулалтын сувгаа тэлэх;
- Ажилтнуудад чиглэсэн идэвхжүүлэлт, сургалт болон олон нийтийн арга хэмжээний хөтөлбөрийг шинэлэг болгох, тус хөтөлбөрүүдэд ажилчдын санал хүсэлтийг тусгах;
- Ажлаас гаралтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох;
- Ажил мэргэжлийн онцлогт тохирсон зан төлөвийн болон мэргэжлийн шалгалтыг авах зэрэг арга хэмжээ байна.

## Үйлдвэрлэлийн эрсдэл

Үйлдвэрлэлийн эрсдэлд урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас бизнес төлөвлөгөөнд тусгасан зардал хэтрэх, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, сул зогсолт болон хэрэгцээт түүхий эд материал хугацаандаа нийлүүлэгдээгүй байх зэрэг эрсдэлүүд багтдаг. Энэхүү эрсдэл нь түүхий эд, сав баглаа боодлын татан авалт, нийлүүлэлтээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн бэлэн болох бүх процесст хамааралтай.

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн эрсдэлийн тухайд тодорхой үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Үйлдвэрлэлийн эрсдэлийн эх үүсвэрийг тодорхойлох: Үйлдвэрлэлийн үйл явц, процессыг нарийн тодорхойлж, үйлдвэрлэл дэх орц, гарц, түүхий эдийн нөөцийн тухай мэдээллийг цаг тухай бүрд үйлдвэрлэлийн алба болон чанарын албанаас авч мэдээллийг боловсруулдаг.
- Үйлдвэрлэлийн эрсдэлээс үүдэлтэй нөлөөлөлд магадлан шинжилгээ хийх: Үйлдвэрлэлийн албанаас жил бүр үйлдвэрлэлийн процесс дэх эрсдэлийн матриц, симуляцын загварыг ашиглаж дүн шинжилгээ хийдэг.
- Үйлдвэрлэлийн эрсдэлээс үүдэлтэй нөлөөллийг бууруулах: Үйлдвэрлэлийн алба ба ХАБЭА албаны хяналт шалгалтын ур дүнд үндэслэн техник, технологийн шинэчлэл хийх, даатгалын хэлбэрээр эрсдэлийг шилжүүлэх, гэнэтийн өөрчлөлтөд зарцуулах төсвийг тусгах зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL

Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР

Үнэт цаас гаргагч нь олон улсын сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашигладаг ба эдгээр тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүдэн үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй. Иймд, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүдэлтэй эрсдэлийн тухайд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Зөвхөн тухайн тоног төхөөрөмжид зориулж олон улсаас нарийн мэргэжлийн инженерүүдийг ажиллуулдаг ба эдгээр нарийн мэргэжлийн инженерүүдийн мэдлэг, ур чадварыг нутагшуулах зорилготойгоор инженерийн туслах орон тоог бий болгож нарийн мэргэжлийн хүний нөөцийн хомсдолоос сэргийлж байна. Түүнчлэн, тус мэргэжлийн сургалтын тэтгэлэг, дадлагажуулах хөтөлбөр зэргийг хэрэгжүүлснээр гадны инженерээс хараат байдлыг бууруулж, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүдэх эрсдэлийг бууруулахаар зорьж ажиллаж байна;
- Krones AG компанийн албан ёсны төлөөлөгчийн газар нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба Үнэт цаас гаргагч нь нарийн мэргэжлийн инженерийн үйлчилгээ аутсорсингийг тус газраас авч тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүдэх эрсдэлийг бууруулах боломжтой байна.

## Техник технологийн эрсдэл

Техник, технологийн эрсдэлд Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны бүх үе шатлалдаа ашиглаж буй техник, технологи, тоног төхөөрөмж нь харилцагчид болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжгүй болсноос үүдэх эрсдэлүүд хамаардаг. Тус эрсдэлийн сөрөг үр нөлөөлөл нь бүтээгдэхүүний чанар доголдох, хяналт доголдох, аюулгүй ажиллагаа доголдох, үйл ажиллагааны тасралтгүй байдал доголдох зэрэг байдлаар илэрнэ.

Үнэт цаас гаргагч нь техник технологийн эрсдэлийг урьдчилан тодорхойлох, эрсдэлийн түвшнийг үнэлэх, бууруулах арга замаар удирдан ажилладаг. Техник технологийн эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд техник технологи, тээврийн хэрэгслийн үзлэгийг механик инженерээр тогтмол долоо хоногт хоёроос доошгүй удаа хийлгэх, шаардлагатай тохиолдолд тухай бүр хийлгэх, тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд нөөц сэлбэгийн үлдэгдэлтэй байх, нөөцийн үлдэгдлийг байнга хянах тогтолцоонд Үйлдвэрийн алба, Түгээлтийн алба болон Санхүүгийн албатай хамтран төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн ажилтнууд үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжтэй зохистой харьцах, зөв арчилж тордох нөхцөлийг бүрдүүлж, холбогдож журам, зааварчилгаануудыг мөрдүүлэн ажиллаж, тогтмол сургалтаар хангаж байна.

## Дотоод процессын эрсдэл

Дотоод процессын эрсдэлд компанийн дотоод харилцаа, холбоо, дотоод зохион байгуулалт сулрах хүний нөөц, үйл ажиллагааны тодорхойгүй, хяналтгүй байдлаас үүсэх эрсдэл, шаардлагатай дүрмээр зохицуулагдаагүй гэнэтийн эрсдэл, үйлдвэрлэлийн процессын хяналт хангагдаагүйгээс үүсэх үйл ажиллагааны тасралтгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүд ордог.

Үнэт цаас гаргагч нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", компанийн "Дотоод хяналтын журам"-аар дамжуулан байгууллагын үндсэн үйл ажиллагааны хэрэгжилт, хууль, дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилт, зорилтот түвшин төлөвлөгөөний биелэлт болон өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа дах дотоод процессын үйл явцыг хянаж, зохицуулдаг. Мөн үндсэн үйл ажиллагааны шаардлагатай стандарт, зөвшөөрлийн бичиг, үзлэг шинжилгээг жил бүр төлөвлөж, хариуцсан алба хэлтсүүдэд үүрэг болгон хуваарилдаг.

СЗХ 2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-25

### 8.1.4. Хууль эрх зүйн эрсдэл

Хууль эрх зүйн эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа дагаж мөрддөг хууль, эрх зүйн зохицуулалтууд болох Хүнсний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм журамд гэнэтийн өөрчлөлт оруулах зэргээс үүдэх сөрөг үр дагавар бүхий эрсдэлүүдийг хамаарна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжид өөрчлөлт орсны улмаас үйл ажиллагаа тасалдах, дотоод дүрэм, журам болон процесс хууль тогтоомжид нийцэхгүй байх эрсдэл үүсэх магадлалтай.

### 8.1.5. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын эрсдэл

#### Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл

Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлд ажилтан, албан хаагч болон үйлчлүүлэгчид ажлын болон үйлчилгээний байранд хөдөлмөрлөх явцад ажилтны эрүүл мэндэд сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл бий болж болохуйц эрсдэлүүдийг авч үзнэ. Үүнд химийн, физикийн, биологийн, сэтгэл зүйн болон физиологийн эрсдэлүүд хамаарна.

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд "Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, өвчлөлөөс ажилтныг хамгаалах ХАБЭА-ны менежментийг нэвтрүүлэх"-ийг ажил олгогчийн үүрэг болгон хуульчилж өгсний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, холбогдох журам, стандартад заасан шаардлагыг хангасан дотооддоо дагаж мөрдөх журмуудыг батлан эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-ны үр нөлөө бүхий удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхийг зорьж холбогдох ажилтнуудаар хяналт тавих тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна.

Энэхүү ХАБЭА-ны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг дэс дараалалтайгаар зохион байгуулах, нутагшуулах;
- Ажиллагсдын болоод эд материал, үйлдвэрийн бүсэд байгаа оршин суугчдын болон үйл ажиллагааны хүрээнд байгаль орчинд учирч болзошгүй аюул осол, эрсдэл ачааллыг танин мэдэж, дүн шинжилгээ хийх;
- Мэдэгдэж байгаа аюул эрсдэлийг хамгаалалтын арга хэмжээний тусламжтайгаар зайлуулах болон бууруулах;
- Галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг тогтмол гаргуулах болон эд хөрөнгийн иж бүрэн даатгалд хамруулах зэрэг арга хэмжээ байна.

Үнэт цаас гаргагч нь компанийн бүхий л үйл ажиллагаанд ХАБЭА-г тогтмол сайжруулах, ХАБЭА-н удирдлага ба хяналтыг нэмэгдүүлснээр ажиллагсдын осол өвчлөлөөс үүдэлтэй цаг хугацааны алдагдал буурч, эд материалын хүрэлцээ хүртээмж дээшилж, улмаар үйлдвэрлэлийн болоод үйл ажиллагааны саатал багасна гэж төлөвлөж байна.


Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### Эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын эрсдэл

Эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын эрсдэлд түүхий эд материал худалдан авах, хадгалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалтын явцад бүтээгдэхүүний чанарын байдалд үүсэж болзошгүй аюултай нөхцөл байдлуудаас үүдэх эрсдэлүүд хамаарна. Эрсдэлийг физикийн, химийн, микробиологийн бохирдол, харшлын эрсдэл гэж ангилна.

Үнэт цаас гаргагч нь савласан цэвэр ус үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн хувьд нэн тэргүүний харах эрсдэл бол хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл юм. Үнэт цаас гаргагч нь дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг. Үүнд:

- Бүтээгдэхүүний чанарыг тогтмол барих, чанарын давтан шинжилгээг хийж, баталгаажуулж байх;
- Бүтээгдэхүүнд гадны биетээр бохирдох эрсдэл гарахаас сэргийлэн харилцагчдад хадгалалт болон тээвэрлэлтийн нөхцөл шаардлагыг таниулах мэдээлэл, сургалтыг тогтмол хийж байх;
- Бүтээгдэхүүний стандартын горим алдагдахаас сэргийлэн чанарын албаны ажилчдыг сургах, дадлагажуулах, хяналтыг сайжруулах зэрэг хэмжээ байна.

## 8.2. Эрсдэлийн удирдлага

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу Компанид учирж болзошгүй эрсдэлийг дор дурдсан үе шаттайгаар системтэйгээр удирдан хянаж байна.

**Схем 15. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын процессын зураглал**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлагын журам"*

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд удирдлагын ерөнхий хяналтыг, Гүйцэтгэх удирдлага, удирдлагын баг үндсэн хяналтыг, тусгай хяналтыг Эрсдэлийн удирдлагын баг (цаашид "Эрсдэлийн удирдлагын баг" гэх) буюу тусгай бүтэц хэрэгжүүлдэг. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага, хяналт нь дээрээс доош, гүйцэтгэл тайлагнал нь доороос дээш буюу дор дурдсан бүтэцтэй байна.

**Схем 16. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо**

Эрсдэлийн удирдлагын баг → Гүйцэтгэх захирал, Удирдлагын баг → ТУЗ

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлагын журам", Компанийн дүрэм*

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах хүрээнд үр ашигтай системийг Компанид бий болгож төлөвшүүлэх, хяналт тавих чиглэлээр тусгай бүтэц ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын баг нь эрсдэлийн үнэлгээг бие даан хийх, эрсдэлийн удирдлагын өдөр тутмын байдалд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эрсдэлийн удирдлагын хяналтын чиглэлээр компанийн бүх алба нэгжүүдэд шаардлага тавих, зөвлөмж өгөх, энэ талаар удирдлагын багт тайлан мэдээлэл танилцуулах чиглэлээр ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын баг нь эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн зэрэглэлээс хамааран улирал тутам, хагас жил тутам, жилд нэг удаа тус тус гүйцэтгэдэг.

## 8.3. Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн үнэлгээ хийх нь эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн үндсэн арга хэлбэр бөгөөд Үнэт цаас гаргагч нь Компанид үүсэж болох эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг төрөлжүүлэн ангилсны үндсэн дээр эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн арга зүйд суурилж хийдэг. Эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэхдээ эдийн засаг, санхүү, эрх зүй, зах зээл, бизнесийн орчин болон компанийн түүхэн мэдээлэл, эх сурвалжуудыг судалж, харгалзах нөлөөлөлтэй нь холбож дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тус бүрээр нь ангилж 9 алхмаар үнэлгээ хийн дүгнэлт гаргадаг. Эрсдэлийн хүчин зүйлсийн болзошгүй нөлөөнөөс үүсэх үр дагавруудыг урьдчилан тооцоолж үр дүнд нь дараах индексүүдийг боловсруулдаг. Үүнд:

- Магадлалын индекс буюу тухайн эрсдэл үүсэх тохиолдлын магадлалыг тооцоолж, ангилах;
- Үр дагаврын индекс буюу тухайн эрсдэлийн сөрөг нөлөөлөл хэдий хугацаанд, ямар хэмжээгээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг тодорхойлон, ангилах.

**Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн тоон үнэлгээний матриц**

| | | Магадлал | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Эрсдэлийн түвшин | | 1 Ховор | 2 Магадгүй | 3 Боломжтой | 4 Өндөр | 5 Байнга |
| | | Жилд 1 удаа тохиох нь ховор | Жилд 1 удаа тохиох магадлал ховор | Жилд 1 удаа тохиох магадлалтай | Жилд заавал 1 удаа тохиох | Жилд заавал 1-ээс дээш удаа тохиох |
| Нөлөөлөл | 1 Ач холбогдолгүй | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | 2 Бага | 2 | 4 | 6 | 8 | 10 |
| | 3 Дунд | 3 | 6 | 9 | 12 | 15 |
| | 4 Өндөр | 4 | 8 | 12 | 16 | 20 |
| | 5 Аюултай | 5 | 10 | 15 | 20 | 25 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлагын журам"*

Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн хариу арга хэмжээний тайлбар

| Эрсдэлгүй | Хүлээн зөвшөөрөх | Эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй |
|---|---|---|---|
| Эрсдэлийг хүлээн зөвшөөрч болно | Эрсдэлийг хяналттайгаар хүлээн зөвшөөрч болно | Эрсдэлийг удирдаж, хяналтыг алдаж болохгүй | Эрсдэлийг зайлшгүй өргөн хүрээнд нэн тэргүүнд удирдах |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлагын журам"*

Үнэт цаас гаргагчийн тодорхойлсон 5 бүлгийн 17 эрсдэлд Эрсдэлийн удирдлагын журамд заасан эрсдэлийн матрицын дагуу шинжилгээ гүйцэтгэхэд нийт эрсдэлийн зүйлсийг дараах байдлаар ангилж байна. Үүнд:

- Маш өндөр эрсдэлтэй – 2 эрсдэлийн зүйлс;
- Өндөр эрсдэлтэй - 6 эрсдэлийн зүйлс;
- Дунд эрсдэлтэй - 5 эрсдэлийн зүйлс;
- Бага эрсдэлтэй- 4 эрсдэлийн зүйлс байна.

Үр дагаврын болон магадлалын индексүүдийг ашиглаж эрсдэлийн хүчин зүйлс бүрийг матрицад байршуулж эрсдэлийн матрицыг боловсруулдаг. Тухайн эрсдэлийн тохиолдох магадлал, үр нөлөөллийг харгалзуулснаар эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тодорхойлж, дундаас дээш түвшний эрсдэлд эрсдэл бууруулах төлөвлөгөөг боловсруулж батлуулан хариуцах удирдлага, хороод, алба нэгж, ажилтнаар дамжуулан хэрэгжүүлдэг.

### 8.4. Үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйлс

Үнэт цаасыг худалдан авч эзэмшихээр төлөвлөж буй хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг худалдан авч эзэмшихтэй холбоотой үүсэж болох эрсдэлийн хүчин зүйлсийг энэ хэсэгт тусгав. Хөрөнгө оруулагч нь Үнэт цаас худалдан авч эзэмшихийн өмнө Үнэт цаас гаргагчтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсээс гадна дараах эрсдэлийн хүчин зүйлстэй танилцсан байвал зохистой. Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчийг Үнэт цаас худалдан авч эзэмшихийн өмнөх шийдвэрээ гаргахад нь болзошгүй эрсдэлийн хүчин зүйлсийн талаар зөвхөн зөвлөмж хэлбэрээр сануулах, мэдээлэл хүргэх байдлаар тусгасан болохыг анхаарна уу.

Үнэт цаас эзэмшихтэй холбоотой үүсэж болох эрсдэлийн хүчин зүйлсийг дурдсан явдал нь тэдгээр эрсдэлүүд одоо болон ирээдүйд бүгд учирч тохиолдоно гэсэн утга агуулгыг илэрхийлээгүй, зөвхөн магадлал таамаглал болохыг дурдаж байна. Энэ бүлэгт тусгагдсан, эсхүл урьдчилан таамаглагдаагүй эрсдэл үүсэх, бий болох тохиолдолд хувьцааны үнэ буурч, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа бүхэлд нь эсхүл зарим хэсгийг алдаж болзошгүйг үгүйсгэхгүй бөгөөд Андеррайтерууд болон Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн хүчин зүйлсийг үүсгэхгүй байх талаар аливаа баталгааг гаргаагүй болно.

Мөн энэ хэсэгт тусгагдсан эрсдэлийн хүчин зүйлс нь Үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулалт хийж, Үнэт цаас эзэмшихтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчдад тулгарч болох бүхий л эрсдэлийн хүчин зүйлсийг дурдаж хамруулаагүй байж болох ба дурдагдсан эрсдэлийн хүчин зүйлсийн хувьд тэдгээрт хамааралтай агуулга бүрд бүрэн хэмжээний тайлбар өгөөгүй байж болно.

Хөрөнгө оруулагчид энэхүү Үнэт цаасны танилцуулгад агуулагдсан мэдээлэл, бусад шаардлагатай баримт материал болон өөрийн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан Үнэт цаасанд хөрөнгө оруулах эсэх шийдвэрээ сайтар судалж гаргах нь зүйтэй гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

## Хувьцааны хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн бүр эрсдэлтэй байх ба хувьцааны хувьд үнийн хэлбэлзэл байна. Үнэт цаас гаргагч нь нээлттэй зах зээл дээрх үнийн амлалт, баталгаа гаргах боломжгүй бөгөөд хувьцааны эрэлт, нийлүүлэлт болон зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан хувьцааны зах зээлийн үнэ тогтоно. Мөн компанийн үйл ажиллагаа, цаашдын хэтийн төлөвтэй холбоотойгоор олон нийтэд цацагдах эерэг болон сөрөг мэдээллээс шалтгаалж хувьцааны үнэ өсөх, буурахад нөлөөлдөг.

## Хөрвөх чадварын эрсдэл

Хувьцааны эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалж хувьцааны арилжааны идэвх хамаардаг. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагчаас арилжааны идэвхийн талаар баталгаа гаргах боломжгүй тул Хөрөнгө оруулагч их хэмжээний арилжаа хийсэн тохиолдолд тухайн үеийн арилжааны идэвхтэй холбоотойгоор хүссэн хэмжээгээр, эсхүл хүссэн үнэ ханшаар худалдах, худалдан авах боломжгүй байх магадлалтай.

## Ногдол ашигтай холбоотой эрсдэл

Үнэт цаасны ногдол ашигтай холбоотой шийдвэрийг ТУЗ-өөс гаргаж, ХЭХ-аар батлах бөгөөд ирээдүйд ногдол ашиг тараахгүй байх, хөрөнгө оруулагчийн хүлээлтээс бага дүнгээр ногдол ашиг тараах зэрэг эрсдэлүүдтэй хөрөнгө оруулагчид тулгарах боломжтой.

СЗХ
2024 04 29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖИЖ БУЙ БОДЛОГО, ЖУРМУУД

9

СЗХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ № 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

# 9. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хэрэгжиж буй бодлогууд

## 9.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Усны тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг дагаж мөрдөн ажиллаж байна.

## 9.2. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм журам

Үнэт цаас гаргагч нь чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гарт хүргэхийн тулд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дотоод дүрэм журмыг боловсруулснаар үйлдвэрлэлийн бүх үе шатанд аюулгүй байдал, эрүүл ахуй, чанарын хяналт тавих бүрэн бололцоог бүрдүүлжээ. Үнэт цаас гаргагч нь батлагдсан технологийн зааврын дагуу, Монгол Улсын савласан цэвэр усны стандарт, шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд үйлдвэрлэн гаргахад дараах дотоод дүрэм, журам, заавурыг баримталж байна. Үүнд:

- Ариутгал цэвэрлэгээний дүрэм;
- Ариутгал цэвэрлэгээний заавар;
- Шавж устгалын хяналтын заавар;
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх журам;
- Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрэм;
- Химийн бодис хадгалах, ашиглах, устгах журам;
- Үйлдвэрлэлийн процесс;
- Дотоод хяналтын журам;
- Агуулахад поддон ашиглах, тавиур дээр ус өрөхөд анхаарах зүйл, аюулгүй ажиллагааны журам;
- Онцгой нөхцөлд хүнсний аюулгүй байдлыг хангах журам;
- Цэвэр ус үйлдвэрлэх технологийн заавар;
- Коронавирусын халдвараас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журам;
- Борлуулалтын зохицуулалтын журам.

Үнэт цаас гаргагчийн мөрдөж буй дээрх дүрэм, журам, заавар, төлөвлөгөө нь холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн тухай Хуулийн зөвлөх компани нь Хуулийн дүгнэлтдээ тусгасан байна. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмуудтай холбоотой дэлгэрэнгүй дүгнэлтийг Хуулийн дүгнэлтээс үзнэ үү. (Хуулийн дүгнэлтийн 24 хуудас, 3.2 дэх хэсэг)



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 .04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

## 9.3. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааныхаа онцлог, хүрээнд хамааралтай дараах тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна.



УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар 02/2015

20 15 оны 02-р сарын 09-ны өдөр

**Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр:**
Ус ашиглах эрхийн бичиг

**Олгосон байгууллага:**
Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газар

**Олгосон огноо:** 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдөр

**Хүчинтэй хугацаа:** 3 жил

Усны тухай хуулийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагаас хоногт ашиглах усны шоо метрээс хамаарч эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргуулан холбогдох байгууллагаас ус ашиглах зөвшөөрөл авахаар заасан байна.

Үүний дагуу Үнэт цаас гаргагч нь Усны газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн дугаар 78 "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг, Нийслэлийн байгаль орчин, ногоон хөгжлийн газрын даргаас 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 02/2015 тоот "Ус ашиглах эрхийн бичиг" авсан бөгөөд уг эрхийн бичигт Сонгино-хайрхан дүүргийн 7-р хороонд байршилтай усны нөөцөөс хоногт 73.82 м3 шоо метр ус ашиглах зөвшөөрөл олгогдсон байна. Зөвшөөрлийн хугацаа нь 3 жил тутамд сунгагдахаар заагдсан бөгөөд үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл хүчинтэй байна.



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 23/17

УСНЫ ГАЗАР

Улаанбаатар ... Сонгинохайрхан

40-р хороо, баруун салаа 19-04 тоот

Цэвэр усны үйлдвэрлэлийн

"ЭМ ЖИ ЭЛ АКУА" ХК

Улаанбаатар ... Сонгинохайрхан

40-р Хороонд

59.9

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

Д.НЯМДОРЖ

Тамга

2023 оны 09-р сарын 29-ны өдөр

**Зөвшөөрөл, сертификат, стандартын нэр:**
Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл

**Олгосон байгууллага:**
Туул голын сав газрын захиргааны дарга

**Олгосон огноо:** 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр

**Хүчинтэй хугацаа:** 1 жил

Үнэт цаас гаргагч нь Туул голын сав газрын захиргааны даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр олгосон 23/17 дугаартай Зөвшөөрлийн бичгийн дагуу Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авсан байна. Тус зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгасанд тооцохоор заасан. Зөвшөөрөл нь Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар 2024 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр хүртэл хүчинтэй байна.

СЗХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## 9.4. Оюуны өмчийн эрх

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой дараах барааны тэмдгийн эрхийг эзэмшиж байна.




**Анхдагч огноо:** 2012.03.21

**Гэрчилгээ олгосон огноо:** 2012.09.25

**Хүчинтэй байх хугацаа:** 2032.03.21

Үнэт цаас гаргагч нь 2012 оны 03 сарын 21-ний өдөр барааны тэмдэгийг бүртгүүлэх хүсэлт, мэдүүлгийг гаргаж, Монгол Улсын Шадар Сайдын 2012 оны 18 дугаартай тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч 40-0010129 тоот барааны тэмдгийн гэрчилгээ олгосон байна.




**Анхдагч огноо:** 2012.03.21

**Гэрчилгээ олгосон огноо:** 2012.09.25

**Хүчинтэй байх хугацаа:** 2032.03.21

Үнэт цаас гаргагч нь 2012 оны 03 сарын 21-ний өдөр барааны тэмдэгийг бүртгүүлэх хүсэлт, мэдүүлгийг гаргаж, Монгол Улсын Шадар Сайдын 2012 оны 18 дугаартай тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч 40-0010128 тоот барааны тэмдгийн гэрчилгээ олгосон байна.




**Анхдагч огноо:** 2012.03.21

**Гэрчилгээ олгосон огноо:** 2012.09.25

**Хүчинтэй байх хугацаа:** 2032.03.21

Үнэт цаас гаргагч нь 2012 оны 03 сарын 21-ний өдөр барааны тэмдэгийг бүртгүүлэх хүсэлт, мэдүүгийг гаргаж, Монгол Улсын Шадар Сайдын 2012 оны 18 дугаартай тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч 40-0010127 тоот барааны тэмдгийн гэрчилгээ олгосон байна.




**Анхдагч огноо:** 2018.04.27

**Гэрчилгээ олгосон огноо:** 2018.11.23

**Хүчинтэй байх хугацаа:** 2028.04.27

Үнэт цаас гаргагч нь уг барааны тэмдэгийг бүртгүүлэх тухай хүсэлт, мэдүүлгийг 2018 оны 04 сарын 27-ны өдөр Монгол Улсын Оюуны өмчийн газарт гаргаж, Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2018 оны 11 сарын 23-ны өдрийн А/51 тоот тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч 40-0019158 тоот барааны тэмдгийн гэрчилгээ олгосон байна. Энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар уг барааны тэмдэгийг Үнэт цаас гаргагч эзэмшдэг, 2028 оны 04 сарын 27-ны өдөр хүртэл хүчинтэй байна.

СЗХ 2024.04.29 БҮРТГЭВ №11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ

## 9.5. Гэрээ хэлцэл

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан гэрээнд хийсэн хуулийн зөвлөхийн дүгнэлтийг хураангуйлан тусгалаа.

### 9.5.1. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.7 дах хэсэг болон МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.3.7 дахь хэсэгт заасны дагуу үнэт цаас гаргагч үнэт цаасаа бүртгүүлэхдээ хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээллийг үнэт цаасны танилцуулгадаа тусгасан байх шаардлагатай байдаг.

Энэхүү танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 600,000,000 (зургаан зуун сая) төгрөг бөгөөд түүний 5 хувь нь 30,000,000 (гучин сая) төгрөг байна. Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 151 гэрээ байгуулсан, эдгээрээс 51 гэрээ хэрэгжиж байгаагаас 27 нь гэрээний төлбөрийн үлдэгдэлтэй байна. Эдгээр гэрээнүүдийн хэрэгжилттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн өр төлбөр, бусад үүргийн зөрчилтэй холбоотой аливаа шаардах эрх үүсээгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлээгүй шүүх болон арбитрт нэхэмжлэл, шаардлага гараагүй, иргэний хэрэг үүсээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлээгүй, хэвийн хэрэгжиж байна гэж Үнэт цаас гаргагчийн Хуулийн зөвлөх компани нь Хуулийн дүгнэлтдээ тусгаж дүгнэсэн байна. Тус гэрээ хэлцлүүдтэй холбоотой дэлгэрэнгүй дүгнэлтийг Хуулийн дүгнэлтээс үзнэ үү. (Хуулийн дүгнэлтийн 51 хуудас, 4.4 дэх хэсэг)

### 9.5.2. Их хэмжээний хэлцэл

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх хэсэгт "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87.1.2 дах хэсэгт "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор хуульчилсан. Компанийн тухай хуульд тодорхойлогдсон их хэмжээний хэлцэлд тооцогдох өндөр үнийн дүн бүхий гэрээг байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд томоохон ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг тул Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 88 дугаар зүйлийн 88.1-т зааснаар төлөөлөн удирдах зөвлөлгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаас их хэмжээний хэлцэл хийх шийдвэр гардаг. Хуулийн дүгнэлтийг үндэслэвэл Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилд их хэмжээний гэрээ хэлцэлд тооцогдох нийт 5 хэлцэл байгуулсан байна.

Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилд байгуулсан дээрх гэрээ хэлцлүүд нь ХЭХ-аас олгосон зохих шийдвэрийн үндсэн дээр байгуулагдсан, хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл гэж дүгнэжээ. Эдгээр их хэмжээний гэрээ, хэлцлийн талаарх дүгнэлтийг Хуулийн дүгнэлтээс үзнэ үү. (Хуулийн дүгнэлтийн 54 хуудас, 5.1 дэх хэсэг)

"Эм Жи Эл Аква ХХК" MGL AQUA Co.,Ltd

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescor

### 9.5.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг байгуулах журмын харилцааг зохицуулсан бөгөөд Хуулийн зөвлөхийн боловсруулсан хуулийн дүгнэлтийг үндэслэвэл Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн дагуу сонирхлын зөрчилтэй гэж тооцогдох нийт 10 хэлцэл байгуулсан байна. Хуулийн зөвлөх нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг Компанийн тухай хуулийн 59 дүгээх зүйлийн 59.2, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасныг баримтлан баталсан, хүчин төгөлдөр хэлцэл гэж дүгнэсэн байна. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх дүгнэлтийг Хуулийн дүгнэлтээс үзнэ үү. (Хуулийн дүгнэлтийн 55 хуудас, 5.2 дах хэсэг)

## 9.6 Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас нийтэд санал болгон гаргасны дараа дагаж мөрдөх дүрэм, журам

Үнэт цаас гаргагч нь компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, сайн туршлагыг нэвтрүүлэх, компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хяналтын арга замыг тогтоох, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, компанийн оролцогч талуудын харилцааг зохицуулах, зохистой засаглалыг бий болгох зорилгоор дараах дүрэм, журмын төслийг боловсруулсан. байна. Үүнд:

- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн ТУЗ-ын үйл ажиллагааны журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Ёс зүйн дүрэм;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Ногдол ашиг хуваарилах журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурал хуралдуулах журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Цалин урамшууллын бодлого;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Залгамж халааны бодлогын баримт бичиг;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн хөндлөнгийн аудит томилох журам;
- "Эм Жи Эл Акуа" ХК-ийн Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам.

Дээрх журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 23/12/3 тоот тогтоолоор журмуудын төслийн агуулгыг сайшаасан бөгөөд Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нийтэд санал болгон амжилттай гаргасны дараа ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлахаар төлөвлөж байна. Журмын төслийг Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхтэй хамтран боловсруулсан бөгөөд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулсан гэж мэдэгдсэн болно. (Хуулийн дүгнэлтийн 36 хуудас, 3.3.3 дах хэсэг)

СЗХ
2024 он 04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

MGL aqua

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

10

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ

# 10. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

## 10.1. Нягтлан бодох бүртгэлийн стандарт баримтлал

Үнэт цаас гаргагчийн 2018, 2019, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг "СМД Аудит" ХХК-аар, 2020 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл, 2021, 2022 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 2023 оны 6-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон хагас жилийн санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитыг "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК-аар тус тус гүйцэтгүүлсэн байна.

Дээрх аудитын компаниуд нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудыг нягталж, хараат бус аудиторын дүгнэлт гаргах ажлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу гүйцэтгэсэн байна.

Үнэт цаас гаргагчийн удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, тайлант оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаарх дуусгавар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг НББОУС 34, Сангийн Яамнаас баталсан аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу тайлагнах үүрэгтэй ба санхүүгийн тайлангууд нь стандартын дагуу бэлтгэгдсэн байна. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн гүйцэтгэх удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Дотоод хяналтыг үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж ажиллуулах;
- Компанийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, тодорхой хугацааг хамарсан байдлаар тайлагнаж, нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах;
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх;
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Залилангийн асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх.

## 10.2. Орлого, үр дүнгийн тайлангийн шинжилгээ

**Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан, сая төгрөг, 2018-2023 оны 6-р сарын 30**

| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 6,621.34 | 9,541.47 | 8,301.51 | 20,894.69 | 33,351.22 | 9,754.47 |
| Борлуулалтын өртөг | 4,347.45 | 6,148.51 | 5,540.94 | 12,483.78 | 20,331.68 | 5,114.55 |
| Нийт ашиг ( алдагдал) | 2,273.89 | 3,392.95 | 2,760.57 | 8,410.91 | 13,019.55 | 4,639.92 |
| Хүүгийн орлого | - | 5.37 | 3.96 | - | - | 0.27 |
| Бусад орлого | 11.96 | 3.65 | 114.93 | 31.35 | - | - |
| Борлуулалт маркетингийн зардал | 6.29 | 44.44 | 19.58 | 38.00 | 18.27 | 330.79 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,592.69 | 2,007.53 | 1,938.10 | 2,459.53 | 7,228.77 | 1,806.84 |
| Санхүүгийн зардал | - | - | - | 208.76 | 274.25 | 542.16 |
| Бусад зардал | 34.62 | 105.28 | 34.42 | 111.88 | 59.04 | 377.11 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз) | 0.44 | 23.88 | (1.13) | (4.75) | 422.45 | 0.99 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз) | - | - | 257.83 | (7.46) | - | (0.18) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - | - | - | - | (37.16) |
| Бусад ашиг, алдагдал | - | - | - | - | - | (137.77) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 652.70 | 1,268.60 | 1,144.06 | 5,611.89 | 5,861.67 | 1,408.87 |
| Орлогын татварын зардал | 67.05 | 131.78 | 91.76 | 547.78 | 599.00 | 196.11 |
| Татварын дараах ашиг (алдагдал) | 585.64 | 1,136.81 | 1,052.29 | 5,064.11 | 5,262.67 | 1,212.75 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

## Борлуулалтын орлого

**График 3. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, сая төгрөг, 2018-2023 оны 6-р сарын 30**




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2018 онд 6,621 сая төгрөг байсан бөгөөд 5 жилийн хугацаанд нийт 403.7 хувийн, жилийн 49.8 хувийн нийлмэл дундаж өсөлтийг үзүүлж 2022 онд 33,351 сая төгрөгт хүрсэн байна. Үнэт цаас гаргагчийн 2020 оноос 2022 оны хугацааны борлуулалтын орлого нь савласан цэвэр ус, түүхий эд материал болон үзүүлсэн үйлчилгээний орлогоос бүрдсэн. Үнэт цаас гаргагчийн түүхий эд материал борлуулалтын орлого нь нэг удаагийн шинж чанартай байсан бөгөөд үндсэн бизнес хэлбэрээр цаашид үргэлжлэхгүй. Тиймээс Үнэт цаас гаргагч нь 2023 оноос хойш бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох савласан цэвэр усны чиглэлээр дагнан ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн 2021 оны нийт борлуулалтын орлогын 47.7 хувийг, 2022 оны нийт борлуулалтын орлогын 55.4 хувийг савласан цэвэр усны борлуулалт эзэлж байна. 2022 онд савласан цэвэр усны борлуулалт нь 2021 оноос 85.2 хувиар, 2023 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсөж 9,364 сая төгрөгт хүрсэн байна. Дээрх түүхэн үзүүлэлтээс харахад савласан цэвэр усны борлуулалт хурдацтай өсөж байгааг илэрхийлж байна.

Үнэт цаас гаргагчийн түүхэн борлуулалтын өсөлтөд нөлөөлөгч гол хүчин зүйлс нь шинэ бүтээгдэхүүнүүд болох 330 мг, 200 мг, 800 мг савлагаатай цэвэр усыг 2018 оноос хойш үе шаттайгаар зах зээлд амжилттай нэвтрүүлсэн, мөн зах зээлд хэдийнээ танигдсан 4.5 литр, 1.5 литр, 500 мл савлагаатай цэвэр усны борлуулалтын хэмжээ нэмэгдсэн явдал юм.

Түүхий эд материалын борлуулалт нь 2020 онд Монгол Улсад КОВИД-19 цар тахлын халдвар эрчимжиж байсан үед Үнэт цаас гаргагч нь борлуулалтын төлөвлөгөөндөө хүрэх, ашигт ажиллагааг хангах болон ажлын байрыг хадгалан бизнесийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхийн тулд түүхий эд материалын үнэ хямдарсан үед импортоор оруулж ирэн борлуулж орлогын нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлснээс үүссэн. Түүнчлэн, эдийн засгийн хүнд нөхцөлд Үнэт цаас гарагч нь бүтээгдэхүүний өртгийн дийлэнх хувийг бүрдүүлдэг мөхлөг, бөглөө ба савны бариулын бэлдэц зэрэг түүхий эдийг урьдчилан нөөцөлсөнтэй холбоотойгоор цар тахлын үеэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тасралтгүй байдлыг хангаж ажилласан. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг бизнесийн хувьд найдвартай түүхий эд нийлүүлэгчтэй байх, түүхий эдийн нөөцийг зохистой түвшинд бүрдүүлэх нь үйлдвэрлэл болон борлуулалтыг тасралтгүй явуулах үндсэн зарчмуудын нэг юм.

Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Invescore

СЗХ 2024.04.29 он сар өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үзүүлсэн үйлчилгээний орлогод Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн газрын тодорхой хэсгийг үйлдвэрлэлийн зориулалтаар түрээслэгч "Санвин" ХХК-д ашиглуулсны төлбөр багтдаг бөгөөд Үнэт цаас гаргагч нь "Санвин" ХХК-иас зарим савлагааны хуванцар хуруу сав, бариул, бөглөөний бэлдэц хэвлэх үйлчилгээг авдаг. 2021 ны 01-р сарын 01-ний өдөр байгуулсан Түрээсийн гэрээний дагуу "Санвин" ХХК нь дараах төлбөрүүдийг Үнэт цаас гаргагчид төлдөг байна. Үүнд, авто зогсоол, халаалт дулаан, цэвэр бохир ус, цахилгаан шат, хог, СӨХ, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын төлбөр зэрэг байна.

Борлуулсан бэлэн бүтээгдэхүүнийг нэр төрлөөр задлан харвал, Үнэт цаас гаргагч нь 2023 оны 06-р сарын 30-ны байдлаар зах зээлд нийт 2 төрлийн, 6 ялгаатай хэмжээний савлагаа бүхий савласан цэвэр усыг борлуулж байна.

**График 4. Борлуулсан бүтээгдэхүүний биет хэмжээ, мянган тонн, нийт биет хэмжээнд эзлэх хувь**
2018-2023 оны 6-р сар




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

2018 оноос 2022 оны хооронд Үнэт цаас гаргагчийн нийт борлуулсан бүтээгдэхүүний биет хэмжээний жилийн дундаж нийлмэл өсөлт 11.7 хувь байсан. 2022 онд 33.9 сая литр савласан цэвэр ус борлуулсан нь 2018 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 55.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэ нь тус хугацаанд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж улмаар үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм. 2023 оны эхний хагас жилийн байдлаар борлуулсан савласан цэвэр усны биет хэмжээ 15.9 мянган тонн байна.

Түүхэн таван жилийн үзүүлэлтийг дундажлаж харвал нийт борлуулсан савласан цэвэр усны биет хэмжээнд том савлагаатай бүтээгдэхүүнүүд 83.3 хувийг, амны цангаа тайлах нэг удаагийн савлагаатай бүтээгдэхүүнүүд 16.7 хувийг бүрдүүлж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар 15.9 мянган тонн савласан цэвэр ус борлуулснаас том савлагаатай бүтээгдэхүүнүүд 82.1 хувийг, амны цангаа тайлах нэг удаагийн савлагаа 17.9 хувийг тус тус эзэлсэн байна.

Түүнчлэн, хүн амын үндны цэвэр усны хэрэглээ нэмэгдэж, хэрэглээний хэв маяг өөрчлөгдөж буйтай холбоотойгоор хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх нь энэхүү зах зээлд өрсөлдөх чадварыг дэмжих давуу талыг бий болгож байна.

СЗХ 2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны борлуулалтын орлого 2018 оноос жилийн дундаж 29.2 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж, 2022 онд 18,463 сая төгрөгт хүрсэн. Түүхэн 5 жилийн үзүүлэлтийг дундажлаж харвал нийт борлуулсан савласан цэвэр усны борлуулалтын орлогын 62.4 хувийг том савлагаатай цэвэр ус, 37.6 хувийг амны цангаа тайлах нэг удаагийн савлагаатай цэвэр ус тус тус бүрдүүлж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар савласан цэвэр усны борлуулалтын орлого 9,364 сая төгрөг байсан ба үүнээс том савлагаатай бүтээгдэхүүнүүд 54.6 хувийг, амны цангаа тайлан нэг удаагийн савлагаа 45.4 хувийг тус тус эзэлсэн байна.

**График 5. Савласан цэвэр усны борлуулалтын орлого савлагаа бүрээр, сая төгрөг, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүний нэр төрлийг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн тогтмол хөгжүүлж ажилладаг. 2023 оноос байгалийн хужраар эрдэсжүүлсэн Ph8.5 шүлтлэг 330 мл болон 500 мл савлагаатай цэвэр усыг зах зээлд нэвтрүүлсэн нь Үнэт цаас гаргагчийн савласан усны зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлсээр байна.

2020 онд КОВИД-19 цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт буурч, Монгол Улсын Их Хурлаас халдварын тархалтыг хязгаарлахаар хөл хорионы дэглэм тогтоосон байсантай холбоотойгоор явган хүний хөл хөдөлгөөнийг үе шаттайгаар хязгаарлах арга хэмжээ хэрэгжсэн. Улмаар савласан цэвэр усны зах зээлийн эрэлт буурсан нь Үнэт цаас гаргагчийн савласан усны борлуулалтын орлого буурахад нөлөөлсөн. Гэсэн хэдий ч Үнэт цаас гаргагчийн Монгол Улсын савласан цэвэр усны зах зээлд эзлэх хувь өсөлттэй гарсан байна.

СЗХ 2024.04.29
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

**График 6. Үнэт цаас гаргагчийн савласан усны зах зээлийн биет хэмжээнд эзлэх хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

### Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогод эзлэх борлуулсан бүтээгдэхүүний өртөг 2018 онд 65.7 хувийг эзэлж байсан бол 2022 онд 61.0 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс Үнэт цаас гаргагч нь борлуулалтын бүтээгдэхүүний өртгийн өсөлтийг зохистой түвшинд барьж, нийт ашгийн ахиуцыг нэмэгдүүлж, орлого зардлын менежментийг оновчтой хэрэгжүүлсэн нь харагдаж байна.

**График 7. Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон нийт борлуулалтад эзлэх хувь, сая төгрөг,**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd

Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртгийг савласан цэвэр ус бүрдүүлдэг байсан бол 2021-2022 онд түүхий эд материалын борлуулсан бүтээгдэхүүний өртөг 60 орчим хувийг бүрдүүлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 92.5 хувийг савласан цэвэр усны өртөг, үлдсэн хувийг түүхий эд материал болон үзүүлсэн үйлчилгээний өртөг тус тус эзэлж байна.

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох савласан цэвэр усны борлуулсан бүтээгдэхүүний өртөг 2018-2020 онуудад нийт борлуулалтын орлогын дунджаар 65 хувийг эзэлж байсан бол 2021-2022 онуудад дунджаар 24 хувь болж буурсан. Борлуулалтын орлогод эзлэх савласан цэвэр усны борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурсан нь түүхий эд материал борлуулсантай холбоотой юм.

**График 8. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба нийт борлуулалтад эзлэх хувь задаргаагаар, сая төгрөг**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Иймд савласан цэвэр усны борлуулсан бүтээгдэхүүний өртгийн савласан цэвэр усны борлуулалтын орлогод эзлэх хувийг дараах графикт харуулав.

**График 9. Савласан цэвэр усны борлуулалтын орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба эзлэх хувь, сая төгрөг,** 2018-2023 оны 6-р сарын 30




***Эх сурвалж:*** *Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Дээрх графикаас харахад савласан цэвэр усны борлуулалтын орлогод эзлэх савласан усны өртөг 2018 онд 65.7 хувийг эзэлж байсан бол тус хэмжээ жил бүр буурч 2022 онд 41.7 хувь болсон байна. Энэхүү үзүүлэлт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 49.8 хувь байна.

Түүхэн үзүүлэлтийг дундажлан харвал савласан усны борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон савласан усны борлуулалтын орлогын харьцаа нь дунджаар 57.5 хувь байгаа бөгөөд гол хэлбэлзлийн хүчин зүйл нь шууд материалын үнийн хэлбэлзэл байна. Үнэт цаас гаргагчийн түүхэн гүйцэтгэлээс үзэхэд борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 77 орчим хувийг шууд материалын зардал буюу түүхий эд материалын болон гүний ус ашиглалтын төлбөр, 23 орчим хувийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал болон шууд хөдөлмөрийн зардал тус тус бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дийлэнх хувийг шууд материалын зардал эзэлдэг бөгөөд гол түүхий эд нь хуванцар хуруу сав, бөглөө, шошго, бариул, баглаа боодол юм. Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд түүхий эд материалыг 180 хоногоор нөөцөлдөг байна.

Шууд материалын тодорхой бүрдэл болох үйлдвэрлэлийн зориулалтаар ус, рашаан нөөц ашигласны төлбөрийг усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ гэх хуулийн зохицуулалтуудыг тус тус үндэслэн ашигласан газрын доорх усны хэмжээнээс шалтгаалан усны шоо метрээр тооцдог байна.

Цэвэр усны савлагаа бүрд ордог түүхий эдийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Үнэт цаас гаргагчийн 4.5 литрийн савлагааг үйлдвэрлэхийн тулд 2018 онд 110 грамм жинтэй хуруу савыг ашигладаг байсан бол хуруу савны жинг үе шаттайгаар хөнгөрүүлж 85 грамм жинтэй хуруу савыг ашиглах болсноор тус зардлыг 30 гаруй хувиар бууруулсан юм. Мөн 1.5 литр савлагааг үйлдвэрлэхийн тулд 36 грамм жинтэй хуруу савыг ашигладаг байсан бол 35.1 грамм жинтэй хуруу саваар орлуулан хуруу савны жинг хөнгөрүүлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь 2023 оноос эхлэн жижиг савлагаанд ашиглагддаг хуруу савны жинг 18 граммаас 17.5 грамм болгон бууруулсан. Энэ байдлаар хуванцар савны жинг хөнгөрүүлэх нь савлагааг хөнгөн болгож зөөж тээвэрлэхэд хялбар болгохоос гадна хуруу савны түүхий эдийг үйлдвэрлэхэд ашигладаг байгалийн нөөцийн ашиглах хэмжээг бууруулж, хөрсөнд задрах хугацааг богиносгон байгаль орчинд ээлтэй байдлыг нэмэгдүүлдэг байна.

Савласан цэвэр усны үндсэн түүхий эд болох хуруу савыг хүнсний зориулалттай PET мөхлөгөөр үйлдвэрлэдэг тул хуруу савны үнэд мөхлөгийн үнийн хэлбэлзэл голлон нөлөөлдөг. 2023 оны эхний хагас жилийн байдлаар хүнсний PET мөхлөгийн зах зээлийн үнэ бүс нутгуудын хувьд хэлбэлзэлтэй байсан. Европ, Африк, Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улсуудад мөхлөгийн үнэ 2023 оны эхэн үеэс 12.1 хувь, 9.6, 11.1 хувиар тус тус багасаж 1 кг мөхлөг 1.24, 1.13, 1.04 ам.доллар болж буурсанд хуванцар хог хаягдлын гадаад худалдааны хатуу бодлого, хуванцар үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн илүүдэл үүссэн нь голлон нөлөөлсөн. АНУ-д мөхлөгийн үнэ 2023 оны эхэн үеэс 3.0 хувиар өсөж 1 кг мөхлөг 1.38 ам.доллар болсон нь АНУ-д цахилгаан хэрэгсэл, өргөн хэрэглээний цахилгаан бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэнтэй холбоотой юм.

БНХАУ-ын хувьд мөхлөгийн үнэ 2023 оны эхний дөрвөн сард 2.7 хувиар өссөн бол зургаадугаар сард 4.5 хувиар буурч 1 кг мөхлөгийн үнэ 1.07 ам.доллар болсон байна.

**График 10. Мөхлөгийн үнэ, бүс нутгаар, ам.доллар/кг, сараар,** 2020-2023 оны 6-р сар, 2023-2024 оны төсөөлөл




***Эх сурвалж:** Business Analytic судалгааны байгууллага*

Хуруу савны үнийн хэлбэлзэл нь хуруу саванд ашиглагддаг PET түүхий эдийн хэмжээ болон түүний зах зээлийн үнэ, ялангуяа БНХАУ-ийн хүнсний зориулалттай PET мөхлөгийн зах зээлийн ханшаас хамаарч хөдөлдөг хандлагатай юм.

СЗХ
2024 он 04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

## Зардлын бүтэц

**График 11. Нийт зардлын бүтэц ба нийт зардалд эзлэх зардлын хувийн жин, сая төгрөг, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

**Хүснэгт 16. Борлуулалтын орлогод эзлэх зардлуудын хувь, 2018-2023 оны 6-р сар**

| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий ба удирдлагын зардал | 24.1% | 21.0% | 23.3% | 11.8% | 21.7% | 18.5% |
| Борлуулалт маркетингийн зардал | 0.1% | 0.5% | 0.2% | 0.2% | 0.1% | 3.4% |
| Санхүүгийн зардал | 0.0% | 0.0% | 0.0% | 1.0% | 0.8% | 5.6% |
| Бусад зардал | 0.5% | 1.1% | 0.4% | 0.5% | 0.2% | 3.9% |
| Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 0.0% | 0.0% | 0.0% | 0.1% | 0.0% | 1.8% |
| Орлогын татварын зардал | 1.0% | 1.4% | 1.1% | 2.6% | 1.8% | 2.0% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртгөөс бусад зардлыг үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус гэж ангилдаг. Үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын зардал болон борлуулалт маркетингийн зардал багтдаг бол үйл ажиллагааны бус зардалд санхүүгийн зардал, бусад зардал, гадаад валютын ханшийн зөрүүний гарз болон орлогын татварын зардал гэсэн зардлууд багтдаг байна.

Үнэт цаас гаргагчийн нийт зардал нь 2018 онд 1,701 сая төгрөг байсан бол 2022 онд борлуулалтын орлогын өсөлттэй уялдан 8,179 сая төгрөг болж өссөн. Үүнээс орлогын албан татварын зардлаас бусад зардлуудын нийлбэр дүнг борлуулалтын орлогод эзлэх хувиар тооцоолбол 2018-2021 оны хооронд 24.7 хувиас 13.5 хувь болж буурсан ба 2022 онд 22.7 хувьтай байна. Энэ нь ерөнхий ба удирдлагын зардал 2021 оноос 4,769 сая төгрөгөөр өсөж 7,229 сая төгрөгт хүрсэн ба Үнэт цаас гаргагч толгой компанид менежментийн зөвлөх үйлчилгээний 3,256 сая төгрөгийг төлсөнтэй холбоотой. Үнэт цаас гаргагч нь "Ти Эм Эл Трейд" ХХК-ийн охин компани бөгөөд толгой компанитай менежментийн гэрээ байгуулж, компанийн стратеги, хөрөнгө оруулалт, санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ, зах зээлийн судалгаа, төслийн эдийн засгийн үндэслэл боловсруулах болон тээвэр, логистикийг хариуцан зохион байгуулах, бүтээгдэхүүний борлуулалт, түүхий эд, бараа материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтээр хангах зэрэг үйлчилгээг толгой компаниас авсан байна. Цаашид Үнэт цаас гаргагч нь менежментийн үйлчилгээг жил бүр тогтмол авах төлөвлөгөөтэй байгаа ба нэлттэй компани болсноор менежментийн төлбөрийн дүнг жилийн 240 сая төгрөг байхаар 2 жилийн хугацаатай гэрээ байгуулсан.

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Ти Эм Эл Трейд" ХХК нь импорт, худалдааны чиглэлээр олон төслүүдийг хэрэгжүүлсэн 10 жилийн туршлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчийн түүхий эд, сэлбэг хэрэгслийг хямд зардлаар, богино хугацаанд, тасралтгүй, найдвартай тээвэрлэхэд шаардлагатай логистикийн үйл ажиллагааг Улаанбаатар, Замын-Үүд, Эрээн хотуудад хүний нөөц бүрдүүлэн зохион байгуулдаг. Үнэт цаас гаргагч нь толгой компаниас түүхий эд материал, сэлбэг хэрэгсэл, тээвэр, гаалийн үйлчилгээг авдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь цаашид толгой компаниас менежментийн үйлчилгээ авснаар үйл ажиллагааны үр ашигт байдлыг сайжруулахаас гадна дээрх ажил үйлчилгээг нэгдсэн менежментээр найдвартай түвшинд зохион байгуулах боломж бүрддэг байна.

Ерөнхий ба удирдлагын зардалд ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хуулийн дагуу төлж буй бүх төрлийн татвар, хураамж, төлбөр, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, даатгал, сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн урсгал засвар, түлш шатахуун тослох материал, лабораторийн шинжилгээ, элэгдэл хорогдол, хөдөлмөр хамгааллын зэрэг зардлууд багтдаг.

2018 оноос 2021 оны үзүүлэлтийг түүхэн дунджаар авч үзвэл, хүний нөөцтэй холбоотой зардал нийт ерөнхий удирдлагын зардлын 60.0 хувийг цалингийн зардал, үйлдвэрлэлийн зардал 13.1 хувийг, тээвэр ба логистикийн зардал 15.9 хувийг, үлдсэн хувийг бусад зардлууд тус тус бүрдүүлсэн. 2022 онд менежментийн үйлчилгээ авсантай холбоотойгоор нийт ерөнхий удирдлагын зардлын 45.0 хувийг менежментийн зардал, 37.2 хувийг цалингийн зардал, үйлдвэрлэлийн зардал 6.1 хувийг, тээвэр ба логистикийн зардал 7.8 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардлыг доорх төрөлд ангилж үзэж болно. Үүнд:

- Хүний нөөцтэй холбоотой зардалд цалин, нийгмийн даатгалын шимтгэл, сургалтын зардлууд;
- Үйлдвэрлэлийн зардалд ашиглалт, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн урсгал засвар, элэгдэл хорогдол, хангамж, лабораторийн шинжилгээний зардлууд;
- Тээвэр ба логистикийн зардал, үүнд түгээлтийн тээврийн хэрэгслийн түрээс, түлш шатахуун, түгээлтийн тээврийн хэрэгслүүд дээр сурталчилгааны хуулга наалгах, олон нийтийн сувгаар сурталчилгаа явуулах зардлууд;
- Бусад зардал багтдаг,

2018 онд түрээсийн зардал 105 сая төгрөг байсан бол 2022 оны байдлаар 121 сая болж нийт 15.2 хувиар нэмэгдсэн. Үнэт цаас гаргагч нь 2022 онд 12 ширхэг ачааны тэвштэй тээврийн хэрэгсэл түгээлтийн үйл ажиллагаанд зориулан худалдан авснаар 2023 оноос эхлэн тээврийн хэрэгслийн түрээстэй холбоотой зардал дахин гарахгүй. Мөн Үнэт цаас гаргагч нь хуруу савны түүхий эд болох мөхлөгийг бэлтгэн нийлүүлэгчийн үйлдвэрийн хашаанаас зөөвөрлөдөг бөгөөд үүнтэй холбоотойгоор хүнд даацын ачааны машины болон мөхлөг хадгалах агуулахын түрээсийн төлбөрийг тус тус тогтмол төлдөг.

2018 оноос 2022 оны хугацааны түүхэн дунджаар борлуулалтын орлогод эзлэх ерөнхий удирдлага ба борлуулалт маркетингийн зардлын хувийн жин дунджаар 20.6 хувь байна. Тус хугацаанд ашгийн маржин өсөж үйл ажиллагааны зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь буурсан нь үйл ажиллагаа харьцангуй тогтворжиж, зардлын менежментийг үр ашигтай байдлаар зохион байгуулж эхэлснийг харуулж байна. Цаашид үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал нь тогтворжиж, гэнэтийн зардал ихсэх эрсдэл харьцангуй бага, үйл ажиллагааны зардлын борлуулалтад эзлэх түвшин хэвийн байхаар харагдаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар борлуулалтын орлогод эзлэх ерөнхий удирдлага ба борлуулалт маркетингийн зардлын хувийн жин 21.9 хувь байна.

## Цэвэр ашиг

**График 12. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг, жил бүрийн өөрчлөлт, сая төгрөг, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гарагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаардаг. Цэвэр ашгийн хэмжээ 2020 онд өмнөх оноос 7.4 хувиар буурсан нь КОВИД-19 цар тахлаас үүдэн хөл хорио тогтоож, эдийн засаг агшиж, улмаар бүтээгдэхүүний эрэлт буурснаар цэвэр усны үйлдвэрлэлийн салбарын өсөлт удааширч, улмаар Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого буурсан болович Үнэт цаас гаргагч нь зардлын төлөвлөлтийг оновчтой хийж цэвэр ашгийн ахиуц хувийн өсөлтийг хадгалж чадсан байна. 2022 онд нийт цэвэр ашиг 5,263 тэрбум төгрөгт хүрч, 15.8 хувийн цэвэр ашгийн ахиуцтай ажилласан бол 2023 оны эхний хагас жилээр 12.4 хувь болж буурсан нь үйлдвэрлэлийн шинэ шугам угсрахтай холбоотойгоор хуучин шугамуудыг нүүлгэн шилжүүлэх ажиллагааны улмаас үйлдвэрлэлийн зайлшгүй сул зогсолт 1 сар орчим хугацаанд үүссэнтэй холбоотой. Зөвхөн савласан цэвэр усны цэвэр ашгийн ахиуц нь 2022 онд 28.5 хувьд хүрсэн ба шинэ шугам ажиллаж эхэлснээр үйлдвэрлэлийн гарц нэмэгдэж эрэлтийг бүрэн хангах хэмжээнд хүрэх төдийгүй нэгж бүтээгдэхүүний өртөг буурах төлөвтэй байгаа нь ашгийн ахиуцын өсөлтөд хөшүүрэг болохоор байна.

СЗХ 2024 .04. 29 он сар өдөр Nº 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## 10.3. Санхүү байдлын тайлангийн шинжилгээ

**Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлан, сая төгрөг**
2018-2023 оны 6-р сарын 30

| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | **3,654.80** | **6,586.68** | **13,831.83** | **21,485.61** | **23,945.32** | **18,229.40** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 42.63 | 27.15 | 98.00 | 21.25 | 41.91 | 296.41 |
| Дансны авлага | 2,319.53 | 5,488.82 | 669.59 | 874.80 | 1,040.38 | 2,227.18 |
| Татвар, НДШ-ийн авлага | 18.75 | - | 46.76 | - | - | - |
| Бусад авлага | 87.86 | 87.81 | 3,606.75 | 5,684.55 | 9,470.98 | 3,515.31 |
| Бараа материал | 1,186.02 | 982.23 | 2,923.27 | 1,306.63 | 2,166.46 | 3,312.74 |
| Урьдчилж төлсөн зардал | - | 0.67 | 6,487.47 | 13,598.38 | 11,225.58 | 8,877.76 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **1,465.03** | **977.40** | **1,081.32** | **1,441.18** | **3,999.97** | **17,735.69** |
| Үндсэн хөрөнгө | 1,005.17 | 968.76 | 1,073.89 | 1,435.07 | 2,908.10 | 16,556.89 |
| Биет бус хөрөнгө | 9.86 | 8.64 | 7.43 | 6.11 | 4.99 | 1,178.80 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 450.00 | - | - | - | - | - |
| Дуусаагүй барилга | - | - | - | - | 1,086.88 | - |
| **Нийт хөрөнгийн дүн** | **5,119.83** | **7,564.08** | **14,913.15** | **22,926.79** | **27,945.29** | **35,965.09** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **5,025.54** | **6,332.97** | **12,749.75** | **14,949.28** | **15,455.12** | **15,012.5** |
| Дансны өглөг | 4,993.22 | 6,155.01 | 7,215.68 | 7,852.79 | 5,980.69 | 1,462.10 |
| Цалингийн өглөг | 1.04 | - | 119.51 | 1,215.61 | - | 241.16 |
| Татварын өр | 18.29 | 139.09 | 62.88 | 242.35 | 1,529.92 | 1,888.05 |
| НДШ-ийн өглөг | - | 18.59 | - | - | 148.10 | 145.56 |
| Банкны богино хугацаат зээл | - | - | - | 1,950.00 | 1,378.95 | 7,877.46 |
| Урьдчилж орсон орлого | 0.28 | 9.29 | 7.06 | 8.05 | 36.88 | 34.82 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 12.72 | 10.99 | 5,344.61 | 3,680.48 | 6,380.59 | 3,363.38 |
| **Урт хугацаат өр төлбөр** | **120.00** | **120.00** | - | **750.00** | - | - |
| Урт хугацаат зээл | 120.00 | 120.00 | - | 750.00 | - | - |
| Бусад урт хугацаат өр төлбөр | - | - | - | - | - | - |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **5,145.54** | **6,452.97** | **12,749.75** | **15,699.28** | **15,455.12** | **15,012.52** |
| Хувьцаат капитал | 573.57 | 573.57 | 573.57 | 573.57 | 573.57 | 600.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - | - | - | - | 7,245.92 |
| Хуримтлагдсан ашиг | (599.28) | 537.54 | 1,589.83 | 6,653.94 | 11,916.61 | 13,106.65 |
| **Эздийн өмчийн дүн** | **(25.71)** | **1,111.10** | **2,163.40** | **7,227.51** | **12,490.17** | **20,952.57** |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **5,119.83** | **7,564.08** | **14,913.15** | **22,926.79** | **27,945.29** | **35,965.09** |

***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 04 29
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

### 10.3.1. Нийт хөрөнгийн бүтэц

**График 13. Нийт хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө нь 2018 оноос 2022 онуудад 5,120 сая төгрөгөөс 27,945 сая төгрөг болж 5 жилийн хугацаанд 5.5 дахин өссөн байна. Эдгээр 5 жилийн хугацаанд борлуулалтын орлого 5 дахин өсөж 27,275 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийт хөрөнгийн өсөлтөд гол нөлөөг үзүүлсэн. Түүхэн таван жилийн дунджаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 86.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 13.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 50.7 хувийг эргэлтийн хөрөнгө, 49.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна

СЗХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Эргэлтийн хөрөнгө

**График 14. Эргэлтийн хөрөнгийн дүн ба бүтэц, сая төгрөг, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




**Хүснэгт 18. Эргэлтийн хөрөнгийн бүтэц, эргэлтийн хөрөнгөд эзлэх хувь**
2018-2023 оны 6-р сарын 30

| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 1.2% | 0.4% | 0.7% | 0.1% | 0.2% | 1.6% |
| Дансны авлага | 63.5% | 83.3% | 4.8% | 4.1% | 4.3% | 12.2% |
| Татвар, НДШ - ийн авлага | 0.5% | 0.0% | 0.3% | 0.0% | 0.0% | 0.0% |
| Бусад авлага | 2.4% | 1.3% | 26.1% | 26.5% | 39.6% | 19.3% |
| Бараа материал | 32.5% | 14.9% | 21.1% | 6.1% | 9.0% | 18.2% |
| Урьдчилж төлсөн зардал | 0.0% | 0.0% | 46.9% | 63.3% | 46.9% | 48.7% |

***Эх сурвалж:*** *Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 2018 онд 71.4 хувь байснаас 2022 онд 85.7 хувь болж өссөн. Түүнчлэн, эргэлтийн хөрөнгийн өсөлтийг сэлбэг хэрэгсэл, шошго татан авалтай холбоотой үүссэн авлага, үндсэн түүхий эд материалын болон үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөрийн дүн голчлон бүрдүүлсэн байна. Үнэт цаас гаргагч үйлдвэрийн тасралтгүй байдлыг хангахын тулд түүхий эд материал болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг зургаан сараас нэг жил хүртэлх хугацааны зохимжит нөөцийг бүрдүүлэх урьдчилгаа төлбөр төлдөг байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар эргэлтийн хөрөнгө 18,229 сая төгрөг болж буурсанд жижиг савлагаатай цэвэр усны үйлдвэрлэлийн шинэ шугамыг гаалиар оруулж ирэн хүлээн авч, суурилуулж, сэлбэг хэрэгслийг татан авсантай холбоотойгоор урьдчилж төлсөн зардал болон бусад авлага нийт 8,303 сая төгрөгөөр багассан байна.

2018 оноос 2022 оны хугацааны түүхэн дунджаар эргэлтийн хөрөнгийн 0.5 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 32.0 хувийг дансны авлага, 19.2 хувийг бусад авлага, 16.7 хувийг бараа материал, 31.4 хувийг урьдчилгаа төлбөр, үлдсэн хувийг бусад эргэлтийн хөрөнгүүд тус тус бүрдүүлсэн байна.



MGL AQUA Co.,Ltd
InvesCore CAPITAL

СЗХ 2024.03.29
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь түүхий эд материалын татан авалтыг үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу тухай бүрд худалдан авдаг бөгөөд 2020 оны цар тахлын нөхцөлтэй харьцуулахад 2021 оноос түүхий эд материалыг их хэмжээгээр нөөцлөхөө больж, төлөвлөгөөний дагуу бараа материалын зохимжит хэмжээг барьж ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн дансны авлага 2020 онд 670 сая төгрөг байсан бол тус хугацаанаас хойш тасралтгүй нэмэгдсээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар 2,227 сая төгрөгт хүрсэн. Дансны авлага нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээтэй харилцагч нарын тоо нэмэгдэж, борлуулалт өссөнтэй холбоотойгоор нэмэгдсэн хэдий ч эргэлтийн хөрөнгөд эзлэх хувь буурч, авлага цуглуулах дундаж хугацаа 10 хоногт хүрсэн. Үүнээс Үнэт цаас гаргагч нь авлагын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн нь харагдаж байна.

**Хүснэгт 19: Авлага цуглуулах дундаж хугацаа, хоног**
2018-2023 оны 6-р сарын 30

| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Авлага цуглуулах дундаж хугацаа | 92 | 149 | 135 | 13 | 10 | 73 |

*Эх сурвалж: Үнэт цаас гарагчийн санхүүгийн аудитлагдсан тайлан ба тооцоолол*

## Эргэлтийн бус хөрөнгө

**График 15. Эргэлтийн бус хөрөнгийн хэмжээ ба бүтэц, сая төгрөг, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гарагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагч 2018 онд 1,465 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй байсан бол 2022 оны байдлаар тус үзүүлэлт жилд дунджаар 28.5 хувиар нэмэгдэж 4,000 сая төгрөгт хүрсэн. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн ихэнх хувийг үндсэн хөрөнгө эзэлдэг бөгөөд 2018 оноос 2022 оны түүхэн үзүүлэлтээс харахад үндсэн хөрөнгийн хэмжээ эргэлтийн бус хөрөнгийн 87.9 хувийг эзэлж байсан. 2022 онд түгээлтийн ачааны тээврийн хэрэгслүүдийг худалдан авсантай холбоотойгоор үндсэн хөрөнгө 2021 оноос 1,531 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар эргэлтийн бус хөрөнгө 2022 оны жилийн эцсээс 13,736 сая төгрөгөөр өсөж 17,736 сая төгрөгт хүрсэнд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болон зэргэлдээ компаниас үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан нь нөлөөлсөн байна.

СЗХ
2024 оны 04 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ

Усны үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон үйл ажиллагааны бусад эргэлтийн бус хөрөнгө Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани "Ти Эм Эл" ГХОХХК-ийн тайлан балансд бүртгэгдсэн байсан ба Үнэт цаас гаргагч тус хөрөнгүүдийг өөрийн нэр дээр хуулийн дагуу шилжүүлэн авч, 2023 оны эхний хагас жилийн байдлаар Хөндлөнгийн Үнэлгээний компаниар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээний үр дүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг эргэлтийн бус хөрөнгүүдийг 17,736 сая төгрөгөөр дахин үнэлсэн ба үүнтэй холбоотойгоор 7,246 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэсэн. Мөн хөрөнгийн үнэлгээний үр дүнд ашиглагдахгүй хуучирсан хөрөнгүүдийг актлах замаар үндсэн хөрөнгийн бүртгэлийг шинэчилсэн.

**Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн, сая төгрөг**
2023 оны 6-р сарын 30

| № | Хөрөнгө | Үнэлгээний өмнөх үнэ цэн | Дахин үнэлүүлсний дараах үнэ цэн |
|---|---|---|---|
| 1 | Барилга байгууламж | 3,376 | 8,908 |
| 2 | Машин, тоног төхөөрөмж | 4,933 | 5,072 |
| 3 | Тээврийн хэрэгсэл | 1,854 | 2,244 |
| 4 | Тавилга, эд хогшил | 235 | 307 |
| 5 | Компьютер, бусад хэрэгсэл | 16 | 26 |
| 6 | Газар эзэмших эрх | - | 1,095 |
| 7 | Биет бус хөрөнгө | 77 | 83 |
| 8 | Нийт | 10,490 | 17,736 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Улмаар 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгийн 93.4 хувийг үндсэн хөрөнгө, үлдсэн хувийг биет бус хөрөнгө бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагчийн биет үндсэн хөрөнгөд барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл гэсэн хөрөнгүүд бүртгэгдэж байгаа бол биет бус хөрөнгөд газрын гэрчилгээ, программ хангамж бүртгэгддэг байна. Түүнчлэн, нийт эргэлтийн бус хөрөнгийн 50.2 хувийг барилга байгууламж, 28.6 хувийг тоног төхөөрөмж, 12.7 хувийг тээврийн хэрэгсэл, үлдсэн хувийг бусад эргэлтийн бус хөрөнгүүд тус тус эзэлж байна.

**График 16. Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц ба эзлэх хувь, сая төгрөг**
2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гарагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore Capital
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
MGL AQUA
2628333
ГСТ1398
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.04.29
он сар өдөр
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### 10.3.2. Эх үүсвэр ба эздийн өмчийн бүтэц

#### Эх үүсвэрийн бүтэц

Санхүүгийн тайлангийн өр төлбөр ба эздийн өмч хэсэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийн бүтцийг харуулдаг. Үнэт цаас гаргагч нь 2018-2019 онуудад нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг буюу 85.5-аас 100.0 орчим хувийг өр төлбөрөөр санхүүжүүлж байсан бол 2021 оноос эхлэн ашигт ажиллагааны түвшин сайжирч хуримтлагдсан ашиг нэмэгдэн 2022 онд 55.3 хувийг өр төлбөрөөр, үлдсэн 44.7 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбоотойгоор эх үүсвэрийн 58.3 хувийг эздийн өмч буюу хувьцаа эзэмшигчийн хөрөнгө бүрдүүлж байна.

**График 17. Эх үүсвэрийн бүтэц, нийт эх үүсвэрт эзлэх хувь, сая төгрөг**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

2024.04.29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

## Өр төлбөр

**График 18. Өр төлбөрийн задаргаа, сая төгрөг**
2018-2023 оны 6-р сарын 30




***Эх сурвалж:*** *Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

2018 оноос 2022 оны үзүүлэлтийг дундажлан харвал 67.5 хувийг дансны өглөг, 4.3 хувийг богино хугацаат зээл, 26.4 хувийг бусад богино хугацаат өр төлбөр, 1.8 хувийг урт хугацаат өр төлбөрүүд эзэлж байна. Үнэт цаас гаргагч нь ихэвчлэн дотоод бэлтгэн нийлүүлэгчдээс түүхий эд материалыг худалдан авдаг бөгөөд үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор түүхий эдийн нөөцийг бүрдүүлдэг. Үнэт цаас гаргагч нь бэлтгэн нийлүүлэгчидтэй гэрээгээр буюу дараа төлбөрт нөхцөлөөр хуруу сав, бөглөө, бариул, багцлагч, ороогч, шошго зэргийг худалдан авах үед түүхий эд материалтай холбоотой дансны өглөг үүсдэг байна.

Үнэт цаас гаргагчийн бусад богино хугацаат өр төлбөр ангилалд зэргэлдээ болон холбоотой талуудын хооронд үүссэн түүхий эд бэлтгэн нийлүүлэх, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл бэлтгэн нийлүүлэхтэй холбоотой өглөг бүртгэгддэг.

Үнэт цаас гаргагчийн богино хугацаат зээлийн үлдэгдэл нь нэг жил хүртэлх хугацаатай зээлийн дүн бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 7,877 сая төгрөг байна. Энэ нь үйлдвэрлэл болон түгээлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж болон түгээлтийн шинэ тээврийн хэрэгслүүдийн худалдан авалтаас үүссэн зээл юм.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар аливаа урт хугацаат зээл болон урт хугацаат өр төлбөргүй байна.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

**График 19. Бусад богино хугацаат өр төлбөр, сая төгрөг, жил бүрийн өөрчлөлтийн хувь**
2018-2023 оны 6-р сарын 30




***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн 2023 оны эхний хагас жилийн байдлаарх бусад богино хугацаат өр төлбөрийн 59 хувийг түүхий эдийн татан авалт болон Krones AG савлах, багцлах цогц систем бүхий тоног төхөөрөмжийн худалдан авалтаас үүссэн холбоотой талуудыг өглөг, 41 хувийг татвар болон хүүгийн өглөг бүрдүүлж байна.

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

## Эздийн өмчийн бүтэц

Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 600 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 13,107 сая төгрөгийн хуримтлагдсан ашиг, хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотойгоор 7,246 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс тус тус бүрдэж байна.

**График 20. Эздийн өмчийн бүтэц, сая төгрөг**
2018-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн дүн 2018 онд хасах утгатай байсан бол 2019 онд цэвэр ашиг өссөнөөр 1,111 сая төгрөг болж нэмэгдсэн. 2018 оноос хойш эздийн өмч жилийн дундаж 369.5 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж 2022 онд 12,490 сая төгрөгт хүрсэн. 2023 оны эхний хагас жилд эздийн өмч 20,953 сая төгрөгт хүрч өмнөх оноос 67.8 хувиар өссөн байна. 2018 онд хувь нийлүүлсэн хөрөнгө 574 сая төгрөг байсан ба 2023 оны эхний хагас жилд 600 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн. Хуримтлагдсан ашиг 2018 онд алдагдалтай байсан бол ашигт ажиллагаа тогтмол өссөөр 2023 оны эхний хагас жилд 13,107 тэрбум төгрөгт хүрч жилийн дундаж 111.2 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлсэн байна. Энэхүү өсөлт нь менежментийн шинэчлэл хийгдэж, Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилсний үр дүнд үйл ажиллагаа тогтворжиж, тогтмол ашигтай ажилласан гүйцэтгэлтэй холбоотой байна.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore

СЗХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### 10.3.3. Санхүү байдлын онцлох харьцаа үзүүлэлтүүд

#### Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагч нь ирээдүйд учирч болох төлөвлөсөн болон төлөвлөөгүй үүргийн гүйцэтгэлийг барагдуулах, үйл ажиллагааг тасралтгүй явуулахад хөрөнгийн хөрвөх чадварын зохистой түвшинд хадгалж ажиллах нь чухал байдаг.

**Хүснэгт 21. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд, тоо**
2018-2023 оны 6-р сарын 30

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Эргэлтийн харьцаа | 0.7 | 1.0 | 1.1 | 1.4 | 1.5 | 1.2 |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | 0.5 | 0.9 | 0.9 | 1.3 | 1.4 | 1.0 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөрөө барагдуулах чадварыг илэрхийлдэг. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа 2018 онд зохистой хэмжээнд биш буюу 1.0 гэсэн харьцаанаас доош 0.7 байсан бол тус үзүүлэлт нь 2019 оноос эхлэн нэмэгдсээр 2022 онд 1.5, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1.2 болж тус тус өссөн нь богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөр барагдуулах хангалттай чадвартайг харуулж байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг хөрвөх чадвар харьцангүй багатай хөрөнгө болох бараа материалыг эргэлтийн хөрөнгөөс хасаж тооцдог ба богино хугацаат өр төлбөрөө түргэн хөрвөх чадвартай хөрөнгөөр хэрхэн барагдуулах чадамжтайг харуулдаг үзүүлэлт юм. Үнэт цаас гаргагчийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2018 онд 0.5 байсан бол 2022 онд 1.4, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1.0 болж нэмэгдэж байгаа нь Үнэт цаас гаргагч нь өр төлбөрөө амжилттай бууруулж, хөрвөх чадварын эрсдэл багатай байгааг харуулж байна.

#### Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд

**Хүснэгт 22. Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, хоног, удаа**
2018-2022

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Авлага цуглуулах дундаж хугацаа | 92 | 149 | 135 | 13 | 10 |
| Бараа материалын дундаж наслалт | 76 | 64 | 129 | 62 | 31 |
| Дансны өглөгийн хугацаа | 320 | 342 | 326 | 253 | 119 |
| Үндсэн хөрөнгийн эргэц | 6.8 | 9.7 | 8.1 | 16.7 | 15.4 |
| Нийт хөрөнгийн эргэц | 1.6 | 1.5 | 0.7 | 1.1 | 1.3 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн авлага цуглуулах дундаж хугацаа жил бүр буурсан үзүүлэлттэй байгаа нь авлагын удирдлага тогтмол сайжирч байгааг харуулж байна. 2018 оны байдлаар тус үзүүлэлт 92 хоног байсан бол 2022 онд 10 болж буурч байгаа нь сайшаалтай үзүүлэлт юм.

Үнэт цаас гаргагч нь авлагын насжилт, бүтцийн шинжилгээг тогтмол гүйцэтгэж, авлагын эрсдэлийн түвшнийг тодорхойлон найдваргүй авлагын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилладаг. 2023 оны хагас жилийн байдлаар 0-30 хоногийн хугацаатай авлагын хэмжээ нийт дансны авлагад 69.5 хувийг эзэлж байна.

Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd
InvesCore CAPITAL

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

**Хүснэгт 23. Авлагын үлдэгдлийн насжилт, авлагад эзлэх хувь**
2018-2023 оны 6-р сарын 30

| Хугацаа хоног | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|
| 0-30 | 32.1% | 38.5% | 69.5% |
| 30-60 | 9.2% | 22.9% | 9.3% |
| 60-90 | 2.9% | 10.7% | 6.4% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн бараа материалын дундаж наслалт 2018 онд 76 хоног байсан бол жил тутам буурсаар 2022 онд 31 хоног болсон нь бараа материалын худалдан авалтыг зохистой хэмжээнд урьдчилан тооцоолж, түүний дагуу үр ашигтай худалдан авалт хийж байсантай холбоотой юм.

Үнэт цаас гаргагчийн өглөг барагдуулах дундаж хугацаа жил бүр буурсан үзүүлэлттэй байна. 2018 оны байдлаар 320 хоног байсан бол 2022 онд 119 болж буурсан байгаа Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа сайжирч, өр төлбөрөө барагдуулах чадамж нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгийн эргэц нь компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтын үр ашгийг хэмждэг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг Үнэт цаас гаргагчийн хувьд тус үзүүлэлт тасралтгүй нэмэгдэх нь чухал юм. 2018 онд тус харьцаа үзүүлэлт нь 6.8 байсан бол 2022 онд 15.4 болж өссөн нь сайжирсан үзүүлэлт юм. Үндсэн хөрөнгийн эргэц жил бүр тогтмол нэмэгдэж байгаа шалтгаан нь үндсэн хөрөнгө 2018 оноос 2022 оны хугацаанд 189.3 хувиар нэмэгдсэн бол борлуулалтын орлого 403.7 хувиар өссөн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгийн хэмжээ тоног төхөөрөмжийн худалдан авалт болон хөрөнгийн дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой оны эхнээс 13,649 сая төгрөгөөр нэмэгдсэнээр үндсэн хөрөнгийн эргэц 1.1 болж буурсан.

Нийт хөрөнгийн эргэц нь компанийн борлуулалт хийхэд ашиглагдаж буй нийт хөрөнгийн үр ашгийг харуулдаг харьцаа үзүүлэлт ба тус харьцаа үзүүлэлт нь их байх тусам хөрөнгийг бүрэн хүчин чадлаар ашиглаж чадаж байгаа эсвэл бага хэмжээний хөрөнгөөр үр ашигтай ажиллаж байгааг илтгэдэг. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн эргэц 2022 онд 1.3 болж өссөн нь нийт борлуулалтын өсөлт нь хөрөнгийн өсөлтөөс илүү байсныг илтгэнэ.

## Төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд

**Хүснэгт 24. Төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд, тоо**
2018-2023 оны 6-р сарын 30

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Өрийн харьцаа | 1.01 | 0.85 | 0.85 | 0.68 | 0.55 | 0.42 |
| Өр төлбөр, эздийн өмчийн харьцаа | -200.15 | 5.81 | 5.89 | 2.17 | 1.24 | 0.72 |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Компани бизнесийн үйл ажиллагаагаа өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байвал санхүүгийн хувьд тогтвортой байна гэж үздэг ч өрийн санхүүжилтийг үр ашигтай ашигласнаар компани үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломжтой байдаг. Иймд компанийн санхүүгийн тогтвортой байдлыг зээл төлөх чадвартай нь уялдуулан авч үздэг. Өр зээлийн түвшин хэт өндөр байх тусам компанийг өрийн дарамтад оруулдаг бол хэт бага өртэй байх нь компанийг үр ашгийн зохистой түвшинд ажиллахгүй байгааг харуулдаг.

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгөд эзлэх өр төлбөрийн хэмжээ болон өр төлбөрийн эздийн өмчтэй харьцуулсан үзүүлэлт жил бүр буурсаар 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн 43.1 хувийг өр төлбөр эзэлж байгаа нь өр төлбөр хэвийн хэмжээнд байгааг харуулж байна.

## Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд

**Хүснэгт 25. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд, нийт борлуулалтын цэвэр ба нийт ашгийн ахиуц, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашгийн ахиуц | 8.8% | 11.9% | 12.7% | 24.2% | 15.8% | 12.4% |
| Нийт ашгийн ахиуц | 34.3% | 35.6% | 33.3% | 40.3% | 39.0% | 47.6% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн ахиуц хувь жил бүр тогтмол өсөлттэй байгаа нь 2018 оноос 2021 он хүртэлх түүхэн үзүүлэлтээс харагдаж байна. 2022 онд нийт болон цэвэр ашгийн ахиуц буурсан нь толгой компаниас менежментийн үйлчилгээ авсантай холбоотой ба цэвэр ашгийн ахиуц хувь буурсан хэдий ч түүхэн дундаж үзүүлэлтээс өндөр хэвээр байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар цэвэр ашгийн ахиуц 12.4 хувь болж буурсан нь нэг удаагийн шинж чанартай буюу үйлдвэрлэлийн шинэ шугам угсрахтай холбоотойгоор үйлдвэрлэлийн зайлшгүй сул зогсолт нэг сар орчим хугацаанд үүссэнтэй холбоотой юм.

2023 оноос Үнэт цаас гаргагч нь үндсэн бизнес болох савласан цэвэр усны үйлдвэрлэлийн чиглэлээр дагнаж ажиллах тул савласан цэвэр усны нийт ахиуц ашгийн үзүүлэлтийг салган авч харвал жил бүр тогтмол өсөлттэй байна. 2022 оны байдлаар савласан усны нийт ашгийн ахиуц 57.1 хувьд хүрсэн нь компанийн түүхэнд хамгийн өндөр гүйцэтгэлтэй ажилласан жил болсон. 2023 оны эхний хагас жилийн байдлаар савласан усны нийт ашгийн ахиуц 49.5 хувьд хүрсэн байна.

**Хүснэгт 26. Ашигт ажиллагааны үзүүлэлт, савласан цэвэр усны нийт ашгийн ахиуц, хувь**
2018-2023 оны 6-р сарын 30

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Савласан цэвэр усны нийт ашгийн ахиуц | 34.3% | 35.6% | 33.6% | 48.4% | 57.1% | 49.5% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж нь 2020 оны цар тахлын нөхцөл байдлаас хойш өсөх хандлагатай байгаа бол өөрийн хөрөнгийн өгөөж нь харьцангуй хэлбэлзэл өндөртэй байна. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг жил бүр өсөлттэй, мөн цэвэр ашгийн ахиуц хувь тогтвортой бөгөөд өсөлттэй байгаа нөхцөлд өөрийн хөрөнгийн өгөөж хэлбэлзэл өндөртэй байгаа нь 2018-2020 онуудад Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтцийн дийлэнх хэсгийг өр төлбөрөөр бүрдүүлж байсантай холбон тайлбарлаж болно. 2021 оноос Үнэт цаас гарагчийн өр төлбөрийн хэмжээ хэвийн түвшинд хүртэл буурч, бизнесийн үйл ажиллагаа тэлж эхэлснээр өөрийн хөрөнгийн өгөөж цаашид тогтвортой өсөлтийг үзүүлнэ гэж үзэж байна.

**Хүснэгт 27. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд, нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгийн өгөөж, хувь**
2018-2022 он

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Түүхэн дундаж |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт хөрөнгийн өгөөж | 14.1% | 17.9% | 9.4% | 26.8% | 20.7% | 17.8% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | -183.9% | 209.5% | 64.3% | 107.9% | 53.4% | 108.7% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

СЗХ
2024 он 04 сар 20 өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

## Ду-Понт шинжилгээ

**Хүснэгт 28. Ду-Понт шинжилгээ, нэгж, хувиар**
2018-2022 он

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашиг | 586 | 1,137 | 1,052 | 5,064 | 5,263 |
| Борлуулалтын орлого | 6,621 | 9,541 | 8,302 | 20,895 | 33,351 |
| **Цэвэр ашгийн ахиуц** | **8.8%** | **11.9%** | **12.7%** | **24.2%** | **15.8%** |
| Борлуулалтын орлого | 6,621 | 9,541 | 8,302 | 20,895 | 33,351 |
| Дундаж нийт хөрөнгө | 4,167 | 6,342 | 11,239 | 18,920 | 25,436 |
| **Нийт хөрөнгийн эргэц** | **1.60** | **1.50** | **0.74** | **1.10** | **1.31** |
| Дундаж нийт хөрөнгө | 4,167 | 6,342 | 11,239 | 18,920 | 25,436 |
| Дундаж эздийн өмч | - | 543 | 1,637 | 4,695 | 9,859 |
| **Санхүүгийн хөшүүрэг** | -13.08 | **11.69** | **6.86** | **4.03** | **2.58** |
| **Өөрийн хөрөнгийн өгөөж** | **-183.9%** | **209.5%** | **64.3%** | **107.9%** | **53.4%** |

***Эх сурвалж:*** *Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба тооцоолол*

2019-2022 оны түүхэн үзүүлэлтийг дундажлан харвал Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн өгөөж 108.7 хувь байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Ду-Понт шинжилгээнээс харахад өөрийн хөрөнгийн өгөөжийн өсөлтөд хамгийн өндөр нөлөөлөгч нь цэвэр ашгийн ахиуц хувь болон санхүүгийн хөшүүрэг нөлөөлсөн байна.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг ашиглалт 2019-2021 хооронд харьцангуй өндөр байсан нь өөрийн хөрөнгийн өгөөжид сайнаар нөлөөлж байгаа мэт харагдаж байгаа боловч нөгөө талаас Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн дийлэнх хэсгийг өр төлбөр бүрдүүлж байсантай холбоотой юм. Өр төлбөрийн харьцаа хэт өндөр байх нь дунд хугацаандаа бизнесийн үйл ажиллагаанд дарамт учруулдаг тул 2022 онд санхүүгийн хөшүүрэг 2.58 болж буурч байгаа нь урт хугацаандаа бизнесийн тогтвортой байдал сайжирч, үйл ажиллагааны эрсдэл буурсан сайшаалтай үзүүлэлт юм. Энэ нь 2022 онд Үнэт цаас гарагчийн өөрийн хөрөнгийн өгөөж буурсан хэдий ч цаашид тогтвортой өсөлтийг үзүүлэх чадамжтай болсон байгааг харуулж байна.

2019 оноос эхлэн Үнэт цаас гаргагч нь жил тутам өр төлбөрийн хэмжээг үе шаттайгаар бууруулан нийт хөрөнгийн эргэц болон цэвэр ашгийн түвшнийг нэмэгдүүлэх замаар үйл ажиллагаа болон ашигт ажиллагаагаа сайжруулах замаар өөрийн хөрөнгийн өгөөжийг өндөр түвшинд хадгалан ажиллаж байна.

СЭХ
2024 .04. 29
он сар өдөр
БҮРТГЭВ

MGL aqua

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

# ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

11

СЗХ 2024.04.29 Он сар өдөр БҮРТГЭВ №31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

# 11. Зорилтот зах зээлийн шинжилгээ

## 11.1. Олон улсын эдийн засгийн төлөв байдал

2021 оноос дэлхийн улс орнууд мөнгөний зөөлөн бодлогыг зогсоож, мөнгөний хатуу бодлого руу шилжиж, эрэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах арга хэмжээг авч эхэлсэн. Үр дүнд нь эрчим хүч болон хүнсний салбарын бараа үйлчилгээний үнийн өсөлт саарч, БНХАУ-ын аж үйлдвэрийн салбар идэвхжиж эхэлснээр цар тахлын дараах дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал аажмаар сэргэх хандлагатай ажиглагдсан. Гэсэн хэдий ч геополитикийн хурцадмал байдал, инфляцын нөлөө, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрал, АНУ, Европын орнуудад үүсээд буй банк, санхүүгийн эмзэг байдал зэрэг нь дэлхий дахины эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Үр дүнд нь дунд хугацаанд дэлхий дахинд эдийн засгийн тодорхой бус байдал үргэлжлэхээр байна.

Иймд олон улсын санхүүгийн байгууллагууд 2023 оны 04-р сарын сүүлээр дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг дахин бууруулав. Тухайлбал, Олон Улсын Валютын Сан нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2023 оны 01-р болон 04-р саруудад удаа дараа бууруулсан. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд 2.8 хувь байсан бол Олон Улсын Валютын Сангийн үзэж буйгаар 2023 онд 2.8 хувь, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.

Төв банкнууд мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлснээр эх үүсвэрийн зардал нэмэгдэж, улмаар улс орнуудын хөрөнгө оруулалт, капиталын урсгал буурсан нь хөгжингүй орнуудын банк санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн боломжууд хумигдах хүндрэлийг үүсгэхэд нөлөөлсөн. Түүнчлэн, цар тахлын дараах эдийн засгийн өндөр өсөлтийн хувь хүлээлттэй байсан БНХАУ, БНСУ зэрэг улсуудын эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэлүүд таамагласан хэмжээнд хүрээгүй, мөн ОХУ-Украйны дайны байдал зэрэг хүчин зүйлс нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалыг бууруулах гол хүчин зүйл болсон байна.

Мөн Олон Улсын Валютын Сангийн таамаглалаар дэлхийн инфляцын түвшин 2023 онд 7.0 хувь, 2024 онд 4.9 хувьд тус тус хүрэх төлөвтэй байна. Хүнсний салбарын хувьд инфляцын түвшин 2023 оны эхэн үеэс буурч байгаа хэдий ч, сүүлийн 5 жилийн дунджаас даруй 22.3 хувиар өндөр байгаа нь онцлон анхаарал хандуулах үзүүлэлтүүдийн нэг юм.

Дэлхийн эдийн засгийн дунд хугацааны нөхцөл байдалд дараах улс орнуудын бодлого, авч буй арга хэмжээнүүд өндөр нөлөөтэй юм. Үүнд:

- **Бүгд Найрамдах Хятад Ард Улс**

Дэлхийн Банкны 2023 оны 04-р сарын эдийн засгийн тоймд Зүүн Ази, Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн төлөв 2023 онд тогтвортой байх хэдий ч түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдах, банк санхүүгийн нөхцөл байдал муудах, дэлхийн эдийн засгийн өсөлт удаашрах зэрэг үйл явцуудаас шалтгаалан тус бүс нутгийн өсөлт саарах магадлалтай байгааг дурдсан бол Азийн бүс нутгийн өсөлтөд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт голлон нөлөөлнө гэж олон улсын судлаачид үзэж байна. Мөн тус улсын эдийн засгийн өсөлт нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлэх боломжтой хэмээн Олон Улсын Валютын Сангаас таамаглаад байна.

Цар тахлын эсрэг бодлогоо албан ёсоор цуцалснаас хойш тус улсын эдийн засаг хурдацтай сэргэж байсан ч дотоодын хэрэглээ, худалдан авалтын зарцуулалт буурсны улмаас 2023 оны 04-р сараас эхлэн эдийн засгийн өсөлт нь удааширч эхлэв. Түүнчлэн, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт нь үл хөдлөх хөрөнгийн салбараас өндөр хамааралтай байсаар ирсэн ба тус салбарын өсөлт сүүлийн жилүүдэд удаашрах болсон нь дотоодын зах зээлд төдийгүй олон улсын эдийн засгийн төлөв байдалд нөлөөлж байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd ГСТ1398 Улаанбаатар
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL Улаанбаатар хот

СЗХ 2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Үл хөдлөх хөрөнгийн салбар нь тус улсын ДНБ-ийн ойролцоогоор 30 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд БНХАУ нь үл хөдлөх хөрөнгийн салбарын зах зээлийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг. Иймд тус салбарын борлуулалт хумигдаж, улмаар өрийн дарамт нэмэгдсэн нь БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл нийт банкны секторын зээлийн багцын 20 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байгаа нь тус улсын санхүүгийн зах зээл нь үл хөдлөх хөрөнгийн салбараас ихээхэн хамаарч байгааг харуулж буй юм.

Цаашилбал, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас шалтгаалан хот, мужуудад газрын худалдаанаас алдагдал хүлээж, улмаар банкнууд зээлийн хэмжээгээ нэмэгдүүлэхэд хүрч, тус улсын санхүүгийн системд сөргөөр нөлөөлөх болсон. Үүнтэй холбоотойгоор БНХАУ-ын Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 онд 123 их наяд юань буюу 18 их наяд ам.долларын үнийн дүнтэй байсны 10 орчим их наяд ам.долларын өр нь хот, орон нутгийн засаг захиргааны санхүүжилтийн өр байсан. 2023 оноос эрх баригчид бизнесийн салбар дахь улс төрийн нөлөөллийг бууруулж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үл хөдлөх хөрөнгийн салбарын нөхцөл байдлыг сайжруулах зэрэг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлж байна.

- **Евро бүс**

Евро бүсийн хувьд эдийн засгийн өсөлт 2022 онд 3.5 хувь болж, хүлээлтээс давсан үзүүлэлттэй байв. Орос-Украйны дайнаас шалтгаалсан эрчим хүчний үнийн өсөлт нь аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй хэвээр байгаа ч аялал жуулчлалын орлого, зарим аж үйлдвэрийн салбарын өсөлт төсөөллөөс өндөр гарсан нь эдийн засгийн өсөлт ийнхүү хүлээлтээс сайн гарахад нөлөөлөв.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт бага, инфляц өндөр хэвээр хадгалагдах төлөвтэй гэж Олон Улсын Валютын Сан таамаглаж байгаа ба 2023 оноос 2024 онуудад Евро бүсийн хөгжиж буй улсуудын инфляцын түвшин 5.6 хувиас 3.0 хувь, хөгжингүй улсуудын хувьд 11.7 хувиас 5.5 хувьд хүрч тус тус буурах төлөвтэй байна гэж үзжээ.

Франц, Итали зэрэг улсуудад эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, эдийн засгийн өсөлтийн эрч нэмэгдэж байгаа боловч санхүүгийн салбарын тогтворгүй байдлаас үүсэх эрсдэл нь тус бүсийн эдийн засгийн өсөлтийн хувийг бууруулах магадлалтай юм. Нөгөө талаас, хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний хомсдол, эрчим хүчний үнийн өсөлт, геополитикийн хурцадмал нөхцөл байдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан эдийн засгийн өсөлт буурч, инфляц өсөх эрсдэлтэй байна.

- **АНУ**

Олон Улсын Валютын Сангийн 2023 оны 04-р сарын таамаглалаар Украйнд үргэлжилж буй дайн, өндөр инфляц, санхүүгийн зах зээлийн тодорхойгүй байдал зэргээс шалтгаалан АНУ-ын эдийн засгийн тодорхойгүй байдал үргэлжлэхээр байна. АНУ-ын эдийн засаг 2022 онд 2.3 хувиар өссөн бол 2023 онд 1.7 хувиар өсөх төлөвтэй байна.

Түүнчлэн, 2018 онд АНУ-ын өмнөх Ерөнхийлөгч улсынхаа гадаад бодлогыг “Америкийг эн тэргүүнд тавих” гэж тодорхойлж, гол өрсөлдөгч БНХАУ-тай эдийн засаг, технологиор тусгаарлах стратеги хэрэгжүүлж эхэлсэн нь тус хоёр улсын харилцаа, эдийн засаг, гадаад бодлогод томоохон өөрчлөлт оруулсан билээ. Үүний хүрээнд тус хоёр улсын гадаад худалдаанд ихээхэн хязгаарлалтууд хийгдсэн ба эдгээр хязгаарлалтаас дурдвал өнгөрсөн оны 10-р сараас АНУ нь БНХАУ руу хагас дамжуулагч нийлүүлэхээ хязгаарласан бол БНХАУ нь АНУ руу хагас дамжуулагч үйлдвэрлэлд ашигладаг металлыг экспортлохоо хязгаарласан, зарим бараа бүтээгдэхүүнд гаалийн тарифыг өсгөсөн гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлсэн юм. Дэлхийн эдийн засгийн 42 гаруй хувийг бүрдүүлдэг БНХАУ-АНУ-ын худалдааны дайн Азийн бүс нутгийн худалдаанаас хамааралтай улсуудын эдийн засагт сөргөөр нөлөөлөх магадлалтай гэж Олон Улсын Валютын Сангаас мэдээлсэн байна.

АНУ-ын инфляц 2022 онд 7.0 хувьд хүрсэн бол 2023 онд дунджаар 6.5 хувьд байх төлөвтэй байгаа бөгөөд үнийн өсөлтөд нийлүүлэлтийн тасалдал, эрчим хүч ба шатахууны үнийн өсөлт, ажиллах хүчний дутагдал зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн юм.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd Улаанбаатар хот
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescore Capital Улаанбаатар хот

- **Төв Ази**

Төв банкнуудын мөнгөний бодлого, инфляцын өсөлт, гадаад худалдааны түншүүдийн эдийн засгийн нөхцөл байдал, ОХУ-Украйны дайнаас үүдсэн ОХУ-аас ирэх цагаачдын урсгал, худалдаа болон нийлүүлэлтийн тасалдал зэрэг гадаад хүчин зүйлсээс хамаарч дунд хугацаанд Төв Азийн улсуудад тодорхой бус байдал нэмэгдэхээр байна.

ОХУ-Украйны дайн эхэлснээс хойш гадаад худалдааны нөхцөлд ихээхэн өөрчлөлт орсон ба Азийн бүс нутгийн зарим улсуудад, ялангуяа түүхий эд экспортлогч улсуудын гадаад худалдааны нөхцөл сайжирсан юм. Дайны улмаас түүхий эдийн үнэ өсөж улмаар түүхий эдийн импортоос хамааралтай улсуудад сөрөг нөлөө үзүүлсэн. Геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас үүдэн Азийн улс орнуудын эдийн засгийн өсөлтийг удаашруулж магадгүй гэж Олон Улсын Валютын Сан таамагласан байна.

Олон Улсын Валютын Сангийн таамаглалаар уул уурхайн салбарын өсөлт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хувийн хэвшлийн хөгжил, түншлэлтэй холбоотойгоор Ойрх Дорнод ба Төв Азийн улсуудын эдийн засгийн өсөлт хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтөөс давж, 2023 онд 2.9, 2024 онд 3.5 хувьд тус тус хүрэх хандлагатай байна. Газрын тос, байгалийн хий экспортлогч орнуудын хувьд түүхий эдийн үнэ, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөрөнгө оруулалтын урсгал, худалдааны эргэлт бүгд нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөөтэй ч хүнс болон эрчим хүчний үнийн өсөлт, нийлүүлэлтийн тасалдал, ханшийн сулралт зэрэг хүчин зүйлсээс үүдэн инфляцын түвшин мөн өсөх төлөвтэй байна. 2023 онд Төв Азийн улсуудын инфляц 2022 оноос 1.6 нэгж хувиар өсөж, 2023 онд 15.9 хувь, 2024 онд 12.0 хувьд тус тус хүрэхээр хүлээгдэж байна.

## 11.2. Дэлхийн шингэн хүнсний зах зээл ба савласан цэвэр усны зах зээлийн төлөв байдал

### 11.2.1. Дэлхийн шингэн хүнсний зах зээл

Шингэн хүнсний зах зээлд эдийн засгийн эрчимтэй өсөлт, нэмэгдэж буй хотжилт, хүн амын хооллолтын хэв маяг ба дадал зуршлын өөрчлөлтүүд зэрэг хүчин зүйлс нөлөөлж, өөрчлөлтүүдийг авчирч байдаг. Цар тахлын дараа олон улсад эрүүл амьдралын хэв маяг, дадал зуршлыг хэвшүүлэх хандлага нэмэгдсэн ба үүнтэй зэрэгцэн эрүүл мэндэд зэрэг нөлөөтэй бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн. Улмаар шингэн хүнсний үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүнээ төрөлжүүлж байна.

**График 21. Дэлхийн халдварт бус өвчний өвчлөлийн тоо, сая хүн ам**
2000-2019 он




*Эх сурвалж:* *Ourworldindata статистикийн байгууллага*

Амьдралын хэв маяг, зуршил, хоол хүнсний хэрэглээнээс шалтгаалсан өвчлөл олон улсад жил бүр нэмэгдэж байна. Иймд НҮБ болон бусад олон улсын байгууллагуудаас эрүүл мэндийн үйлчилгээ, хоол тэжээл ба ундны усны хүртээмж, чанар ба аюулгүй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр нэлээдгүй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

2018-2022 онуудад дунджаар шингэн хүнсний зах зээлийн 42 гаруй хувийг согтууруулах бус шингэн хүнсний зах зээл эзэлж байсан ба тус зах зээлийн хэмжээ жил бүр нэмэгддэг онцлогтой байна. 2022 оны байдлаар дэлхийн шингэн хүнсний хэрэглээний 33.5 хувийг савласан цэвэр ус, нийт 80.7 хувийг согтууруулах бус шингэн хүнс эзэлж байна. Согтууруулах бус ундааны төрөлд савласан цэвэр ус, хийжүүлсэн ус, ундаа, шүүс, сироп, кофе, сүү, цай, спиртийн хольцгүй шар айраг, дарс зэрэг бүтээгдэхүүнүүд хамаардаг.

**График 22. Дэлхийн шингэн хүнсний хэрэглээ, төрлөөр, нийт хэрэглээнд эзлэх хувь**
2022 он




***Эх сурвалж:** Statista олон улсын судалгааны байгууллага*

2022 оны байдлаар согтууруулах бус ундааны зах зээл ойролцоогоор 1,337 тэрбум ам.долларт хүрсэн нь 2018 оноос 23.8 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд DPO International олон улсын судалгааны байгууллагын таамаглалаар согтууруулах бус шингэн хүнсний зах зээл 2024 онд 1,489 тэрбум ам.долларт хүрч өсөх хандлагатай байна.

**График 23. Дэлхийн ба АНУ-ын согтууруулах бус шингэн хүнсний зах зээлийн дүн, тэрбум ам.доллар,** 2016-2022 он, 2023-2024 оны төсөөлөл




***Эх сурвалж:** DPO International "Global beverage market overview and insights", 2022 он*

Дэлхийн согтууруулах бус шингэн хүнсний зах зээлийн 35 гаруй хувийг АНУ-ын зах зээл бүрдүүлж, хэрэглээ болон орлогоороо тэргүүлдэг байна. 2022 онд АНУ-ын энэхүү төрлийн шингэн хүнсний хэрэглээ 242 тэрбум литр, шингэн хүнсний борлуулалтын орлого 447 тэрбум ам.долларт хүрч 2018 оноос 1.0 хувь, 11.9 хувиар тус тус өссөн.

Олон улсын савласан цэвэр усны холбооны "АНУ-ын согтууруулах бус шингэн хүнсний зах зээлийн төлөв байдал"-ын тайланд жил бүр савласан цэвэр усны хэрэглээ нэмэгдэж байгааг хийжүүлсэн ундааны хэрэглээ буурсантай холбож тайлбарласан байна.

**График 24. АНУ-ын согтууруулах бус шингэн хүнсний хэрэглээ, бүтээгдэхүүний төрлөөр, тэрбум литр, эзлэх хувь,** 2018-2022 он




***Эх сурвалж:** Олон улсын савласан усны холбоо*

2018 онд АНУ-ын савласан усны хэрэглээ 53.0 тэрбум литр байсан ба жилд дунджаар 3.4 хувиар нэмэгдэж 2022 оны байдлаар 60.6 тэрбум литрт хүрсэн. Сүүлийн 5 жилийн хугацаанд АНУ-ын савласан усны хэрэглээ нийт 14.3 хувиар нэмэгдэж, 2022 онд дэлхийн савласан усны хэрэглээний 13.6 хувийг бүрдүүлэх болсон байна.

### 11.2.2. Дэлхийн савласан цэвэр усны зах зээл

НҮБ-ийн Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэнгээс 2023 онд нийтэлсэн судалгаанд дэлхийн согтууруулах бус шингэн хүнсний зах зээл 2021 онд 1,225 гаруй тэрбум ам.долларт хүрсэн ба тус зах зээлийн 17-24 хувийг савласан цэвэр усны зах зээл бүрдүүлж буйг тусгажээ. Савласан усны зах зээлийн дүн 2018 оноос нийт 11.6 хувиар нэмэгдэж 2022 онд 303 тэрбум ам.долларт хүрээд байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

**График 25. Дэлхийн савласан цэвэр усны зах зээлийн дүн, тэрбум ам.доллар, өөрчлөлтийн хувь**
2018-2022 он




***Эх сурвалж:** Statista олон улсын судалгааны байгууллага*

Дэлхийн савласан усны зах зээл биет хэмжээгээр 2014 оноос жилд нийлмэл дунджаар 4.5 хувиар нэмэгдэж 2021 онд 354 тэрбум литрт хүрсэн. Statista судалгааны байгууллагын тооцооллоор тус үзүүлэлт 2014 оноос жилд дунлжаар 3.4 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж 2021 онд 467 тэрбум литрт хүрсэн. 2022 оны байдлаар дэлхийн савласан усны зах зээлийн биет хэмжээ 446 тэрбум литрт хүрсэн байна.

**График 26. Дэлхийн савласан усны зах зээлийн биет хэмжээ, бүс нутгаар, сая литр**
2010-2021 он




***Эх сурвалж:** Bottled Water: An Evidence-Based Overview of Economic Viability, Environmental Impact, and Social Equity, 2023 он*

СЗХ 2024.04.29 он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Grand View Research олон улсын судалгааны байгууллагын судалгаагаар савласан цэвэр усны зах зээлийн хэмжээ 2023-2030 онуудад жилд дунджаар 5.9 хувиар өсөх төлөвтэй байна. Сүүлийн 10 жилийн савласан цэвэр усны зах зээлийн өсөлт дунджаар 73.0 хувьд хүрсэн нь бусад зах зээлүүдтэй харьцуулахад хамгийн далайцтай өсөж буй зах зээлийн нэгд зүй ёсоор тооцогдож байна.

Савласан усны борлуулалт нь газарзүйн байршлаас хамаарч ихээхэн ялгаатай байдаг. Ази Номхон далайн бүс нутаг нь савласан усны хэрэглээ болон зах зээлийн дүнгээр тэргүүлдэг. Ази Номхон далайн бүс нутгийн савласан усны зах зээл нийт зах зээлийн дүнгийн 49.0 хувийг эзэлдэг бол Хойд Америкийн савласан усны зах зээл 29.0 хувийг, Европ 11.0 хувийг, Латин Америк 9.0 хувийг, үлдсэн 2.0 хувийг Африкийн бүс нутаг тус тус эзэлж байна.

**График 27. Дэлхийн савласан усны зах зээлийн бүтэц, бүс нутгаар, зах зээлд эзлэх хувь**
2021 он




*Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

2021 оны байдлаар дэлхийн савласан усны нийт зах зээлийн 64 орчим тэрбум ам.доллар буюу 24.0 хувийг АНУ, 50 гаруй тэрбум ам.доллар буюу 18.0 хувийг БНХАУ, 22 тэрбум ам.доллар буюу 8.0 хувийг Индонез улсууд эзэлж байна. Эдгээр улсууд нь дэлхийн савласан цэвэр усны зах зээлийн тал хувийг бүрдүүлдэг. Монгол Улсын хувьд савласан усны зах зээл нь 0.05-0.1 тэрбум ам. долларын зах зээлийн хэмжээ бүхий ангилалд орж байна.

**Зураг 21. Дэлхийн савласан усны зах зээлийн дүн, улсаар, тэрбум ам.доллар**
2021 он




*Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

2021 оноос хойш дэлхийн савласан усны зах зээл нь жил бүр 5.2 хувийн жинлэсэн дундаж нийлмэл өсөлтийг үзүүлж байгаа ба бусад шингэн хүнс, тухайлбал, кофены зах зээлийн 3.5 хувийн жинлэсэн дундаж нийлмэл өсөлтөөс хурдацтай өссөн. 2022 оноос энэхүү зах зээлийн өсөлт 2021 оноос хурдацтай болж жинлэсэн дундаж 7.0 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж, 2025-2030 онд зах зээлийн хэмжээ 500 тэрбум ам.долларт хүрнэ гэж BlueWeave, Grandview Reasearch, Statista зэрэг олон улсын судалгааны байгууллагууд таамаглаж байна. Үүнээс шингэн хүнсний зах зээлд савласан усны зах зээл өндөр өсөлтийг үзүүлэх боломжтой нь харагдаж буй юм.

**График 28. Савласан цэвэр усны зах зээлийн дүнгээр тэргүүлэгч ТОП-50 улс, сая ам.доллар**
2021 он




*Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

СЗХ 2024 .01 сар 29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ

Олон Улсын савласан цэвэр усны нийгэмлэгүүдийн зөвлөл, Олон Улсын савласан цэвэр усны холбоо, Үндны усны судалгааны сан зэрэг олон улсын байгууллагуудаас савласан цэвэр усны төрлүүдийг эх үүсвэр, химийн найрлага, хийжүүлсэн эсэхээс хамааруулан ангилдаг ба олон улсын түвшинд савласан усыг үндсэн 3 төрөлд хуваадаг. Үүнд:

- Байгалийн эрдэст ус;
- Рашаан ус;
- Цэвэршүүлсэн ус.

Дээрх ангиллуудаас гадна хийжүүлсэн, артезийн, мөстлийн ус гэх зэрэг савласан усны дэд ангиллууд байдаг.

Байгалийн эрдэст усыг гүнээс олборлон хэрэглээнд шууд хэрэглэдэг бол рашаан усыг гүнээс газрын гадарга дээр гарч ирэх үед олборлон ашигладаг. Цэвэршүүлсэн ус нь гол мөрөн, нуур, гүний усыг нэрэх, ионгүйжүүлэх, урвуу осмос зэрэг аргуудыг ашиглаж усыг цэвэршүүлж ундаанд хэрэглэхэд тохиромжтой болгосон ус юм.

НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэнгийн 2023 онд нийтэлсэн "Дэлхийн шингэн хүнсний зах зээл" тайланд дурдсанчлан 2021 оны байдлаар савласан усны хэрэглээ 470 тэрбум литрт хүрсэн бөгөөд нийт хэрэглээний 42.0 хувийг цэвэршүүлсэн ус, 20.0 хувийг байгалийн эрдэст ус, үлдсэн 28.0 хувийг бусад төрлүүд эзэлсэн. Үндсэн 3 төрлийн савласан усны хэрэглээ 350 тэрбум литрт хүрч нийт хэрэглээний 74.5 хувийг бүрдүүлж байна. Бусад усны төрөлд рашаан, хийжүүлсэн, артезиан, мөстлийн усны төрлүүд хамаардаг ба доорх графикт харуулав.

**График 29. Савласан усны төрлүүд ба хэрэглээ, тэрбум литр, 450 тэрбум литрт эзлэх хувь**
2021 он




**График 30. Савласан усны үндсэн төрлүүд ба хэрэглээ, тэрбум литр, 350 литрт эзлэх хувь**
2021 он




*Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

Үндсэн 3 төрлийн савласан усны зах зээл 2021 онд 270 тэрбум ам.долларт хүрсэн ба зах зээлийн 28.0 хувийг цэвэршүүлсэн ус, 22.0 хувийг байгалийн эрдэст ус, үлдсэн хувийг бусад байгалийн усны борлуулалт эзэлж байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024 он 04 сар 29 өдөр № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

**График 31. Савласан усны төрлүүд ба орлогын дүн, тэрбум ам.доллар, 270 тэрбум ам.долларт эзлэх хувь**




*Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

Савласан усны зах зээлд цэвэршүүлсэн ба байгалийн эрдэст усны зах зээл бусад төрлийн усны зах зээлээс хурдацтай өсөж 2018 оноос жилд дунджаар тогтмол 10.0 хувь, 12.0 хувиар тус тус өссөн. Ижил хугацаанд, байгалийн бусад төрлийн усны зах зээлийн өсөлт харьцангуй бага буюу жилд ойролцоогоор 5.0 хувиар өссөн байна.

Дэлхийн өмнөд бүсийн улсуудаас Египет Улс цэвэршүүлсэн усны зах зээлийн өсөлтөөрөө тэргүүлж, 2018-2021 онуудад зах зээлийн хэмжээ нь жилийн дундаж нийлмэл өсөлтөөр 40 гаруй хувиар өссөн бол Алжир, Бразил, Индонез, АНУ, Энэтхэг, Марокко, Саудын Араб зэрэг улсууд удаалж 10.0-17.0 хувийн өсөлтийг үзүүлжээ.

Харин байгалийн эрдэст усны хувьд 2018-2021 онуудад зах зээлийн жилийн дундаж нийлмэл өсөлтөөрөө БНСУ 28.0 хувиар, Энэтхэг Улс 27 хувиар, Япон Улс 24.0 хувиар тэргүүлсэн бол Египет, Алжир, Франц, Перу, Өмнөд Африк зэрэг улсууд удаалав. Бусад байгалийн савласан усны зах зээлийн өсөлтөөр Европын улсууд тэргүүлдэг ба Бельги, Нидерланд, Их Британи, Франц зэрэг улсуудын рашаан усны зах зээл 6.0-9.0 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

**Хүснэгт 29. Савласан цэвэр усны зах зээлийн өсөлтөөр тэргүүлэгч улс орнууд, усны төрлөөр, жилийн дундаж нийлмэл өсөлтийн хувь,** 2018-2022 он

| № | Цэвэршүүлсэн ус | | Байгалийн эрдэст ус | | Байгалийн бусад ус | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Египет | 43.3% | БНСУ | 28.0% | Бельги | 9.4% |
| 2 | Алжир | 17.5% | Энэтхэг | 27.1% | Нидерланд | 7.8% |
| 3 | Бразил | 17.2% | Япон | 24.2% | Аргентин | 7.5% |
| 4 | Индонез | 14.8% | Египет | 17.7% | Англи | 7.1% |
| 5 | Арабын Эмират | 12.9% | Алжир | 16.6% | Франц | 6.3% |
| 6 | Энэтхэг | 12.5% | Франц | 16.1% | Япон | 6.0% |
| 7 | Нидерланд | 10.6% | Өмнөд Африк | 13.2% | Испани | 5.9% |
| 8 | Өмнөд Солонгос | 10.3% | Перу | 13.0% | Мексик | 5.6% |
| 9 | Марокко | 10.3% | Малайз | 12.3% | Непал | 5.4% |
| 10 | Саудын Араб | 10.1% | Австрали | 12.3% | Сингапур | 5.4% |

*Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

СЗХ
2024.04.29
БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ

Дээрх хүснэгтээс дүгнэвэл Ази, Номхон далайн бүс нутгийн улсуудын цэвэршүүлсэн ба байгалийн эрдэст савласан усны зах зээлийн жилийн нийлмэл дундаж өсөлт бусад бүс нутагтай харьцуулахад өндөр байгаа бол Америк, Европын бүс нутгийн улсуудын савласан усны зах зээлийн жилийн нийлмэл дундаж өсөлт харьцангүй бага байна.

Савласан усны зах зээлд нөлөөлөх хүчин зүйлс улс бүрийн хувьд харилцан адилгүй. Өндөр орлоготой хөгжсөн улсуудын хувьд ундны усны дэд бүтэц хөгжсөн байдаг ч савласан усны хэрэглээ өндөр хэвээр байдаг. Канад, АНУ улсуудын хүн амын 31.0 хувь ба 38.0 хувь нь савласан усыг ундны усны үндсэн эх үүсвэрээр хэрэглэдэг. Франц Улсад савласан ус нь цоргоны уснаас 350 дахин үнэтэй байдаг ч тус улсын ус ундааны зах зээлийн 64.0 хувийг савласан усны зах зээл эзэлдэг. Итали ба БНСУ-ын хүн амын 60 гаруй хувь нь савласан цэвэр усыг ундны усны гол эх үүсвэрээр хэрэглэдэг.

Өндөр хөгжилтэй орнуудын савласан цэвэр усны өндөр хэрэглээ дараах хүчин зүйлстэй холбоотой. Үүнд:

- Эрүүл мэнд: савласан усыг цоргоны уснаас чанартай, аюулгүй гэж үздэг;
- Амт: савласан ус зохимжит эрдсийн агууламжтай тул илүү амттай байдаг бол цоргоны уснаас хлор амтагддаг, усны амтанд өөрчлөлт орсон гэж үздэг;
- Маркетинг: зорилтот бүлгүүдэд, тухайлбал жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, спортоор хичээллэдэг хүмүүст зориулсан савласан усны брэндийг бий болгодог;
- Амьдралын хэв маяг: савласан усыг хаанаас ч худалдан авах боломжтой, хаана ч авч явах, хэрэглэхэд хялбар байдаг зэрэг хүчин зүйлстэй холбоотой савласан усны хэрэглээ өндөр байдаг.

Эдгээр хүчин зүйлсээс шалтгаалан зарим улсуудын хувьд савласан цэвэр ус нь тансаг хэрэглээ байх хандлагатай бол зарим улсуудын хувьд цоргоны усны чанар муу, ундны усны дэд бүтцийн хөгжил дутмаг эсвэл хуучин байдагтай холбоотойгоор савласан цэвэр усыг хэрэглэдэг байна. Мексик Улсын хүн амын ердөө 20.0 хувь нь цоргоны усны чанарт сэтгэл ханамжтай хэдий ч 90.0 хувь нь ундны уснаас шалтгаалж эрүүл мэндийн байгууллагад ханддаг. Тус улсын хүн амын 80.0 гаруй хувь нь савласан цэвэр усыг ундны усны гол эх үүсвэрээр хэрэглэдэг. Ази, Номхон далайн бүс нутгийн улсуудад ундны усны төв шугамтай холбогдсон хүн амын түвшин бага байдаг учир савласан усыг ундэнд хэрэглэх нь элбэг. Үүнтэй холбоотойгоор Индонез, Тайланд, Филиппин зэрэг улсуудын савласан усны зах зээлийн өсөлт өндөр байдаг. Гана Улсад савласан ус нь хотын хүн амын ундны усны 43.0 хувь, хөдөө суурьшдаг хүн амын ундны усны 12.0 хүртэлх хувийг бүрдүүлдэг бол Нигери Улсад хотын хүн амын 12.0 хувь нь ундны усны гол эх үүсвэрт савласан усыг хэрэглэдэг байна. Эндээс савласан усны хэрэглээ хүн амын орлоготой эерэг хамааралтай нь харагдаж байгаа юм.

Хөгжиж буй улсуудын хувьд савласан усны хэрэглээний хандлага дараах хүчин зүйлсээс шалтгаалдаг. Үүнд:

- Цэвэр, чанартай, аюулгүй ундны усаар хангах хэрэгцээ;
- Хотжилт нэмэгдэхийн хэрээр цэвэр ундны усны дэд бүтцийн дутмаг байдал зэрэг хүчин зүйлстэй холбоотой савласан усны хэрэглээ нэмэгддэг.



"Эм Жи Эл Аква" ХХК MGL AQUA Co.,Ltd 2628333 ГСТ1398 УЛААНБААТАР
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР

График 32. Савласан цэвэр усны хэрэглээгээр тэргүүлэгч ТОП-50 улс, усны төрлөөр, сая литр




Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он

СЗХ 2024.04.29
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ 03

Гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал өндөр хэвээр, гэнэтийн сөрөг өөрчлөлтүүд илрэх магадлал их байгаа өнөөгийн нөхцөлд гадаад секторын эрсдэл даах чадварыг үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай юм. Энэ нь эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

### 11.3.2. Монгол Улсын шингэн хүнсний зах зээл

Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын орчныг шинэчлэх ажлын хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг баталж мөрдөж эхэлсэн. Эдгээр баримт бичигт хүнсний аюулгүй байдлын тухай ойлголт, тодорхойлолтыг тодорхой тусгаж өгсөн байдаг ба хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулснаар иргэд чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн юм.

#### Монгол Улсын аж үйлдвэрийн салбар

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй согтууруулах бус ундааны салбар нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт хамаардаг. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүтцийг дэд салбараар авч үзвэл, 2022 онд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 30.1 хувийг, ундаа үйлдвэрлэл 20.2 хувийг, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 9.1 хувийг, нэхмэлийн үйлдвэрлэл 11.3 хувийг, хувцас үйлдвэрлэл 4.9 хувийг, металл үйлдвэрлэл 6.6 хувийг тус тус эзэлж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар аж үйлдвэрийн салбарт бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж байгууллагуудын 7.0 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарт 6,220 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаагаас хүнсний салбарт 29.8 хувь, ундаа үйлдвэрлэлийн салбарт 2.4 хувь нь хамаарч байна. Мөн энэхүү салбарт 97,447 хөдөлмөр эрхлэгчид ажиллаж байна.

**График 40. Аж үйлдвэрийн салбарт Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, дэд салбараар** 2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

2015 оноос өмнө боловсруулах аж үйлдвэрийн салбарын ихэнх хувийг ундааны үйлдвэрлэл бүрдүүлдэг байсан бол 2015 оноос эхлэн "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" болон Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний бодлогуудыг хэрэгжүүлсэнтэй холбоотой боловсруулах үйлдвэрлэлийн салбарын тал хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлдэг болсон.

Савласан усны хэрэглээгээр тэргүүлдэг АНУ-ын хувьд байгалийн эрдэст усыг түлхүү хэрэглэдэг бол БНХАУ-ын хувьд байгалийн эрдэст ба цэвэршүүлсэн усны хэрэглээ ойролцоо түвшинд байна. Бусад улсуудын хувьд цэвэршүүлсэн савласан усны хэрэглээ нийт хэрэглээний ихэнх хэсгийг эзэлж байна.

Савласан усны чанарт усны эх үүсвэр, цэвэршүүлэх арга, үйл явц, савлагаа, хадгалах нөхцөл, усанд агуулагдах эрдэс бодис, гадны биетийн хэмжээ зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын 2022 оны судалгаагаар бүх усны төрөлд тодорхой хэмжээний эрдэс бодисын илүүдэл, бохирдол агуулагддаг ба усны эх үүсвэрээс шалтгаалан тэдгээрийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Ил гадаргын усны эх үүсвэр болон хамгаалалтгүй худаг, булаг шандын ус хамгийн эрсдэлтэй байдаг бол савласан ба төвийн шугамын ус хамгийн аюулгүй байдаг талаар Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын судалгаанд дурдагдсан байна.

Эрдэс бодисын илүүдэл, бохирдол агуулагддаг ба усны эх үүсвэрээс шалтгаалан тэдгээрийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Ил гадаргын усны эх үүсвэр болон хамгаалалтгүй худаг, булаг шандын ус хамгийн эрсдэлтэй байдаг бол савласан ба төвийн шугамын ус хамгийн аюулгүй байдаг талаар Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын судалгаанд дурдагдсан байна.

Савласан цэвэр усны зах зээлд үндэстэн дамнасан томоохон компаниудаас эхлээд тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын компаниуд үйл ажиллагаа явуулж байна. PepsiCo, Coca-Cola, Nestlé S.A., Danone S.A. болон Primo зэрэг томоохон корпорацууд нь дэлхийн савласан усны зах зээлд дангаараа 25.1 хувийг эзэлдэг бөгөөд 2021 оны байдлаар нийт 65 тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажилласан. Үндэстэн дамнасан компаниудаас гадна орон нутгийн жижиг бизнесүүд энэхүү салбарт ихээхэн нөлөө үзүүлж байна. Тухайлбал, АНУ болон Хятад зэрэг улсуудын дотоодын компаниуд дотоодын хэрэгцээт савласан усны бүтээгдэхүүний 70.0 гаруй хувийг үйлдвэрлээд зогсохгүй бусад улсууд руу их хэмжээгээр савласан ус экспортолдог байна.

**График 33. Дэлхийн савласан усны зах зээлийн тоглогчид, зах зээлийн дунд эзлэх хувь**
2021 он




*Эх сурвалж:* *НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он*

СЗХ 2024. 04. 20 БҮРТГЭВ № 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## 11.3. Монгол Улсын шингэн хүнсний зах зээл ба савласан усны зах зээлийн төлөв байдал

### 11.3.1. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

#### Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол Улсын нэрлэсэн ДНБ нь 2013 онд 19.2 их наяд төгрөг байсан ба жилд дунджаар 12.1 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж, 2022 онд 53.8 их наяд төгрөгт хүрээд байна. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд уул уурхайн салбарын өсөлт томоохон нөлөө үзүүлдэг ба цаашдын эдийн засгийн нөхцөл байдал нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, уул уурхайн салбарын өсөлт, түүний хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай байна.

2021 онд Монгол Улсын экспортын үндсэн түүхий эдүүдийн үнэ өссөн хэдий ч уул уурхайн салбарын нийлүүлэлт буурсан бөгөөд үүнд гадаад худалдааны хязгаарлалт, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, БНХАУ-ын "Тэг Ковид" бодлого ба хилийн хорио, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн.

2022 оны дундаас эхлэн хилийн боомтууд дээрх хязгаарлалт суларч, нүүрсний тээвэрлэлт сэргэж буйтай холбоотойгоор 2021 онд уналттай байсан уул уурхайн салбар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, улс орнуудын цар тахлын эсрэг хөл хорионы дэглэм суларч, дотоодын эрэлт сэргэсний үр дүнд эдийн засгийн салбаруудын идэвхжил нэмэгдэн Монгол Улсын нэрлэсэн ДНБ 2021 оноос 21.4 хувиар өсөж, 2022 оны байдлаар 53.8 их наяд төгрөгт хүрсэн.

Олон Улсын Валютын Сангийн таамаглалаар Монгол Улсын эдийн засаг нэрлэсэн дүнгээр 2023-2028 онуудад дунджаар 13.6 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлэх төлөвтэй байна.

**График 34. Монгол Улсын ДНБ-ийн өсөлт, их наяд төгрөг, 2013-2022 оны гүйцэтгэл, 2023-2028 оны төсөөлөл**




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо ба Олон Улсын Валютын Сангийн таамаглал*



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03
2024.04.29

## Гадаад худалдаа

2022 оны эцэст гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5,156 сая ам.доллароор өсөж, 21,243 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд экспорт 35.7 хувиар буюу 3,297 сая ам.доллароор, импорт 27.2 хувиар буюу 1,859 сая ам.доллароор өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,438 сая ам.доллароор өсөж, 3,834 сая ам.долларын ашигтай гарсан байна. Нийт экспортын өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ болон үнийн өсөлт нь голлох нөлөөг үзүүллээ.

Монгол Улс 2023 оны эхний хагас жилд нийт 143 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 11.8 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум ам.доллар, импорт 4.3 тэрбум ам.доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.9 хувиар буюу 2.6 тэрбум ам.доллароор, экспорт 42.5 хувиар буюу 2.3 тэрбум ам.доллароор, импорт 325.6 сая ам.доллароор тус тус өссөн өсөв.

**График 35. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллар**
2013-2022 он




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Хилийн хязгаарлалтууд суларч, Оюу Толгойн ил уурхайн үйлдвэрлэлийн агууламж сэргэн, далд уурхайн үйлдвэрлэл 2023 оны сүүл үеэс жигдэрч эхэлбэл экспортын орлогыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын нэг хэсэг болох Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд Оюу Толгойн гүний уурхайн олборлолтыг 2023 оны 03-р сарын 13-ны өдөр эхлүүлснээр зэсийн баяжмалын үйлдвэрлэлд ил уурхайн хүдрээс гадна нэмж газрын гүний 1.3 км-ээс олборлосон хүдрийг ашиглах боломж бүрдсэн билээ. Гүний уурхай бүрэн ашиглалтад орсноор Монгол Улс дэлхийд дөрөвт эрэмбэлэгдэх өндөр технологийн гүний уурхайтай болж, олон улсын зах зээлд зэсийн томоохон тоглогчдын нэгд тооцогдож эхлэхээс гадна дотоодын эдийн засаг болон улсын төсөвт оруулах үр өгөөж багадаа 3 дахин нэмэгдэх тооцоолол гарсан байна. Оюу Толгойн ил болон гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр 2028-2036 онуудад жилд 500 мянган тонн зэс олборлохоор төлөвлөж байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт түүхий эдийн үнэ, нөгөө талаас экспортын биет хэмжээ хэр байхаас ихээхэн хамаардаг учир хамгийн том худалдааны түнш орон болох БНХАУ-ын эдийн засаг, хилийн хориг саадын нөхцөл байдал ирэх жилүүдэд манай орны эдийн засгийн нөхцөл байдалд шууд нөлөөлөхөөр байна.



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
Эм Жи Эл Акуа ХХК
MGL AQUA Co.,Ltd

2024.04.29
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ 03

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын нийт экспортын 93 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн байгаа нь уул уурхайн салбарын дотоодын эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр өндөр байгааг илэрхийлж байна. Иймд уул уурхайн экспортын голлох түүхий эд болох зэс болон нүүрсний үнийн хэлбэлзэл манай улсын эдийн засагт томоохон нөлөөлөл үзүүлдэг.

2022 оны байдлаар дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ мянган тонн тутам нь 8,375 ам.доллар байна. Цаашид дэлхийн сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон гибрид машин, хотжуулалт, цахилгаанжуулалт, эрүүл мэндийн салбаруудын өсөлттэй холбоотойгоор зэсийн үнэ 2023 онд мянган тонн тутам нь 11,000 ам.доллар, 2024 онд 12,000 ам.доллар болж жилд дунджаар 20 орчим хувиар өсөх төсөөллийг Goldman Sachs хөрөнгө оруулалтын банкны зүгээс гаргасан байна. Мөн худалдан авалтын зэсийн эрэлтийн ихээхэн хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал зэсийн үнэд ихээхэн нөлөөтэй байдаг.

БНХАУ-ын "Тэг Ковид" бодлогын хязгаарлалт суларч, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр тус улсын нүүрсний импорт 2023 онд эрчимжив. 2023 оны эхний хагас жилд БНХАУ-ын коксжих нүүрсний импорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 73.7 хувиар өсөж 7.7 сая тоннд хүрсэн ба коксжих нүүрсний импортын 49.0 гаруй хувийг Монгол Улс дангаараа хангасан байна. 2021 оноос хойш Монгол Улс, ОХУ-ын нүүрсний экспорт бусад улсуудаас өндөр хувийг эзэлж байгаа ба энэ үзүүлэлт цаашид өсөхөөр хүлээгдэж байна.

Нүүрсний экспортын хувьд 2022 онд нүүрсний дундаж үнэ тонн тутамд 353.4 ам.долларт хүрсэн нь 2021 оноос 172.4 ам.доллароор өндөр буюу 95 гаруй хувиар өссөн дүн байна. 2021 оны сүүлээс эхэлсэн эрчим хүчний хямрал ОХУ-Украйны дайнаас шалтгаалан улам нэмэгдэх хандлагатай байгаа ба ОХУ-ын нүүрсэнд Европын орнууд хориг тавьсан нь нийлүүлэлтийг багасгаж, үнийг өсгөж, Өмнөд Африк болон бусад орнуудын нүүрс олборлогчдын орлогыг нэмэгдүүллээ. Цар тахлын дараах эрэлтийн улмаас нүүрсний үнэ 2021 оны 10-р сараас хойш тасралтгүй өссөн бөгөөд 2022 оны эхэн үетэй харьцуулахад ойролцоогоор 3 дахин өсөв. Дунд хугацаанд дэлхий нийтийн эдийн засгийн сэргэлт, эрчим хүчний томоохон үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт нэмэгдэж нүүрсний үнэ тогтворжино гэж шинжээчид таамаглаж байна. Харин Дэлхийн банкны түүхий эдийн зах зээлийн төлөв байдлын тайланд дурдсанаар инфляцын талаарх түгшүүртэй байдал, тээвэр логистикийн хүндрэл, эдийн засгийн өсөлтийн тодорхойгүй байдал зэргээс улбаалан нүүрсний үнэ тонн тутам нь 2023 онд 42.0 хувиар, 2023 онд 23.0 хувиар буурах төсөөллийг гаргаад байна.

**График 36. Дэлхийн зах зээл дээрх нүүрс ба зэсийн үнэ, ам.доллар, улирлаар**
2013-2023 оны 6-р сарын 30




*Эх сурвалж: Fred St.Louis Fed судалгааны байгууллага*



МГЛ Аква ХХК MGL AQUA Co.,Ltd
InvesCore CAPITAL

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ

## Шинэ сэргэлтийн бодлого

Монгол Улсын Засгийн Газрын Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шинээр 3,358 км төмөр зам барьж ашиглалтад оруулан 13 аймагт дэд бүтэцтэй болохыг зорьж байгаа билээ. Уг бодлогын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас дараах 10 төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

**Хүснэгт 30. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хийгдэх боомтын сэргэлтийн ажлын төсөл**

| Төмөр замын чиглэл | Хийгдэх ажил | Хугацаа |
|---|---|---|
| Сүхбаатар-Замын Үүд | Төмөр замыг шинэчлэн сайжруулах | 2022-2030 |
| Эрээнцав-Баянтүмэн (238 км) | Төмөр замыг шинэчлэн сайжруулах | 2022-2026 |
| Зүүнбаян-Ханги (226.9 км) | Шинээр барих | 2022-2023 |
| Чойбалсан-ХӨӨТ (192 км) | Шинээр барих | 2022-2024 |
| Хөөт-Бичигт (294.1 км) | Шинээр барих | 2022-2024 |
| Сайншанд-Баруун-Урт (394 км) | Шинээр барих | 2024-2027 |
| Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн (1,255 км) | Шинээр барих | 2022-2026 |
| Тавантолгой-Зүүнбаян (415.9 км) | Шинээр барих | 2022 |
| Тавантолгой-Гашуутсухайт (226.6 км) | Шинээр барих | 2022 |
| Богдхаан (144.6 км) | Шинээр барих | 2021-2024 |

*Эх сурвалж: Монгол Улсын Зам Тээврийн Хөгжлийн яам*

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Боомтын сэргэлтийн ажлууд хийгдэж, дэд бүтэц хөгжсөнөөр зүүн, баруун бүсэд байрладаг 230 ашигт малтмалын ордуудыг эргэлтэд оруулах, төмөр замаар тээвэр хийх ачааны хэмжээ 100 сая тонн хүрч, экспортын нүүрс тээвэрлэлтээс олсон орлого 5-6 тэрбум ам.долларт хүрч, 13,000 байнгын болон 20,000-30,000 түр ажлын байр бий болгох урьдчилсан таамаглал гарсан байна.

2023 онд үндэсний их бүтээн байгуулалт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км хэвтээ тэнхлэгийн төмөр зам ашиглалтад орох төлөвлөгөөтэй ба уг төмөр зам нь Тавантолгойн бүлэг ордын уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ, ОХУ руу экспортлох шинэ гарц бий болгохоос гадна төмөр замын трассын дагуу Цагаан суварга, Хармагтай, Манлай зэрэг нүүрс, төмөр, зэс, цайрын томоохон орд газруудад байрлаж байгаа нь ирээдүйд уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхэд голлох дэмжлэг үзүүлэх төмөр замын чиглэл болох юм. Зүүнбаян-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор жилдээ 30-50 сая тонн нүүрс экспортолж, Тавантолгой бүлэг уурхайн олборлолт 2-3 дахин нэмэгдэнэ гэж төсөөлсөн байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23

## Инфляц

2021 онд Монгол Улсын инфляц 14.8 хувьд хүрсэн ба энэхүү огцом өсөлтөд шатахууны үнийн өсөлт, импортын бараа бүтээгдэхүүний саатал, тээвэрлэлтийн салбар дахь үнийн нэмэгдэл, хорио болон бусад хүндрэлүүд голлох нөлөө үзүүлсэн. Дотоодын хэрэглээний 60 гаруй хувийг импортоор авдаг Монгол Улсад импортын барааны тасалдлаас үүдэж барилгын материал болон бусад бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ хурдацтай өссөн.

2022 оны эцсийн байдлаар инфляц 13.2 хувь байсан нь олон улсын геополитикийн сөрөг нөхцөл байдал, гадаад худалдааны тогтворгүй байдал, хориг арга хэмжээнүүд зэрэг хүчин зүйлсийн нөлөөтэй. Шинжээчид инфляцын түвшнийг 2023 оныг дуустал Монголбанкны зорилтот интервалаас давсан хэвээр байна хэмээн таамаглаж байна. Махны үйлдвэрлэл нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр хүнс, эрчим хүчний үнэ буурч, Монгол Улс ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүнийг хямдралтай үнээр авах тохиролцоонд хүрсэн зэрэг нь инфляцыг бууруулах боломжтой байна.

Дунд хугацаанд гадаад үнэ тогтворжих, ханш бага зэрэг чангарснаар импортын бараа, үйлчилгээний инфляц алгуур буурах ба хүнсний салбарын инфляцын хувьд дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ буурах, нийлүүлэлтийн доголдол арилах зэрэг нөлөөгөөр буурч, 2024 оны 2-р улирлаас нэг оронтой тоонд хүрч тогтворжих төлөвтэй. Ийнхүү нийт инфляц 2023 оны эцэст цаашид тогтвортой буурах хүлээлттэй байна.

**График 37. Монгол Улсын инфляцын түвшин, ХҮИ-ээр тооцсон оны дундаж үзүүлэлт**
2013-2022 он, 2023-2028 он




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

## Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2022 онд хил гаалийн хязгаарлалт, тээвэр логистикийн асуудалтай холбоотойгоор нүүрс болон үндсэн түүхий эдийн экспорт зорилтот дүндээ хүрээгүйтэй холбоотой 727 сая ам.долларын алдагдалтай гарсан. Тухайн жилд урсгал дансны алдагдал 2,304.0 сая ам.доллар, хөрөнгө болон санхүүгийн данс нь 1,798.0 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

2024 .04 .29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

**Хүснэгт 30. Монгол Улсын тэнцэл, сая ам.доллар**
2013-2022 он

| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Урсгал данс | (4,732) | (1,935) | (949) | (700) | (1,155) | (2,207) | (2,162) | (675) | (2,108) | (2,304) |
| Хөрөнгийн данс | 141 | 136 | 116 | 91 | 78 | 92 | 161 | 103 | 114 | 154 |
| Санхүүгийн данс | 2,808 | 1,504 | 788 | 812 | 2,599 | 2,091 | 2,678 | 1,504 | 1,982 | 1,644 |
| Алдаа, орхигдуулаг | (84) | (176) | (223) | (221) | (62) | (118) | (224) | (146) | (209) | (222) |
| Төлбөрийн тэнцэл | (1,867) | (471) | (268) | (18) | 1,460 | (142) | 453 | 787 | (222) | (727) |

***Эх сурвалж:*** *Үндэсний Статистикийн Хороо*

Нүүрсний экспортын биет хэмжээ 2023 оны 01-р улиралд түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь экспортын орлогын өсөлтөд голлон нөлөөлсөн. Мөн хэрэглээний бүтээгдэхүүний импорт буурснаар урсгал тэнцлийн алдагдал багассан ч, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт, үйлчилгээний дансны алдагдал өндөр хэвээр байна.

## Гадаад өр

2022 оны жилийн эцэст Монгол Улсын Засгийн газрын гадаад өр өмнөх оны мөн үеэс 444.8 сая ам.доллароор буурч, 8,009.4 сая ам.доллар болсон нь олон улсын зах зээлд арилжаалсан зарим бондын үндсэн төлбөрийг төлсөнтэй холбоотой. Монголбанкны гадаад өр 2022 оны жилийн эцэст өмнөх оны мөн үеэс 431.8 сая ам.доллароор буурч, 2,178.2 сая ам.долларт хүрсэн байна.

2023 оны 01-р улирлын байдлаар Монгол Улсын гадаад өр 330.7 сая ам.доллароор буурч 33.6 тэрбум ам.доллар болоод байгаа бол үүний 8.2 тэрбум ам.доллар нь Монгол Улсын Засгийн газрын өр, 2.1 тэрбум ам.доллар нь Монголбанкны, 13.5 тэрбум ам.доллар нь гадаадын шууд хөрөнгө оруулалт эсвэл компани хоорондын зээл, үлдсэн 8.2 тэрбум ам.доллар нь компанийн өр зээл байна.

Тэгвэл Монгол Улсын Засгийн газраас өрийн удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс олон улсын зах зээл дээр Гэрэгэ болон Хуралдай бондуудад бүтцийн өөрчлөлт хийх тендер саналыг 2023 оны 01-р сарын 09-ний өдөр зарласан. Түүний дагуу Гэрэгэ бондын хөрөнгө оруулагчдаас 109.3 сая ам.долларыг хугацаанаас өмнө худалдах, 273.3 сая ам.долларыг шинэ бондоор солих, Хуралдай бондын хөрөнгө оруулагчдаас 49.3 сая ам.долларыг хугацаанаас өмнө худалдах, 295.2 сая ам.долларыг шинэ бондоор солих хүсэлт ирсэн. Харин шинэ бондоор солих саналыг Гэрэгэ бондын хувьд 40 сая доллар буюу 16.98 хувиар, Хуралдай бондын хувьд 160 сая ам.доллар буюу 55.922 хувиар тус тус биелүүлсэн. Ингэснээр хуучин бонд эзэмшигчдээс 200 сая ам.доллар, шинээр ирсэн захиалга 450 сая ам.доллар байсан ба нийт 650 сая ам.долларын 8.65 хувийн хүүтэй, 2028 оны 01-р сарын 19-нд дуусах шинэ бонд олон улсын зах зээлд гарсан. Тус бондоос босгосон мөнгөөр 2022 оны 05-р сард Гэрэгэ бондын үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулсан.

Шинжээчид Монгол Улсын гадаад өр төлбөрийн оргил үеийг 2023-2024 онуудад байна гэж үзэж байна. Учир нь 2023-2024 онуудад "Сэргэн мандалт" евробондын үлдэгдэл 500 сая ам.доллар, "Самурай" бондын үлдэгдэл 235 сая ам.доллар, "Хуралдай" бондын үлдэгдэл 392.56 сая ам.доллар, Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцэл зэрэг төлбөрүүд төлөгдөх хуваарьтай байна. "Самурай" бондоос бусад өр, төлбөрүүдийг гадаад бонд, зээлээр дахин санхүүжүүлэх ба санхүүжилтийн эрсдэл үүсэх тохиолдолд ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээ 60.7 хувиас 65.0 хувьд хүрэхээр байгаа нь Засгийн газрын өрийн таазанд тулах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-02

**Хүснэгт 31. Монголбанкны үндсэн бондын санхүүжилтийн тухай мэдээлэл**

| Үнэт цаас гаргагч | Бонд | Валют | ISIN дугаар | Дуусах огноо | Үндсэн төлбөрийн үлдэгдэл | Купоны хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын Засгийн Газар | Mongolia 17/24 (Хуралдай) | ам.доллар | USY6142NAA64 | 2024/03/09 | 600 сая | 8.75% |
| | Mongolia 17/23 (Гэрэгэ) | ам.доллар | USY6142NAB48 | 2023/05/01 | 533 сая | 5.63% |
| | Mongolia 20/26 (Номад) | ам.доллар | USY6142NAC21 | 2026/04/07 | 600 сая | 5.13% |
| | Mongolia 12/22 (Чингис) | ам.доллар | US60937GAB23 | 2022/12/05 | 138 сая | 5.13% |
| | Mongolia 21/27 (Century) | ам.доллар | USY6142NAF51 | 2027/07/07 | 500 сая | 3.5% |
| | Mongolia 21/31 (Century) | ам.доллар | USY6142NAE86 | 2031/07/07 | 500 сая | 4.45% |
| Монгол Улсын Хөгжлийн банк | DBM' 23 (Самурай) | япон иен | | 2023/12/25 | 30 тэрбум | 1.52% |
| | DBM 18/23 (Сэргэн мандалт) | ам.доллар | USY2056PAA40 | 2023/10/23 | 500 сая | 7.25% |
| МИК ОССК | MGMTGE 21/24 (Бортэ) | ам.доллар | USY6142GAB96 | 2024/02/08 | 250 сая | 8.85% |
| Монголиан Майнинг Корпорэйшн | MMC 19/24 | ам.доллар | USG61759AA70 | 2024/04/15 | 440 сая | 9.25% |
| | MMC 23/26 | ам.доллар | | 2026/09/13 | 180 сая | 12.5% |

*Эх сурвалж: Монголбанкны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл"*

### Мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүү

Монголбанк 2020 оноос 2021 оны эхэн үе хүртэл эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг үе шаттайгаар бууруулж, 6.0 хувьд хүргэсэн боловч гадаад орчинд бий болсон өөрчлөлт, түүнтэй холбоотой логистикийн хүндрэлээс үүдсэн зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляцын түвшин 2021 оны эцэст улсын хэмжээнд 11.2 хувь болон нэмэгдсэн. Иймд Монголбанк нь инфляцыг бууруулах зорилготойгоор бодлогын хүүг 2022 оны 01-р сарын 31-нд 0.5 нэгж хувиар, 03-р сарын 24-нд 2.5 нэгж хувиар, 06-р сарын 22-нд 1.0 нэгж хувиар, 09-р сарын 20-нд 2.0 нэгж хувиар, 12-р сарын 16-нд 1.0 нэгж хувиар тус тус нэмэгдүүлэн оны эцэст 13.0 хувьд хүргэсэн. 2023 оны 06-р сарын 30-ны байдлаар бодлогын хүү 13.0 хувь хэвээр байна.

2023 оны эхний улиралд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, банкны системийн гадаад цэвэр актив нэмэгдсэнээр M2 мөнгөний нийлүүлэлт эрчимжсэн. Тус оны 04-р сард арилжааны банкнуудын гадаад актив буурснаар M2 мөнгөний өсөлтийн хурд саарав. Банкны системийн эх үүсвэр талаас гадаад валютын харилцах дансны өөрчлөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөлсөн. Банкны системийн зээл өнгөрсөн оны сүүлийн улирлуудад хурдацтай саарч байсан бол 2023 оны эхний 4 сарын байдлаар тогтвортой байна. Зээлийн зориулалтаар нь авч үзвэл хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл өсөлттэй байсан бол бизнесийн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад хумигдсан.



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL
Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ

**График 38. Монголбанкны бодлогын хүү, хувь**
2018-2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж:* Монголбанк

## Гадаад валютын нөөц

2022 оны эхээс Монгол Улсын гадаад валютын албан нөөц нь 3.9 тэрбум ам.долларт хүрсэн бол 06-р сараас аажмаар буурсан байна. Үүнд экспортын орлого буурсан болон Монголбанк валютын ханшийг тогтвортой байлгахын тул интервенц ихээр гүйцэтгэсэн нь нөлөөлсөн байна. Сүүлийн жилийн хугацаанд гадаад шокийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарч, инфляц нэмэгдэх нь дотоодод тэнцвэргүй байдал үүсгэсэн ба экспортын орлого буурснаар урсгал дансны алдагдал 2022 оны 06-р сард 2.0 тэрбум ам.долларт хүрсэн.

2023 эхэн үеэс экспортын орох урсгал нэмэгдэж, гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 2023 оны эхний 5 сарын турш эерэг байсан нь гадаад валютын албан нөөц 2023 оны эхний хагас жилийн байдлаар 3,818 сая ам.доллар хүрэхэд нөлөөлөв. Гэвч АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ 2023 оны 05-р сард үргэлжлүүлэн нэмэгдүүлж, ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарч байгаа нь төгрөгийн ханшид сулрах дарамт үзүүлсэн хэвээр байна.

**График 39. Гадаад валютын албан нөөц, сая ам.доллар, сараар**
2022-2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж:* Монголбанк

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

Боловсруулах аж үйлдвэрийн салбар нь дараах дэд салбаруудаас бүрддэг. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
- Ундааны үйлдвэрлэл /согтууруулах бус ба согтууруулах ундаа хамаарна/;
- Бусад гээд нийт 10 дэд салбараас бүрддэг.

**График 41. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүтэц, дэд салбар, хувь**
2013-2021 он




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2022 онд 1.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 162 тэрбум төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн бол хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 1.7 их наяд төгрөг болж, 2021 оноос 211 тэрбум төгрөгөөр буюу 14.2 хувиар нэмэгдсэн. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар нь мах, сүү, жимс, үр тариа гэх мэт дэд салбаруудыг хамаардаг.

**График 42. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба борлуулалт, их наяд төгрөг**
2013-2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03
2024.04.29
БҮРТГЭВ

Монгол Улс сүүлийн жилүүдэд хүнсний аюулгүй байдалд ихээхэн анхаарал хандуулж, дотоодын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх зорилтыг тавин бодлого, хөтөлбөр хэрэгжүүлсээр байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ундааны үйлдвэрлэл 2022 онд 1.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 195 тэрбум төгрөгөөр өссөн бол тус салбарын борлуулалт 2022 онд 1.7 их наяд төгрөгт хүрч, 2021 оноос 318 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Энэхүү үзүүлэлтүүд 2023 оны эхний хагас жилийн байдлаар тус бүр 0.5 их наяд, 1.0 их наяд төгрөг болсон байна.

**График 43. Ус, ундаа үйлдвэрлэл ба борлуулалт, их наяд төгрөг**
2013-2023 оны 06-р сарын 30




***Эх сурвалж:** Үндэсний Статистикийн Хороо*

Ундаа үйлдвэрлэлийн дэд салбарт архи, спирт, дарс, шар айраг, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, амтат ус, ундаа, сироп, шүүс, цай, энергийн ундаа зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамааруулдаг.

Монгол Улсын шингэн хүнсний үйлдвэрлэл 2013-2022 онуудад жилд дунджаар 6.8 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж 2022 онд 541 мянган тоннд хүрсэн. Түүхэн 10 жилийн хугацаанд шингэн хүнсний үйлдвэрлэлийн дунджаар 29.9 хувийг согтууруулах төрлийн шингэн хүнс, 70.1 хувийг согтууруулах бус шингэн хүнсний үйлдвэрлэл эзэлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар эдгээр үзүүлэлт 26.0 хувь, 74.0 хувьд тус тус хүрсэн байна.

Согтууруулах төрлийн шингэн хүнсэнд спирт, архи, дарс, шар айраг багтдаг бөгөөд 2013 онд нийт шингэн хүнсний үйлдвэрлэлд 32.8 хувийг эзэлж байсан бол 2022 онд 30.6 хувь болж буурсан. Согтууруулах бус шингэн хүнсэнд цэвэр ус, амтат ус, ундаа, шүүс, сироп, цай энергийн ундаа багтдаг ба 2013 онд нийт шингэн хүнсний үйлдвэрлэлд 67.2 хувийг эзэлж байсан бол 2022 онд 69.4 хувь болж өссөн. Үүнээс Монгол Улсын шингэн хүнсний үйлдвэрлэлийн ихэнх хувийг согтууруулах бус төрлийн шингэн хүнс эзэлж байгаа нь харагдаж байна.


"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ

**График 44. Монгол Улсын шингэн хүнсний үйлдвэрлэлийн хэмжээ, дэд салбараар, мянган тонн**
2013-2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй согтууруулах бус шингэн хүнсний салбарын гадаад худалдааны тэнцэл 2022 онд 51.1 сая ам.доллар болж, 2021 оноос 83.1 хувиар нэмэгдсэн.

**График 45. Согтууруулах бус шингэн хүнсний гадаад худалдаа, сая ам.доллар**
2013-2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж: Гаалийн цахим үйлчилгээний систем*

Сүүлийн 10 жилийн согтууруулах бус шингэн хүнсний импортын дүн жилд дунджаар 8.8 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж, 2022 онд 51.4 сая ам.долларын согтууруулах бус шингэн хүнсний бүтээгдэхүүн импортолж, 0.27 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолсон. Импортолсон шингэн хүнсний бүтээгдэхүүнээс дунджаар 4.8 хувийг савласан ус, хийжүүлсэн ус, мөс, үлдсэн 95.2 хувийг бусад бүтээгдэхүүн бүрдүүлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар тус харьцаа 8.5 хувь ба 91.5 хувь болж, шингэн хүнсний импортод эзлэх савласан усны хэмжээ нэмэгдсэн байна.

СЗХ 2024-02-29
MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### 11.3.3. Монгол Улсын савласан цэвэр усны зах зээл

Монгол Улсын савласан усны импортын дүн түүхэн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 18.0 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж 2022 онд импортын дүн 4.3 сая ам.доллар болсон. Тус үзүүлэлт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1.2 сая ам.доллар байна.

**График 46. Согтууруулах бус шингэн хүнсний импорт, төрлөөр, сая ам.доллар**




*Эх сурвалж: Гаалийн цахим үйлчилгээний систем*

Савласан усны экспорт өмнөх жилүүдэд хэлбэлзэлтэй байсан бөгөөд 2021, 2022 онуудад савласан усны экспорт хийгдээгүй юм. Иймд савласан усны үндэсний үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ экспортод гаргах боломж байгааг харуулж байна.

**График 47. Савласан усны экспорт, нийт согтууруулах бус шингэн хүнсний экспортод эзлэх хувь, сая ам.доллар, хувь**




*Эх сурвалж: Гаалийн цахим үйлчилгээний систем*

Монгол Улсын савласан усны зах зээлийн хэмжээг хүн амын хэрэгцээ болон үйлдвэрлэлийн статистик, импорт ба экспортын статистикийг үндэслэн тодорхойлох боломжтой. Дотоодын нийлүүлэлт болон импорт, экспортын хэмжээгээр тодорхойлсон нийт зах зээлд Үнэт цаас гаргагчийн эзлэх хувь 2022 оны байдлаар 32.1 хувь байна.

**Хүснэгт 32. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь**
2018-2022 он

| Үзүүлэлт, мянган тонн | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023H1 |
|---|---|---|---|---|---|---|
| Савласан усны үйлдвэрлэл | 73,740 | 98,641 | 74,606 | 98,362 | 100,463 | 55,032 |
| Савласан усны импорт | 1,556 | 2,119 | 1,869 | 3,349 | 5,079 | 1,296 |
| Савласан усны экспорт | 12.9 | 52.2 | 0.0 | - | 0.1 | 0.1 |
| Монгол Улсын савласан цэвэр усны зах зээл | 75,284 | 100,707 | 76,475 | 101,711 | 105,542 | 56,328 |
| Үнэт цаас гаргагчийн борлуулалт | 21,714 | 27,741 | 26,907 | 29,890 | 33,847 | 15,889 |
| **Эзлэх хувь** | **28.8%** | **27.5%** | **35.2%** | **29.4%** | **32.1%** | **28.2%** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол, Үндэсний Статистикийн Хороо, Гаалийн цахим үйлчилгээний систем*

Монгол Улс түүхэн 5 жилийн хугацаанд савласан цэвэр усны дотоод хэрэгцээний дунджаар 97.1 хувийг дотоод үйлдвэрлэл, 2.9 хувийг импортоор хангасан байна. Энэ хугацаанд Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь 28.8 хувиас 32.1 хувь болж өсснөөр Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь нэмэгдэж байгааг харуулж байна.

**График 48. Савласан цэвэр ус үйлдвэрлэлийн хэмжээ , мянган тонн, зах зээлд эзлэх хувь**
2018-2023 оны 06-р сарын 30




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Гаалийн цахим үйлчилгээний систем*

Дэлхийн банкны "Монгол Улс, Өмнөд говийн бүс: Гидроэкономик шинжилгээ" судалгаанд хүн амын өсөлт нь хүн амын ус хэрэглээний цаашдын өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйл гэж тусгасан ба 2013-2022 онуудад савласан усны зах зээлийн хэмжээ ба Монгол Улсын нийт хүн амын тоог үндэслэн жишиг нэг хүнд ногдох савласан усны жилийн хэрэглээг тооцсон байдаг. Тус үзүүлэлт 2013 онд 13.7 литр байсан бол 2022 онд 30.6 литр болж, жилийн дунджаар 9.3 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлсэн байна.

**График 49. Монгол Улсын нэг хүний савласан цэвэр усны жилийн хэрэглээ, литр**
2013-2022 он




***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн тооцоолол, Үндэсний Статистикийн Хороо*

Дээрх нэг хүний жишиг хэрэгцээ болон дотоодын бодит савласан цэвэр усны үйлдвэрлэл, савласан цэвэр усны импорт, экспортын статистик мэдээллийг үндэслэн зах зээл, Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувийг тодорхойлоо. Савласан усны зах зээлд хүн амын өсөлт, өрхийн дундаж орлого, хэрэглэгчийн зан төлөв, тухайн бүс нутгийн аж үйлдвэржилт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг бөгөөд Монгол Улсын савласан цэвэр усны хэрэглээ олон улсын дундаж хэрэглээтэй харьцуулахад бага байгааг дараах хүснэгтээс харж болно.

СЗХ
2024 .04 .29 өдөр
БҮРТГЭВ
№ 21

MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

**Хүснэгт 33. Олон улсын нэг хүний савласан цэвэр усны жилийн хэрэглээ, литр**
2018-2020 он

| Улс | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|
| Нижер | 10.7 | 10.9 | 10.5 |
| Вьетнам | 13.9 | 15.0 | 14.9 |
| Дани | 17.4 | 17.2 | 15.6 |
| Тажикстан | 20.8 | 21.2 | 19.0 |
| Малайз | 20.8 | 21.0 | 20.5 |
| **Монгол Улс** | **23.2** | **30.5** | **22.8** |
| Камбож | 24.6 | 25.3 | 22.9 |
| Кени | 25.3 | 26.2 | 26.6 |
| Киргизстан | 27.4 | 27.6 | 25.7 |
| Узбекистан | 28.0 | 30.5 | 28.1 |
| Австрали | 29.6 | 29.2 | 28.3 |
| Нигери | 30.3 | 30.1 | 28.2 |
| Катар | 38.8 | 39.0 | 33.6 |
| Хорват | 42.4 | 41.8 | 40.9 |
| Египет | 47.8 | 50.6 | 48.9 |
| Тайвань | 50.5 | 49.4 | 41.6 |
| **Дэлхийн дундаж** | **51.9** | **54.3** | **52.4** |
| Тайланд | 52.3 | 57.6 | 53.3 |
| Эквадор | 57.8 | 57.0 | 49.5 |
| Колумб | 62.1 | 62.6 | 55.7 |
| Казахстан | 66.1 | 67.8 | 62.8 |
| Болгар | 72.9 | 75.9 | 71.9 |
| БНХАУ | 74.9 | 79.5 | 74.5 |
| Эл Сальвадор | 75.8 | 76.6 | 67.5 |
| Турк | 81.2 | 80.5 | 86.4 |
| Чили | 84.1 | 84.4 | 78.1 |
| Аргентин | 93.9 | 93.3 | 89.0 |
| Франц | 140.7 | 142.5 | 125.4 |
| ОХУ | 154.3 | 155.2 | 152.7 |
| АНУ | 160.4 | 165.4 | 170.8 |
| ХБНГУ | 143.3 | 143.2 | 125.1 |
| Итали | 187.0 | 199.9 | 221.3 |

***Эх сурвалж:*** *Олон улсын савласан усны холбоо, Statista олон улсын судалгааны байгууллага*

Олон улсад өнгөрсөн жилүүдэд нэг хүнд ногдох савласан усны хэрэглээ тогтвортой өссөн бөгөөд савласан шингэн хүнсний салбарын хамгийн хурдацтай хөгжиж буй дэд салбар бол савласан цэвэр усны салбар юм. 2018-2020 оны байдлаар олон улсын судалгааны байгууллагуудаас гаргасан савласан усны хэрэглээний жилийн дундаж нийлмэл өсөлт 6.5 хувь байсан ба 2026 он хүртэл савласан усны хэрэглээ олон улсад жил бүр 10.0 хувиар өсөх төлөвтэй байна гэсэн судалгааг Рейхманы Тогтвортой хөгжлийн сургууль, Хайфагийн Байгаль орчны инженерийн факультет, Хайфагийн Технион-Израил технологийн дээд сургуулиуд хамтран гаргасан байна.

Хүн амын бодит өсөлт 2013-2022 онуудын хооронд жилд дунджаар 1.8 хувийн нийлмэл өсөлттэй байсан ба Үндэсний Статистикийн Хорооноос тооцсон "Монгол Улсын харьяат хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, хүйс, насны бүлэг, дунд хувилбар 26, 2020-2050 он" төсөөллийн дагуу хүн амын ирээдүйн буюу 2023-2028 оны жилийн дундаж өсөлт 1.6 хувь байна гэж таамагласан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
2024 .04с 29

## Савласан цэвэр усны зах зээлийн өрсөлдөөн

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар дотоодын 152 үйлдвэр савласан ус, үндсэн үйлдвэрлэл чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ба 45 гаруй брэндийн цэвэр, амтжуулсан, хийжүүлсэн, эрдэст рашаан зэрэг савласан усны брэндүүд үүсээд байна.

**Хүснэгт 34. Савласан цэвэр ус үйлдвэрлэгчид**

| № | Савласан ус үйлдвэрлэгч | Савласан усны брэнд |
|---|---|---|
| 1 | "Эм Жи Эл Акуа" ХХК | Voyage |
| 2 | "М-Си-Эс Кока Кола" ХХК | Bonaqua |
| 3 | "Жем интернэйшнл" ХХК | Khujirt |
| 4 | "АПУ" ХК | Vita |
| 5 | "Монос хүнс" ХК | Ekos |
| 6 | "Витафит" ХХК | Orgiluun |
| 7 | "Мон жүүс" ХХК | Ara |
| | Бусад | Бусад |

***Эх сурвалж:** Үндэсний Статистикийн Хороо, Ebazaar on time захиалгын систем*

Ebazaar ontime захиалгын цогц системийн компани 2023 оны 6-8 сар буюу зуны гурван сарын хугацаанд Монгол Улсын 1,637 худалдааны цэгийн цэвэр ус, хийжүүлсэн усны борлуулалтын гүйцэтгэлд судалгаа хийсэн. Судалгаанд хамрагдсан худалдааны цэгүүдийн 73.1 хувь нь Улаанбаатар хотод, 26.9 хувь нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байна.

Монгол Улсад савласан усыг хүн амын хэрэглээний онцлогоос хамаарч дөрвөн төрөлд ангилдаг байна. Үүнд:

- Цэвэр ус;
- Хийжүүлсэн ус;
- Амтжуулсан ус;
- Эрдэст рашаан ус.

Судалгаа гүйцэтгэх хугацаанд, эдгээрээс цэвэр усны борлуулалт нийт савласан усны борлуулалтын 77.3 хувийг бүрдүүлсэн.

**График 50. Савласан усны борлуулалтын орлогод эзлэх хувь, усны төрлөөр**
2023 оны 6-8-р сар




***Эх сурвалж:** Ebazaar on time захиалгын систем*

Тус тоон мэдээлэл дээр суурилсан судалгааны үр дүнд савласан усны савлагааны хэмжээ нь 250 мл - 10 литр хүртэл байдаг бөгөөд биет хэмжээгээр 2-5 литрийн савлагаатай ус нь нийт савласан цэвэр усны зах зээлийн 47.1 орчим хувийг бүрдүүлж байна гэсэн тооцоолол гарсан байна.

**График 51. Савласан цэвэр усны зах зээлийн биет хэмжээнд савлагаа бүрийн эзлэх хувь**
2023 оны 6-8-р сар




*Эх сурвалж:* *Ebazaar on time захиалгын систем*

Зах зээлд борлуулагдаж буй савласан цэвэр уснаас жижиг савлагаатай усны борлуулалт нийт борлуулалтын орлогын 51.9 хувийг, 2-5 литрийн дунд савлагаатай ус 22.8 хувийг эзэлж байна гэсэн үр дүнг харуулсан

**График 52. Савласан цэвэр усны зах зээлийн борлуулалтын орлогод савлагаа бүрийн эзлэх хувь**
2023 оны 6-8-р сар




*Эх сурвалж:* *Ebazaar on time захиалгын систем*

СЗХ
2024.04.29
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ, САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

12

СЗХ 2024 04 29 БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

# 12. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги, санхүүгийн төлөвлөгөө

## 12.1. Дунд хугацааны стратеги

Үнэт цаас гаргагч нь экологийн тэнцвэрийг хамгаалан өвлүүлж, бүс нутагтаа хариуцлагатай бизнесээр тэргүүлэх алсын хараатайгаар ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний зорилго нь эрүүл ахуйн шаардлага хангасан савласан цэвэр усыг Монгол Улс даяар боломжийн үнээр борлуулах чиглэлд төвлөрч байгаа бөгөөд энэхүү дунд хугацааны стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, урт хугацааны тогтвортой хөгжил, тогтвортой өсөлтөд чиглэсэн бодлогыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллана. Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны стратегийн хүрээнд бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу тал үүсгэх дараах зорилтуудыг тодорхойлсон. Үүнд:

- Нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах;
- Харилцагчдын тоог нэмэгдүүлэх;
- Бүтээгдэхүүн төрөлжилтийг нэмэгдүүлэх;
- Борлуулалтын хил хязгаараа тэлэх.

Эдгээр зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр Үнэт цаас гаргагч нь зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлээд зогсохгүй хэрэглэгчид, харилцагчдадаа чанартай бүтээгдэхүүнийг боломжит үнээр худалдан авах боломжийг нэмэгдүүлж, хүрээлэн буй орчиндоо эерэг нөлөөллийг бий болгох боломжтой юм.

Үнэт цаасны танилцуулгын 11 дэх бүлэгт тусгагдсан зах зээлийн нөхцөл байдалд үндэслэхэд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын савласан цэвэр усны үйлдвэрлэл 2022 оны байдлаар 105,542 тонн хэмжээтэй байгаагаас Үнэт цаас гаргагч нь 32 хувийг дангаар үйлдвэрлэсэн байна. Үнэт цаас гаргагч нь стратеги төлөвлөлтийн хүрээнд тодорхойлсон зорилтуудаа амжилттай хэрэгжүүлснээр зах зээлд эзлэх байр сууриа 2028 оны байдлаар 50.6 хувь хүртэл өсгөх боломжтой гэж үзэж байна.

**График 53. Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны зах зээлийн биет хэмжэнд эзлэх хувь ба Монгол Улсын савласан цэвэр усны зах зээлийн биет хэмжээний төсөөлөл, хувь, мянган тонн**
2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL

СЭХ
2024 он 01 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооноос гаргасан тайлангаас харахад сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын хэмжээнд цэвэр усыг боловсруулан үйлдвэрлэсэн тонн хэмжээ жилийн 11.7 хувийн жилийн дундаж нийлмэл өсөлттэй байна. Сүүлийн жилүүдэд хэрэглэгчдийн хэрэглээний хандлага сахрын агууламжтай бүтээгдэхүүнээс татгалзаж, эрүүл органик хэрэглээг илүү чухалчлах болсон. Түүнчлэн хэрэглэгчдийн ундны усны хэрэглээний хандлага өөрчлөгдөн, өдөр тутмын хүнсэндээ худгийн эсвэл төв шугамын усыг шууд хэрэглэхээс илүүтэйгээр савласан цэвэр усыг худалдан авч хэрэглэх хандлага ажиглагдах болсон. Дээрх нийгмийн хандлагын өөрчлөлт нь савласан цэвэр усны зах зээлд эергээр нөлөөлнө гэж үзсэн тул Үнэт цаас гаргагч нь савласан усны зах зээлийн ирэх таван жилийн өсөлт нь 11.7 хувь байна гэж тооцоолж байна.

### 12.1.1. Нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн жилүүдэд үйлдвэрлэлийн бүхий л хүчин чадлаар ажиллаж Улаанбаатар хотын болон ойролцоох аймаг сумдад савласан цэвэр усаа хангалттай хэмжээнд түгээхэд хүчин чармайлт гарган ажилладаг байсан ч Үнэт цаас гаргагчийн цэвэр усны эрэлт нь нийлүүлэлтээс үргэлж өндөр байсаар ирсэн. Иймд Үнэт цаас гаргагч нь 2023 онд ус цэвэршүүлэгч үйлдвэрийн тоног төхөөрөмжөө шинэчилснээр Монгол Улсын савласан цэвэр усны хэрэглээг бүрэн хангах хүчин чадалтай болсон бөгөөд масс (олон тоо ширхгээр) үйлдвэрлэлийг дотооддоо хангалттай түвшинд хийх боломжийг ашиглан нийлүүлэлтийн тасалдалгүй байдлыг хангана.

Монгол Улсад бий болгосон савласан цэвэр усны тэргүүлэгч үйлдвэрийн хүчин чадлын давуу талыг ашиглан зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх зорилтын хүрээнд дараах алхмуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- **Хэмнэлттэй, боломжийн үнийн бодлогыг үргэлжлүүлэн баримтална.**

Үйлдвэрлэлийн өртгийг үе шаттайгаар бууруулах ажлын хүрээнд усны савлагааны жинг судалгаа болон технологийн шийдлийг ашиглан үе шаттайгаар бууруулах, мөн хүнсний стандартын шаардлага хангасан дахин боловсруулсан түүхий эдийг ашиглаж эхэлсэн байна. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн өртгийг бууруулаад зогсохгүй, хуванцар савны ухаалаг хэрэглээг бий болгохоор төлөвлөж байна. Дижитал технологийн боломжууд болон үр дүнтэй менежментийн арга барилыг ашиглан тээвэрлэлтийн үр ашигтай системийг бий болгож нэгж бүтээгдэхүүнд ногдох тээврийн зардлыг бууруулах чиглэлд ажиллаж байна.

- **Улаанбаатар хотын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллана.**

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй супермаркетууд, жижиг болон сүлжээ дэлгүүрүүдэд нийлүүлэлтийн хомсдол үүсээд байгаа бөгөөд энэхүү хомсдолыг нөхөхийн тулд түгээлтийн менежментийг сайжруулах чиглэлд ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн тооцоолж байгаагаар нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг ханган ажилласнаар борлуулалтын тоо ширхэг 30 хувь хүртэл өсөх боломжтой гэж үзэж байна.

Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### 12.1.2. Харилцагчийн тоог нэмэгдүүлэх

Үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн нь Үнэт цаас гаргагчид савласан цэвэр усны нийлүүлэлтээ нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх, борлуулалтын сувгуудыг үр дүнтэй ашиглах боломжийг нээж өгсөн юм.

- Үнэт цаас гаргагчийн харилцагчийн тоог нэмэгдүүлэх стратегийн хүрээнд зочид буудал, нийтийн хоол үйлчилгээний салбарт /ХоРеКа суваг/ үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна.
- Харилцагчийн урт хугацааны хамтын ажиллагаанд чиглэсэн урамшуулал, идэвхжүүлэлтийн хөтөлбөрийг бий болгож зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх, тогтвортой хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- Судалгаа хөгжүүлэлтийн хөтөлбөрийг нэвтрүүлэх хэлбэрээр зах зээл болон харилцагчийн зан төлөвийн судалгаа, харилцагч мэдээллийн өгөгдлийн сан үүсгэж, судалгаан дээр суурилсан оновчтой шийдвэр гаргалт, үр ашигтай үйл ажиллагааны схемийг нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна. Түүнчлэн харилцагчид тулгамдаж буй асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх байдлаар үйл ажиллагааны сайжруулалтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллана.
- Орон нутагт борлуулалтын сувгийг тэлэх стратегийн хүрээнд бүсчилсэн салбар, гэрээт харилцагчдаар дамжуулан орон нутгийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг түгээж, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ.

#### Зочид буудал, нийтийн хоол үйлчилгээний салбар

2022 оны байдлаар Улаанбаатар хотод нийт 2,200 орчим аж ахуйн нэгж зочид буудал, нийтийн хоол үйлчилгээний салбар /ХоРеКа суваг/-т үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагчийн 2022 оны харилцагчдын мэдээллийг харвал нийт харилцагчдын 6 хувь, нийт борлуулалтын ердөө 3 хувийг нь тус салбарын харилцагчид бүрдүүлж байна. Үүнээс харахад Үнэт цаас гаргагч нь энэ салбарын харилцагчидтай хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж, харилцагчдын тоог нэмэгдүүлснээр зах зээлд байр сууриа нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

**Хүснэгт 35. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын байгууллагуудын тоо**

| № | Үйлчилгээний төрлөөр | Аймаг | Нийслэл | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Ресторан | 256 | 1,021 | 1,570 |
| 2 | Зочид буудлын дэргэдэх ресторан | 160 | | |
| 3 | Амратлын газрын дэргэдэх ресторан | 133 | | |
| 4 | Кафе | 121 | 225 | 400 |
| 5 | Кофе шоп | 54 | | |
| 6 | Баар (караоке, пива) | 386 | 945 | 1,331 |
| 7 | Түргэн хоолны газар | 85 | - | 85 |
| 8 | Эмнэлэг, сувилал | 44 | 100 | 544 |
| 9 | Цэцэрлэг сургууль | 915 | 685 | 1,600 |

*Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо*



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### 12.1.3. Бүтээгдэхүүн төрөлжилтийг нэмэгдүүлэх

Үнэт цаас гаргагч нь хэрэглэгч бүрийн хэрэглээний онцлог, амьдралын хэв маягт нийцсэн савлагааны сонголтууд болон бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 2023 онд хүчил шүлтийг тэнцвэржүүлсэн Ph8.5 шүлтлэг цэвэр усыг 330 мл болон 500 мл-ийн савлагаатайгаар зах зээлд нэвтрүүлсэн.

Түүнчлэн, ирэх жилүүдэд зах зээлд танилцуулахаар бэлдэж буй бүтээгдэхүүний төлөвлөгөөг доорх хүснэгтээр харуулж байна.

**Хүснэгт 36. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн төлөвлөгөө**

| Хэрэгжүүлэх хугацаа | Бүтээгдэхүүн | Зураг |
|---|---|---|
| 2024 | Өдөр тутмын ундны цэвэр усаа худалдааны байгууллагаас худалдан авч хэрэглэдэг хэрэглэгчдэдээ зориулсан 9 литрийн савлагаатай цэвэр ус |  |
| 2025 | Монгол орны цаг уураас шалтгаалан хүний биед нийтлэг дутагддаг витамин Д-ээр баяжуулсан эрдэст ус<br>Монгол хүүхдүүдийн 75.9% нь фторын дутагдлаас үүссэн шүд цоорох өвчлөлтэй байна. Тус фторын хэрэгцээг зохимжит хэмжээгээр нөхөх фторжуулсан цэвэр ус |  |
| 2026 | Хоол шингээлт сайжруулах, хэрэглэгчийн сонголтыг бий болгосон хийжүүлсэн цэвэр ус |  |
| 2028 | Шилэн савлагаатай цэвэр ус |  |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

### 12.1.4. Борлуулалтын хил хязгаараа тэлэх

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжаалах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хэсгийг орон нутагт, тэр дундаа стандартын шаардлага хангасан цэвэр усны хомсдолтой нүүр тулаад байгаа Өмнөговь аймагт цэвэр усны үйлдвэр барихад зарцуулна. Үүний үр дүнд Өмнөговь аймагт оршин суудаг болон уул уурхайн нөлөөллийн бүсэд ажилладаг хэрэглэгчдэд чанарын шаардлага хангасан цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүлэхээс гадна ойролцоох аймаг сумдад савласан цэвэр усыг хямд зардлаар түгээх боломжтой болно.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг савласан цэвэр ус үйлдвэрлэгчид ихэнх нь Улаанбаатар орчим бүс нутагт төвлөрсөн байдаг бөгөөд хөдөө орон нутагт бүтээгдэхүүн нийлүүлэхэд бүтээгдэхүүний онцлогоос шалтгаалан үүсдэг даацын хүндрэл, тээврийн зардал, хадгалалт тээвэрлэлтийн чанар алдагдал гэх асуудлаас үүдэн цөөн тоо хэмжээгээр, өндөр үнэтэйгээр нийлүүлдэг. Иймд Үнэт цаас гаргагч нь ижил үнээр Монгол Улсын өнцөг булан бүрд чанарын шаардлага хангасан савласан цэвэр усыг боломжит хямд үнээр түгээхийн тулд бүсчилсэн үйлдвэрлэлийн цогцолборыг бий болгохыг зорьж байна.

Үнэт цаас гаргагч нь Өмнөд бүс, Зүүн бүс, Баруун бүс, Төвийн бүс гэсэн бүсчилсэн тэлэлтийг хийхээр төлөвлөж байна. Цаашлаад Үнэт цаас гаргагч нь ирэх жилүүдэд Бүгд Найрамдах Узбекистан (цаашид "Узбекстан" гэх) улсад цэвэр усны үйлдвэрийг байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд одоогоор зах зээлийн судалгаа, бичиг баримтын бүрдлийн ажлууд эхэлсэн байна.

Үнэт цаас гаргагчийн зах зээл, хил хязгаараа тэлэх стратегийн хүрээнд хэрэгжүүлэх анхны төсөл бол "South Gobi Voyage" төсөл юм. Уг төсөл нь 2024 онд Өмнөговь аймагт буюу уул уурхайн төвлөрсөн бүс нутагт эхлүүлэхээр судалгаа, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна.

Өмнөд бүсийн онцлог нь уул уурхайн нөлөөллийн бүс нутаг бөгөөд уул уурхайн олборлолт голчлон тус аймгийн төсвийн орлогыг бүрдүүлдэг боловч ундны цэвэр ус нь маш их эрдсийн агууламжтай, эрүүл мэндийн шаардлагыг бүрэн хангаддаггүй сул талтай. Нөгөө талаас уул уурхайн салбарт ажилладаг хүмүүс хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажил үүргээ эрхэлдэг тул Улаанбаатар хотын төвийн оршин суугчидтай харьцуулахад ундны цэвэр усны хэрэгцээ өндөртэй юм.

Өмнөговь аймгийн хүн амын тоо сүүлийн 10 жилийн хугацаанд 14.0 хувиар өссөн бөгөөд 16,000 орчим хүн Өмнөговь аймагт оршин суухаар шилжин ирсэн нь орон нутагт шилжин суурьшсан хүн амын үзүүлэлтээр тэргүүлэх аймгуудын нэг болж байна. Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооны 2022 оны үзүүлэлтээс харахад Өмнөговь аймагт 73,939 хүн ам, 23,712 айл өрх бүртгэлтэй байгаагаас ажиллах хүчний 20-64 насны хүн ам нийт аймгийн хүн амын 55.7 хувийг бүрдүүлж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

СЗХ
2024.04.29 өдөр
БҮРТГЭВ

**График 54. Өмнөговь аймгийн ажиллах хүчний хүн амын тоо, насны ангиллаар, аймгийн нийт хүн амд эзлэх хувь.** 2022 он




**График 55. Өмнөговь аймгийн хүн амын тоо,** 2012-2022 он




*Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо*

Өмнөговь аймгийн хүн амын шилжих хөдөлгөөний тренд нь Уул уурхайн салбарын өсөлттэй хамааралтай байх шинж ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, 2012 он болон 2013 онуудын уул уурхайн салбарын өсөлт нь хүн амын шилжин ирэх хөдөлгөөнд эергээр нөлөөлсөн байна. 2022 оны байдлаар Өмнөговь аймагт шилжин суурьшсан хүн амын тоо 1,769 байгаа нь өнгөрсөн 10 жилийн дундаж шилжин ирсэн хөдөлгөөнөөс өндөр байгаа юм.

**График 56. Өмнөговь аймгийн шилжих хөдөлгөөн, хүний тоо**
2012-2022 он




*Эх сурвалж: Монголын Улсын Үндэсний Статистикийн хороо*



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd Улаанбаатар
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL Улаанбаатар хот

## Өмнөговь аймгийн эдийн засгийн байдал

Өмнөговь аймгийн ДНБ нь 2022 оны байдлаар 1.9 их наяд төгрөг байгаа нь Улсын нийт ДНБ-ий дөрвөн хувийг бүрдүүлж байна. 2022 оны байдлаар Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ нь 26.1 сая төгрөгт хүрч, 2012 оны дүнтэй харьцуулахад тав дахин өссөн байна. 2022 оны үзүүлэлтээр Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ нь Монгол Улсын нийт аймгуудын дундаж дүнгээс 10.42 сая төгрөгөөр өндөр байна.

**График 57. Монгол Улсын ба Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох ДНБ, сая төгрөг**
2012-2022 он




*Эх сурвалж: Монголын Улсын Үндэсний Статистикийн хороо*

Өмнөговь аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт нь 2012 оноос хойш 10 жилийн хугацаанд 14 дахин тэлж 443 тэрбум төгрөгөөс 6.7 их наяд төгрөг болж өссөн байна. 2022 оны Өмнөговь аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт нь улсын дүнгийн 22 хувийг бүрдүүлсэн нь тус аймгийн эдийн засгийн тэлэлт хүчтэй байгааг харуулж байна. Цаашлаад Өмнөговь аймаг нь уул уурхайн стратегийн бүс нутгийн хувьд аймгийн эдийн засаг, хүн ам зүйн өсөлт нь уул уурхайн салбарын өсөлттэй тодорхой хувиар холбогдсон байдаг. Үүний үр дүнд уул уурхайн салбарын өсөлтийг дагалдан Өмнөговь аймгийн аж үйлдвэржилт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

**График 58. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт, их наяд төгрөг**
2012-2022 он




*Эх сурвалж: Монголын Улсын Үндэсний Статистикийн хороо*

## Өмнөговь аймгийн усны чанарын үзүүлэлт

Доорх график дээр "Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны өнөөгийн байдал-2018" түүвэр судалгааны үр дүнг харуулсан бөгөөд тус судалгаагаар хэрэглээний усны чанарын 40% нь дунд зэрэг, 33% нь цэвэр, 12% нь бохир, мөн 12% нь маш бохир гэсэн үзүүлэлт гарсан байна.

**График 59. Өмнөговь аймгийн усны чанарын түвшин, нийт дээж авсан худгийн тоон дунд эзлэх хувь**
2018 он




*Эх сурвалж: "Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны өнөөгийн байдал-2018" түүвэр судалгааны тайлан*

Түүнчлэн Алтайн өвөр говийн сав газарт харьялагдах зарим сумдын усны чанарын судалгаагаар Өмнөговь аймгийн Хүрмэн сумын 4, Баяндалай сумын 2, Гурвантэс сумын 6, Сэврэй сумын 4, Ноён сумын 6, Булган сумын 2, Мандал-Овоо сумын 1 нийт 25 худгийн дээжид усны чанарын шинжилгээ хийлгэхэд шинжилгээнд хамрагдсан 25 худгийн ус 10 үзүүлэлтээр стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс зөрүүтэй байжээ. Дээрх усны чанарын судалгаагаар Өмнөговь аймгийн усанд төмрийн агууламж Ханхонгор, Цогт овоо, Баяндалай сумын усанд, манганы агууламж Ноён, Хүрмэн Мандал овоо сумуудын усад ундны усны стандарт хэмжээнээс өндөр буюу ундны усанд зохисгүй хэмжээнд гарсан байна. Мөн Сэрвэй, Хүрмэн, Ноён сумуудын ундны усны худгийн эрдсийн агууламж нь стандарт хэмжээнээс өндөр гарсан байна. Энэхүү нөхцөл байдал нь Өмнөговь аймгийн хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болох амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн тохиолдол бусад аймгуудад бүртгэгдсэн тохиолдлуудаас өндөр (2017 оны байдлаар) байхад нөлөөлсөн байх магадлалтай гэж эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд үзсэн байна.

### Өмнөговь аймгийн хүн амын савласан цэвэр усны хэрэглээ

Дэлхийн банкны дэргэдэх 2030 Усны Нөөцийн Бүлгийн санаачлагчаар Монгол Улсын Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яамтай хамтран 2020 онд гаргасан “Монголын Өмнөд Говийн бүсийн Гидроэкономик шинжилгээ”-ний тайланд дурдсанаар Өмнөговь аймгийн Уул Уурхайн нөлөөллийн бүс дэх хүнсний үйлдвэрлэлийн усны эрэлт нь 2019 оны байдлаар 32,450 м3/жил буюу нэг жилд 32,450 тонн савласан цэвэр усны эрэлт үүсдэг гэсэн тооцооллыг гаргасан байна. Энэ нь тус оны Монгол Улсын нийт савласан усны үйлдвэрлэлийн 32 хувийг эзэлж байна. Өмнөговь аймгийн Уул Уурхайн нөлөөллийн бүст Даланзадгад, Ханбогд, Ханхонгор, Цогтцэций, Баян-Овоо, Мандал-Овоо, Номгон, Баяндалай, Хүрмэн сумууд багтдаг байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь Өмнөговь аймгийн савласан цэвэр усны хэрэглээний 10-12 хувийг хангасан бөгөөд 2024 оноос тус аймагт цэвэр усны үйлдвэр ашиглалтад орсноор тус зах зээлийн 30-50 хувийг бүрэн хангах боломжтой болж, аливаа тээврийн зардал, жижиглэн дэлгүүрийн үнийн нэмэгдэлгүйгээр шууд үйлдвэрээс нийлүүлэх юм. Үнэт цаас гаргагчийн тооцоолж байгаагаар Өмнөговь аймагт үйлдвэрийн 330 грамм, 500 грамм, 1,500 граммын савлагаа бүхий үйлдвэрийн жижиг шугам, 4,500 граммын савлагаа бүхий үйлдвэрийн том шугамыг суурилуулах төлөвлөгөөтэй байна.

### 12.1.4.1. Узбекистан Улсын нийгэм, эдийн засгийн байдал

Узбекистан Улсын эдийн засаг 2022 онд 80.42 тэрбум ам.долларт хүрч 2021 оноос 15.6 хувиар нэмэгдсэн. Олон Улсын Валютын Сангийн төсөөллөөр Узбекистан Улсын ДНБ 2023 онд 12.4 хувь, 2024 онд 10.0 хувиар өсөх таамаглалтай байна. Тус улсын эдийн засаг 2019 оноос 2022 оны хүртэлх дөрвөн жилийн хугацаанд 33.4 хувийн өсөлт үзүүлсэн нь хөдөө аж ахуй, үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарууд өссөнтэй холбоотой.

СЗХ
2024 оны 02 сарын 29 өдөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

**Хүснэгт 37. Узбекистан Улсын макро үзүүлэлтүүд**
2013-2022 он, 2023-2028 оны төсөөлөл

| | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ДНБ, тэрбум, ам.доллар | 73.19 | 80.85 | 85.66 | 85.66 | 62.08 | 52.87 | 60.28 | 60.23 | 69.60 | 80.42 |
| Инфляци, хувь | 11,7% | 9.1% | 8.5% | 8.8% | 13.9% | 17.5% | 14.5% | 14.5% | 10.8% | 11.4% |
| Ажилгүйдлийн түвшин, хувь | 4.9% | 5.1% | 5.2% | 5.2% | 5.8% | 9.3% | 9.0% | 10.5% | 9.6% | 8.9% |
| Хүн ам, сая | 29.99 | 30.49 | 31.02 | 31.58 | 32.12 | 32.66 | 33.26 | 33.91 | 34.56 | 35.27 |

| | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т | 2028Т |
|---|---|---|---|---|---|---|
| ДНБ, тэрбум, ам.доллар | 90.39 | 99.58 | 113.03 | 129.04 | 147.35 | 167.74 |
| Инфляци, хувь | 10,2% | 10.0% | 10.4% | 8.2% | 6.3% | 5.2% |
| Ажилгүйдлийн түвшин, хувь | 8.4% | 7.9% | 7.4% | 6.9% | 6.4% | 5.9% |
| Хүн ам, сая | 36.03 | 36.74 | 37.48 | 38.23 | 38.99 | 39.77 |

*Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан*

Узбекистан Улсад үйлчилгээний салбар нь ДНБ-ий 47.3 хувийг бүрдүүлдэг бөгөөд худалдаа, тээвэр, харилцаа холбоо, аялал жуулчлал зэргээс бүрддэг. 2022 онд аялал жуулчлалын зорилгоор тус улсыг зорьсон гадаад иргэдийн тоо 5.2 саяд хүрч, өмнөх оноос 52.9 хувиар өсөж, 3.4 сая хүнээр нэмэгдсэн.

Узбекистан Улсын хөдөө аж ахуйн салбар тус улсын ДНБ-ий 23.5 хувийг бүрдүүлдэг бөгөөд нийт ажиллах хүчний 1/3 хэсэг нь тус салбарт ажилладаг. Хөдөө аж ахуйн гол бүтээгдэхүүнд хөвөн, улаан буудай, жимс ногоо, мал аж ахуй багтдаг. Тус улс нь 2022 онд 940 мянган тонн хөвөн үйлдвэрлэж, хөвөнгийн үйлдвэрлэлээр дэлхийд 6-д буюу Энэтхэг, БНХАУ, АНУ, Бразил, Пакистан улсуудын дараа жагсдаг. Түүнчлэн, 2022 онд 19,776 мянган тонн улаан буудай үйлдвэрлэж, дэлхийд буудай үйлдвэрлэлээр 11-т орсон байна.

Түүнчлэн, Узбекистан Улс нь 2022 оны байдлаар уул уурхайн үйлдвэрлэлээрээ дэлхийд 12-т, ураны үйлдвэрлэлээр тавд, алтны үйлдвэрлэлээр 8-д, байгалийн хийн үйлдвэрлэлээр 11-т жагссан ба ураны нөөцөөр 7-д, зэсийн нөөцөөр 9-т ордог байгалийн их хэмжээний нөөц баялагтай. Уул уурхайн салбар нь тус улсын стратегийн салбаруудын нэг ба ДНБ-ий 3.9 хувийг бүрдүүлдэг байна.

Узбекистан Улс нь Төв Азийн хамгийн том цахилгаан үйлдвэрлэгч улс төдийгүй алтны нөөцөөрөө дэлхийд 4-т жагсдаг байна. Мөн тус улсын Засгийн газраас нээлттэй эдийн засагтай улс болох шийдвэр гаргаснаас хойш гадаад шууд хөрөнгө оруулалт тасралтгүй өссөөр байна.

Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

**График 60. Узбекистан Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэрбум ам.доллар**
2013-2022 он




*Эх сурвалж: Дэлхийн банк*

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнесийн орчныг сайжруулах бодлогын хүрээнд тус улсын Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх, хөрөнгө оруулалтын баталгаа гаргах, бизнесийн үйл ажиллагаа явуулахад таатай орчноор хангах, татварын хөнгөлөлт зэрэг дэмжлэгийг үзүүлэхээс гадна хөдөө орон нутагт боловсрол, эрүүл мэндийн систем, ажил эрхлэлт хязгаарлагдмал байдагтай холбоотойгоор нийгмийн тусламжийн хөтөлбөр, дэд бүтцэд чиглэсэн хөрөнгө оруулалт, хөдөө орон нутагт эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогуудыг хэрэгжүүлж байна.

## Узбекистан Улсын савласан цэвэр усны зах зээл

Узбекистан Улсын Засгийн газар нь хүнсний аюулгүй байдлыг хангахад ундны усны хүртээмж, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэн, томоохон хот, суурин газарт усны бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоход анхаарал хандуулан ажиллаж байна. Тус улсын хүн амын талаас илүү хувьд цэвэр ундны усны хүртээмж хангалтгүй байдаг нь гол мөрний бохирдол, ус дамжуулах хоолой нь шаардлага хангаагүй байдаг зэрэгтэй холбоотой юм. Иймд Дэлхийн банкны 2015 онд нийтэлсэн "Төв Азийн усан хангамж, ариун цэврийн үйлчилгээний нийгэмд үзүүлэх нөлөөлөл: Узбекистан Улс" тайланд ус түгээх төвийн шугамтай холбогдсон айл өрхүүдийн 84 орчим хувь нь цэвэршүүлсэн ундны усыг хэрэглэдэг ба тэдгээр айл өрхүүдийн 69 хувь нь усыг буцалгаж, 13 хувь нь шүүлтүүр ашиглан цэвэршүүлж хэрэглэдэг тухай онцолсон байна. Мөн айл өрхүүдийн 15 хувь нь хоёрдогч усны эх үүсвэрийг түлхүү ашигладаг буюу ус түгээх шугамаас ирж байгаа уснаас 1,000 дахин үнэтэй савласан усыг ундны усны хэрэглээнд ашигладаг байна.

Узбекистан Улсын савласан цэвэр усны импортын хэмжээ 2018 оноос жил бүр дунджаар 53.4 хувиар нэмэгдэж, 2022 онд 6.5 сая ам.долларт хүрсэн. 2022 оны байдлаар савласан цэвэр усны импортын 74.0 хувийг Гүрж Улс, 8.4 хувийг ОХУ, 4.8 хувийг Казахстан Улсууд тус тус бүрдүүлсэн. Импортолсон савласан усны хэмжээний 97.5 хувийг байгалийн цэвэр ус, 2.5 хувийг бусад ус бүрдүүлж байна. Узбекистан Улсын Ерөнхийлөгчийн тогтоолоор 2020 оны 01-р сараас эхлэн савласан цэвэр усны импортын татварыг 30-50 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой 2020 онд савласан цэвэр усны импортын хэмжээ буурсан хэдий ч 2021 оноос үргэлжлэн жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

СЗХ 2024.04.29 он сар өдөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

**График 61. Узбекистан Улсын нэг хүний савласан цэвэр усны жилийн хэрэглээ ба нийт хүн амын тоо, литр, сая хүн,** 2018-2022 он, 2023-2027 оны төсөөлөл




*Эх сурвалж: Олон Улсын Валютын сангийн "Дэлхийн эдийн засгийн төлөв байдал", 2023 оны 04-р сар*

Олон улсын судалгааны байгууллагын тооцооллоор Узбекистан Улсын хүн ам өсөхийн хирээр нэг хүний савласан цэвэр усны хэрэглээ нэмэгдэж, тогтворжих төлөвтэй байна. Тус улсын савласан цэвэр усны зах зээлийн хэмжээ 2018 оноос тасралтгүй өсөж 2022 онд 913.7 мянган тоннд хүрсэн бөгөөд эдийн засгийн өсөлт, дэд бүтцийн хурдацтай хөгжил, ажлын байрны хүртээмж нэмэгдэхтэй холбоотой тус үзүүлэлт жил бүр нэмэгдэх боломжтой юм.



МГЛ Аква ХХК MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL

**График 62. Узбекистан Улсын савласан цэвэр усны зах зээлийн биет хэмжээ ба дүн, мянган тонн, сая ам.доллар,** 2018-2022 он, 2023-2027 оны төсөөлөл




***Эх сурвалж:** Statista олон улсын судалгааны байгууллага*

2017 онд Узбекистаны Төв банк хөвөгч ханшийн системд шилжсэнээр ам.доллартой харьцах сумын (Узбекистан Улсын мөнгөн тэмдэгт) ханш суларч улмаар савласан цэвэр усны зах зээлийн ам.доллароор илэрхийлсэн дүн огцом буурсан. 2018 оноос хойш савласан цэвэр усны зах зээл 2022 он хүртэл 453.4 хувиар өсөж, 173.9 сая ам.долларт хүрсэн ба энэхүү үзүүлэлт ирэх жилүүдэд өсөх хандлагатай байна.

2023-2025 онуудад Узбекистан Улсын эдийн засгийг Төв Азийн улсуудаас хамгийн өндөр өсөлт үзүүлэх боломжтой орнуудын нэг болно гэж олон улсын байгууллагууд таамаглаж байгаа нь иргэдийн хэрэглээ нэмэгдэх төлөвтэй байгааг илтгэж буй юм.

СЗХ 2024.04.29 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## 12.2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан дунд хугацааны төлөвлөгөө, компанийн стратеги төлөвлөлт болон дэлхийн ба Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал дээр үндэслэн 2023-2028 оны санхүүгийн үзүүлэлтийн төсөөллийг дараах байдлаар боловсруулсан болно.

**Тодруулга:** Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн төсөөллүүд нь Үнэт цаас гаргагчийн өөрсдийн төсөөлөл дээр суурилсан бөгөөд ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Санхүүгийн тайланд "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК аудитын компани нь аудит гүйцэтгэсэн бөгөөд ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэг аудит, нягтлах ажил болон аливаа ажилбар хийж гүйцэтгээгүй. Тиймээс, энэхүү танилцуулгад багтсан санхүүгийн ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэгэн дүгнэлт гаргаагүй болно. Хөндлөнгийн үнэлгээний компани болох "Итгэлт Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэхдээ санхүүгийн төсөөллийг өөрийн аргачлалаар боловсруулсан учир Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын төсөөллөөс зөрж болохыг анхаарна уу.

**Тодруулга:** Үнэт цаас гаргагч нь 2023 оноос хойших санхүүгийн төсөөллийг боловсруулахдаа Үнэт цаас гаргагчийг 2023 онд нийт энгийн хувьцааны 26.73 хувийг олон нийтэд анх удаа санал болгон, 15,235 сая төгрөгийг татан төвлөрүүлсний дараах байдлаар тооцсон болно. Цаашлаад, хувь нийлүүлсэн болон нийт хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн тооцоололд Үнэт цаас гаргагчийг 2023 онд энгийн хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгосны дараах байдлаар тооцсон.

### 12.2.1. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн төсөөлөл

**Хүснэгт 38. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөлөл, сая төгрөг**
2023-2028 оны төсөөлөл

| | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т | 2028Т |
|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 23,110 | 34,224 | 50,636 | 62,852 | 76,664 | 91,633 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 11,263 | 15,535 | 22,626 | 27,739 | 33,776 | 40,311 |
| **Нийт ашиг** | **11,847** | **18,689** | **28,010** | **35,113** | **42,888** | **51,322** |
| Борлуулалт ба маркетингийн зардал | 869 | 4,997 | 6,260 | 7,483 | 8,332 | 9,052 |
| Удирдлагын зардал | 4,384 | 4,074 | 5,046 | 5,550 | 5,812 | 6,316 |
| Үйл ажиллагааны бус зардал | 568 | 101 | 170 | 154 | 178 | 209 |
| **Хүү Татварын Өмнөх Ашиг** | **6,027** | **9,517** | **16,534** | **21,926** | **28,566** | **35,744** |
| Хүүгийн зардал | 1,186 | 1,219 | 1,388 | 1,008 | 728 | 485 |
| Бодит бус ашиг/алдагдал | (0.18) | - | - | - | - | - |
| **Татварын өмнөх ашиг** | **4,840** | **8,298** | **15,146** | **20,918** | **27,838** | **35,259** |
| Татварын зардал | 514 | 1,286 | 2,421 | 3,637 | 5,058 | 6,646 |
| **Цэвэр ашиг** | **4,327** | **7,012** | **12,725** | **17,281** | **22,780** | **28,614** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

2024.04.29
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

## Борлуулалтын орлого

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөллийг нэгж бүтээгдэхүүний борлуулах тоо ширхэг болон нэгжийн үнэ дээр үндэслэн тооцоолсон.

2022 онд Үнэт цаас гаргагч нь 33,851 тонн, 2023 эхний хагас жилийн байдлаар 15,889 тонн савласан цэвэр ус тус тус борлуулсан байна. 2024 онд Үнэт цаас гаргагч нь 1) үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн, түгээлт ба хамтын ажиллагааны менежментийг сайжруулж, 2) Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүнийг амжилттай танилцуулж, 3) Өмнөговь аймгийн үйлдвэрийн салбар ашиглалтад орсноор 2024 оны нийт борлуулалтын тонн хэмжээг 53,379 тонн хүртэл нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

**График 63. Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны борлуулалтын биет хэмжээ, мянган тонн, өсөлтийн хувь,** 2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

Үнэт цаас гаргагчийн бэлэн бүтээгдэхүүн борлуулах үнэ нь Монгол Улсын хүнсний салбарын инфляц, түүхий эдийн олон улс дээрх зах зээлийн үнэ, төгрөгийн ханшийн өөрчлөлтөөс хамаарч хэлбэлздэг тул тэдгээрийн тооцоолол дээр үндэслэн үнийн стратегийг гаргасан.

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2023 оноос 2028 оны хооронд дунджаар жилийн 32 хувийн өсөлт үзүүлнэ гэж таамаглаж байна. Энэхүү өсөлтөд гол нөлөөлөгч хүчин зүйл нь Өмнөговь аймгийн салбар үйлдвэрийн борлуулалт юм. Өмнөговь аймгийн үйлдвэрийн борлуулалтын таамаглалыг Өмнөговь аймгийн хүн ам зүй, бүс нутгийн эдийн засгийн үзүүлэлт дээр хийгдсэн судалгаа болон Үнэт цаас гаргагчийн өмнөх жилүүдийн борлуулалтын туршлага дээр суурилан тооцсон. 2028 он гэхэд Өмнөговь аймгийн үйлдвэрийн салбарын борлуулалт Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын орлогын 23.7 хувийг бүрдүүлэхээр байна.

Тодруулга: Доорх графикт Үнэт цаас гаргагчийн 2021 болон 2022 оны борлуулалтын орлогын түүхэн үзүүлэлтийг авч үзэхдээ савласан усны борлуулалтын дүнг салган авч тооцсон нь тус онуудын аудитын тайлангийн дүнгээс зөрүүтэй байгаа боловч аудитын тайлангийн борлуулалтын орлого, өртөг хэсгийн тодруулга тайлангийн бэлэн бүтээгдэхүүн борлуулсны орлогын дүнтэй дүйцэж байгааг мэдэгдэж байна. Үнэт цаас гаргагч нь ирэх жилүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө савласан цэвэр усны борлуулалтаас өөр орлого олохгүй гэж үзсэн тул ирээдүйн төсөөллийг харьцуулагдахуйц байх үүднээс доорх графикт бэлэн бүтээгдэхүүн борлуулсны орлогын дүнг нийт борлуулалтын дүнгээс салган авч үзсэн болно.



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

**График 64. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөлөл, сая төгрөг**
2023-2028 он




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

## Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн тооцоололд шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэсэн үндсэн бүрэлдэхүүн нөлөөлдөг бөгөөд тэдгээрээс шууд материал нь хувьсах шинж чанартай байдаг.

### Шууд материал

Бэлэн бүтээгдэхүүний шууд материалын зардал нь хуруу сав, бөглөө, лого, шошго, багцлагч, бариул, огнооны хор, шошгын цавуу гэсэн бүрдлээс гадна усыг эрдэсжүүлэгч түүхий эд гэсэн материалуудаас бүрдэнэ. Шууд материалын үнийн хэлбэлзэл нь түүхий эдийн олон улс дээрх зах зээлийн үнэ, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс хамааралтай хэлбэлздэг. 2023 оны дэлхий нийтийн инфляцын өсөлтөөс шалтгаалан олон улсад түүхий эдийн үнэ өссөний улмаас 2024 оноос 17.5 граммын хуруу сав 45 хувиар, 35.1 граммын хуруу сав 40 хувиар, 28 граммын хуруу сав 39 хувиар тус тус нэмэгдэж, түүнээс цааш жил бүр 6 хувийн өсөлттэй байхаар тооцсон.

### Шууд хөдөлмөр ба Үйлдвэрийн нэмэгдэл зардал

Шууд хөдөлмөр болон үйлдвэрийн нэмэгдэл зардал нь богино-дунд хугацаандаа тогтмол шинж чанартай боловч шууд хөдөлмөрийн зардалд үйлдвэрийн ажилтнууд болон инженерүүдийн цалин урамшуулал, үйлдвэрийн нэмэгдэл зардалд үйлдвэрлэл явуулахад шаардлагатай цахилгаан, дулаан ашиглалт, цэвэрлэгээ ариутгал, үзлэг оношилгоо, засвар үйлчилгээний зардал бүртгэгдэх бөгөөд эдгээр зардлууд нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл, цалин хөлсний өсөлт, цахилгаан дулааны үнийн тарифын өөрчлөлтөөс шалтгаалан хэлбэлзэх хандлагатай тул цалин хөлсний зардлыг жил бүр 8 хувийн өсөлттэй, үйлдвэрийн нэмэгдэл зардлыг жил бүр 6 хувийн өсөлттэй байхаар тооцоолсон.

Тиймээс Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь олон тоо хэмжээгээр үйлдвэрлэх тутам нэгжид ногдох тогтмол зардлын дүн буурах бөгөөд нийц ашгийн ахиуц хувь өсөх хандлагатай байна.

**График 65. Үнэт цаас гаргагчийн савласан цэвэр усны борлуулалтын өртөг ба нийт ашгийн ахиуцын төсөөлөл, сая төгрөг, хувь,** 2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

## Үйл ажиллагааны зардал

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал нь маркетинг, борлуулалтын зардал, болон ерөнхий удирдлагын үйл ажиллагааны зардал гэсэн бүрдэл хэсэгтэй байна. Маркетинг, борлуулалтын зардал нь борлуулалтын орлогын хэмжээтэй уялдсан бөгөөд дунджаар тухайн жилийн борлуулалтын орлогын 10-15 орчим хувьтай дүйцэх хэмжээнд байхаар төсөөлсөн. Үнэт цаас гаргагчийн хувьд 2023 оныг хүртэл борлуулалт, түгээлтийн ажилтнуудын цалингийн зардлыг ерөнхий удирдлагын зардалд бүртгэдэг байснаас үүдэн борлуулалт, маркетинг удирдлагын зардал борлуулалтын орлогын 3-4 хувьтай тэнцэж харагдаж байсан бол 2024 оноос нягтлан бодох бүртгэлийн бодлого, компанийн засаглалын сайжруулалт хийж байгаатай холбоотой борлуулалт, түгээлтийн ажилтнуудын цалин, хангамжийн зардлыг борлуулалт, маркетингийн зардлын ангилалд бүртгэх болсноор борлуулалт, маркетингийн зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь хэмжээ огцом өссөн хувьтай харагдаж байгааг тодотгож байна.

**График 66. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардлын төсөөлөл, сая төгрөг, хувь**
2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

2024.04.29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### Хүүгийн зардал

Үнэт цаас гаргагч нь 2023 оны байдлаар 7,000 сая төгрөгийн богино хугацаат банкны зээлтэй байна. Мөн 2024 онд ашиглалтад орох Өмнөговь аймгийн үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг болох 2,500 сая төгрөгийг зээлээр санхүүжүүлнэ гэж тооцоолж байгаа тул тус тооцоололтой холбоотой хүүгийн зардлыг тооцсон. Мөн Үнэт цаас гаргагч нь 2025 онд шинэ бүтээгдэхүүнтэй холбоотой үйлдвэрийн шинэ тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн. Хүүгийн зардлыг арилжааны банкнуудын дундаж хүүгийн түвшнээр тооцон төсөөлсөн.

## 12.2.2. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлангийн төсөөлөл

**Хүснэгт 39. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөг**
2023-2028 оны төсөөлөл

| | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т | 2028Т |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1,678 | 10,036 | 20,178 | 29,734 | 49,066 | 74,990 |
| Дансны авлага | 4,051 | 4,615 | 7,012 | 9,207 | 10,310 | 15,616 |
| Бусад авлага | 3,658 | 3,884 | 4,926 | 5,379 | 5,530 | 6,284 |
| Бараа материал | 3,603 | 4,881 | 6,948 | 7,208 | 10,025 | 10,048 |
| Урьдчилж төлсөн зардал | 6,890 | 3,258 | 1,011 | 2,618 | 3,721 | 4,307 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | **19,881** | **26,675** | **40,074** | **54,146** | **78,652** | **111,244** |
| Биет хөрөнгө | 15,668 | 26,945 | 28,392 | 27,055 | 25,678 | 24,237 |
| Биет бус хөрөнгө | 1,176 | 1,168 | 1,160 | 1,152 | 1,144 | 1,136 |
| Хөрөнгө оруулалт | | | | 4,300 | 4,300 | 4,300 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | **16,843** | **28,113** | **29,552** | **32,507** | **31,122** | **29,673** |
| **Нийт хөрөнгө** | **36,724** | **54,788** | **69,626** | **86,653** | **109,774** | **140,917** |
| Дансны өглөг | 1,996 | 2,008 | 3,392 | 4,294 | 5,282 | 6,857 |
| Татварын өр төлбөр | 938 | 503 | 1,378 | 1,575 | 2,260 | 3,059 |
| Богино хугацаат зээл | 7,000 | 2,461 | 1,526 | 1,859 | 921 | 110 |
| Урьдчилж орсон орлого | 38 | - | - | - | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 2,742 | 2,360 | 2,406 | 2,580 | 3,107 | 4,073 |
| **Нийт эргэлтийн өр төлбөр** | **12,713** | **7,332** | **8,703** | **10,309** | **11,571** | **14,100** |
| Урт хугацаат зээл | - | 2,039 | 2,781 | 921 | 0 | 0 |
| **Нийт урт хугацаат өр төлбөр** | - | **2,039** | **2,781** | **921** | **0** | **0** |
| **Нийт өр төлбөр** | **12,713** | **9,371** | **11,484** | **11,230** | **11,571** | **14,100** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 600 | 819 | 819 | 819 | 819 | 819 |
| Нэмэгдэж төлөгдсөн капитал | | 14,175 | 14,175 | 14,175 | 14,175 | 14,175 |
| Хуримтлагдсан ашиг | 16,165 | 23,177 | 35,902 | 53,183 | 75,963 | 104,577 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 7,246 | 7,246 | 7,246 | 7,246 | 7,246 | 7,246 |
| **Нийт эздийн өмчийн хэсэг** | **24,011** | **45,417** | **58,142** | **75,423** | **98,203** | **126,817** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмчийн хэсэг** | **36,724** | **54,788** | **69,626** | **86,653** | **109,774** | **140,917** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

СЗХ 2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## Хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2023 оны эхний хагас жилийн байдлаар 35.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2024 онд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсний дараа нийт хөрөнгө 54.8 тэрбум төгрөгт хүрнэ гэж төлөвлөж байна. Үүний үр дүн нийт хөрөнгийг 51.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө, 48.7 хувийг эргэлтийн хөрөнгүүд эзэлж байна.

**График 67. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн төсөөлөл, сая төгрөг, нийт хөрөнгөд эзлэх хувь**
2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

Нийт хөрөнгийн бүтцээс харахад 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн 50 хувь нь эргэлтийн хөрөнгө, 50 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол 2028 онд нийт хөрөнгийн 71 хувийг эргэлтийн хөрөнгө, 29 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлнэ гэж үзэж байна.

СЗХ
2024.04.29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### Дансны авлага

Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн 20-оос ихгүй хувийг бүрдүүлж байгаа дансны авлагын тооцохдоо түүхэн авлагын эргэц суурилсан бөгөөд ирэх жилүүдэд дансны авлагын эргэц өмнөх жилүүдийн дундажтай ойролцоо буюу 7-9 орчим байна гэж тооцоолж байна.

**График 68. Үнэт цаас гаргагчийн дансны авлага ба авлагын эргэцийн төсөөлөл, сая төгрөг, эргэцийн тоо**
2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

Нийт хөрөнгийн бүтцээс харахад 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн 50 хувь нь эргэлтийн хөрөнгө, 50 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол 2028 онд нийт хөрөнгийн 71 хувийг эргэлтийн хөрөнгө, 29 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлнэ гэж үзэж байна.



Эм Жи Эл Акуа ХХК
MGL AQUA Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## Бараа материал

Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн 18-аас ихгүй хувийг бүрдүүлж байгаа бараа материалыг тооцохдоо түүхэн бараа материалын эргэцэд суурилсан бөгөөд ирэх жилүүдэд бараа материалын эргэц өмнөх жилүүдийн дундажтай ойролцоо буюу 4 орчим байна гэж тооцоолж байна.

**График 69. Үнэт цаас гаргагчийн бараа материалын төсөөлөл ба эргэц, сая төгрөг, эргэцийн тоо**
2023-2028 оны төсөөлөл




***Эх сурвалж:** Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

## Үндсэн хөрөнгө

Үнэт цаас гаргагч нь 2023 онд ус цэвэршүүлэх үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө бүхэлд нь сайжруулсан бөгөөд одоогийн Монгол Улсын савласан цэвэр усны хэрэглээнээс хоёр дахин их цэвэр ус үйлдвэрлэх хэмжээнд үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн юм. Мөн өнгөрсөн хугацаанд хийгдсэн үйлдвэрийн байршлын газар, тус газар дээр баригдсан үйлдвэрийн зориулалттай болон үйлдвэрийн ажилтнуудад зориулсан барилга байгууламжийг дахин үнэлэн зах зээлийн үнэлгээг тогтоосон бөгөөд тус үнэлгээг үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй "Гэрэгэ Эстимэйт" ХХК гүйцэтгэсэн болно. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болох 7,246 сая төгрөг Үнэт цаас гаргагчийн 2023 оны санхүүгийн тайланд бүртгэгдсэн. Хөрөнгийн дахин үнэлгээний тайлан болон тус үнэлгээний бүртгэлтэй холбоотой тодруулга нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээний тайлан болон 2023 оны хагас жилийн аудитын тайланд тус тус тусгагдсан болно.

Үнэт цаас гаргагч нь 2024 онд Өмнөговь аймагт цэвэр усны үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн бөгөөд тус график 20-ийн хөрөнгө оруулалтын зардлыг 8,568 сая төгрөг байхаар урьдчилсан тооцоо гаргасан.

Мөн Үнэт цаас гаргагч нь 2024 онд 4.5 литрийн савлагаатай цэвэр усны хүчин чадлыг нэмэгдүүлэхээр үйлдвэрийн шугамд 4,500 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

2025 онд Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлэн хийжүүлсэн цэвэр ус бухий шинэ бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд тус шинэ бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хэмжээг 3,000 сая төгрөг байхаар урьдчилан тооцоолж байна.

2026 онд Үнэт цаас гаргагч нь Узбекистан Улсад савласан цэвэр усны үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлнэ гэж тооцоолж байгаа бөгөөд уг үйлдвэрийн хөрөнгө оруулалт 4,300 сая төгрөгийг төсөөлж байна.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd 2628333
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024-04-29 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн бизнесийн онцлогоос шалтгаалан жил бүр үйлдвэрийн тоног төхөөрөмжийн эд ангийн засвар үйлчилгээнд капитал засварын зардал гардаг бөгөөд уг капитал зардлын төсөөллийг түүхэн гүйцэтгэл дээр үндэслэсэн дундажлан тооцсон болно.

**График 70. Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийн төсөөлөл, сая төгрөг**
2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

## Эх үүсвэр

2023 оны эхний хагас жилийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт эх үүсвэрийн 42 хувийг өр төлбөр, 58 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн.

2023 оны эхний хагас жилийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эздийн өмч 20,953 сая төгрөг байгаа бөгөөд 100 хувь толгой компанид буюу "Ти Эм Эл Трейд" ХХК-д ногдож байна.

2024 онд Үнэт цаас гаргагч нь 13.6 тэрбум төгрөгөөр үйлдвэрийн тоног төхөөрөмж болон Өмнөговь аймаг үйлдвэрийн бүтээн байгуулалт хийх бөгөөд үүнээс 19 хувийг буюу 2.5 тэрбум төгрөгийг арилжааны банкны санхүүжилтээр, 81 хувийг анх удаа хувьцаагаа санал болгох замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэхээр төсөөлсөн.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd 2628333 ГСТ1398 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317939 1119277128 УЛААНБААТАР ХОТ

2024 .02. 29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

**График 71. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн төсөөлөл, сая төгрөг**
2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

Үнэт цаас гаргагч нь 2024 онд нийтэд анх удаа хувьцаа санал болгосноор хувьцаат капиталыг 15.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ. Улмаар тайлант хугацаанд эздийн өмчийн хэмжээ 45.4 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 82.9 хувийг бүрдүүлж байна. 2028 онд эздийн өмч 126.8 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 86.1 хувийг бүрдүүлнэ гэж төсөөлж байна.

## Дансны өглөг ба Урьдчилж орсон орлого

Үнэт цаас гаргагчийн дансны өглөг, урьдчилж орсон орлого, бусад өглөгүүд нь түүхэн дансны өглөгийн эргэц дээр суурилсан бөгөөд өглөгийн эргэц нь дунджаар 7 орчим байхаар төсөөлж байна.

## Богино болон Урт хугацаат зээл

Үнэт цаас гаргагч нь 2023 онд богино хугацаат зээлээр эргэлтийн өр төлбөрийг санхүүжүүлсэн бөгөөд тус зээлийн эргэн төлөлт нь 2024 онд хийгдэхээр төлөвлөгдөж байна. Мөн 2025 оны шинэ бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийн худалдан авалтын санхүүжилт болох 3,000 сая төгрөгийг, Өмнөговь аймгийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын 2,500 сая төгрөгийг банкны зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co.,Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Invescore CAPITAL

СЗХ
2024 .04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

**График 72. Үнэт цаас гаргагчийн дансны өглөгийн төсөөлөл ба дансны өглөгийн эргэц, сая төгрөг, эргэцийн тоо,** 2023-2028 оны төсөөлөл




*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

### 12.2.3. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын төсөөлөл нь Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь 2024 онд 8,568 сая төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар Өмнөговь аймагт салбар үйлдвэр байгуулах, 4,500 сая төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар Улаанбаатар хотын үйлдвэрийн салбарын 4.5 литрийн савлагааны шугамаа өргөжүүлэхээр, 2025 онд 3,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар шинэ бүтээгдэхүүний үйлдвэрийн өргөжилт, 2026 онд Узбекистан улсад цэвэр усны үйлдвэрийн хөрөнгө оруулалт хийхээр тус тус төсөвлөсөн. Мөн жил бүр тогтмол дүнгээр хийгддэг капитал засварыг тухай бүрийн хэрэгцээний дагуу тооцсон. Эдгээр хөрөнгө оруулалтын шийдвэрүүд үр дүнгээ өгч, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа сайжран, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр болон өр төлбөрөө төлөх бүрэн чадамжтай байх төлөвтэй байна.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

Хүснэгт 40. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл, сая төгрөг
2023-2028 он

| | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т | 2028Т |
|---|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | | | | | | |
| **Үйл ажиллагааны орох мөнгөн урсгал** | **24,948** | **37,309** | **55,186** | **66,418** | **81,010** | **96,826** |
| Бэлэн бараа материал борлуулснаас орох | 24,913 | 37,270 | 55,142 | 66,371 | 80,957 | 96,764 |
| Бусад үйл ажиллагаанаас орох | 35 | 39 | 44 | 46 | 53 | 62 |
| **Үйл ажиллагааны гарах мөнгөн урсгал** | **(21,593)** | **(25,853)** | **(43,175)** | **(49,535)** | **(58,109)** | **(72,726)** |
| Ажилтанд төлсөн | (4,166) | (6,085) | (7,784) | (8,881) | (9,667) | (10,562) |
| Нийгмийн даатгалд төлсөн | (532) | (817) | (1,040) | (1,184) | (1,289) | (1,409) |
| Түүхий эд материал худалдан авахад төлсөн | (10,780) | (11,700) | (23,039) | (27,594) | (34,200) | (39,080) |
| Ашиглалтад төлсөн | (72) | (63) | (77) | (86) | (91) | (96) |
| Шатахуун, тээврийн хэрэгсэлд төлсөн | (490) | (984) | (1,434) | (1,862) | (2,228) | (2,461) |
| Хүүгийн зардалд төлсөн | (1,186) | (1,219) | (1,388) | (1,008) | (728) | (485) |
| НӨАТ-т төлсөн | (974) | (1,081) | (2,013) | (2,393) | (3,243) | (3,980) |
| Татварын байгууллагад төлсөн | (795) | (630) | (900) | (1,854) | (3,029) | (4,347) |
| Даатгалд төлсөн | (37) | (54) | (69) | (74) | (70) | (70) |
| Бусад үйл ажиллагааны зардалд төлсөн | (2,560) | (3,220) | (2,655) | (4,600) | (3,563) | (5,681) |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал** | **3,355** | **11,455** | **14,787** | **16,883** | **22,901** | **28,655** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал** | | | | | | |
| Үндсэн хөрөнгө худалдан авалт зарцуулсан | (842) | (14,990) | (4,453) | (1,500) | (1,710) | (1,810) |
| Хөрөнгө оруулалт | - | - | - | (4,300) | - | - |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал** | **(842)** | **(14,990)** | **(4,453)** | **(5,800)** | **(1,710)** | **(1,810)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал** | | | | | | |
| Энгийн хувьцаа гаргаснаас орсон | | 14,394 | | | | |
| Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас орсон | | 2,500 | 3,000 | | | |
| Зээл, өрийн үнэт цаас эргэн төлсөн | (877) | (5,000) | (3,193) | (1,526) | (1,859) | (921) |
| **Санхүүгийн цэвэр мөнгөн урсгал** | **(877)** | **11,894** | **(193)** | **(1,526)** | **(1,859)** | **(921)** |
| **Цэвэр мөнгөн урсгал** | **1,636** | **8,359** | **10,141** | **9,556** | **19,332** | **25,924** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 42 | 1,678 | 10,036 | 20,178 | 29,734 | 49,066 |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,678** | **10,036** | **20,178** | **29,734** | **49,066** | **74,990** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*



MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03
MGL AQUA Co., Ltd
InvesCore CAPITAL

2024.04.29
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### 12.2.4. Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

#### Ашигт ажиллагааны харьцаа

**Хүснэгт 41. Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтийн төсөөлөл, хувь**
2023-2028 он

| | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т | 2028Т |
|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашгийн ахиуц | 18.7% | 20.5% | 25.1% | 27.5% | 29.7% | 31.2% |
| Нийт ашгийн ахиуц | 51.3% | 54.6% | 55.3% | 55.9% | 55.9% | 56.0% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 13.4% | 15.3% | 20.5% | 22.1% | 23.2% | 22.8% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 23.7% | 20.2% | 24.6% | 25.9% | 26.2% | 25.4% |
| Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн харьцаа | 53% | 21% | 20% | 15% | 12% | 11% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

Үнэт цаас гаргагч нь баталсан бизнес төлөвлөгөөний дагуу бизнесийн үйл ажиллагаагаа тэлж, үйл ажиллагааны менежментээ сайжруулснаар цэвэр ашгийн ахиуц жил бүр тогтмол өсөлттэй байна гэж төсөөлж байна.

Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн ахиуц хувь жил бүрээр өсөх хандлага ажиглагдаж байгаа нь борлуулалтын тоо хэмжээ нэмэгдэх бүрд нэгж бүтээгдэхүүнд ногдох тогтмол зардлын хэмжээ буурч, нэгж бүтээгдэхүүний өртөг буурч байна.

Нийт хөрөнгийн өгөөж нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн ашиглалтын үр ашигт байдлыг харуулах бөгөөд энэхүү харьцаа нь өсөх тутам хөрөнгийн ашиглалт сайжирч байгааг илтгэнэ. 2023 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж 13.4 хувь байхаар төлөвлөж байгаа бөгөөд жил бүр тогтвортой өсөлт үзүүлсээр 2028 онд 22.8 хувь хүртэл өснө гэж тооцоолж байна.

**Тодруулга:** Хувь нийлүүлсэн болон нийт хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн тооцоололд Үнэт цаас гаргагчийг 2023 онд энгийн хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгосны дараах байдлаар тооцсон.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

2024.04.29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

## Ду-Понт шинжилгээ

**Хүснэгт 42. Үнэт цаас гаргагчийн үзүүлэлтийн Ду-Понт шинжилгээ**
2023-2028 он

| | 2023Т | 2024Т | 2025Т | 2026Т | 2027Т | 2028Т |
|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашгийн ахиуц | 18.7% | 20.5% | 25.1% | 27.5% | 29.7% | 31.2% |
| Нийт хөрөнгийн эргэц | 0.71 | 0.75 | 0.81 | 0.80 | 0.78 | 0.73 |
| Санхүүгийн хөшүүрэг | 1.77 | 1.32 | 1.20 | 1.17 | 1.13 | 1.11 |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 23.7% | 20.2% | 24.6% | 22.9% | 23.2% | 22.6% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө*

2023 оноос Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн өгөөж нь 23.7 хувьд хүрч ирэх жилүүдэд тогтвортой өсөлт үзүүлнэ гэж төсөөлж байна. Өөрийн хөрөнгийн өгөөжид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны цэвэр ашиг нэмэгдэж, өр төлбөрийн хэмжээ буурснаар эерэг нөлөөг үзүүлнэ гэж харж байна.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгийн бүртгэлдээ дахин үнэлгээ хийлгэсэн бөгөөд уг ажиллагаатай холбоотой үндсэн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний өсөлт нь Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн дүнг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд 2023 оны нийт хөрөнгийн эргэц 0.71 байх бөгөөд ирэх жилүүдэд Үнэт цаас гаргагчийн төлөвлөсөн хөрөнгө оруулалт нь нийт хөрөнгийн эргэцэд сайнаар нөлөөлж хөрөнгийн ашиглалт сайн байна гэж тооцоолж байна.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг нь 2023 онд 1.77-аас 2028 онд 1.11 болон буурснаар Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал сайжран өр төлбөрийн хэмжээ буурч, ашигт ажиллагаа нэмэгдсэнээр санхүүгийн хөшүүрэг тогтворжино гэж төсөөлж байна.

**Тодруулга:** Хувь нийлүүлсэн болон нийт хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн тооцоололд Үнэт цаас гаргагчийг 2023 онд энгийн хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгосны дараах байдлаар тооцсон.

СЗХ
2024 .04. 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

MGL aqua

# НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

13

# 13. Нийтэд санал болгож буй үнэт цаасны тухай

## 13.1. Нийтэд санал болгож буй үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, Эм Жи Эл Акуа ХХК-ийн дүрмийн холбогдох хэсэг, Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Ти Эм Эл Трейд" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2023 оны 11-р сарын 30-ны өдрийн хурлын Б/15 дугаартай "Охин компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, охин компанийн хувьцааг нэмж гаргах, охин компанийн хувьцааг анх удаа нийтэд санал болгон гаргах тухай" шийдвэр, Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчийн 2023 оны 11 сарын 30-ны өдрийн хурлын Б/499 дугаартай "Компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийн хувьцаа нэмж гаргах, компанийн хувьцааг нийтэд анх удаа санал болгон гаргах тухай" шийдвэр, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын 23/12/2 тоот "Нийтэд санал болгон нэмж гаргах энгийн хувьцааны үнэ, нөхцөл тогтоох тухай" тогтоолоор нийт гаргасан хувьцааны 26.73 хувьтай тэнцэх 87,555,616 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган МХБ-ээр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

**Хүснэгт 43. Нийтэд санал болгож буй үнэт цаасны тухай**

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | "Эм Жи Эл Акуа" ХХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийт эргэлтэд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг | 240,000,000 |
| Нийтэд санал болгох эзэмшлийн хувь | 26.73% |
| Анхдагч зах зээлд санал болгох үнэ | 174 төгрөг |
| Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг | 87,555,616 |
| Нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо ширхэг | 327,555,616 |
| Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөхцөл | • Нэмж гаргах хувьцааны 80 хувь хүртэлх хувь буюу 70,044,492 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох;<br>• Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сараас доошгүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх |
| Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөөц | Үлдсэн хэсэг буюу 20 ба түүнээс дээш хувийг хувь тэнцүүлэн хуваарилах нөхцөлөөр |
| Татан төвлөрүүлэх дүн | 15,234,677,184 төгрөг |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр нээх төслийн хөрөнгө оруулалт, том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам, трансформатор, эргэлтийн хөрөнгийн дахин санхүүжилт |
| Хувьцааг арилжаалах арга | Тогтоосон үнийн арга |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

СЭХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01

2024-02-23 БҮРТГЭВ 03

## 13.2. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 2.5 (хоёр аравны тав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 240,000,000 (хоёр зуун дөчин сая) ширхэг энгийн хувьцаатай бөгөөд нэмж 87,555,616 (наян долоон сая таван зуун тавин таван мянга зургаан зуун арван зургаа) ширхэг буюу нийтэд анх удаа санал болгосны дараах нийт энгийн хувьцааны 26.73 хувьтай тэнцэх энгийн хувьцааг нийтэд нээлттэй санал болгон арилжаална. Хувьцаа нэмж гарган нийтэд анх удаа санал болгон нээлттэй хүрээнд арилжаалсны дараа Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц нь доорх байдлаар өөрчлөгдөнө.

**Хүснэгт 44. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтцийн өөрчлөлт**

| Хувьцаа эзэмшигч | Хувьцаа гаргахаас өмнө | | Хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|
| | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшлийн хувь | Нэмж хувьцаа гаргасны дараа | Эзэмшлийн хувь |
| | Ширхэг | Хувь | Ширхэг | Хувь |
| "Ти Эм Эл Трейд" ХХК | 240,000,000 | 100% | 240,000,000 | 73.27% |
| Олон нийт | - | - | 87,555,616 | 26.73% |
| НИЙТ | 240,000,000 | 100% | 327,555,616 | 100% |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

## 13.3. Хувьцааг нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн үнэлгээний компани болох "Итгэлт-Эстимэйт" ХХК (цаашид "Үнэлгээний компани" гэх) нь Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаатай холбоотойгоор "Эм Жи Эл Акуа" ХХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон ба үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хараат бус бизнесийн үнэлгээний тайлангаар хүргүүлсэн.

Үнэлгээний компани нь Үнэлгээний Олон Улсын Стандарт болон Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу зах зээлийн үнэ цэний суурийг сонгож, Үнэт цаас гаргагчийн бизнесийн зах зээлийн харьцуулалтын, орлогын болон хөрөнгөд суурилсан аргуудаар үнэлсэн бөгөөд Орлогын хандлагын мөнгөн гүйлгээ хорогдуулан тооцох аргаар хийсэн үнэлгээнд 100 хувь ач холбогдол өгсөн болно.

### 13.3.1. Цэвэр активын аргад суурилсан үнэлгээ

Үнэлгээний компани нь цэвэр активын аргаар үнэлгээг хийхдээ 2023 оны 06-р сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланд дахин үнэлгээний нэмэгдэл тусгагдсан байсан тул зөвхөн өр төлбөрийг хасаж тооцоолсон. Уг үнэлгээний аргын хүрээнд Үнэлгээний компанийн тайланг үндэслэвэл Үнэт цаас гаргагчийн цэвэр хөрөнгө нь үнэлгээний өдрийн байдлаар 20.95 тэрбум төгрөг байна.

### 13.3.2. Зах зээлийн харьцуулалтын арга

Үнэлгээний компани нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ТОП-20 индексэд багтдаг Монгол Улсад хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй "Мах Импекс" ХК, ""Монос хүнс" ХК, "Түмэн шувуут" ХК-уудын мэдээллийг үндэслэн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн тайлангийн мэдээлэл, үнэлгээний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ болон бусад үзүүлэлтийг авч үзсэн. Харьцуулсан компаниудын зах зээлийн үржүүлэгч нь Үнэ/цэвэр ашгийн дундаж харьцааны (P/E) хувьд 11.7 байхаар гарч байна. Тус үзүүлэлтийг ашиглан Үнэт цаас гаргагчийн үнэ цэнийг баримжаалан тооцоолоход Үнэт цаас гаргагчийн 100 хувийн өмчийн P/E харьцаагаарх зах зээлийн үнэ цэнэ үнэлгээний өдрийн байдлаар 69.69 тэрбум төгрөг байх үр дүн гарч байна.

### 13.3.3. Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох арга



"Эм Жи Эл Акуа" ХХК MGL AQUA 2620333 ГСТ1398 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024 он 01 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ 03

Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн 5 жилийн бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн таамаглалд үндэслэн жил тутмын ирээдүйн чөлөөт мөнгөн урсгалыг тооцож, хорогдуулалтыг 24.8 хувиар, урт хугацааны тогтвортой өсөлтийг 8.8 хувиар тооцон өнөөгийн үнэ цэнийг тооцоолох байдлаар бизнесийн үнэ цэнийг 66.5 тэрбум төгрөг гэж үзсэн байна.

Орлогын хандлагаар буюу ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох үнэлгээний аргачлал нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж, хязгааргүй хугацаанд үйл ажиллагаагаа эрхлэх гэсэн бизнесийн үндсэн философитой нийцдэг тул Үнэлгээний компани энэ аргачлалын үр дүнд 100 хувийн ач холбогдол өгсөн байна.

### 13.3.4. Үнэлгээний үр дүн

Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, үнэлгээний ажлын зорилготой уялдуулан үнэлгээний эцсийн үр дүнг орлогын хандлагын аргаар хийж гүйцэтгэсэн үр дүнгээр дүгнэсэн болно.

**Хүснэгт 45. Бизнесийн үнэлгээний үр дүн**

| Үнэлгээний хандлага | Үнэлгээний арга | Бизнесийн үнэ цэн, сая төгрөгөөр |
|---|---|---|
| Зах зээлийн харьцуулалтын арга | Үржүүлэгчийн арга | 69,697.4 |
| Орлогын хандлагын арга | Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга | 66,458.4 |
| Хөрөнгөд суурилсан арга | Цэвэр хөрөнгийн үнэлгээний арга | 20,952.6 |
| **Эцсийн үнэлгээ** | | **66,458.4** |

*Эх сурвалж: "Итгэлт-Эстимэйт" ХХК-ийн Үнэлгээний тайлан*

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 240,000,000 (хоёр зуун дөчин сая) ширхэг энгийн хувьцаатай байгаа бөгөөд нийтэд анх удаа санал болгон арилжаалах 87,555,616 (наян долоон сая таван зуун тавин таван мянга зургаан зуун арван зургаа) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаснаар нийт 327,555,616 (гурван зуун хорин долоон сая таван зуун тавин таван мянга зургаан зуу арван зургаа) ширхэг энгийн хувьцаатай болно.

Үнэлгээний компаниас тооцоолсон бизнес үнэлгээний үр дүнгээр нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ цэн 202.9 (хоёр зуун хоёр аравны ес) төгрөг байхаар тооцсон ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 12-р сарын 07-ны өдрийн хурлын 23/12/12 тоот тогтоолоор нэгж хувьцааны үнийг 14.24 хувийн хямдруулсан үнээр буюу 174.0 (зуун далан дөрөв) төгрөгөөр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

## 13.4. Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь нийтэд нэгж бүрийн 174.0 (зуун далан дөрвөн) төгрөгийн үнэтэй 87,555,616 (наян долоон сая таван зуун тавин таван мянга зургаан зуун арван зургаа) ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 15,234,677,184 (арван таван тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун наян дөрөв) төгрөгийн татан төвлөрүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна.

**Хүснэгт 46. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө**

| № | Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө | Хувь |
|---|---|---|
| 1 | Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр нээх төслийн хөрөнгө оруулалт | 39.8% |
| 2 | Том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам | 29.5% |
| 3 | Трансформатор | 3.6% |
| 4 | Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт | 27.0% |
| | **Нийт** | **100.0%** |



Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd 2828333 ГСТ1398 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг дээрх байдлаар, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, найдвартай тасралтгүй ажиллагааг хангаж, үр ашгийг нэмэгдүүлэх байдлаар зарцуулахаар Үнэт цаас гаргагч төлөвлөсөн байна.

### Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр нээх төслийн хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 39.8 хувь буюу 6.06 тэрбум төгрөгөөр 2024 онд Монгол Улсын уул уурхайн бүс нутаг болох Өмнөговь аймагт савласан цэвэр усны үйлдвэрийн барилга байгууламжид зарцуулахаар төлөвлөж байна. Өмнөговь аймаг нь уул уурхайн стратегийн бүс нутагт тооцогддог бөгөөд тус аймгийн оршин суугчдаас гадна уул уурхайн 30,000 гаруй ажилчид хүн тус аймагт зорчин очдог байна. Үүн дээр үндэслэн харахад савласан цэвэр усны томоохон хэрэглэгчид нь уул уурхайн компанийн ажилтнууд бөгөөд Өмнөговь аймагт уул уурхайн 80 гаруй орд, 14 туслан гүйцэтгэгч компани, 1,400 гаруй туслан гүйцэтгэгч компани үйл ажиллагаа явуулж байна. Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтын чуулганаас гаргасан дата товхимолд дурдсанаар 2022 онд уул уурхайн 2 том компани орон нутгийн 125 аж ахуй нэгжийг 835 тэрбумын худалдан авалтаар дэмжсэн байна. Оюутолгой компани орон нутгийн компаниас 821 тэрбум төгрөгийн худалдан авалт, "Энержи Ресурс" ХХК нь 14 тэрбум төгрөгийн худалдан авалтыг тус тус хийсэн байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн тооцоолж байгаагаар уул уурхайн ажилтнуудын савласан усны өдрийн норм 1-5 ширхэг байдаг.

**Хүснэгт 47. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг зарим уул уурхайн компаниудын ажилтны тоо болон тэдгээрийн савласан усны хэрэглээний норм**

| Уул уурхайн компаниуд | Байршил | Ажилтны тоо | Өдрийн дундаж хэрэглээ | Жилийн хэрэглээ |
|---|---|---|---|---|
| Оюутолгой | Ханбогд | 20,000+ | 5 ширхэг | 18,000,000 ш |
| Чинхуа-Мак | Ханбогд | 500+ | 1 ширхэг | 500,000 ш |
| Тавантолгой | Цогтцэций | 1,000+ | 1 ширхэг | 360,000 ш |
| ЭТТ | Цогтцэций | 5,000+ | 5 ширхэг | 9,000,000 ш |
| Энержи рес | Цогтцэций | 1,000+ | 1 ширхэг | 328,120 ш |
| МАК | Гурван тэс | 1,000+ | 1 ширхэг | 360,000 ш |
| Өсөх зоос | Гурван тэс | 800+ | 1 ширхэг | 288,000 ш |
| Саус гоби | Баяндалай | 1,200+ | 1 ширхэг | 432,000 ш |
| Тэрра энержи | Ноён | 800+ | 1 ширхэг | 288,000 ш |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн Өмнөговь аймгийн судалгаа*

Тус төслийн явц нь одоогоор үйлдвэрийн байршлыг стратегийн түвшинд судалж байна. Үйлдвэрийн байршлын хувьд Цогтцэций сум болон Ханбогд сумуудыг тусгайлан судалж байгаа бөгөөд доорх нөхцөлүүдийг харгалзан үзэж байна. .

**Хүснэгт 48. Өмнөговь аймгийн Цогтцэций болон Ханбогд сумын харьцуулсан судалгаа**

| Стратеги | Стратеги | Стратеги |
|---|---|---|
| Стратегийн уул уурхайн компаниуд | "Энержи ресурс" ХХК<br>"Таван толгой" ХХК болон түүний туслан гүйцэтгэгч компаниуд | "Оюутолгой" ХХК болон түүний туслан гүйцэтгэгч компаниуд |
| Дэд бүтэц | Хатуу хучилттай замаар холбогдсон, цахилгааны эх үүсвэрт шууд холбогдох боломжтой.<br>10/0.4 кв Цогтцэций дэд станц 35/0.4 дэд станц | Хатуу хучилттай замаар холбогдсон, цахилгааны эх үүсвэрт шууд холбогдох боломжтой.<br>35/10 кв Ханбогд дэд станц |



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co.,Ltd 2933333 ГСТ1398 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

| | | |
|---|---|---|
| Засаг захиргааны дэмжлэг | Засаг дарга нар нь орон нутгийн үйлдвэрийг бодлогоор дэмжин ажилладаг | Засаг дарга нар нь орон нутгийн үйлдвэрийг бодлогоор дэмжин ажилладаг |
| Усны нөөц болон боломжууд | Гашуун худгийн усны нөөц 1,300 тонн/хоног | Гүний хоолойн усны нөөц 75,168 тонн/хоног |
| | Наймантын хөндийн усны нөөц 4,579 тонн/хоног | Галбын говийн усны нөөц 31,967 тонн/хоног |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн Өмнөговь аймгийн судалгаа*

Үнэт цаас гаргагчийн хувьд Өмнөговь аймгийн савласан усны үйлдвэрийн байршлын тодорхойлохдоо дараах хүрээнд ач холбогдол өгөн судалгааны ажлыг хийж байна. Үүнд нь савласан ус хэрэглэгчдийн эрэлт болон хэрэгцээ шаардлага, бизнесийн тогтвортой хамтын ажиллагаа,  орон нутгийн засаг захиргааны үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого, урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгох эдийн засгийн үр өгөөж бүхий байршлыг чухалчилж байна.

Усны судал болон усны чанарын судалгааны хувьд Үнэт цаас гаргагчийн Өмнөговь аймагт байршуулахаар төлөвлөж буй тоног төхөөрөмж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрийн тоног төхөөрөмж бөгөөд энэхүү төхөөрөмж нь техникийн хүчин чадлын хувьд усан дахь бүх нян, бактери, бусад нэг болон олон валенттай эрдсүүдийг 100 хувь шүүх хүчин чадалтай тул усны судлын судалгааг хийхдээ усны нөөц болон байгаль орчны экологийн тэнцвэр байдлыг хадгалах чиглэлд анхаарал хандуулан судалж байна. Савласан цэвэр усны үйлдвэр нь уул уурхайн болон бусад боловсруулах үйлдвэртэй харьцуулахад байгаль орчны орчныг сүйтгэдэггүй, үйлдвэрлэлийн явцад  химийн болон хортой бодис ялгаруулдаггүй давуу талтай. Цаашлаад байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжсэнээр тухайн бүс нутгийн эдийн засгийг төрөлжүүлж, шинэ ажлын байрыг бий болгож, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, усны ундаргыг хүний хүчин зүйлээс шалтгаалсан бохирдол, аюулаас хамгаалах юм. Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн хамгийн боломжит үнээр чанарын шаардлага хангасан цэвэр усыг зах зээлд нийлүүлэх зарчим нь тухайн бүс нутгийн оршин суугчдад ундандаа эрүүл цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

Үйлдвэрийн хүчин чадлын хувьд жилд 40 сая литр усыг цэвэршүүлэх хүчин чадал бүхий Францын Sidel брэндийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Өмнөговь аймагт суурилуулахаар бэлдсэн. Уг тоног төхөөрөмж нь Улаанбаатар хотын үйлдвэрт ашиглаж байсан төхөөрөмж бөгөөд 2023 онд Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шинэ тоног төхөөрөмжийг суурилуулсан тул өмнө ашиглаж байсан тоног төхөөрөмжийг Өмнөговь аймгийн үйлдвэрлэлийн байр ашиглалтад ормогц нүүлгэн шилжүүлэхэд бэлэн болсон.

Үнэт цаасны танилцуулгын 12-р бүлэгт дурдсан Өмнөговь аймгийн эдийн засаг болон савласан усны зах зээлийг судалж үзэхэд тус аймагт байрлах үйлдвэрийн хүчин чадал нь тухайн бүс нутгийн савласан усны жилийн эрэлтийг 1.6 дахин хангах хүчин чадалтай. Мөн Өмнөговь аймгийн усны чанарын үзүүлэлт нь Монгол улсын бусад бүх нутгийн усны чанартай харьцуулахад эрдсийн агууламж өндөртэй байдаг тул оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг байна. Үнэт цаас гаргагчийн үйлдвэрийн хүчин чадал нь усан дахь нян, вирусийг 100 хувь устгаж, нэг болон олон валент эрдсүүдийг бүрэн шүүдэг тул Өмнөговь аймгийн хэрэглэгчдэд чанарын шаардлага хангасан савласан цэвэр усыг аливаа тээврийн болон бусад нэмэгдэлгүй, үйлдвэрийн үнээр хэрэглэх боломж бий болгож байгаа юм.

Өмнөговийн салбар үйлдвэрийн төслийн ТЭЗҮ тооцоололд үндэслэвэл хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 4.3 жил байгаа нь тухайн төсөл анх оруулсан хөрөнгөө нөхөх хэмжээний үр ашигтайг илтгэж байна.



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК Invescore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.04.29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

### Том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 29.5 хувь буюу 4.5 тэрбум төгрөгөөр 2024 онд том савлагаатай бүтээгдэхүүний сав үлээх, савлах, багцлах цогц систем бүхий үйлдвэрлэлийн шугамыг суурилуулж, үйлдвэрийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Тус тоног төхөөрөмжийн судалгааг хийсний үр дүнд салбартаа 30 гаруй жилийн туршлагатай БНХАУ-ын сав үлээх тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр тэргүүлэгч Guozhu Group компаниас худалдан авахаар төлөвлөсөн. Тус шугамыг суурилуулснаар том савлагаатай савласан цэвэр усны борлуулалтыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийн бүтээмж өсөж, улмаар зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх боломжтой юм.

**Зураг 22. Том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам**




Том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугамыг импортоор оруулж ирж буй тул импортын барааны гаалийн албан татвар болох 5 хувийг төлдөг. Түүнчлэн, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11.1-т заасны дагуу тоног төхөөрөмжийн борлуулалтын үнэлгээний 10 хувиар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх юм.

### Трансформатор

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 3.6 хувь буюу 550 сая төгрөгөөр 2024 онд трансформаторыг Улаанбаатар хот дах үйлдвэртээ суурилуулахаар төлөвлөж байна. Үнэт цаас гаргагчийн одоогийн трансформаторыг 20 жил тасралтгүй ашигласан тул тогны хэлбэлзлийн хяналтыг сайжруулахын тулд шинэ трансформаторыг суурилуулах шаардлага үүссэн..

### Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 27.0 хувь буюу 4.1 тэрбум төгрөгийг 2024 онд үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулж, үйл ажиллагааг хэвийн тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулах бөгөөд өөр байдлаар зарцуулахгүй болно. Татан төвлөрүүлэх хөрөнгийн ашиглалт болон Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр бий болох бизнесийн өсөлт, эдийн засгийн үр өгөөжийг Үнэт цаас танилцуулгын 12-р бүлгээс үзнэ үү.

Үнэт цаас гаргагч нь хувьцааг анх удаа нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат болох ажлын хүрээнд үнэт цаас гаргахтай холбоотой гарах зардлыг олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс суутган тооцохгүй болно.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co.,Ltd
ГСТ1398
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024 .04 сар 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ-03

### 13.5. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого

Үнэт цаас гаргагч нь "Эм Жи Эл Акуа ХК-ийн Ногдол ашиг хуваарилах журам"-ыг Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн Хуулийн зөвлөхтэй хамтран боловсруулсан. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй болсны дараа ТУЗ-ийн анхдугаар хурлаар хувьцаат компанийн хурлаар тус Ногдол ашиг хуваарилах журмыг батлуулахаар төлөвлөж байна.

Энэхүү журамд компанийн ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, хуваарилах тухай шийдвэр гаргах болон тэдгээртэй холбогдон гарах аливаа харилцааг зохицуулна.

#### 13.5.1. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана. Үнэт цаас гаргагч нь дараах нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа Компани төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх.

Дээрх нөхцөл бүрэн бүрдсэн бөгөөд Компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалт, тусгай зориулалтын санд зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа тохиолдолд ногдол ашиг хуваарилахаар төлөвлөсөн байна. Үнэт цаас гаргагч нь эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

#### 13.5.2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргаж ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлнэ. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг танилцуулах үүрэгтэй байна.

#### 13.5.3. Ногдол ашиг хуваарилах

Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журмыг нь хувьцаа эзэмшигчдэд тохиромжтой байхаар тогтооно. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс Компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх захирал хариуцахаар Ногдол ашиг хуваарилах журмын төсөлд зохицуулсан.

Ногдол ашгийг олгох хэлбэр нь мөнгөн хөрөнгө, зах зээлд идэвхтэй арилжаалагддаг үнэт цаасны хэлбэртэй байж болно. Хувьцаа эзэмшигч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд эд хөрөнгийн хэлбэрээр олгож болно. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна. Хувьцаа эзэмшигч нь ногдол ашгаа аваагүй нөхцөлд нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй байна.

### 13.6. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигчид нь Монгол улсын Компанийн тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн төсөлд заасан дараах нийтлэг эрх, үүргийг эдэлнэ.



Эм Жи Эл Акуа ХХК MGL AQUA CO.,LTD 2020333 ГСТ1398 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

### 13.6.1. Хувьцаа эзэмшигчийн эрх

- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй санал эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа (Үнэт цаас гаргагч давуу эрхийн хувьцаа гаргах тохиолдолд) эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
- Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх ;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах;
  - Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
  - Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн;
  - Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;
  - Нэг хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон бол.
- Энгийн хувьцааны тавaас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;
- Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;
- Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн 8.2-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

### 13.6.2. Хувьцаа эзэмшигчийн үүрэг

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны тавaас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх;

- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
- Хууль тогтоомж болон Дүрмээр тогтоосон бусад үүрэг.

## 13.7. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

### 13.7.1. Зохицуулагч байгууллагын шийдвэр

Үнэт цаас гаргагч нь анх удаа нийтэд санал болгон гаргах Үнэт цаасаа бүртгүүлж, арилжаалах зөвшөөрөл авах хүсэлтийг МХБ болон СЗХ-нд тус тус гаргах бөгөөд уг зохицуулагч байгууллагууд зөвшөөрөл олгосноор олон нийтэд санал болгон арилжаална.

### 13.7.2. Үнэт цаасыг нийтэд танилцуулах

СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.5 дах хэсэгт заасны дагуу Андеррайтер нь Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагаа эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө СЗХ мэдэгдэнэ. Андеррайтер нь Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны талаарх танилцуулгыг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг ажлын 10 өдрийн дотор, хувьцааны захиалгын бүртгэлийг ажлын таван өдрийн дотор тус тус хийж гүйцэтгэнэ.

Үнэт цаас олон нийтэд танилцуулах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэт цаасны мэдээллийг хүргэх;
- Нээлттэй болон хаалттай хүрээнд танилцуулга уулзалт зохион байгуулах;
- Үнэт цаасны танилцуулга, хураангуй танилцуулгыг хөрөнгө оруулагчдад танилцуулах;
- Маркетингийн төлөвлөгөөнд заасан бусад арга хэлбэрээр танилцуулах.

СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.4 дэх хэсэгт заасны дагуу Андеррайтер нь Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнөх хугацаанд стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хувьцааны талаар танилцуулж болно.

### 13.7.3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 12-р сарын 07-ны өдрийн 23/12/2 тоот тогтоолын дагуу нийтэд анх удаа санал болгон нэмж гаргах хувьцааны нэгжийн үнийг 174 (зуун далан дөрөв) төгрөгөөр тогтоосон бөгөөд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 4-р бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Тогтоосон үнийн аргаар арилжааг явуулахад хөрөнгө оруулагч нь худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

### 13.7.4. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө СЗХ болон МХБ-д мэдэгдэж, анхдагч зах зээлийн захиалгыг эхлүүлнэ. Стратегийн хөрөнгө оруулагчдаас анхдагч зах зээлийн захиалгыг Андеррайтерууд, олон нийтээс анхдагч зах зээлийн захиалгыг МХБ гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан тус тус авна.

Үнэт цаасны захиалгын бүртгэлийн ажиллагааг МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжааны программаар зохион байгуулна. Хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн захиалгын хугацаанд Үнэт цаас гаргагчийн тогтоосон үнээр тоо ширхэг, нийт үнийн дүнг зааж захиалга өгнө. Хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнөх хугацаанд өөрийн харилцдаг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгсөн нөхцөлд уг захиалга нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгын үед арилжааны программд шивэгдэж орно.

- **Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар**

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Үнэт цаасыг худалдан авахаар төлөвлөж буй хөрөнгө оруулагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд дор дурдсан зааврын дагуу оролцоно.



СЗХ 2024.04.29 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03
MGL AQUA Co., Ltd УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

**Схем 46. Үнэт цаасны арилжаанд оролцох заавар**

1. **Үнэт цаасны данс нээлгэх:**
Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ.

2. **Захиалга өгөх:**
Өөрийн сонгон үйлчлүүлж буй үнэт цаасны компанидаа хувьцаа худалдан авах захиалга өгнө.

3. **Мөнгө байршуулах:**
Үнэт цаасны дансанддоорх зааврын дагуу мөнгөн дүнг арилжааны шимтгэлийн хамт байршуулна.

- Дансны дугаар: **** **** ****
- Банкны нэр: Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
- Дансны нэр: Харилцагчийн нэр
- Гүйлгээний дүн: Хөрөнгө оруулах хэмжээ+Арилжааны шимтгэл

***Үнэт цаасны дансанд мөнгө байршуулсаны дараа тухайн үнэт цаасны компанидаа буюу брокертоо эргэн мэдэгдэх ёстойг анхаарна уу.**

4. **Захиалга биелэх:**
"Эм Жи Эл Акуа" ХК-ийн хувьцаа эзэмшигч болсон танд баяр хүргэе.

### 13.7.5. Анхдагч зах зээлийн арилжаа идэвхжүүлэх

Андеррайтер нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах арилжааг идэвхжүүлэх зорилгоор СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.6 дах хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа худалдаж авна. Андеррайтер нь үнэт цаасыг нийтэд санал болгосны дараа түүний худалдагдаагүй үлдсэн хэсгийг худалдан авах буюу commitment үүрэг хүлээгээгүй болно.

### 13.7.6. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт хийх

Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалт хийх үйл ажиллагааг Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөн СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу гүйцэтгэнэ.

**Хүснэгт 49. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт**

| Хөрөнгө оруулагчийн төрөл | Санал болгох хувь | Санал болгох хувьцааны тоо ширхэг | Санал болгох үнэ |
|---|---|---|---|
| Стратегийн хөрөнгө оруулагчдад | 80% хүртэлх | 70,044,492 хүртэлх | 174 төгрөг |
| Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад | 20% ба түүнээс дээш | 17,511,124 ба түүнээс дээш | 174 төгрөг |
| **Нийт** | **100%** | **87,555,616** | |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч арилжааны журам"-ын 3.3 дахь заалтыг үндэслэн, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын 600 ширхэг хүртэл хувьцааны захиалга бүрэн биелнэ.

Хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан хувьцааны нийт захиалгын тоо нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тооноос илүү байх тохиолдолд ХУВЬ ТЭНЦҮҮЛЭХ АРГА-ыг ашиглан хуваарилалт хийх бөгөөд Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авахаар өгсөн захиалгыг хувь тэнцүүлэх хуваарилалтад оруулахгүй болно.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг арилжааны захиалга эхлэхээс өмнө Арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

СЗХ 2024 .01 сар 29 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024 -02- 23 БҮРТГЭВ-03

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-д хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон Арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

- **Стратегийн хөрөнгө оруулагч**

Стратегийн хөрөнгө оруулагч нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасыг 6 сарын хугацаанд тусгаарлах үүрэг хүлээсэн, 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөг болон түүнээс дээш үнийн дүнгээр хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэй хөрөнгө оруулагчийг хэлэх ба тус стратегийн хөрөнгө оруулагчдыг Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд тодорхойлж, стратегийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна. Стратерийн хөрөнгө оруулагчдын өгсөн захиалга 100 хувь биелэх буюу хувь тэнцүүлэх хуваарилалтад орохгүй болно.

### 13.7.7. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцох тухай

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгох 87,555,616 ширхэг хувьцааг 100% хувь амжилттай борлуулснаар анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзнэ. Өөрөөр хэлбэл анхдагч зах зээлийн арилжаагаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ 100 хувь биелсэн тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нэлттэй худалдах ажиллагааг амжилттай биелсэнд тооцно.

Анхдагч зах зээлийн арилжаанд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд хувьцаа нэмж гаргахгүй буюу Greenshoe хэрэгжүүлэхгүй болно.

### 13.7.8. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд СЗХ-ны зөвшөөрлөөр Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр анхдагч зах зээлийн арилжаанаас хувьцаа худалдан авсан хөрөнгө оруулагчид өөрийн эзэмшилд буй хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээгдэнэ. Хэрэв хөрөнгө оруулагч нь хувьцааг тусгаарлуулах нөхцөлтэйгөөр худалдан авсан бол хувьцаа тусгаарлуулах хугацаа дуусгавар болсны дараа хувьцаагаа худалдах эрх нь нээгдэхийг анхаарна уу.

### 13.7.9. Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр

Үндсэн андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 (зургаа) сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Үндсэн Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас худалдаж авах буюу хувьцааны үнийг тогтворжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан. Энэхүү үйл ажиллагааг дараах нөхцөлтэйгөөр явуулах бөгөөд хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8-р зүйлд заасан зохицуулалтуудад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

**Хүснэгт 50. Үнэт цаас гаргагчийн хувьцааг үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл**

| Нөхцөл | Хязгаарлалт |
|---|---|
| Үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх үнийн дүн | 1,000,000,000 (нэг тэрбум) хүртэлх төгрөгийн үнийн дүнгээр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ |
| Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа | Хувьцааны хоёрдогч зах зээлий арилжаа эхэлснээс хойш 6 (зургаа) сарын хугацаанд |



MGL AQUA Co., Ltd 2629... ГСТ4598 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 ... 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024 .04.29 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

| | |
|---|---|
| Үнэ тогтворжуулах нөхцөл | Үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны үнэ анх гаргасан үнээс 15 (арван тав) хувь болон түүнээс дээш хэмжээгээр буурсан тохиолдолд |
| Багцын арилжаа | Багц арилжааны хэлцэл нь энэхүү хөтөлбөрт хамаарахгүй |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хувьцааг үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл*

Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх зардал нь Үнэт цаас гаргагчийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс суутгагдахгүй бөгөөд Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80-р зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй, хууль тогтоомжийн дагуу ажиллагааг явуулах бөгөөд түүнийгээ батлан талууд холбогдох баримт бичгүүдээр энэ тухай баталгаажуулсан болно.

Үндсэн андеррайтер, зах зээл үүсгэгч нь Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа дууссан өдрөөс хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын гурван өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлнэ.

### 13.7.10. Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгон үйлчлүүлж буй үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компанийн шимтгэлийн нийт дүн багтсан байдаг.

Хөрөнгө оруулагчаас суутгах үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй байдгийг анхаарна уу.

### 13.7.11. Албан татвар

Үнэт цаас худалдан авч буй хөрөнгө оруулагч нь Монгол Улсад оршин суугч хувь хүн байх тохиолдолд "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.1.3 дэх хэсэгт заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 17.1.3 дэх хэсэгт заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 21.5 дахь хэсэгт заасан 5% хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаас худалдан авч буй хөрөнгө оруулагч нь Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу Аж ахуйн нэгж байх тохиолдолд "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 18.6.2 дэх хэсэгт заасан (ногдол ашгийн орлого) нийт дүнгээс, 18.3 дахь хэсэгт заасан (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого) худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 20.2.1 болон 20.2.5 дах хэсэгт заасан хувь хэмжээгээр татвар төлнө.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд өөрийн харьяалах улс нь Монгол Улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон хэрэв давхар татварын гэрээтэй байх тохиолдолд тухайн гэрээний агуулга нөхцөлүүдийг сайтар судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

### 13.7.12. Мөнгөн тэмдэгт

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

### 13.7.13. Бүхэлчлэх

Зарим мөнгөн дүн болон хувийг тоймлон оруулсан тул зарим хүснэгтэд бүхэл утгаар илэрхийлсэн тоон дүнгүүд нь арифметик бүхэлчлэх аргыг ашигласан дүн болно.

### 13.7.14. Хэл

Энэхүү танилцуулгыг Монгол хэлээр үйлдсэн бөгөөд гадаад хэл рүү орчуулсан орчуулга нь Монгол хувилбараас утга, агуулга, ямар нэгэн байдлаар зөрсөн тохиолдолд энэхүү Монгол эх хувилбарыг давуу хүчинтэйд тооцно. Танилцуулгад олон улсад тогтсон жишиг, практикийн дагуу нэр томьёоны тайлбарт туссан зарим Англи нэр томьёолол ашиглана.



Эм Жи Эл Аква ХХК MGL AQUA Co., Ltd 2620333 ГСТ1396 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.04.29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

14

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

СЗХ
2024.04.29
он сар өдөр
БҮРТГЭВ

Андеррайтер

"Инвескор Капитал ҮЦК" ХХК

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, 1-р хороо, 13-р хороолол, Парисын гудамж 42, Ай Си Ти Тауэр барилга, 15 давхар, 1503 тоот |
| Утас: | (976) 7755 0077 |
| И-мэйл: | info@icapital.mn |
| Вэб хуудас: | www.icapital.mn |

Туслах андеррайтер

"Таван Богд Капитал ҮЦК" ХХК

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа Улаанбаатар худалдааны төв, 1 давхар |
| Утас: | (976) 7272 7282 |
| И-мэйл: | cr@tavanbogdcapital.com |
| Вэб хуудас: | tavanbogdcapital.com |

Аудитын компани

"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъяан гүний гудамж-18/1, Даун Таун Оффис, 602 тоот |
| Утас: | (976) 7505 7979 |
| И-мэйл: | info@pkf.mn |
| Вэб хуудас: | www.pfk-ifs.mn |

СЭХ 2024 он 04 сар 29 өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

## Үнэлгээний компани

ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ

**"Итгэлт- Эстимэйт" ХХК**

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүнну, Олимп плаза, 401 тоот |
| Утас: | (976) 7600 5638 |
| И-мэйл: | itgelt_estimate@itgeltgroup.mn |
| Вэб хуудас: | www.itgeltgroup.mn |

## Хуулийн зөвлөх

SNOW HILL CONSULTANCY

**"Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси" ХХН**

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын өргөө, 6-р давхар |
| Утас: | (976) 7711 8193 |
| И-мэйл: | info@snowhill.mn |
| Вэб хуудас: | www.snowhill.mn |

### 14.1.1. Андеррайтерийн тухай

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм.

Компани нь үнэт цаасны брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй этгээд бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүйн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олноор бага бүрдүүлсэн. "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Биржийн болон Биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, харилцагч үйлчлүүлэгчдийг мэргэшсэн зөвлөгөөгөөр хангах, үнэт цаасны арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцох, Mergers and Acquisitions (M&A) болон хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн туршлагатай компани юм.

"Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

**2019 он** "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгон гаргах ажиллагаанд туслах андеррайтераар оролцож нийт 18.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

---

**2021 он** Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас "Инвескор Актив ХБҮЦ"-ыг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан гаргах ажиллагаанд андеррайтераар ажиллаж нийт 4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Уг үнэт цаас гаргах ажиллагаанд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу хөрөнгө худалдагчаар "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК оролцсон.

---

**2021 он** Хувийн хэвшлийн анхны өрийн хэрэгслийн хөтөлбөр болох "Инвескор ББСБ" ХК-ийн нийт 20 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Инвескор Бонд өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргасан бөгөөд 100% борлуулсан.

---

**2021 он** Биржийн Бус Зах Зээлд "Кэй Эй Майнинг" ХХК-ийн нийт 10 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий "Хишиг Бонд 2022 15%" өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж, Транч 1 болох 3.2 тэрбум төгрөгийг амжилтай татан төвлөрүүлсэн.

---

**2021 он** Биржийн бус зах зээлд "Инвескор ББСБ" ХК-ийн 10 тэрбум хүртэлх төгрөгийн хаалттай өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж, хөтөлбөрийн хүрээнд нийт 6,740,000,000 төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

---

**2022 он** "Шунхлай" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Шунхлай Бонд" идэвхтэй үлдэгдэл бүхий давтамжтай үргэлжлэх холимог хугацаат өрийн хэрэгслийн хөтөлбөрийг хөрөнгө оруулагчдад санал болгон гаргахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлж тус өрийн хэрэгслийн хөтөлбөрийн хүрээнд 2 удаагийн хэсэгчлэн гаргах ажиллагааны үр дүнд 23.9 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

2024.04.29

**2022 он**

"Актив Гарден" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Актив Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 6.4 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

**2022 он**

"Ай Си Рэит" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Рэит Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 10 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

**2022 он**

"Инвескор ББСБ" ХК-ийн биржийн бус зах зээлд "Инвескор Хаалттай Бонд" өрийн хэрэгслийг хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгон гаргаж 10 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

**2022 он**

"Инвескор ББСБ" ХК-ийн FPO буюу нэмэлт хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 16.7 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

**2022 он**

Монгол Улсын түүхэн дэх хамгийн томд тооцогдох IPO-н нэг болох "Голомт Банк" ХК-ийн хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 118.8 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх түүхэн үйл ажиллагаанд үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

**2022 он**

"Инвескор ББСБ" ХК-ийн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргахаар бүртгүүлсэн нээлттэй бонд болох 50 тэрбум хүртэлх төгрөгийн өрийн хэрэгслийг хөтөлбөр болгон үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж, 2023 оны 04-р сарын 05-ны өдөр бондын хөтөлбөрийн 3 дахь траншаа амжилттай гаргаж, нийт 30 тэрбум төгрөгийн амжилттай татан төвлөрүүлсэн.

**2022 он**

Монгол төрийн компаниудын хувьчлалын эхлэлийг тавьсан "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн үнэт цаасыг биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж, 11.9 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх түүхэн үйл ажиллагаанд үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн.

**2023 он**

"Монложистикс Холдинг" ХХК-ийн нийт 11.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх, 59.4 сая ширхэг хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй байдлаар арилжаалсан бөгөөд тус үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн. Анхдагч арилжаагаар тус хувьцааны захиалгын дүн төлөвлөгөөт дүнгээс давж 103.08 хувийн гүйцэтгэлтэй хаагдсан.

**2023 он**

"Инновэйшн Инвестмент" ХХК-ийн нийт 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх, 157.1 сая ширхэг хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй байдлаар арилжаалсан бөгөөд тус үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн. Анхдагч арилжаагаар тус хувьцааны захиалгын дүн төлөвлөгөөт дүнгээс давж 100.34 хувийн гүйцэтгэлтэй хаагдсан.



Эм Жи Эл Аква ХХК MGL Aqua Co., Ltd Улаанбаатар хот
"Инвескор Капитал ҮЦК" ХХК InvesCore Capital Улаанбаатар

СЭХ
2024.04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

## Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр АҮГ_230410/01 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ"-г байгуулж, уг гэрээгээр Үнэт цаас гаргагчийн хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгон гаргах үйл ажиллагааны хүрээнд талуудын хооронд үүсэх харилцаа, эрх, үүргийг зохицуулжээ.

Гэрээгээр Андеррайтер нь Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах, Үнэт цаас гаргагчид шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татан төвлөрүүлэх болон нийтэд анх удаа санал болгох ажлыг зохион байгуулж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дах хэсэгт заасны дагуу Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүхий л хүчин чармайлт гаргаж ажиллахаар зохицуулсан байна.

Андеррайтер нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг, үзүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн журам, үнэт цаас санал болгон гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж гүйцэтгэх, Гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой аливаа асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцан аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, ажлын төлөвлөгөөнд заасан ажиллагаануудыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудад Үнэт цаас гаргагчид зөвлөх, дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллах, Үнэт цаас гарагчийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж ашиг сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалын бүрэн бүтэн байдал, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хамаарах аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагч нь андеррайтерт үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах аливаа материалыг түргэн шуурхай гаргаж өгөх, андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах, үнэн зөв мэдээлэл өгөөгүйгээс шалтгаалан гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах, андеррайтераас шилжүүлж өгсөн нийтэд ил болоогүй бүх төрлийн мэдээлэл, зөвлөмж, тайлан мэдээ, төсөл төлөвлөгөөг зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд ашиглах ба андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх арга барил, ноу-хау, баримт материалын нууцлалыг хадгалж, зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, задруулахгүй, хуулбарлахгүй, дамжуулахгүй байх үүрэгтэй.

Мөн гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчийн харилцааг зохицуулсан байх бөгөөд үүнд Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд, албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд, үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны "Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам-"д заасан бусад этгээдийг ойлгоно. Уг этгээдүүд нь гэрээ дуусгавар болох хүртэлх хугацаанд үнэт цаасны ханш, арилжааны хэмжээний хэлбэлзэл, үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцох, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах, үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны "Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам" болон эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох журмын дагуу хориглосон бусад үйл ажиллагаа үйлдэхийг хориглосон байна.

СЗХ
2024.04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-02-23
БҮРТГЭВ-03

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖООР БОДИТ БОЛГО

### 14.1.2. Туслах андеррайтерийн тухай

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь 2011 онд "Зэт Жи Би ҮЦК" ХХК нэртэйгээр брокерийн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан бөгөөд 2021 оны 04 сард бүтцийн өөрчлөлт хийж, Таван Богд Трейд ХХК-ийн 85%-ийн хөрөнгө оруулалттайгаар өөрчлөн байгуулагдсан

Ийнхүү 2021 оны 04 сараас үйл ажиллагаандаа томоохон өөрчлөлтийг хийж Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлтээр Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Мөнгөн хөрөнгийн номинал данс эзэмших, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах худалдан авахад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг авч харилцагч, хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн өргөн хүрээнд үйлчилгээг үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь 2021 оны 12 дугаар сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд үндсэн андеррайтераар ажиллан Говь ХК, Таван Богд Финанс ББСБ ХХК, Эко Кар Центр ХХК, БИД ББСБ, Гэрэл Финанс ББСБ болон Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-ийн нийт 268.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг биржийн бус зах зээлээс, Инвескор ББСБ ХХК-ийн нийт 50 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нээлттэй зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн байна. Мөн Газар шим ХК, МонБийф ХХК болон Хаан банк ХК-ний IPO гаргалт дээр туслах андеррайтераар ажиллан нээлттэй зах зээлээс 196.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

### Туслах андеррайтертэй байгуулсан гэрээний тухай

Үндсэн андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Туслах андеррайтер "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр 43/ТА-01 дугаартай "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан. Уг гэрээгээр Үнэт цаас гаргагчийн хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох, худалдах үйл ажиллагааг ажилттай зохион байгуулах зорилгын хүрээнд хамтран ажиллахтай холбоотой талуудын эрх, үүргийг зохицуулсан байна.

Гэрээний дагуу Андеррайтерууд нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд санал болгож, байршуулах төлөвлөгөөг хамтран боловсруулахаар тохирсон. Андеррайтерууд нь гадаад, дотоодын боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, тэдгээрээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, Үнэт цаас гаргагчийг төлөөлөн танилцуулга хийх, санал тавих, уулзалт зохион байгуулах, зуучлах, хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийхэд болон гэрээ байгуулахад зуучлах, хамтран ажиллах үүргийг харилцан хүлээсэн байна,

Талууд үйл ажиллагаандаа Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцааг олон нийтэд санал болгох, худалдах, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийг нэгдсэн зорилго болгож, бие биенийхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, хамгаалах болон шударга байх зарчмыг баримтлан ажиллах, Үнэт цаас гаргагчийн нууцад хамаарах мэдээ, мэдээллийг чандлан хадгалахаар харилцан тохирчээ.



Эм Жи Эл Аква ХХК
MGL AQUA Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.04.29 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-02-23 БҮРТГЭВ-03

### 14.1.3. Аудитын компанийн тухай

"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК аудитын фирм нь анх "Координат Аудит" ХХК нэртэйгээр 1998 онд үүсгэн байгуулагдсан анхны олон танигдсан аудитын компаниудын нэг юм. Тус компани нь аудит, санхүүгийн салбарт 25 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулахдаа мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, нийтийн ашиг сонирхлыг хангах үндсэн үүрэг хариуцлагыг ухамсарлан, үйлчлүүлэгч, харилцагчдад мэргэжлийн өндөр түвшинд чанартай ажил, үйлчилгээг үзүүлэх, тэднийг үнэн зөв мэдээллээр хангах эрхэм зорилгыг баримталж ирсэн.

Мөн санхүүгийн салбарын хөгжил, дэвшилд багагүй хувь нэмрийг оруулж аудит ба баталгаажуулалт, татвар, бизнесийн зөвлөх үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч олон улсын сүлжээ фирмүүдийн нэг "PKF International" сүлжээ фирмтэй 2016 оноос хойш хамтран ажиллаж байгаа ба тус сүлжээ фирмийн Монгол Улс дахь албан ёсны төлөөллийг хэрэгжүүлэх гишүүн фирмийн эрхийг 2017 онд хүлээн авч үйлчлүүлэгч, харилцагчдад олон улсын стандартад нийцсэн, чанартай, мэргэжлийн ажил, үйлчилгээг үзүүлж байна.

"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК нь Олон төрлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын түнш, харилцагч, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, ур чадвартай багийг бүрдүүлэн хувийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллага, төсвийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрүүд зэрэг эдийн засгийн салбар бүрд хамрагдах 200 гаруй байгууллагад аудитын болон зөвлөх үйлчилгээ үзүүлсэн, төрийн байгууллагуудын захиалгаар санхүүгийн шинжээчийн ажлуудыг гүйцэтгэсэн ажлын арвин туршлагатай хамт олон билээ.

"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэлийн, зөвлөх, татварын зөвлөх болон цалин хөлсний үйлчилгээний чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

**Татварын зөвлөх үйлчилгээний чиглэлээр:**

- Татварын хууль дүрмийн хэрэгжилт
- Татварын шалгалтын өмнөх аудит
- Татварын тайлан бэлтгэх
- Хувийн татварын үйлчилгээ
- Татвар төлөлтийг төлөвлөх
- Гадаад мэргэжилтнүүдийн үйлчилгээ

**Цалин хөлсний үйлчилгээний чиглэлээр:**

- Ажил олголтын бүтэц, зохион байгуулалт
- Цалин, урамшууллын багцын зөвлөгөө
- Суутган татварын тооцоолол, тайлагнал
- Ажлаас халагдсаны тэтгэмжийн зөвлөгөө
- Нийгмийн даатгал болон бусад зөвлөгөө
- Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийн зөвлөгөө

СЗХ
2024 .04 сар 29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -02- 23
БҮРТГЭВ-03

**Аудит, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний чиглэлээр:**

- Бие даасан санхүүгийн тайлангийн аудит
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит
- Нийцлийн аудит
- Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт (СТОУС)-ын хэрэглээ болон сургалт
- Дотоод аудитын үйлчилгээ
- Дотоод хяналтыг дахин нягтлах үйлчилгээ
- Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан бэлтгэх үйлчилгээ
- Шуухийн шинжилгээ, баримтын шалгалт
- Санхүүгийн баримт бичгийн бүрдүүлэлт

**Зөвлөх үйлчилгээний чиглэлээр:**

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах үйлчилгээ
- Бизнесийн болон удирдлагын зөвлөгөө
- Санхүүгийн программ хангамжийн зөвлөгөө, сургалт
- Харилцан тохиролцсон горимын үйлчилгээ
- Эрсдэлийн удирдлагын зөвлөгөө
- Компанийн засаглалын зөвлөгөө
- IPO гаргаж буй компанийн зөвлөгөө
- Санхүүгийн шинжилгээ
- Бусад аутсорсинг үйлчилгээ
- Олон улсын төслийн зөвлөх үйлчилгээ

## Аудитын компанитай байгуулсан гэрээний тухай

